

# ДЭМШГЭГЭЙН АЖЛАЛ

БОЛСОН ЯВДАЛ



# ДЭМШГҮЙН ЯВДА

БОЛСОН ЯВДАЛ

Г.Нямсэлүү

Аймшгийн яриа  
Зохиолч: Г.Нарсайн

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

# Өмнөх үг

Миний бие Аймшгийн яриа ( болсон явдал ) фэйсбүүк бүлгэмийг анх 2013 оны 8 сард хэсэг нөхдийн хамт нээж байсан билээ . Яагаад бүлгэмээ нээх болсон шалтгаан гэвэл тэр бүр тохиолдоод байдаггүй салшгүй юмс үзэгдлүүд , мэдрэмжүүд болон амьдралд минь тохиолдож байсан далд ертөнцийнсэдэвтэй зүйлс энэ холбоотой байсаар ирсэнд юм. Айдас хүйдэс болон ухаарал сургамжийг бүлгэмээрээ дамжуулан олон нийтэд аль болох зөв талаас нь мессеж хүргэхийг хичээсээр ирлээ. Уншигчидтайгаа хамт байсаар багагүй хугацааг өнгөрүүлжээ. Өнгөрсөн 2 жил гаруйн хугацаанд нийт уншигчид , бүлгэмийн гишүүдийн маань тоо удахгүй 70.000 болон түүнээс дээшээ өсөх хандлагатай байгаа юм. Бүлгэм маань шинэ мэдээ мэдээлэл , нийтлэлүүдээр өдөр бүр арвиждаг билээ. Энэхүү тэмдэглэлүүдээ зөвхөн бүлгэмийн гишүүд дундаасаа хоёр жил цуглуулсны үндсэн дээр нэгтгэн хэвлүүлж та бүхэндээ хүргэхээр шийдлээ. Тэмдэглэл дотор хүмүүний айдас хүйдэс, далд ертөнцийн хачин жигтэй явдлууд болон онц сонирхолтой шууд ярианаас иш татан оруулснаараа бусад номоос онцлогтой юм.Энэхүү номондоо гишүүдийн ирүүлсэн үнэн бодит тэмдэглэлүүдийг хамтад нь багцлан нэмэлт хачиргүйгээр маш энгийнээр оруулахаар шийдлээ. Тиймдээ ч бусад ном зохиолуудаас онцгой бүтээл болно гэж бодсон билээ. Энэхүү онц сонирхолтой тэмдэглэлүүдийг маань уншсанаар таныг уйдаахгүй гэдэгт итгэж байна. За ингээд уншигч та бүхнийг айдсын ертөнцөөр аялахыг урьж байна.

# Нэгдүгээр бүлэг

## Шөнийн гийчин

Надад тохиолдсон явдал бусад хүмүүсийнх шиг тийм ч аймар биш л дээ. Би шинэ монгол ахлах сургуулийн урд байдаг байранд амьдарч байсан юм. Шинэ баригдсан барилга болохоор өмнө нь хүн амьдарч байгаагүй. Манайх анхных нь. Хятадууд барьж байсан, хятад эзэнтэй байр л даа. Гэртээ олуулаа шуугилдаж байх үед зүгээр байдаг хирнээ ганцаараа хонох болохоор л шөнө 02:40-өөс бараг 3 цаг хүртэл хаалга балбадаг байсан. Аймар их айдаг байсан болохоор хаалгаа тайлдаггүй, тэгээд чимээгүй болсных нь дараа хаалга нэвтрээд нэг юм орж ирээд ард ирж зогсоод мөрөн дээр гараа тавьж байгаа юм шиг санагддаг, гэрт нэг юм нааш цаашаа яваад байгаа ч юм шиг бүр үнэхээр эвгүй. Нэг өдөр би жижиг өрөөнд, ах том өрөөнд унтсан юм. Өглөө 5 цагийн үед ахыг унтаж байхад нь хаалгаар хүн орж ирээд хажууд нь унтсан гэсэн. Найзыгаа ирчихлээ гэж бодоод хажуу тийшээ харах гэсэн чинь толгойгоо даахаа больчихоор нь өөрийгөө үстэж байж хажуу тийшээ харсан чинь хажууд нь хүн байгаагүй гэсэн. Тэгээд яаж ч чадахгүй байхад нь би сэрж гэрэл асаагаад гайгүй болсон гэнэ лээ. Тэр үедээ бид хоёр зүүд гээд л өнгөрсөн. Манай бэр эгчид бас надтай адилхан юм мэдрэгддэг юм шиг байна лээ. Хоорондоо тэр талаар ярьдаггүй л дээ, жаахан эвгүйтээд л өнгөрдөг. Тэр хэрвээ сүнс сүүдэр мөн бол гайгүй томоотой л сүнс юм шиг байгаа юм аа.

\*\*\*

Надад 5 жилийн өмнө нэг сонин зүйл тохиолдсон юм. Манайх Дарь-Эхийн 33-н буудалд амьдардаг байлаа. Би тэнд Хүслэн Лууяа гэдэг 2 найзтайгаа энд тэндхийн хоосон хүнгүй эвгүй байшингуудын цонх хагалаад зугтаадаг байлаа. Тэр үед манай арын гудамжинд нэг хоосон байшин байдаг байсан юм. Бид 3 энэ хавийн хүнгүй эвгүй л гэсэн бүх байшингийн цонхыг хагалсан мөртлөө яагаад ч юм тэр эзэнгүй байшингийн цонхыг хагалаагүй байв. Бид гурав ярьж байгаад тэр байшингийн цонхыг хагалахаар болоод харьсан юм. Тэгээд маргааш бид гурав уулзтал Лууяа "Манай өвөө өчигдөр цонх хагалж дүрсгүйтэхээ боль, тэгж байгаад Лхамаагийн цонхыг хагалчихав, холуур яваарай гэсэн. Тэр эзэнгүй орхисон байшингийн хуучин эзнийг Лхамаа гэдэг эмгэн байсан" гээд Лууяа ярихад, Хүслэн худлаа даа хагалсан ч яадаг юм гээд бид гурав маргаж явсаар байгаад нөгөө байшингийн хажууд очсон байсан. Тэгээд бид гурав нэлээд харж зогсож байтал Хүслэн нээрээ эвгүй юм байна, больё гэхэд би гэнэт зориг ороод яавал гэж гээд наад талын цонх руу чулуу шидсэн чинь аймар чанга бас их олон зүйл хагарч байгаа юм шиг дуугарахаар нь бид гурав зугтаасан юм. Тэр явдлаас хэд хоногийн дараа би коток дээр тоглож байтал миний араас хүн түлхээд би өвдөг дээрээ сөхрөөд унасан. Эргээд хартал хэн ч байгаагүй, би хичээлээ таслаад ганцаараа тоглож байсан юм. Тэгээд босох гэтэл хөл босч чадахгүй байсан, яаж ч хичээгээд босч чадахгүй байсан мөртлөө өөр хүүхэд иртэл зүгээр л босчихсон. Тэгээд хэд хоносны дараа би шөнөжин зурагт үзээд 2 цагийн алдад чихэвч зүүгээд унтах гээд гэрийн хана руугаа хартал хөшигний ард нэг юм байгаа юм шиг байхаар нь тэмтэртэл хүний нүүр мэдэгдсэн. Би аймар айгаад утсаа шидтэл хүний нүүр цохих шиг болсон. Тэгээд би гэрлээ асаагаад гэрээр дүүрэн юм болсон. Түүний дараа манайх нүүсэн. Ээж аав ламд үзүүлсэн л гэсэн. Тэгээд л нүүсэн, учрыг нь би мэдээгүй, ээж аав ч надад юм хэлээгүй би лав тэр байшингаас л болсон гэж боддог. Аймар

байсан, одоо болтол бодогддог.

\* \* \*

цочин сэрж их л айдаст автсан байсан ч зүүдээ санаагүй, тэгээд өөрийгөө хууран байж тайвширсан. Гэвч маргааш нь зүүднийхээ хагасыг санасан. Тэр нь аавыгаа үхэж байгаа мөчийг хажууд нь байгаа юм шиг мэдэрсэн байсан. Тэгээд бас уйлсан. Харин төрсөн өдрөөрөө толинд харж, өөрийгөө аавынхаа үхэлд бруутай хэмээн уйлж байгаад гэрэлтэйгээ унтчихсан байсан. Тэр өдөр зүүдэлсэн зүүд аавын минь захиа байсан ба сэрээд харахад толинд миний биш аавын дүрс харагдаж байсан. Ахиад зүүдэлж байна уу гэж бодоод өөрийгөө бүр хутгаар зүсэж үзсэн одоо тэр сорвийг харах болгондоо тэр захиаг санадаг. Энэ аймар биш байх л даа гэхдээ намайг тухайн үедээ л айдаст авгуулдаг

Энэ надад тохиолдсон зүйл юм аа. Миний аав 2012 онд намайг 1-р курсийн оюутан болж ирэхэд бас яг намайг 18 хүрэхээс 5хоногийн өмнө бурхан болсон юм. Аавыгаа бурхан болох үед би шөнийн 2 цагт байсан.

\* \* \*

Би өөртөө тохиолдсон нэг зүйлийг энд ярья аа. 7 буудлаас хойшоо байдаг лагерт манайх гардаг байсан юм. Тэнд байгаад байхаар их юм болно оо, нэрээр дуудна, шөнө дунд унтаж байхад хөл доор хүн ирж сууна гэх мэт. Тэгсэн нэг удаа би ганцаараа хонох болдог юм байна. Дөнгөж орж ирээд байж байсан чинь тог тасарчихав. Лаа асаагаад ороо засчихаад хэсэг хэвтлээ. Ганцаараа байсан болохоор айдас төрөх маягтай. Ядаж байхад 2 давхар байшин учраас би дээд давхарт нэлийсэн том орон дээр чимээ чагнаад л хэвтэж байлаа. Тэгсэн хаалга чанга саваад л хүн ороод ирж байна. Манайх бүргэд хаалгатай. Тэгээд их чанга хаагддаг юм. Нэг их том хөлийн чимээ л алхаад орж ирээд дээшээ шатаар гараад л ирж байна аа. Би ч айгаад, хулгайч ороод ирлээ л гэж бодоод хөнжлөө бүтээгээд хэсэг хэвтлээ. Тэгсэн нөгөө хөлийн чимээ хажууд ирээд л чимээгүй болчихсон. Айж хэвтэж байгаад хөнжлөө сөхөөд хартал хэн ч юу ч байгаагүй. Би ч бараг үүр цайтал сэрүүн хэвтсэн байх аа.

Бас нэг удаа тэнд эгчтэйгээ хоёулаа дээд давхарт унтах гээд юм яриад хэвтэж байлаа. Тэгсэн эгч аль хэдийнэ унтчихжээ. Сар цонхоор тусаад, өрөө гэрэлтэй байсан юм. Би хэсэг хэвтэж байгаад намайг хүн хараад байгаа юм шиг санагдахаар нь нүдээ нээх үү байх уу гэж бодож бодож нээгээд хартал яг миний дээрээс зэвхий цагаан юм хараад сууж байсан гээд бод. Би ч бараг л ухаан алдах шахаад эгчийгээ сэрээх гээд чадаагүй, дуу ч гарахгүй бас л үүр цайлгасандаа хөөрхий...

\* \* \*

Нэг ах минь даацын машин барьж яваад Заамарын наахна оршуулгын ойролцоо машин нь тоормосгүй болоод хаалгаараа үсрээд дугуйн доороо орж бурхан болсон шөнө байсан юм билээ. Бид очиж биеийг нь цуглуулж өмсөж байсан күртикээр нь хучсан. Мэдээж цагдаа түргэн байсан. Ингээд л оршуулга болсон эхнэр хүүхэд нь Христос шашинтан болохоор углаашийг нь хамт хайрцаглан хийгээд, өөрсдийнхөөрөө л оршуулсан. За ингээд л хэд хонож байтал бид ээлж ээлжээрээ зүүдэлж эхэлсэн. Нүүр ам нь танигдахгүй дээл хувцсаа нэхээд гар

нь савчаад юм нэхээд л, ээ бурхан минь манайхан бүгд айдастай. Удалгүй бас нэг ах маань өвдлөө. Элэг нь мууджээ. Бид лам хар бөө гээд л чадлаараа гүйлээ дээ. Тэгсэн өөрийн гэсэн бүх юмыг нь тэр өнгөрсөн газар нь аваачиж шатаа сүнс нь тэндээ л үсчээд байна, та нарыг бүгдийг чинь дуудаж байна. Хар ямаа, дээлийн торго бэлд гээд бид очиж тэнд нь юм хийлгэсэн. Гэхдээ өвдсөн ах минь өөд болсон. Хайрцаг саванд нь хийх ёстой юмыг нь хийгээгүй, шашны зан үйл тохироогүй энээ тэрээ гээд олон л юм гарсан. Юмыг нь шатааж, хоол өгөөд л нам жим болсон бид нэгнийдээ бөөгнөрч хонодог байсан. Муу ээж минь л хэцүү байсан....

\* \* \*

Үй зайгүй нөхөрлөдөг нэг найзын маань хүүхэд сар гарантай байхдаа бурхан боллоо. Эрэгтэй л дээ. Лам хүүхдээ гурван замын уулзварт тавь гэжээ. Тэгээд өвлийн нүүр нүдгүй шуургатай нэг өдөр бид хоёр машинтай Тавантолгойн наахна очлоо. Уулзвараа олоод найз маань өлгийтэй хүүхдээ тавих болоод л эргэж битгий хараарай гээд буулгасан чинь очоод нэг тавих гэснээ буцааж тэврээд уйлаад зогсчихсон. Ёоо аймар элэг эмтэрмээр, аав болоод хэчнээн баярлаж байлаа. Ах нь аавтай нь цуг араас нь очиж амьгүй хүүг нь булаацалдан байж аваад орж ирээд би хүүгээ хүйтэн шуурганд хээр орхиод явж чадахгүй гэж уйлаад, аймар. Бид нар бүгд шимшрээд л үнэхээр өрөвдмөөр. Дараа нь авгайгийнх нь бие сайн тэнхрэхгүй дордоод, бас л лам хар болсон чинь хүүхэд чинь явахгүй эхийгээ хормойдоод байна гэсэн гэнэ лээ. Нэлээн л юм хийлгэж гайгүй болсон. Тэгж хоргодож болдоггүй юм билээ.

\* \* \*

Энэ жил ахлах сургуульд оров оо. Дотуур байртай сургууль. Тэгээд 12 ортой өрөөнд орлоо. Тэнд эхний улирал байхад нэг их юм болоогүй, харин нэг охин бүх гэрэл унтрахаар эзэнгүй орон дээр суугаад байдаг байсан. Хааяа хөдөлдгийг нь нэг их тоогоогүй, энэ улирал эхлэв. Тэгээд өөр өрөөнд ортол эхний өдрөөсөө эхлээд л сонин сонин юм болоод эхлэв. Эхний өдөр 2 найзтайгаа газар унтсан чинь нэг найз маань зүүв зүгээр байж байгаад уйлчихсан. Яасан гэсэн чинь толгойд нь хүний гар хүрсэн гэсэн. Харин яг тэр талд нь би хар юм харсан. Дараа нь бүгд шөнө унтаж байхад шүүгээний хаалга аймар чанга унасан. Өрөөнийхөн бүгд сэрсэн байтал миний толгой дээр унахад би сэрээгүй бас шөнө найз маань суугаад л байсан, хэвтээч гэсэн чинь нөгөөх чинь унтаж байсан. Тэгээд л айгаад хана руугаа харсан хар юм хэвтэж байсан. Би аймар чанга орилоход хэн ч сонсоогүй бас оройтож сэрээд өрөөндөө ганцаараа байж байсан. Дутуу татсан хөшиг шууд хаагдсан бас цонх өөрөө түгжээ нь тайлагдаад нээгдсэн. Ер нь охидыг ганцаараа байхад их юм болдог. Би халуураад хэвтэж байхад толгой илээд, шүүгээ дуугараад, тойроод алхаад л байсан. Шөнө ор чийхарч дуугардаг. Бас орон доороос тогшдог. Ламд үзүүлсэн чинь хуучин өрөөний сүнс дагаад ирсэн байна. Ер нь гүйдэлтэй газар байна гэсэн. Энэ мэтчилэн олон юм болдог. Дараа улирлаас өөр өрөөнд орно. Тэр нь гайгүй гэж найдъя. Сургууль маань Оросын хуучин цэргийн байр байсан гэсэн.

\* \* \*

6-р ангид байхад тохиолдож байсан явдал. Найзындаа дөрвүүлээ хонож байлаа. Тэгээд унтаж байгаад шөнө дунд гэнэт сэрсэн чинь зуны улирал байсан мөртлөө нэг л хүйтэн жихүүдэс хүргэм байсан. Тэгээд 00 ороод унтахаар явж байтал жижиг өрөөнд нэг цагаан халаадтай

эмэгтэй хүн ширээ налаад уйлаад сууж байна. Гайхаад найзын эгч нь юм байлгүй дээ гэж бодоод тайвшруулах санаатай юу болсон юм тайвшир даа гэх мэт аргадах гэж оролдсон боловч юу ч хэлсэнгүй уйлаад л байсан. Тэгэхээр нь би ч унтахаар явж байтал миний ард-уур нөгөө эгч чинь орц руу гараад яваад өгсөн удахгүй орж ирэх байлгүй гэж бодоод унтаад өглөө. Сэрээд найзаасаа өчигдөр шөнө танай эгч яагаад уйлаад байсан юм бол гэсэн чинь юу яриад байгаа юм эгч Эрдэнэт явсан. Нөгөөдөр ирнэ гэдэг байгаа хамаг биений хөлс чийхраад сонин болоод л явсан. Тэр явдлаас хойш тэднийд ахиад очоогүй ээ. Хамгийн аймшигтай нь би тэр зүйлд маш ойрхон зогсож байснаа бодохоор л хамаг бие салганаад байдаг юм.

\* \* \*

Манай ах өөрийнхөө амийг хорлосон, яагаад гэдгийг нарийн хэлж чадахгүй. Тэгээд хойно 7 буудлаас хойш байдаг лагерийн уулан дээр байдаг ганц модон дээр очиж өөрийгөө боомилчихсон. Тэгээд очоод харсан ч итгэж чадахгүй л байлаа. Их дотно байсан болохоор итгэж чаддаггүй юм билээ. Эцсийн үгээ ч хэлж чадаагүй гэнэтийн явдал байсан болохоор их л хэцүү байлаа. Тэгээд надад нэг тэнэг санаа төрсөн. Хүний нас барсан газар нь очоод гар утсаараа тэр хүний утас руу нь нас барсан газарт нь тавиад залгавал сонсож чаддаг гэж сонсож байснаа туршиж үзэхээр шийдсэн. Тэгээд надтай ярилцсан. Энэ худлаа биш шүү. Түүнээс хойш байнга зүүдэнд ирдэг болсон. Надад юм захиана. Охин нь одоо 5-р анги. Миний зүүдэнд ирээд охинд минь энэ гутлыг аваачаад өгөөрэй гэж хэлсэн. Охин нь ээжтэйгээ амьдардаг юм. Тэгээд би дүүгийнхээ сургууль дээр очиход дүү уранхай гуталтай явж байсан. Тэгээд би шинэ гутал авч өгсөн. Одоог хүртэл миний ах зүүдэнд минь орж ирдэг. Эхнэрээ зүүдэнд жирэмсэн байна гэж харуулсан. Тэгээд би фэйсбүүкийг нь үзэхэд хүнтэй суучихсан юм л даа, тэр жирэмсэн болсон зургаа постлосон байсан. Надад бол би тэр нэг юмыг хийснээс болж л ах минь над дээр ирдэг гэж боддог надад бол муудсан юм нэг ч алга....

\* \* \*

Надад тохиолдсон явдал юм аа. Богд ар хорооллын ба байранд нэг орой хамаатны хүүхдүүд ирээд хөзөр тоглож байтал хамгийн эхэнд хусагдаад уурлаад зогсож байтал хажуу өрөөнөөс (тэр өрөөнд нялх хүүхэд тэргэн дээрээ унтаж байсан юм) тэрэг нүдэж байгаа чимээ гараад за за дуу байгаа юм чинь гээд тэр өрөөнд орохоор (өрөө харанхуй байсан) явж байтал гал тогооны (гал тогоо тэр өрөөний яг хажууд байдаг) нэг шүүгээ онгойгоод буцаж хаагдаад ядаж байхад гал тогооны тавилга улаан өнгөтэйг ч хэлэх үү хэсэг харж зогсож байснаа гэнэт сэхээ аваад тэд нар луу очоод хажууд нь сууж байгаад унтсан байсан. Дараа нь тэр байрыг оффис болгоод ашиглаж байхад нь очоод тэр тухайгаа ч мартсан байсан. Тэгээд нэлээн удаан том өрөөнд зурагт үзэж байгаад, олигтой юм гарахгүй болохоор ээж рүү очихоор явж байгаад эргээд хартал хөшигний урд нэг дүрс намайг хараад зогсож байснаа замхраад алга болсон. Би ч өмнөх болсон юмыг санаад хар хурдаараа гүйгээд ээж дээр очсон. Харин тэндээс яг гарах гэж байхад чихэн дээр "ЭРГЭЭД ХАР" гэж хэлэх шиг болсон. Би яахаа мэдэхгүй дэмий л ээжийг яаруулаад байж байтал үүдний толинд дүүжлүүлсэн эмэгтэй харагдсан. Нэг мэдэхэд л тэндээс гарчихсан байсан. Тэр явдлаас хойш дахиж тийшээ зүглээгүй ээ....

\* \* \*

Надад туслаач! Намайг жоохон хүүхэд болохоор хэн ч итгэхгүй байх л даа. Саяхан нүүж орсон



гурван өрөө байранд минь сонин юм болоод байна. Миний өрөөнд тогтмол үүрийн 05:30 гээд хэн нэгэн өрөөний хаалга нүддэг. Үүнээс болоод би хаалгаа онгорхой унтах болсон ч эхэндээ бүх зүйл хэвийн байсан ч удалгүй үүрийн 05:30 гээд ямар нэг зүйл хана тогшин эсвэл гялгар уут шаржигнуулах, ширээн дээрх үзэг унах гэх мэт үзэгдэл эхэлдэг. Ээж аавдаа хэлэхээр итгэхгүй юм. Нэг удаа би аав дүү хоёрыг өрөөндөө хонуулаад би том өрөөнд унтсан. Өглөө сэрэхэд аав өөр өрөөнд ороод унтаж байсан. Би яагаад тэгснийг асуухад юу ч хэлээгүй. Одоо ч би тийм байдалд байна. Нэгэнт лам дуудаж чадахгүй хойно өөрөө энэ бүхнийг мэдэхийг хүсэж байна. Надад тусалж зөвлөгөө өгөөч.

\* \* \*

Саяхан өвөө маань өнгөрөөд 49 хоног дотроо гэрээ эргэнэ гэж бичсэн дэвтрийг нь олж уншиж байсан юм. Гэтэл яг 49 хоног нь арай дуусаагүй байхад шөнийн 3 цагийн үед миний бие нээх хөшөөд хүйт даагаад өөрөө сэрчихсэн юм. Тэгсэн нэг л эвгүй мэдрэмж төрөөд босоод суучихсан. Зурагтынхаа удирдлагыг олоод асаасан чинь аав ээж 2-ийн өрөө хаалга нь онгойгоод коридор руу хүн алхаж байгаа чимээ сонсогдоод нэг юм гараад явчихсан. Би өвөө минь ирсэн болов уу гэж боддог. Нас барахынхаа өмнөх шөнө намайг үнсэнэ гэж байсан.

\* \* \*

4 жилийн өмнө ах дүүсээрээ хөдөө Монголын алдартай сүм хийд дуган үзээд буцах замдаа төв аймагт төөрлөө. 1 урт микро, 1 жижиг тэрэгтэй явсан юм. Хавь ойрд айл байхгүй, зүг чигийн баримжаагаа жолооч ах маань алдчихаад нэг газраа л эргээд байсан юм. За за больё эндээ хоноод өглөө хөдөлбө майхнаа засацгаа гээд нээх тогтуун шөнө 2 майхнаа засаад шөнө унтацгаасан юм. Манай майханд ээжийн нэг том ах унтаад, зайлуул унадаг өвчтэй байсан юм. Шөнө дунд нэг хүн ёолоод л майхан тойроод байна. Хэн бэ гэхээр л дуугарахгүй, ёолоод л майхан тойроод хөлөө чирээд байсан. Ээжийн ах руу харсан чинь уналт өгөөд татчихсан гэрэл байхгүй гарт мэдрэгдээд арай гэж эм танг нь өгөөд иллэг хийж өгөөд үүр цайлгаад гарсан. Тэгсэн чинь хажуу майханд бас хүн ёолоод унтуулаагүй гээд гараад ирдэг юм. Тэгээд бүгдээрээ харсан чинь хоёр том, нэг хүүхдийн оршуулгын яг хөлд нь, бараг овоолсон чулууг нь дэрлээд хоноцгоосон байсан.

\* \* \*

Би нэг дүүтэй байлаа. Эхээс хоёулаа. Манайх амгаланд байдаг байсан юм. Тэр нэгэн зуны улирал юм даг, дүүтэйгээ явж байгаад амгалангийн замын доогуур урсдаг горхин дээр тоглож байгаад зам хөндлөн гүйж гарахдаа дүүгээ хөтөлж гараагүйгээс болоод дүү маань машинд дайруулж нас барсан юм. Би 3-р ангид байлаа. Дүүгийнхээ үхсэн биеийг тэврээд эмнэлгийн машинд зүрхийг нь чагнаж байснаа хальт санадаг юм. Тэр явдлаас хойш дүүгээ их зүүдэлдэг байлаа. Дандаа унаж үхэж байна гэж зүүдэлнэ хоёулаа зэрэг унахаар л би амьд үлддэг. Би оюутан боллоо. Тэр нэг өвлийг хүртэл амар тайван байсан юм. Тэгсэн шөнө сэртэл(хагас унтаа байдалтай) миний хажууд сандал дээр суусан нэг эрэгтэй хүүхэд юм ярьж байсан. Би яриад л байсан гэхдээ юу яриад байгаагаа санадаггүй, ганц санаж байгаа зүйл нь "Би явах боллоо та унт унт" гэж хэлснийг саналаа. Өглөө нь сэрээд, юу болов гэж бодоод таньдаг бөө дээрээ очоод хэлтэл, өө танай дүү чамтай одоо болтол хамт байдаг юм байна. Эхээс хоёулаа болохоор аминчхан юм байжээ зайлуул. Чамд муу юм болох гэж байгааг

эртнээс анхааруулж ирсэн юм байна гэж хэлсэн. Сүүлд нь нээрэн л надад муу зүйл болохыг анхааруулж хэлсэн юм билээ.

\* \* \*

Манай эмээгийн тэнд их суварга дүнзэн хуучин байшингууд их байдаг. Замын хажууд зайдуухан ганц дүнзэн байшин байдаг байсан юм. Дээр үед Хятад панзчидын агент байсан гэнэ. Нэг орой нөгөө Батаа гээд жоохон уучихдаг том биетэй ах морьтойгоо халамцуу гэрлүүгээ ирж явахад нь тэр байшингийн хавиас нэрээр нь дуудаад байсан гэсэн. Айж болдоггүй юм гэнэ лээ гээд зориглон алгуурхан явсаар гэртээ орж ирээд ухаан нь орж гарсан гэнэ лээ. Тэгээд бөөн яриа болсон доо. 97 онд хүүхэд нь ярьж өгч байсан юм. Тэрийг ярьж өгсөн хүүхдээс чамд юм тохиолдож байв уу гэхэд яг сүнс чөтгөр хараагүй, гэхдээ орой болгон морио чөдөрлөөд буцдаг. Харанхуйд морио чөдөрлөх гээд явж байхад нь морийг нь түших чөтгөрийн гал харагдсан гэсэн.

\* \* \*

Би 8-р ангид ордог жил. Намар дуусаад өвөл болж байлаа. 11 сарын сүүлээр манай гэр урагшаа харсан том цонхтой байсан юм. Нэг орой гал түлээгүй их хүйтэн хонож билээ. Би давхар хөнжилтэй дотуур өмдтэйгөө унтаж байсан. Гэтэл шөнө их халууцаад хэн гал түлсэн юм бол гэж бодоод давхар хөнжлийнхөө нэгийг нь хуулаад унтлаа. Бас л их халууцаад байхаар нь дотуур хувцсаа тайлах санаатай босож суугаад тайлж байтал нүдний үзүүрт нэг хар юм тороод, юу билээ гээд хартал манай байшингийн голд зүүн тал руу хараад хүн зогсож байсан юм. Тэр харсан зүгт манай талийгаач өвөө эмээ буурай ээжийн зүраг сирвантан дээр байдаг байлаа. Би ч айх гайхах зэрэгцээд ээжийгээ дуудаад гэрлээ асаагаач ээ гэлээ. Тэгсэн манай байшингийн голд зогсож байсан хүн шууд л үүд үрүү явж харанхуйд уусан алга болсон юм. Гэтэл ээж намайг унтаач гээд загнаад би ч толгой дээгүүрээ хөнжлөө нөмрөөд хэвтээд ойр орчмоо харж байтал үүднээс хэн нэгэн намайг ширтээд байх шиг байсан. Тэгээд л хөшиж орхисон. Маргааш өглөө ээж намайг сэрээхэд л гайгүй ухаан орж билээ.

\* \* \*

Энэ бөө нар их олширсон цагт юм юмыг л үзлээ. Миний нэг таньдаг бөө байдаг юм. Тэр хүнтэй уулзах санаатай гэрт нь очсон юм л даа. Тэгсэн яг шүтээн нь буух гэж байгаатай таарсан юм. Тэгээд төд удалгүй шүтээн нь буугаад амар мэнд эрээд байж байтал гаднаас нэг мангардуу гэмээр хүн орж ирээд тэр бөөд үзүүлсэн юм. Тэгээд хараад байж байтал нөгөө залуу маань бөөгийн яг өмнө нь очоод суутал бөө маань мангардуу залууд хандан чи наад бие дотроо орсон албингаа хэзээ хөөж гаргах гэж байна гэхэд мангардуу залуу чиний жинхэнэ шүтээн гэж юу байсан юм гээд учиргүй уурлаад байлаа. Тэгсэн бөө маань толгой дээр нь гараа тавиад за чи муу тэнэмэл сүнс миний голомтод орж ирчхээд ингэж аашлах болоогүй шүү гээд нөгөө мангардуу залуугийн нруу дундуур ганц цохисон чинь нөгөө залуу цусаар бөөлжиж байснаа гэнэт ухаан орсон уу гэлтэй юу болоод байна аа гээд хаана байгаагаа мэдэхгүй байгаа юм шиг байсан. Тэгээд нөгөө бөө маань тэр мангардуу залууд нэг олбог өгөөд наадахаа сайн хадгалж яваарай гээд явуулсан. Гэтэл төд удалгүй нөгөө залуу чинь орцны гадаа гарчихсан нөгөө бөөгийн өгсөн олбогийг ам руугаа чихэн зогсож байлаа. Тэгэхээр нь сандраад хүүе ээ чи чинь солиорчихсон юм уу наад олбогоо ам руугаа чихэхээ

болиоч ээ гээд хэлсэн чинь нөгөө мангардуу залуу чинь эд нар чинь миний чихэнд наад бөө чинь худал би үнэн, тиймээс наад олбогоо ам руугаа чих гээд байна шүү дээ гээд ам руугаа цус гартал хүчтэй чихээд өөрийгөө яг алах шахаж байхад нь миний таньдаг шүтээний улаач маань гарч ирээд ойртож очоод чихэнд нь ганц үг хэлтэл зүгээр болчихсон юм даа. (Албин гэдэг муу сүнсийг хэлдэг, улаач гэдэг нь бөөг буулгадаг хүнийг хэлнэ)

\* \* \*

Өөрт тохиолдсон явдлаа бичихээр шийдлээ. Тээврийн товчоонд байдаг 2-р сургуулийн хажуу талд том бетонон хашаатай цагаан том хаус шиг барилга байдаг . Тэнд манай эгч нялх хүүхэдтэйгээ нүүж очсон юм. 3 өрөө байр л даа уг нь. Хэдхэн сар түрээслэхэд их л юм болсон доо. Би тэнд очиж амьдрахаар болоод 7 хонож байтал янз бүрийн юм эхэлсэн юм даа. Уг байрыг тавилгатай нь түрээсэлж байсан юм. Би зөөгч хийгээд их орой тарна. Эхний хэд хоног юм ажиглагддаггүй байсан. Эгч өрөөндөө унтахгүй, том өрөөнд газар унтаад байхаар нь гайхаад асуутал тэр орон дээр унтах болгонд хар дараад байна гэдэг юм байна. Би ч том өрөөнд зураг үзэж байгаад зурагтаа унтраагаад фм сонсож байтал гэнэт л дотор арзайгаад, яг л үүднээс хүн гөлрөөд байгаа юм шиг. Бүр харанхуйд нүд дасчихаад байхад дүрлийсэн хар юм зогсоод салдаггүй, би ч тэр өдөр тэгс хийгээд л амарлаа. Тэр өдрөөс хойш янз бүрийн юм сонсож эхэллээ. Ажлаа тараад амрах гэсээр байтал шөнийн нэг хоёр цаг болчихно. Зурагтаа унтраахаар л миний өрөөний хаалганы цаана хүний хөлийн чимээ сонсогдоно, аягүй эвгүй, төмөр чирэх чимээ, хаалга онгорхой үлдээчихлээр л юм ширтээд байдаг байлаа.

\* \* \*

Сая нэг зайран ахаасаа юм олж мэдлээ. Шөнө оройн цагаар гадуур яваад байвал гүйдэл, буг шүгэлчихдэг гэж ярьдаг шүү дээ за тэгвэл тэр нь ийм учиртай юм байна.

Хүний өөрийн биологийн цагаар бол ямар ч хүн 3-5 цагийн хооронд бие нь маш сулардаг. Ер нь бол үүнээс болж 3-5 цагийн хооронд хөгшин хүмүүс өөд болох нь элбэг байдаг. Тэгээд маш сул байх үедээ янз бүрийн мэдэхгүй газраар, янз бүрийн харанхуй булан(Буланд буг чөтгөр нь элбэг байдаг), эзэнгүй газар, тал хээр гэх мэт газраар явах үед хүний биед чөтгөр буг шүглэхэд амар болчихдог гэсэн. Тэгээд бүр тэр нь сул байх үед чинь хийморь лундааг чинь гутааж орхидог. Түүнээс болж хүмүүс архинд ордог гэж байна шүү. Ер нь шөнийн 2 цагаас хойш гадуур явах сайн биш. Бас хүний биед тэр буг чөтгөр нь шүгэлсэн бол зан болон харилцаанд нь их өөрчлөлт орж хүний нүдрүү эгц харж чадахаа больдог гэсэн шүү!

\* \* \*

Манайх хуучны 9 давхарт амьдардаг. Хааяа лифт ажилладаггүй болохоор дээшээ шатаар өгсөж унах шахаад 8 давхарт гардаг. Гарах болгонд хэн нэгэн намайг харж байгааг мэдэрдэг. 6 давхраас дээшээ гарах яг тэр үед ямар нэгэн айдсыг дэндүү их мэдэрдэг. Нэг удаа 6 давхарт явж байгаад бие хөшчихсөн, тэгээд яаж гэртээ орсноо санадаггүй. Энэ явдлыг тохиолдсоноос хойш байнга тосуулдаг болсон. Амралтын өдөр цаг орой болсон хойно охин минь зайрмаг идье гэхээр нь гараад лифт хүлээгээд зогсож байсан чинь охин минь ээж ээ энэ маамаа гэсэн. Тэгээд харсан чинь хэн ч байгаагүй. Би бүр сандраад, шууд охиноо шүүрээд авсан, тэгээд амандаа мэддэгногоон дарь эхээ бруу зөвгүй уншиж гарсан. Одоо бодоход намайг хөдөлж

чадахгүй болтол айлгасан тэр жижигхэн юм хүүхдийн сүнс байсан юм болов уу гэж боддог. Хүнд үзүүлэхээр юманд сэвтсэн байна гэсэн.

\* \* \*

Дүүгийн хуримд очих гээд аймгаас машинтай гараад давхисан юм. Нар жаргахын өмнөхөн шаргын говьд нэг гүн жалга руу давхиад орсон. Нэг хүн өмдөө шувталсан, өвдөг дээрээ сөхрөөд суучихсан гараа өргөөд ам нь ангалзаад хашгираад байх юм. Зогсох гэсэн чинь хотоос ирсэн аав эгч хоёр "Чөтгөр байна хурдан яв" гэж загнаад тэгэхээр нь би зогсоод авья энэ говьд хатаад үхэх байх гэсэн ч нагац эгчийн үгэнд ороод зогсолгүй яваад өгсөн. Замд эгч тэр жинхэнэ чөтгөр гээд би болохоор согтуу хүн байсан гэж маргасаар Бугат орж билээ.

\* \* \*

Манай нөхөр урд 5 жил сурсан юм. Тэгээд эхний 2 жил хямдхан гэж бодоод Бээжинд ахмадын хороололд хамаатны 2 охинтойгоо байр хөлсөлдөг байж л дээ. Тэгсэн чинь ороод удаагүй байхад нь өдөр, шөнө ч хамаагүй унтахаар нь л нруу руу нь цохиод сэрээчихдэг байсан гэнэ. Хамаатныхаа 2 охиныг тоглоод байна гэж бодоод маяглаад байгаарай гэхээр нөгөө хоёр нь гайхаад та өөрөө битгий сэрээгээд бай гээд өнгөрдөг байж. Тэгсэн нэг өдөр 2 дүү нь аялалд явсан хойгуур шөнө унтаж байхад нь нрууг нь илээд явсан гэсэн.

\* \* \*

2 жилийн өмнө миний бие их өвдөөд гэртээ хэвтэж их оройтож унтсан юм. Шөнө сэртэл миний дээр 3 хүн дүрстэй юм босчихсон дээрээс хараад байж байсан. Юу юм бол гээд нүдээ томруулж нэг их сайн харагдахгүй байсан айсандаа дуугарч чадахгүй хөдөлж болохгүй амаа ангайгаад л. Тэгэхэд нэгийг нь л харж чадсан. Урт саарал үстэй ноорхой дээлтэй гэмээр эмэгтэй хүн байсан санагддаг юм.

\* \* \*

Манай хуучин байр их хачин жигтэй байсан юм. Шөнө дүнд юм түжигнээд л хогийн уут хулгана ухаж байгаа юм шиг дуугараад л, сандал дээр хүн сууж байгаа чимээ гараад. Гэрт ирж хоносон хүнийг шөнө юм дараад ч байх шиг олон удаагийн тохиолдол бий. Үүрээр сэрээд хальт харахад нэг цагаан юм үүдний зүгт гүйгээд алга болох шиг харагдсан удаатай. Нэг удаа бас найзыгаа дагуулж гэртээ хонотол шөнө сэрчихсэн гэсэн. Ойр ойрхон хурдан хурдан алхсан түг түг гэсэн хөлийн чимээ тойроод гүйгээд байсан гэнэ. 10 минут хэртэй харзнатал миний унтаж байсан орны зүг очоод зогссон гэнэ. Тэгээд хэсэг байснаа үүдний зүг яваад чимээ намжсан гэж байгаа.

\* \* \*

Бас нэг удаа би CD-ний хайрцган дээр бөгж тавьж байгаа зураг дарж байсан юм. Санаандгүй байдлаар дараа нь нөгөө зурган дээр дүрс буусан байхаар нь компьютер дээр буулгаад томруулаад эргүүлээд хартал яалт ч үгүй хүний дүрс 2 нүдний хэсгийг нь сайн харвал 2 улаан цэг амаа ангайчихсан соёотой ч гэмээр хар срочик юм уу тийм цамцтай дүрс буусан.

\* \* \*

Өнгөрсөн өвөл нэг сард Ховд руу 6 найзтайгаа, 2 машинтай зугаалах гээд явсан юм. Нөгөө машин маань түрүүлээд явсан. Би машин бариад явж байсан юм. Миний нойр хүрээд нэг найзаа алив чи барь гээд бариулчихаад, халыг зүүрмэглэж байтал машин зогсоод дугуй хагарчихлаа гээд гурвуулаа буусан чинь нэг найз маань ойр орчмоо ажиглаж байснаа эндээс хурдан явья, энэ гүйдэлтэй газар бид хэд замаасаа төөрсөн байна гэж хэлээд сонин болгож билээ. Тэгээд сандарсан бид хэд гялс запас дугуйгаа солиод хөдлөөд удаагүй явж байтал машин замаас холгүй нэг дээлтэй хүн зэрэгцээд гүйгээд байсан. Бүр алмайрч байгаа юм чинь. Удалгүй нэг хадан дундуур сүлжээд алга болсон.

\* \* \*

Нэг хүний ярьсан юм санаанд орлоо. Манай нэг багшийг Жаргалсайхан гэдэг. Их сургуулийн маркетингийн багш л даа. Мань хүн нэг удаа ярилаа л даа. Төв номын санд "Толь" гээд орчуулгын нэг ном ганцхан хувь байдаг юм уу даа одоо. Тэр ном ер нь их алдартай ном юм байх аа. Орчуулсан хүн нь галзуурсан ч гэх шиг ярих жишээний. Харин манай Жаргалсайхан багш тэр номыг зориуд уншья гээд, бараг л даргаар нь яриулж байгаад гэрээр авч уншиж л дээ. Миний санахын Төв номын сан гэрээр ном өгдөггүй шиг санагдаж байна. Ажилтай, багш хүн тул шууд уншаад дуусгасангүй дээ. Бараг 10 хоног уншиж. Тэгтэл маш их айдас хүйдэст автаад, 10 хоног сүнс сүлдгүй хүн шиг явсан гэсэн. Хамгийн сонин нь Төв номын сангийн номын санчид нь хүртэл тус номыг гэрээр өгөхдөө та хамаагүй ганцаараа байхдаа, эсвэл оюун ухаан чинь эмзэг бол уншаад хэрэггүй гээд бүр үнэхээр серьёзный хэлж байна гэнэ. Зөрүүдлээд л уншихаар аваад явж. Тэгээд үнэхээр шаналж, айж, гэрийнхээ толийг харахаас эмээж, толь ямар тохиолдолд аймшгийг өөртөө агуулж, яаж чаддагийг үнэхээр мэдэрч л дээ. Толь бүр янз янз. Бүр шинжлэх ухааны маягийн төвшинд судалгаа хийж, бичсэн гэж байгаа зохиолч нь. Түүгээрээ доктор хамгаалсан түүхтэй гэдэг юм билээ. Японых гэл үү хаанахынх гэлээ. Тэгээд эцэст нь номоо өгөхөд нь номын санчид "Та гайгүй юу, бие сэтгэл санаа чинь зүгээр үү?" гэж хүртэл асууж амжсан гэдэг. Тэгэхээр бас зүгээргүй л ном байх шиг байгаа юм л даа. Тэр номыг Жака багш хэлэхдээ зүгээр ч нэг "ном" гэдэг ухагдахуунд багтах цаасан дээр шивсэн текст биш. Тэр бол амьд, гэхдээ хүний оюун ухаанд их хортой ном гэж байгаа.

\* \* \*

КТМС-н хойшоо шөнө хүн хүргэж өгчихөөд буцах гээд хөдөлтөл хэн нэгэн машины цонх тогшдог юм байна. Зөөлхөн хөдөлж байсан болохоор юмаа машинд мартсан юм бол уу гээд цонхоо онгойлготол хэн ч алга, тоглоод байгаа юм байх гэж бодоод машинаа тойртол хэн ч алга. Эргээд суугаад хөдөлтөл дахиад тогшдог юм даа. Хэн бэ гээд уурандаа хараалын үг урсгаад цонхоо онгойлготол урд копуд балбаж гардаг юм. Дотроосоо түгжээд л гишгээд тэр аюулаас мултарсан даа...

\* \* \*

Би дөнгөж 2-р ангид байхдаа эгчтэйгээ нэг эгчийндээ амралтаараа очсон юм. Гэрт нь өдөр хүн байхгүй үед хоёулаа гэрийг нь цэвэрлэж байсан юм. Би том өрөөнд, эгч жижиг өрөөнд нь. Дундаа гал тогоотой, их урт коридортой байр байсан. Тэндээ би тоос арчих гээд зурагтын

ард руу өнгийлөө.Тэгсэн үснээс нэг юм зулгаах шиг.Нүднийхээ булангаар тэр зүг харсан цонхон дээр нэг сэгсгэр үстэй жижигхэн зүйл сууж байх юм.Айгаад үснээсээ зулгааж байсан юмаа аяархан аваад тавих гэсэн " тог "-ний утас бариад нэг хэсэг юу болсноо мэдэхгүй сэрсэн чинь нөгөө өрөөнд байсан эгчийнхээ гарыг хазчихсан зогсож байсан.Би чанга орилоод нөгөө урт коридороор хамаг нүд нь орой дээрээ гарчихсан ирээд л шууд хазсан гэсэн. Энэ сүнс эсвэл " тог "-нд цохиулснаас болсон уу? би одоо хүртэл мэддэггүй.

\* \* \*

Өөрт тохиолдсон нэг явдлаа ярья. Би жуковт найзтайгаа байр хөлсөлдөг байлаа. Нэг өдөр тв хараад хэвтэж.байтал хүүхэд уйлах дуу хажуу өрөөнд сонсогдлоо. Бид хоёр ч гайхаад очоод үзсэн юу ч байдаггүй, тэр өдөр тэгсгээд л өнгөрсөн.Нэлээн хэд хоногийн дараа манай нэг найз ирж хоносон шөнөө найзаа гэрлээ асаагаарай, гээд л уйлаад орилоод босоод ирсэн( эрэгтэй хүн ). Бид 3 ч тэгээд сандралдаад. Хоолойг нь эмэгтэй жоохон хүүхэд боогоод байна гээд л тэр чигтээ хувцсаа өмсөөд манайхаас зугтаагаад явчихсан.Тэгээд л ер нь нөгөө хүүхдийн сүнс бид хоёрыг ч зүгээр байлгахаа больсон доо. Гэхдээ шөнө яах ч үгүй хирнээ өдрийн цагаар үстэнэ,гэнэт уйлна,энэ тэнд алхаж мөлхөж байгаа чимээ гарна. Аймар юм байна лээ. Яг тийм зүйл бидэнд тохиолдож л байлаа. Одоо ч гэсэн тэр байрны эзэд хүмүүст хөлслүүлсэн хэвээр байгаа юм билээ..

\* \* \*

Зуны амралтаараа нэг кафе д ажиллаж байв.Жижигхэн газар, жижигхэн кафе болохоор тогооч/эзэн нь өөрөө тогооч нь юм/ бид хоёр л ажилладаг байв.Хоолныхоо юмыг бэлдэж өгөөд л зөөгч хийнэ дээ. Нэлээд олон хоног ажиллаж байтал тогооч эгч намайг орой болохоор л хамт байж бай, манай нөхрийг ирэхээр яв гээд явуулдаггүй 2 цаг гаран хүлээлгэдэг байв.Тэгсэн архи зардаггүй өдөр бараг ч орлогогүй болчихдог байв.Бараг л бид хоёр хүнгүй амрах шахуу л байцгаана даа.Гэтэл цагдаагийнхан өөрсдөө орж ирснээ хаалга түгжчих бид уух гэсэн юм гээд сууцгаалаа.Хоол унд архи пиво гээд бүгдийг нь хүссэнээр нь өгчихөөд хоёулаа нэг өрөөнд нь ороод дуг хийцгээж хэсэг амрав.Тэгсэн нэг зүүрмэглэхэд хүн гал тогоонд аяга угааж байна.Ус дуугараад л аяга таваг харшиж байна.Би яана аа.Эзнээрээ юм угаалгаж байна гээд л сандраад сэрсэн чинь тогооч эгч хажууд унтаж байна.Гайхаад очоод харахад гал тогооны ус өөрөө гоожиж байна.Би уг нь хаасандаа гээд л өнгөртөл орой гал тогооны текний хажуугаар нэг эмээ сүүмийгээд өнгөрлөө. Хий юм байлгүй гээд өнгөрсөн чинь хүмүүсээс сураг сонсох нээ чөөгийтэй кафе гэдгийг нь мэдсэн.Тогооч эгч өөрөө ганцаараа үлддэггүй нь бас тийм учиртай байж. Тэгээд өөрөөс нь сонсох нээ анх байр аваад, байранд юмаа зөөж тавьчихаад өглөө нь ирэхэд бүх юмыг нь бужигнуулсан байсан гэсэн. Тэгээд авсан хүндээ хэлэхэд, урд нь нэг эмгэн хоёр хүүхдээ хүлээсээр өөд болсон. Сүнс нь хоргодсон юм байлгүй гэсэн гэнэ. Танайх кафе ажиллуулах юм чинь зүгээрээ, тэгээд ч би хямд зарсан шүү гээд халгаагаагүй гэж ярьж өглөө. Тэндээ би бараг 3 сар ажилласан. Эхэндээ маш их айдаг байсан ч сүүлдээ дасчихдаг юм билээ. Нэг өдөр нойлд байхад тог тасарсан нь л хамгийн аймшигтай байсан. Хүмүүсийн ярианаас энэ эмгэн хоёр хүүхдээ үхэн үхлээ хүлээсэн гэнэ. Хүү нь шоронд, охин нь гадаадад байдаг байгаад ирж уулзаагүй, өнгөрснийх нь дараа байрыг нь зараад л явсан гэсэн.Одоо хүртэл тэр байр кафе байдаг. Хүн хонодоггүй шүү. Саяхан зарах зар өгсөн байна лээ.

\* \* \*

Би хүүхэд байхдаа " хүүхдийн зусланд " амарсан юм. Өрөөндөө гурвуулаа байдаг байв. Гэхдээ өөд өөдөөсөө харсан дөрвөн ортой, бүлгийн ахлагч унтаарай гээд орой болгон цонх тогшдог байв. Өрөөний хоёр унтчихсан үед цонх тогшлоо. Би ч за унтах гэж байнаа гээд хэллээ, тэгсэн нөгөө чимээ цонхны урд байсан шүүгээн дээр дуугарлаа. Удалгүй шалан дээр хүн алхаж байгаа юм шиг миний орны толгойн дээр ирээд таг болсон. Тэгэхэд хав харанхуй, нөгөө 2 маань унтаад бүр аниргүй болсон байсан. Миний зүрх аймаар цохилоод чичрээд юун унтах манатай нэг мэдэхэд л үүр цайсан байсан үнэхээр аймаар.

\* \* \*

Нэг өдөр ээж бид хоёр өвөөгийн дээр ирээд байж байтал ээж гараад явчихсан юм. Нэлээн удлаа... Нэлээн ч орой болсон байсан. Би гайхаад ээжийг гарч хайгаад, урд талын хоосон хашаа руу манай хашаагаар дамжиж ордог хаалга байдаг юм. Яг тэрний урд ирээд ээж та байна уу гэхэд нэг хvн хаа нэгтээгээс ээж нь энд байна гэх шиг сонсогдсон. Гэхдээ би тийшээ орох гэсэн ч яагаад ч юм оролгvй өвөөгийнх рүү буцан орсон. Тэр хоолой ээжийн хоолой биш байсан болоод ч тэр үү. Гэтэл удалгvй ээж орж ирэхэд нь хаана байсныг асуухад дэлгvvp орчихоод ирлээ. Худалдагчтай нь жаахан буу халаад гэв. Яг тэр хашаанд өмнө нь амьдарч байсан эгч хэдэн жилийн өмнө нас барсан юм гэнэ лээ.

\* \* \*

Би баян хошуунд амьдардаг юм л даа. Манай гэрийн ойролцоо их жалгатай ба 1990 ээд оны үед япончууд амьдардаг байсан гэх том хашаатай хүлэмж бас нэлээн хэдэн угсарсан цагаан байшин байдаг байлаа. Би тэгэхэд 8 анги байсан юм. Өдөр 7 цаг хичээллээд орой харанхуйд найзуудтайгаа гэр лүүгээ явж байлаа. Гэтэл тэр хашааны хажуугаар явж байтал юм дуугарах шиг болов. Гайхаад хартал хүлэмжид нэг хүн явж байх нь тэр бид ч гайхаад л өнгөрсөн. Гэтэл бидний хажууд нэгэн саравчтай малгайтай эмгэн явна. Энэ өвлийн хүйтнээр ямар тэнэг эмгэн бэ гээд бодоод эргээд хартал байдаггүй. Бид нэлээн айж цочирдоод л гэртээ харьсан. Хариад ээж ааваасаа асуутал дээр үед тэнд гэр бүлээрээ амьдардаг япон хүмүүс нас бараад сүнс нь хорогдсон. Элдвийн зүйлс харагддаг гэлцдэг хэмээн ярьж билээ. Бид нарыг харснаас хойш ч хүмүүс тэр хүлэмжийн талаар элдвийг ярьдаг байсан.

\* \* \*

Би гэртээ хүүхэдтэйгээ 2 лаа байж байсан юм. Ороо засаад унтах гээд шкафнаас хөнжлөө авах санаатай тонгойтол хажуугаар жижигхэн хөл зөрөөд жижиг өрөө лүү яваад орчихсон. Тэгэхээр нь миний үр ороо дэлгэхгүй гээд өндийгөөд хартал. Хүүхэд маань яасан ээжээ гээд том өрөөнөөс гараад ирсэн. Тэр үед дотор пал хийгээд жижиг өрөөнийхөө гэрлийг асаагаад хартал хэн ч байгаагүй.

\* \* \*

Би өнөөдөр гэртээ ганцаараа байгаа юм л даа . Ажил төрөл гээд наадмаар хотод үлдэх болчихоод . Сая цагийн өмнө хаалга тогшоод . Тэгээд очоод хэн бэ гэсэн чинь хэн ч байгаагүй

. Тэгээд л за за гээд хоолоо идэнгээ зурагт үзэж байсан бүр чанга тогшлоо. Тэгээд хэн бэ гэж асуулаа. Хэн ч дуугарсангүй, ингээд дахиад хэд хэд тогшихоор нь аргаа бараад хаалгаа отож байгаад яг тогших үеэр нь онгойлгосон ч хэн ч байдаггүй. Тэгээд эр хүн юунаас айдаг юм гээд байж байтал бие өвдөөд болдоггүй . Одоо найзындаа ирчихээд хэвтэж байна. Хүмүүс минь эр эм гэлтгүй хаалга үүдээ хүнд битгий тайлаарай . Ялангуяа эрчүүл минь ямар ч хүдэр цээж хүнд булчин иймэрхүү зүйлтэй дүйцэхгүй шүү.

\* \* \*

Манай нэг ахад тохиолдсон явдал юм. Ахын дээд айлд нь байнга хэрүүл болдог байсан юм. Гэтэл нэг өдөр дээд айлд байдаг эгч нас барсан тэгээд тэндээ хорогдчихсон юм шиг байна лээ чааваас. Манай ах гэртээ ганцаараа байхад гал тогоонд байнга юм түжигнэх чимээ гардаг болсон. Тэгээд сүүлдээ унтах гээд, яг орны урд толь байдаг юм. Тэгээд гэнэт мэдэхгүй шалтгаангүй гэнэт сэрээд хартал ард нэг хүн байсан гэсэн ахын маань эхнэр хүртэл сүүлдээ аймар айгаад тэр байрнаас нүүсэн.

\* \* \*

За манай найзын эмээд тохиолдсон эртний явдал. Эмээгийнх нь ээж хуучилсан гэсэн. Үнэн бодит шүү. Эмээ нь ээжтэйгээ хоёулхнаа хөдөө мал дээр байжээ. Тэр үед нярай хүүхдийг хананы нүднээс өлгийтэй нь бүсээр уяад тогтоодог байж. Гаднаас бадарчин шиг таяг тулсан хазгар өвгөн орж ирсэн гэдэг. Тэр үед цай аягалж өгөөд ёроолд нь будаатай хийж өгдөг байжээ. Гэтэл өнөөх өвгөн цайгаа уугаад л будаагаа энгэр лүүгээ нулимаад байж. Тэгэхээр нь та будаагаа идэхгүй бол би танд боогоод өгье та замдаа ид гэж хэлэхэд за яахав яахав гээд л үргэлжлүүлээд нулимаад уугаад байж. Тэр ч тоолгүй цай дуусаж байсан тул түлээ, ус оруулахаар гарчээ. Эргээд ороод ирэхэд нь өвгөн ханын нүднээс уяатай охин луу дөхчихсөн шүлсээ залгилан яг л идэх гэж байгаа юм шиг харж байж. Үүнийг харсан ээж нь -За манай адуунд явсан улс олуулаа цангаж ирнэ" гээд тогоо дүүрэн ус оруулж ирээд үйхэд өвгөн ухас хийж, за би ч явах уу даа гээд гарчээ. Ээж нь араас нь гараад хартал (говийн нутаг ) шааных нь ард довон дээр явж байж гэнэ. Эргэж ороод сүх аван гарч ирээд хартал тэртээ овооны дэргэд тоос манарган гүйж байсан гэдэг. Хүний мах иддэг эл адгуус нь хүнээс хэд дахин хүчтэй төдийгүй хурдан шаламгай байдаг юм гэжээ. Дээр үед ч элбэг байжээ.

\* \* \*

Жил гаруйн өмнө МУБИС-ын 5-р дотуур байранд өглөө үүрийн 4-н цагийн орчим байрандаа унтаж байлаа. Манай тасаг нэг давхарт л даа. Их халуун байдаг болохоор бид нар цонхоо нээлттэй унтдаг юм. Тэгтэл гэнэт аймар салхилаад цочоод цонх хаахаар өндийтөл цонхон дээр нэг эрэгтэй хүн над руу харчихсан зогсож байсан. Би айгаад хөдөлж чадахгүй таг гацчихсан. "Ээжээ" гээд л дуу алдаад өөр амнаас үг ч гарахгүй чичрээд маш их айсан. Тэгтэл манай тасгийнхан бүгд сэрээд "яасан" гэхээр нь би цонхон дээр хүн байна гээд хэлтэл, цонхон дээр байсан эрэгтэй "өө чи минь сэрчихсэн үү" гээд л аймар муухай дуугараад л манай нэг тасгийн эгч "яваач зайлаач" гэж хэлсэн чинь өөдөөс нь сонин үг хэллэг хэлээд л байсан. Манай найз ирж хонож байсан юм. Тэр босоод ус авчирч цацчихаад зайл энэ тэр гээд хөөхөд цаашлаад зогссон. Тэгэхээр нь би босоод цонхоо хаахдаа хөшгөө татаад л бариад зогсоод байсан. Маш их айсан болохоор аймар салганаад байсан. Унтах гэж бөөн юм болж



байж унтсан. Өглөө гэгээ орчихоод байхад цонх руугаа харж ч чадахгүй байсан. Манай тасгийн эгч хэлэхдээ өмдөө тайлчихсан байсан гэсэн. Тэр явдлаас хойш би хоёр 7 хоног нойр муутай байсаар дээд давхар луу шилжсэн. Жич: Гаж донтой хүн байсан. Хоолой нь залуухан ч настайвтар хүн гэсэн. Ганц манай тасаг биш 120-р тасагт ч урьд нь ийм зүйл болж байсан гэсэн. Шөнө орой ер нь явалтгүй болжээ, аймар юмаа охид минь болгоомжтой байгаарай. (Жинхэнэ болсон шүү багшийн дээд хавиар одоог хүртэл байгаа гэсэн.)

\* \* \*

Би ер нь нэлээн жаахан байхаасаа элдэв зүйлс харж мэдрэх болсон. Хамгийн анх Орост байхдаа модон дээр сууж байдаг нэг хар дүрсийг харж билээ. Ер нь аав ээж орост наймаа хийдэг байсан болохоор байшин түрээслэнэ. Тэд нар нь голцуу дээр үеийн байшин. Дор хаяж тавин жил болчихсон. Тэнд нь их юм бий. Орост байхдаа би их олон сүнс харсан. Зарим нь гэмгүй. Хамгийн анх харсан аймшигтай сүнс маань моргт байсан. Морг ч гэж дээ, дээр үед морг байсан газрыг балгас болгоод хог хаядаг байлаа. Харин манайх урд талд нь байдаг 2 давхар, өмнө нь эмнэлэг байсан байшинд байдаг байв. Манай бүх цонх тэр балгас руу харсан. Шөнө болохоор л намайг хэн нэгэн дуудаад байгаа юм шиг санагддаг байв. Нэг орой цонхны тавцан дээр суучихсан ном уншиж байгаад намайг дуудахыг сонссон, тэгээд харсан чинь хүзүү нь гилжийгээд хугарчихсан, арзайсан үстэй эмэгтэй байсан. Цаашаа юу болсныг санагддаггүй юм. Ямартай ч хэсэг хугацааны дараа орон дээрээ л сэрсэн.

Энэ мэтээр сүнс их хардаг болсон. Тэгэх болгондоо ганц мэддэг тарни болох ногоон дарь эхийн тарниа уншиж гарна шүү дээ. Сүүлдээ дөжирчихдөг юм байна лээ. Нэг их айхаа больж шөнө явж байхад нэрээр дуудах, зөөлөн цохих зэргийг тоохоо болиод байлаа. Гэхдээ би өмнө нь жинхэнэ сүнс яг юу хийж чаддагийг огт мэддэггүй байсан юм байна лээ.

\* \* \*

Намайг 10-р ангид ордог жил манайх Хайлаастанд байшин авсан юм. Гадаа 00-той усаа зөөдөг л бол л болохоос биш яг байр шиг бас дөрвөн өрөөтэй. Хамгийн буланд миний өрөө байв. Өмнөх айлынх нь ажлын өрөө байсан гэсэн. Тэр өрөө цаанаа л хүйт даасан, ороод жаахан байхаар л хамаг биеийн үс босоод байдаг байлаа. Анх би тэр өрөөний сүнсийг харсан юм. Өвөл тэр өрөө их хүйтэн учраас гал тогоондоо би байдаг байсан. Гал тогоонд яг миний ширээний ард буюу нурууны ард миний өрөөтэй холбогдсон том цонхтой, тэрүүгээр хэн нэгэн хараад байгаа юм шиг мэдрэмж байнга төрнө. Хаалгыг нь байнга хаадаг байв. Тэр өдөр би 12 өнгөрөөж усанд орчихоод өрөөнийхөө толинд харчихсан үсээ самнаж байсан юм. Ард юм хөдлөх шиг болохоор нь эргээд хартал нэг гаргүй хүн байсан. Шууд л буцаад урагшаагаа харсан ч тэр зүйлийн дүрс толин дээр бууж над луу ойртож эхэлсэн. Хамаг бие таг хөшөөд юу ч мэдрэхгүй, нүд л хөдөлсөөр, амнаас авиа ч гарахгүй үнэхээр хэцүү байсан. Аавыг хажууд ирээд намайг дуудахад л сэхээ орсон.

\* \* \*

Нэг удаа хаалгаа хаахаа мартаад унтаж байтал нэг лагс хүн эвхдэг орыг маань шажигнуулаад хөл дээр суучихсан. Би гайхаад хартал хар сүүмийсэн хүн байхыг нь харсан. Би шууд босоод хаалга хааж байгаад -Чи муу одоо битгий давраад байгаарай гэж хэлээд унтаад өгсөн. Тэгсэн

зүүдэнд нэг хүн орж ирээд- Дотроо байгаатай нь тэмцэж чадахгүй юм байж гэдгийг л сонсчихоод сэрсэн. Энэ явдлаас хойш иймэрхүү явдал болоогүй ч аав дүү бид гурав аль хэдийнэ хэд хэдэн удаа тэр сүнсийг харсан ч ээж бид 3-т ерөөсөө итгээгүй юм. Тэр зун нь өвөөгийн бие өвдөөд аав дархан луу явсан юм. Яг гурав дахь хоногийн орой би 00 руугаа явж байгаад ард хүнд алхаа гарахыг сонссон. Тэгээд гэрэл тусгаад харахад юу ч байгаагүй болохоор нь жаахан тайвширч байтал хүзүүн дээр амьсгалах хүний амьсгаа мэдрээд орилоод гэр лүүгээ гүйчихсэн дээ. Ээж тэр шөнө нөгөө сүнсийг хараад хэд хоногийн дараа гэртээ лүүжин тавиулсан. Манай гэрийнхэн очдог нэг мундаг хандмаатай болсон юм. Тэр намайг бүр жаахан байхаас нэг эмээ маань дагаж байна гээд ном уншиж өгснөөс хойш би солиотой юм шиг л их сүнс хардаг болсон. Бүр автобусанд хүний мөр дэрлээд явж байгаа цэлдэн хөх өнгөтэй нарийхан хүзүүтэй цагаан үстэй амьтан байсан. За тэгээд энэ мэт зүйлс харсаар байгаад өнгөрсөн зун нөгөө хандмаадаа үзүүлээд юу болоод байгааг хэлтэл сүлдийг маань дуудаж өгөхөөр болов. Номоо бараг арван минут уншлаа болдоггүй дээ, намайг бүр хойноос зулгаагаад л болдоггүй. Би угаасаа мундаг хүмүүстэй уулзах юм уу очих гэхээр дотроос нэг юм болоод байдаг байсан. Нөгөө хандмаа маань надад -Чиний дотор хүүхэд байхад чинь ад албин хамаатан садны ёсны холбоогоор ороод удсан байна гэсэн. Тэгээд аймар бүдүүн эрхээр гүвдрүү тагтал нь 3 ороолгоод шатааж уух баахан юм өгсөн юм. Баахан сахиус уухыг хэлж өгсөн. Тэгээд ном уншиж өгсний дараа би дахиж элдэв зүйлс харахаа больсон. Хүн итгэхэд худлаа юм шиг санагдаж болох ч үнэн үргэлж ялдаг шүү дээ.

\* \* \*

За хүмүүсийн бичсэн тааралдсан юмыг уншаад өөрт тохиолдсон зүйлээ бичмээр санагдлаа. Нэг их аймаар зүйл биш шүү хэ хэ. За одоогоос бараг арван жилийн өмнө би хөдөө ахындаа амралтаараа очсон байлаа. Манай ахынх төвөөсөө бага зэрэг зайтай далангийн цаана байдаг юм. Тэгээд нэг өдөр намайг эрт дэлгүүр явуулахаар болов. Би ч замдаа дуу дуулаад л, мөсөн дээгүүр гулгаад, их хөгжилтэй явсан юм. Тэгж явж байгаад халтираад мөсөн дээр дагзаараа саваад унасан чинь толгой дүүрээд л нэг их сонин болоод таг. Нэг мэдсэн нэг хөгшин өвгөн босоорой миний хүү энд удаж болохгүй босоорой гээд л хувцас гөвөөд байсан. Тэгээд нэг мэдэхэд сэрсэн чинь хэн ч байдаггүй юм даа. Толгой өвдөөд бас дээр нь маш их айсан болохоор буцаад гэр лүүгээ гүйчихсэн . Гэртээ ороод юм ярьж чадахгүй уйлаад л байсан . Ядаж байхад аймар хүйтэн өдөр байсан болохоор хацар бараг хөлдчихсэн нус гоожоод л, манайхан тэгсэн намайг баахан загинаад хаагуур юу хийж яваад ирсэн, хов хоосон, захисан юм хаана байна гээд. Тэгсэн би өглөө 09:00 гэж явсан хүн 01:00 болж байхад ирсэн байсан. Гэрийнхэндээ учраа хэлээд л тэд ч намайг тайвшруулж гайгүй болгосон. Дараа нь сонсохнээ миний яг хальтирч унадаг газар нэг өвгөн манай ахынхаас согтуу гарч яваад хөлдөж үхсэн гэсэн. Тэр л намайг хар хүйтэнд осгож үхэхээс аварсан байсандаа.

\* \* \*

Налайхын ТМС-н хичээлийн байр буюу лаборатори гээд 4 давхар байр байдаг юм. Тухайн үед дотуур байрны жижүүр байсан Алтай гэдэг эгч урд нь нярав байхдаа нэг өдөр тайлангаа бичээд сууж байтал хүүхдүүд шуугилдаад явчихаж. Тэгэхээр нь сүүлийн цаг тарж байгаа юм даа гэж бодоод цагаа хартал шөнийн 02:00 цаг болж байсан гэдэг. Тэгээд айгаад хаалгаа түгжээд өрөөндөө хоносон гэж ярьж байж билээ.

Сайн байцгаана уу? Би нэгэн болсон явдал ярих гэсэн юм. Энэ явдал манай ээжид тохиолдсон гэсэн. 1990-ээд оны эхэнд манайх Баянхошууны 112-ын буудал гэдэг газар амьдарч байсан юм. Тэнд ойрхон нэгэн нуур байдаг байсан. Би тэгэхэд их жоохон хүүхэд байлаа. Нэгэн шөнө ээж маань нохойдоо хоол өгчихөөд бие засах гээд 00 руугаа дөхөж явтал хашааны том хаалганы завсраар нэгэн 3,4 настай гэмээр нэхий бор пальтотой хүүхэд ороод ирсэн гэсэн. Тэр шөнө дугараг сартай байсан болохоор их тод харагдаж байсан гэсэн. Тэгээд юун хүүхэд ороод ирдэг билээ хэний хүүхэд юм бол гээд дөхөөд очтол гэнэт цагаан ямаа болоод хажуугаар нь майлаад хажуу айлынх нь хашаа руу яваад орсон гэсэн. Яг энэ үед гэрт ах эгч бид 3 байсан тэр ямаа майлах дуу нь гэрт байсан ахад сонсогдоод эгчид юу ч сонсогдоогүй гэсэн.( би жоохон байсан болохоор юу ч мэддэггүй юм) . Тэгээд манайх тэр хашаагаа удахгүй зараад нүүсэн гэсэн.

### Надад тохиолдсон нэгэн явдал

Надад нэг ийм сонин зүйл тохиолдож байсан юм. Би арван жилийн сурагч л даа. Хавар болохоор мэргэжлийн хичээлийн олимпиадууд болдог доо, би өнгөрсөн жил тэр олимпиадад технологийн хичээлээр орсон юм. Сургуулиас маань их ач холбогдол өгч хичээлээс чөлөөлж 2 багш 8 сурагчид өдөр шөнөгүй бэлдэж гарав аа ...Улирлын амралт эхэлсэн ч бид хэд сургууль дээр бэлдсээр л байлаа. Технологийн олимпиадад ороход их зүйл унших бас их дадлага хийх шаардлагатай болдог л доо. Тиймээс ихэнхдээ оройтож тардаг, заримдаа бүр хонодог байлаа . Манай технологийн өрөө гэж томоо гэгч заал байдаг, тэр л өрөөнд би ганцаараа байж чаддаггүй байлаа. Яагаад ч юм тэр өрөөнд ганцаараа байхаар л пар чохарч дуугараад, энд тэнд хөлийн чимээ гараад байдаг байсан, тэгэхээр нь гараад гүйчихдэг байлаа, айгаад багш найзууддаа хэлж чаддаггүй байсан. Нэг өдөр би ганцаараа тэр өрөөнд ном уншаад сууж байлаа. Гэтэл нөгөө пар хяхтнах ,хүн алхах чимээ гарлаа ,тэгэхээр н гараад гүйх гэснээ дургүй хүрээд хэдий болтол энэ юмнаас айх юм ухааны юм бодоод таг суугаад л байлаа номоо уншиж дуусаад буланд байдаг том төмөр сейфийг онгойлгож өөр номнууд гаргаж аваад газар дээр тавиад ялгаж байтал гэнэт сейфний дээд талд овоолоостой байсан ватум цааснаас нэг нь миний урд аяархан унаад ирдэг юм байна, жаахан эвгүй санагдаад дээш харж чадсангүй ээ, хэсэг сууж байснаа (ямар аймшгийн кино биш дээ ) гэж бодоод босох гэтэл дээр байсан бүх хуйлаастай цааснууд миний дээрээс нураад ирлээ , тэгтэл тэрхэн хооронд өрөөний нөгөө буланд босгоод тавьчихсан байсан томоо гэгчийн хуруу зузаантай гөлмөн төмөр газарт тас гээд л уначихав. Тэр үед юу болсон юм бүү мэд нэг л мэдэхэд хажуугийн зургийн өрөөнд ороод ирчихсэн байлаа .Тэнд надтай хамт бэлдэж байсан ангийн маань найзууд байж байсан , би хэсэг сууж байснаа тэр хоёрт болсон явдлаа ярьтал тэр хоёр их гайхаад надтай хамт буцаад өрөөнд орсон тэгтэл юу ч болоогүй багшид битгий хэлээрэй гээд л өнгөрсөн.

Хамгийн аймар зүйл дараа нь болсон олимпиадын өмнөх орой технологийн хэд сургууль дээр хоносон юм. Манай өрөөнд хүүхдүүд модны ажил хийгээд хөрөө өрөм ний дуу их байхаар нь арай гайгүй болов уу гээд зургийнхаа өрөөнд хичээлээ давгахаар оров. Тэр орой нэг л эвгүй хүйтэн бас сургууль дээр бид нараас өөр хэн ч байгаагүй, тог тасарч ирээд л, намайг өрөөнд ортол зургийн хүүхдүүд план зураг зураад завгүй сууж байлаа. Тэгээд би тэнд

суугаад хичээлээ уншиж дуусчихаад нөгөө хэдтэйгээ юм яриад сууж байв. Оройн 3 цаг болж байсан байх нойр хүрээд ирлээ. Тэгтэл гэнэт миний яг урд байсан том цонхны цаагуур нэг сүүмийсэн цагаан юмнууд ар араасаа гүйгээд өнгөрсөн. Би орилоод доош суучихсан, тэгээд гар чичрээд биеэ салгалаад байсан, тэгэхэд тэнд байсан найз нар маань надаас аймар айчихсан байсан, тэгээд хэлтэл хүн айлгаад гээд уурлаад байлаа. Сууж сууж ширээний араас арай гэж бостол цонхны цаана дахиад нэг юм өнгөрсөн тэгэхэд би бүр сайн харсан цагаан саарал өнгөтэй гэрэл ч гэх юм уу тийм нэг юм надаар тоглож байгаа юм шиг гялс гээд өнгөрсөн. Ээ бурхан минь тэгэхэд надад ямар аймар байсан гээч хөдөлж ч чадахгүй хөшөөд нүднээс нулимс гоожоод ирсэн тэгэхэд манай найзууд надад итгэсэн ч юм уу яасан юм битгий уйл гээд аргадаад байсан, би юм ойлгохгүй хэсэг гацаад (ёоо аймар байсан гээч). Тэгээд дараа нь арай гайгүй болсон, өрөөнөөс гарч чадахгүй айгаад бас цонх руу ч харж чаддаггүй. Тэгэхээр нь цонхны урд, хаалга руу хараад суусан тэгтэл бүр хаалганы хажуу талын толинд хүртэл нөгөө юм чин гүйгээд байсан. Тэр шөнө бидний хэн нь ч унтаж чадаагүй, өглөө олимпиадаа шууд ороод дараа ээжтэйгээ хийд орсон. Тэгтэл лам юмнаас айсан байна гээд ном уншиж өгсөн. Тэр шөнө яагаад тийм юм болсныг мэдэхгүй ямар ч байсан одоо хэр нь бодохоор л айдаг.

\* \* \*

### **Надад тохиолдсон болон сонсож байсан зүйлс:**

1. Хөдөө зуныхаа амралтаар амарсан юм л даа. Манай ах эгч 2 хужаа мотоциклоор сумын төв орчихоод ирье гээд явлаа. Би гэрт нь эгч дүү 2тойгоо үлдлээ. Тэр 2 өглөө эрт явчихаад ирдэггүй ээ. Өдөртөө хүрээд ирчих байх гэж бодож байсан юм. Орой нь бүрэнхий болсон хойно яг манай урдуур гэрэл асаад л хөдлөөд л байсан юм. Яг мотоцикл явж байгаа юм шиг. Тэгэхээр нь бид 3 нөгөө хоёрыгоо төөрчихсөн юм байх гээд л өнгө өнгийн дохио өгдөг гэрэл асаагаад л баахан харж суусан юм. Яг тэр хавьдаа л ийш тийш яваад л. Тэгээд айсандаа гэртээ ороод хаалга түгжээд унтаад өгсөн. Тэгсэн манай 2 маргааш өдөр нь ирдэг юм даа. Тэгээд ирэхээр нь болсон зүйлээсээ яриад та 2 биш байсан юм уу гэсэн чинь бид 2 таньдаг айлдаа хоночхоод ирлээ. Тэнд чинь угаасаа гүйдэлтэй юм. Ганцаараа тийшээ орой шөнө болсон хойно явбал буцаж ирдэггүй юм гээд л айлгаж билээ. Тэгээд орой нь харахад дахиад яг тэр газраа гэрэл асаад л яваад байсан. Орой болгон тэгдэг юм байна лээ.

\* \* \*

2. Би нэг удаа ээжийнхээ ажил дээр шөнө ганцаараа байх болов. Манай ээж үсчин юм л даа. Тэгээд ээж маань хүн тосох гээд намайг орхиод эргэж ирээд авья гээд явлаа. Би үсчинийхээ гэрлүүдийг унтраачхаад гаднаас хүн харвал намайг ганцаараа байгааг мэдчихнэ гэж бодоод л сууж байлаа. Удалгүй нойр хүрээд үсчиний үс угаадаг сандал дээр нь арагшаа налад жоохон дуг хийчихэж. Тэгээд л яг миний толгой дээр нэг хүний гарын сарвуу тас хийтэл бариад авдаг юм байна. Би яг тэр үедээ хэсэг чимээгүй болоод гөлөрчихсөн. Тэгээд айгаад л босоод эргээд харсан чинь хэн ч байхгүй. Аймар хачин болчихоод сууж байсан чинь азаар ээж ороод ирсэн үнэхээр аймар.

\* \* \*

### 3. Манай эгч надад ярьсан юм.

Олон жилийн өмнө ээж эгч нар маань 18,19тэй байцгаасан гэсэн. Тэгээд бүгдээрээ зун хөдөө байсан юм байна л даа, тэгээд морь унаад л хэдэн найзуудтайгаа уул давж ишиг хургандаа явж байсан гэсэн. Тэгээд замдаа өөр өөр айлын хүүхдүүд болохоор салцгаагаад манай ээж эгч тэгээд бас нэг найз нь үлдсэн юм байна. Тэгсэн улаан дээлтэй морь унасан эмгэн ирээд баахан юм асуугаад танайх хаанахын айл юм гээд л байсан гэнэ. Тэр хэд асуусан асуултад нь хариулаад юм яриад явж байсан чинь нөгөө эмгэн нь гэнэт морьтойгоо алга болчихсон гэсэн тэгээд л гэртээ ирээд айгаад аав ээждээ хэлсэн чинь "Хоёр хүрэн " гэдэг нэртэй том уулынх нь голоор гарчихсан байна гэнэ. Тэр уулын голоор явах юм бол тэр эмгэн гарч ирдэг гэсэн. Тэгээд тэр эмгэнийг сүнс гэдгийг нь мэддэг хүмүүс таарвал аль болох айж ичихгүй байхыг хичээх хэрэгтэй юм гэсэн. Тэр эмгэний ар нуруу руу нь харвал хоосон нуруугүй байдаг гэсэн.

\* \* \*

4. Манайхан ургийн баяр гээд л хөдөө ах дүү төрөл саднаараа уулзацгаав. Би их жоохон байсан болохоор эмээгээ дагаад явж байж билээ. Тэгээд шөнө болж байхад нэг айлд очоод ирэхээр болов оо. Би машинд нь дагаж суугаад л цонхоор янз янзын юм хараад явж байсан юм. Тэгээд бид нарыг явж байсан замд нэг цэнхэр хаалгатай гэрийн гадаанаас гэрэл дохиод бид нар бүгдээрээ нэлээд гайхаад тэр гэрт ойртож очингуут гэр нь алга болчихоод ганц малын хоосон хороо л байгаад байх юм. Тэгээд томчууд маань эртхэн төөрчхөөгүй байгаа дээрээ очих газартаа очье буг чөтгөртэй газраар нь орчлоо гээд тэр айлдаа очоод өглөө нь буцаж байсан юм даа.

\* \* \*

Нэлээн хэд хоногийн өмнө адуугаа алдаад сар гаран боллоо. Арга ядаад лавхан гарч ирэхээр 9-р сарын 27-ны өглөө мотоциклтой илүү бензин ганзагалаад замын хань болох хүн ч байсангүй ганцаараа мордоод туучихлаа. Шууд шулуухан замаар 100 гаруй км давхиад.....газарт очоод айлаар адуугаа сурсан ч сураг гарсангүй ээ. Тэгээд усаар ороход ашгүй адуу маань усан дээр зогсож байна. Хэдэн морьд нь бас дутуу, орой байсан болохоор эндээ хоноод өглөө морьдоо энэ хавиар хараад эртхэн адуугаа хөөж нутгийн зүг явья гэж бодон айлд хонохоор шийдээд өндөр газар гарч айл дурандаж суутал ашгүй нэг өргөө харагдлаа, давхиад очвол нэг өвгөн нэг хүүхэн бололтой нэг бор залуу байна. Хонох бодолтой очсон ч зай муутай юм тийм болохоор “Ойр хавьд айл байна уу” хэмээн үгийн далимаар асуухад өвгөн нь хойшоо 4км давхиад айл байгаа гэж байна. Орой харанхуй байсан болохоор эр хүний нэрэлхүү зангаар зам заалгаад мордоод давхилаа.... Нэлээн яваад айлаа олдоггүй ядаад буун тамхи асаан суугаад сорж байтал хүмүүс ярих нь дүнгэр дүнгэр сонсогдов. Дотор уужирч сонсоод байтал юу яриад байгаа нь мэдэгдэхгүй дүнгэр дүнгэр гээд инээгээд ч байгаа юм шиг. Тамхиа дуусгаад ойр хавиараа гэрэл тусгая хэмээн бодоод гэрлээ асаатал сууж тамхи татсан чулуу маань хүний шарилын чулуу байх юм. Хажууд нь бас нэг чулуу хараад дотор арзасхийгээд явчихлаа нуруу руу хүйт даагаад хурдхан хөдлөөд айл эрээд явсан ч байж байгаад л нөгөө чулуун дээрээ хоёр ч удаа эргээд ирлээ. Дотор эвгүй байсан ч айсан шинжгүй чигээрээ хаашаа явж байгаагаа ч мэдэхгүй давхичихлаа. Гэтэл бүдэгхэн гэрэл сүүмэлзээд харагдаж байна чиглээд л давхиад байтал ойртох шинжгүй ойртсон байх ёстой гээд зогсоод хартал нөгөөх чинь яваад байх шиг, чимээ чагнатал чимээ ч гардаггүй, гэрэл ойртоод байх

шиг эргээд л давхилаа. Нэг хартал яг хажууд ирчихсэн дагаж байна. Тэгэхээр нь зогсож байгаад ганзаганд байсан бугуйлаа задалж байгаад чирээд өөдөөс нь гогцоо зангидаад чирээд давхилаа. Нөгөө гэрэл чинь ашгүй тодорч байгаад цагаан цэнхэр болоод тодорч байгаад алга болчихлоо. Шөнөжингөө нэг гэрэлтэй хөөцөлдөн үүр хаяарч ойр орчмыг ажиглавал айл нэлээн зайтайд харагдаж байна. Давхиж очин цай чануулж учир мэдэх гэрийн эзэнтэй танилцангаа яривал харин ч гайгүй өнгөрсөн байна. Заримдаа нэрээр нь дуудаад татаж чангаагаад байдаг гэсэн. Татаж чангааж нэрээр дуудсан бол ч би бараг мажийх байсан байхдаа...

\* \* \*

Дөнгөж сая надад ийм юм тохиолдлоо л доо. Өвөө маань цагдаагийн хурандаа, цагдаагийн хэлтсийг байгуулсан олон жил цагдаад ажилласан хүн байдаг л даа. Манай өвөө 1-р сарын 18-нд нас барсан учраас жил дамжиж 49 хоног хийдэггүй гээд цагаан сарын өмнө буюу маргааш 49 хоногийг нь хийнэ гэсэн. Харин сая 07:30-ын үед гэртээ орох гээд хонхоо дарж байтал манай хаалга дотроосоо дуугараад (хөрш хаалгатай юм л даа) тэгээд нэг буу үүрсэн цагдаагийн хувцастай нүдэнд хүйтэн нэг өвгөн гарч ирээд, би айсандаа зогсоод л байсан, тэгээд бүр айх гайхах зэрэгцээд байж байтал толгой дохиод би бүүр яахаа мэдэхгүй зогсож байтал урагшаа алхаж байснаа эргэж нэг хараад ахиж толгой дохиод явсан. Ямар аймар жигтэй явдал болсон бэ ёооё тэгээд хонх дараад хүн тайлахгүй байж байтал аав дүү 2 ирээд гэртээ орсон доо. Нүд ирмэхийн зуур юу болоод өнгөрөв өө. Нас барсан өвөөгийн маань мэндийг дамжуулж өөр сүнс ирсэн юм болов уу гайхаад байх юм.

\* \* \*

2007-2009 оны хооронд Шанхайн Фуданы их сургуульд сурдаг байлаа. Тэнд гадаад оюутны байр гээд 23 давхар байшин байдаг юм. Тэрний 11 давхарт 1 семестр хуваарилагдав. Уг нь 2 хүний өрөөнд нэг Казахстан залуутай орсон ч тэр нээх удалгүй гадуур байр хөлсөлнө гээд гараад явчихав. Би ганцаараа амьдрах болсондоо бөөн баяр нэг хэсэг сайхан л байв. Нэг өдөр шалгалтандаа бэлдэж байгаад шөнийн 2 3 дөхүүлээд жоохон амрах гээд хэвтсэн юм. Тэгтэл коридорын тэнд байдаг шкафны дээр нэг юм нүдний буланд харагдаад байхаар нь сайн хартал яг нөгөө Grudge дээр гардаг шиг урдуураа хар үсээ унжуулсан цагаан юм бэлхүүсээрээ шкафны дээд талыг нэвглээд гараад ирчихсэн байсан. Би айсандаа дуу ч гарахгүй, бие ч хөдөлж чадахгүй байсан. Тэгээд яахаа мэдэхгүй нүдээ аньж байгаад нээтэл байхгүй болсон байсан. Шууд босоод бүх гэрлээ асаагаад Монголоос авчирсан судартаа мөргөөд байрнаасаа тэр өдөр гараад явсан. Энэ явдал мартагдаад айх нь багасаад харсан зүйлдээ эргэлзэж эхлээд хэдэн 7 хонов оо. Тэгээд 1 өдөр бас л яг хичээлээ хийж байгаад амрах гээд нүдээ аниад хэвтгэл зүүн шилбийг нэг юм илээд ч байгаа юм шиг санагдахаар нь хартал орны хөл дээр зурагт жирэлзэж байгаа юм шиг 1 хүн сууж байв. Бүр сайн детальтай харагдаж байсан. Дээр үеийн маягийн харааны шил, пальто тэгээд хацраар нь бага зэрэг сахал ургасан эрэгтэй хүн байсан. Өмнөх явдлаас хойш би өөрийгөө зоригжуулж ахиж таарвал айхгүй гэж бодож байсан болохоор тэр үед хашхирч босож ирээд цохисон юм. Даанч тэгээд хий цохиод алга болсондоо. Тэгээд өрөөндөө ганцаараа баахан л ярьдаг байсан. "Чи хэн юм, чамд юу хэрэгтэй юм гараад ир айхгүй байна" гэх мэт. Тэгэхээр хүн зоригждог юм билээ. Ахиж нээх үзэгдээгүй. Сүүлд харин шөнө хичээлээ хийгээд сууж байтал нруугаар гэнэт хүйт оргин

чихэн дээр баахан юм шивнээд тэр үнэхээр эвгүй байсан.

\* \* \*

Манай математикийн багшид болсон явдал. 1995 онд залуухан багш байхдаа өвлийн яг энэ үеэр сургуулийнхаа шинэ жилд орох гээд найзаараа дээл хийлгээд харьж явсан юм гэнэ лээ. Сүхбаатар аймагт болсон явдал шүү!!! Тэгээд манай багш ганцаараа харанхуй тал газар явж байсан чинь ард нь бакалтай хөлийн чимээ гарсан гэсэн, гайхаад эргээд харсан чинь хэн ч байхгүй байсан, хий юм сонссон байх гэж бодоод цааш явгал бүр яг араас нь бакалтай хөлийн чимээ гараад байсан гэсэн. Тэгээд дотроо сонин юмаа би чинь сая хоол унд идээд амраад явж байгаа байж ингээд хий юм сонсоод байна гэж баймааргүй юм аа гээд бодоод явж байсан чинь гэнэт толгой нь эргээд дотор нь арзаганаад сонин болсон гэнэ лээ. Азаар урдаас нь хүн ирж байгаа таараад гэрт нь хүргэж өгөх гээд гэрлүү нь очтол нөхөр нь эхнэрээ хараад аймар цочоод чи чинь яачихна энэ вэ? гээд босоод ирсэн гэсэн. Тэгээд нөхөр нь тэр хүнийг явуулаад багшид эм тан өгөөд хоносон гэсэн. Маргааш нь багш гэртээ ганцаараа гэрээ цэвэрлэж байхад нь бүр яг ард нь нөгөө чимээ гарсан гэнэ лээ. Тэгээд орой нөхөр хүү хоёроо ирэхэд нь хэлтэл нөхөр нь гайгүй байлгүй дээ гээд нээх тоогоогүй. Тэгээд унтах болоод багш нөхөр хоёр хүүгээ голдоо хийж унтдаг байсан юм байна л даа, манай багш яг унтах гээд нүдээ аньтал хүн байхгүй талаас нь дахиад л нөгөө чимээ гараад л бүр чанга чанга алхаж байгаа юм шиг сонсогдоод болохгүй болохоор нь хүүгээ захдаа гаргаад өөрөө голд нь ороод унтаад өгсөн гэсэн. Өглөө нь багш зорьж гандан руу очоод хэлсэн чинь тэр орой яг тэр газарт нь дээр үед нэг цэрэг хөлдөөд үхчихсэн байсан, түүний сүнс тэнд хорогдоод орой ганцаараа явж байгаа хүнийг дагах тохиолдол гарч байсан гээд баахан ном уншаад нэг юм гайгүй болсон гэсэн үнэн худлыг нь мэдэхгүй ээ, багш өөрөө ярьсан.

\* \* \*

### **За би яг өөртөө тохиолдсон 3 тохиолдлоо бичье.**

5-6 жилийн өмнө би зуны амралтаараа найзтайгаа цуг Худалдаа Үйлдвэрлэлийн Сургуулийн оюутны байранд нэг зун байсан юм. Би нэг ахынхаа замын компанид туслах, манай найз ээлжийн ресепшн хийдэг. Зун болохоор хоёрхон өрөөнд хүнтэй байдаг.

1. Эхний удаа яг наадмын өмнөх өдөр 2 хоног дарааллаад унталгүй ажиллачихсан. Яагаад гэвэл хот доторх замын ажлыг наадмаас өмнө дуусга гэсэн захирамж гарсан гээд ах шахаад, тэгээд яг наадмын өмнөх өдөр өглөө 5 цагт ядарч унах шахаад байрандаа орж ирээд шууд усанд орёе гээд жижүүр эгчээс халуун усны түлхүүр аваад орсон юм. Тэр байрны халуун ус их эвгүй эмэгтэй нь цаад талдаа эрэгтэй нь наад талдаа дундаа пилтанан ханатай, орж ирсэн охидууд банди нарынхаа бөгсийг хараад цаашаагаа ордог. Тэгээд би ганцаараа юм чинь гэж бодоод хаалгыг нь түгжээд охидын ордог цаад тал руу нь бүүр буланд нь очоод шүршүүрээ гоожуулаад усанд орж байсан чинь яг давхар ус гоожих чимээ гараад би гайхаад усаа хаагаад сонсохоор чимээгүй болоод усаа нээгээд л орохоор яг давхар цаад талд хүн усанд ороод байгаа юм шиг усны чимээ сонсогдоод бүр хүн шүгэлдэж байгаа дуу гараад би гэнэт пал гээд л явсан. Гялс уснаасаа гараад алчуураар биеэ ороогоод л юмаа хамж аваад л нүдээ аниад гүйчихсэн. Арай гэж хаалгыг нь онгойлгоод жижүүр дээр очсон чинь яасан бэ гээд л, би ингээд юм сонсогдоод гэсэн чинь өглөө эрт юм уу шөнө ганцаараа орсон хүмүүс заримдаа

тэгээд байдаг юм гээд тэрнээс хойш тэр байранд ерөөсөө ганцаараа усанд ороогүй.

2. Хэдэн хоногийн дараа би ажлаасаа ирээд манай найз тэр өдөр гараатай байж таарсан юм. Ганцаараа зурагт үзэж байгаад 2 давхарт гараад гэрлээ унтраагаад унтаж байсан чинь шөнө гэнэт сэрээд чимээ чагнасан чинь доод талын орон дээр нэг хүний амьсгаадсан хүнд амьсгал сонсогдоод, би эхэндээ хэн юм бол гээд манай найз ирсэн бол гэрэл асаагаад намайг сэрээнэ дээ гээд л “Хөөе хэн бэ?” гэсэн чинь дуу гардаггүй. Халуун усанд болсон явдал бодогдоод би бүүр айгаад хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрчихөөд сонсоод л хэвтээд байлаа. Тэгсэн гэнэт хаалга онгойх дуу гарснаа цаашаа нэг хүний гүйх хөлийн чимээ гардаг юм байна. Би өө новш хүн ороод ирчихсэн байсан байна цэнэглээд тавьчихсан утас аваад гараад явчихав уу гэж бодоод л үсэрч босоод гэрэл асаасан чинь хаалга замган түгжээгээр түгжээтэй би унтахдаа түгжээд унтсанаа санаж байгаа юм чинь, тэгээд л зүгээр айгаад гялс хувцаслаад сансарт интернет кафенд очиж хоносон. Тэгээд найзыгаа гараатай өдөр дандаа гэртээ юм уу интернет кафенд очиж хонодог болсон доо.

3.

3-4 жилийн өмнө гэрээсээ тусдаа найзтайгаа оюутны байранд амьдарна гээд Хүмүүнлэгийн 2 дугаар оюутны байранд орлоо. Тэгээд өвөл 1 сард байх аа, амралтын өдрөөр нэг удаа өглөө 8 гээд босоод усанд орчихоод явъя гэж бодоод жижүүр эгчээс түлхүүр аваад усанд орж байсан юм. Тэр байрны халуун ус нь нэг өрөөн дотор тус тусдаа хаалгатай, 3 душгэй би дандаа хамгийн наад талд нь ордог байсан юм /шүршүүр нь сайн даралттай гоождог болохоор/ Тэгээд усанд орж байсан чинь хажуу душинд 2 охины юм ярих дуу гараад заримдаа инээгээд ч байгаа юм шиг /одоо бодоход уйлаад ч байгаа юм шиг/ дуу гараад би бүүр энэ 2 юу яриад байгаа юм бол гэж хэрэгт дурлаж чагнасан чинь юу гэж байгаа нь ерөөсөө сайн ойлгогдож сонсогддоггүй . Би ч тоохоо болиод усандаа орчиход гараад душны хаалга түгжихгүй жижүүр эгч дээр очоод түлхүүрийг нь өгөөд дотор 2 охин үлдсэн гэсэн чинь чиний араас хүн ороогүй дээ гэдэг юм. Халуун ус 400 төгрөг болохоор хулгайгаар зарим хүүхдүүд орчихдог. Тэгээд жижүүртэй цуг буцаж очоод голын өрөөний хаалгыг татсан чинь хүн байдаггүй. Би бас зүрх пал гээд л явчихсан. Тэгээд жижүүр эгч юм ярихгүй зүгээр явчихсан юм. Тэгээд би дараа нь энэ явдлаа ярьж байсан чинь тэр байранд 3 жил амьдарч байгаа гээд нэг охин угаасаа голын душны өрөө чинь сүнстэй шүү дээ. Дээр үед 2 охин хамт амиа хорлоод үхчихсэн гэсэн бид нар ерөөсөө голын душ руу ордоггүй гэж авдаг юм. Тэгээд тэр явдлаас хойш бас аль болохоор хүмүүс их ордог үеэр усанд ордог болсон.



# Хоёрдугаар бүлэг

## Далдын хүчин зүйлс

Би 2 жилийн өмнө Эрдэнэт рүү явж байгаад Амарбаясгалан хийдийн чанх харалдаа яг зам дээр хар цувтай хүн зогсож байхыг харсан. Тэгээд хажуудаа байгаа хүнрүүтгээ надтай адил харж байна уу яаж байгаа бол гээд харсан чин ерөөсөө харсан шинжгүй явж байна. Ер нь бол яг тэрийг харахад нэг хэвийн биш юм байна гэдэг нь мэдэгдсэн л дээ. Тэгээд зогсох уу шууд дайраад давхих уу гэдэг сонголт ирсэн шууд дайраад л гарсан даа. Цонхон дээр нэг юм бүрсийгээд л алга болсон доо. Тэгээд ирэх газраа ирчихээд хажуу хүндээ тэр орчим тийм зүйл харсан уу гэсэн үгүй л гэсэн дээ. Гэхдээ яг цагаа тулвал айж эмээхээсээ илүү туслах юмсан гэж бодогдох юм билээ. Манай эмээ үхсэн хүн юм уу сүнснээс айх явдал байхгүй миний охин харин амьд хүнээс л их болгоомжтой байгаарай гэж захидаг байсан шүү.

7 байна уу 8 жилийн өмнө Дарханаас Сэлэнгэ орох замд болсон явдал.

3 сард байсан юм даг. Өглөө 4 цагийн вед суудлын жижиг тэрэгтэй, урд шөнийн орсон цасан дээр халтираа гулгаа ихтэй арай гэж явж байсан ve л дээ. Очих газар дөхсөн болоод ч тэр vv бүгд сэrvvн явж байсан юм. Тэнд нэг өгсvvp давааг өнгөрөөд уруудаж явгал яахын аргагvй нэг бvсгvй зам хөндлөн гарч яваа харагдлаа. Тэр их хvйтэнд нимгэн жилетка өмсөөд явж байсан бvсгvй царцсан гэмээр удаан гарч байгаа нь анзаарагдаж байсан боловч тэр жижигхэн замыг туулаад гарахаар хугацаа өнгөрсөн болохоор хурдаа хассангvй. Тэгсэн золтой л мөргөчихсөнгvй тулж очоод зогслоо. Царайг нь тогтож хартал “Ээ бурхан минь vнэхээр хvйтэн царайтай бvсгvй” байв. Жолоочийн арын суудалд суусан эгч цонхоо онгойлгоод хэдхэн vг хэлтэл дөнгөж саяхан машины хамар дээр гараа тавиад зогсож байсан хvн хаашаа орсон юм гэмээр алга болж орхилоо. Бид ч хэсэг мунгинаж байгаад цааш явахдаа бvгд яасан ч юм унтаж орхижээ. Юу болсныг санаж байгаа хvн нэг ч алга. Хаана яаж ирснээ ч мэдэхгvй баахан сандарч арайхийн зорьсон газраа хvрлээ. Дараа нь тэр хавиар нутагладаг хэд хэдэн хvнээс асуухад бvгдээрээ тэр хэсэг газрыг гvйдэлтэй гэж ярьсан билээ.

\* \* \*

Би өөрт тохиолдсон нэгэн явдлыг оруулмаар санагдлаа. Энэ явдал 2009 оны зун болсон юм. Орбитын эцэст нэг эгчийндээ амарч байсан юм. Тэр хавийн айлууд ихэнх нь байшинд амьдардаг байлаа. Хажуугийн хашаанд хэн ч харсан жихүүцмээр саарал өнгөтэй байшин байдаг байсан юм. Тэр байшинд хэн ч амьдардаггүй гэж ойр хавийнхан хэлдэг ч хааяа шөнө дунд гарах үед гэрэл нь асаалттай дотор нь хүн юм ярьж байдаг байлаа. Эхэн үед сүнс чөтгөр гэж боддоггүй байлаа. Тэгсэн нэг өдөр..... Өдөржингөө хашааны гадаа хүүхдүүдтэй хөл бөмбөг тоглочихоод үдшийн бүрийгээр хашаандаа ганцаараа бөмбөг өшиглөж байгаад өнөөх хажуу хашаа руу бөмбөгөө оруулчихсан юм. Эхлээд шууд ороод авчихья гэж бодсон ч зориг хүрэлгүй гэрлүү орсон юм. Гэхдээ миний хайртай бөмбөг байсан болохоор авахаар шийдэн хашааны үүдэнд нь очин банзан завсраар харлаа. Хашаан дотор 2 хүн чанга чанга инээн сууж байна. Тэгэхээр нь "Ах аа бөмбөг аваад өгөөч" гээд орилчихсон чинь улаан нүдэн дээр алга болчихсон. Би айхаасаа өмнө их гайхаж билээ. Тэгээд шууд хашаа руу нь гүйж ороод

бөмбөгөө аваад гарч явахдаа эргэн харахад байшингийн хаалган дээр нэг эмээ хоолны халбага долоогоод зогсож байсан. Тэгээд яг хашааны хаалгаар гарахад зам дээр нөгөө эмээ бас харагдсан. Миний хамаг бие салгалаад гэрлүү хар эрчээрээ ороод эгчид хэлэхэд дэмий юм яриад гээд загнуулсан. Маргааш өдөр нь нэг найзтайгаа үнэхээр тэр байшинд хүн байдаг үгүйг үзэхээр ороход тэр хашаанд хүн битгий хэл нохой ч ордоггүй нь илт. Өвс, шарилж битүү ургачихсан тэр бүү хэл байшингийн хаалга цонх нь банзаар дараатай байсан юм. Хамгийн захын цонхны банзыг хуулаад цаана нь байсан нимгэн панаарыг чулуугаар цоолоод харахад өдрийн гэрэлд тэр байшин дотор хүнд содон юу ч харагдаагүй. Тэгсэн атлаа үдэш болохоор гэрэл нь асч хүмүүс шуугилдаад эхэлдэг. Уг нь тэр байшинд гэрэл нэвтрэхээр шилэн цонх ч байхгүй. Дээврийн цоорхойгоор л өдрийн гэрэл нэвгэрнэ. Өнгө нь хүртэл тэр зэвүүн байшинг өнгөрсөн жил зорьж очоод үзэхэд яг хэвээрээ байж байна лээ. Харин миний банзыг нь хуулсан цонх бүтэн болчихсон байна лээ.

Энэхүү хуучны сургууль нь 1830-аад онд баригдсан бөгөөд одоог хүртэл Шведэд байдаг. Тэр сургуулийг нэгэн ахимаг насны хүн дуудлага худалдаагаар худалдаж аваад засвар хийлгэхдээ 4 Монгол залуугаар хийлгэсэн бөгөөд өглөөнөөс орой нар жаргатал ажиллаж байсан. Харин байшингийн эзэн орой харанхуй болохоос өмнө тэндээс явчихдаг байж. Ингээд нөгөө Монгол залуус хэд хоног ажилласны эцэст ажлаа дуусгаад явхынхаа урд шөнө жаахан ууж суугаад нэг залуу нь гадаах модноос нь нэг жимс авч идчихээд буцаад орох гэтэл хүүхдийн уйлах дуу сонсогдож, гайхаад ойр байсан нууран дээр очиж нүүрээ угаатал нуурын усанд жаахан хүүгийн уйлсан дүрс харагдахаар нь нөгөө залуу үхтлээ айж буцаж гүйж ороод нөгөө хэддээ хэлтэл ахалж явсан залуу "Чи эндээс янз бүрийн юм аваагүй биз дээ" гэтэл нөгөө хэд нь гайхаж харснаа "Юу гэсэн үг вэ?" гэтэл "Энэ ажлыг хийлгэж байгаа эзэн надад энэ их эртний барилга болохоор янз бүрийн юмаар нь бүү оролдоорой бас ажлаа эрт дуусгаж байгаарай гэсэн. Харин би та хэдэд хэлчихвэл хийхгүй байх гэж бодоод юу ч хэлээгүй юм аа. Энд олон хүн амьдарч байгаад нас барсан. Тэдний сүнс энэ хавиар үзэгддэг гэж эндхийн хүмүүс ярьдаг юм байна лээ. Дээр нь эндхийн юманд зөвшөөрөлгүй хүрч болохгүй гэдэг юм байна лээ гэж хэлсэн" гэхэд нөгөө залуу "Модноос нь алим аваад идсэн шүү дээ одоо яах уу?" гэтэл "Маргааш угаасаа ажил дуусаж байгаа юм чинь маргааш хэдүүлээ эндээс эртхэн явъя" гээд унтацгаасан байна. Харин нөгөө залууд шөнөжингөө хүүхдийн уйлах, инээх чимээ сонсогдсон гэдэг юм байна лээ. Тэнд ажиллаж байсан хүнээр нь би яриулсан юм.

\*\*\*

(Энэхүү зураг нь энэ явдал болсон газрын нуур, байшин юм )

Манай сургуулийн урлагийн үзлэг болох гээд ангидаа юмаа бэлдэж бэлдэж орой 10 өнгөрөөгөөд дотуур байрандаа ороод өрөөндөө ороход гэрэл асаалттай байв. Нээх юм бодолгүй хоол цай эргүүлээд явж байтал өрөөний хүүхэд маань "Энийг хардаа" гэхээр нь очоод хартал ханан дээр томоос том анхааруулах тэмдэг тавьсан байсан. Бүр юмаар ухаж хийсэн ч юм шиг эсвэл хумсаараа ухсан ч юм уу аль нь мэдэгдэхгүй анхааруулах тэмдэг байв. Бас энд тэнд обой урагдаж, дөрвөн хумсаараа маажсан бололтой 3, 4 газар байлаа. Бид ч гайхаад "Өрөөгөө түгжиж явсан биз дээ? Яагаад ингэсэн байдаг билээ" ярилцаж байгаад л "За за маргааш учрыг нь олъё" гээд унтацгаалаа. Тэгээд тэр явдлаас хойш хэд хоногийн дараа миний бие маш их халуураад хичээлдээ ч явж чадахгүй орондоо 2 хоногийг өнгөрөөлөө.

Гэтэл эхний халуурдаг өдрийн орой хүүхдүүд оройн тоогоо өгөх гээд гарсан байсан юм. Би тэгээд утсаараа чихэвчээ зүүгээд дуу сонсоод байж байтал өрөөн дотор хүн яваад байгаа юм шиг хүний гутлын чимээ гарахаар нь гайхаад хартал хэн ч байгаагүй. Тэгээд за за юу ч биш байж гэж бодоод буцаад дуугаа сонсоод нүдээ аниад хэвтгэл нэг хүн хөл дээр суулаа. Тэгээд гайхаад хартал хэн ч байгаагүй. Айгаад л хүүхдүүд хурдан орж ирээсэй гэж бодоод хөнжилөө дээгүүрээ нөмрөөд хэвгэв. Тэгтэл ахиад л нэг хүн өрөөн дотор яваад эсвэл хөлд суугаад байсан. Би маш их айж байтал хүүхдүүд удалгүй ороод ирэв. Тэгэхээр нь тэдэнд хэлтэл "Битгий тоглоод бай" гээд л би ч "Үнээн энд нэг юм байна" гээд л хэлээд байсан. Тэгээд манай найз бөө юм л даа тэр найзыгаа дуудаад асуутал "Энд сүнс байна. Одоо бид нарыг харж байна" гэхэд миний биеийн хамаг хөлс гараад чичрээд бие үнэхээр муу болсон. Найз маань "Хүч муутай сүнс байна. Би жоохон ч болов аргалъя" гээд гараад явсан. Тэгээд маргааш нөгөө найзаасаа асуутал "Чи ханан дээр 4 хүний нэр бичсэн юм байна лээ. Тэгээд энэ ханан дээр анхааруулах тэмдэг зурсан юм байна" гэж хэлэхэд дотор пал гээд л сонин болсон. Тэгээд тэрнээс хойш нэр энэ тэрээ бичихээ больсон. Аймар юм байна лээ

\* \* \*

Манайх нэг хашаа байшинд арваад жил амьдарсан юм. Тэр хашаа байшин их сонин. Хамгийн их тохиолддог байсан өдөрт гэрт ганцаараа байх үед байшингийн шатаар хүн өгсөх чимээ гарна (өсгийтэй гутлын чимээ) тэгээд л гүйгээд очихоор хэн ч байхгүй, орой 00 орох гээд гарч ороход яг ард хүний алхах чимээ эргээд харахад хэн ч байхгүй, тэргэл сартай шөнүүдэд нохойнууд маань ёстой унтуулдаггүй байсан. Шөнөжин байшингийн үүд рүү боргож хуцна. Бусад үед зүгээр байдаг хирнээ (манай аав ээж 2 баргийн сүнс сүгэнд итгэдэггүй юм). Нэг орой хашаанд байдаг гэртэй айлаас гараад байшин руугаа орох гэтэл араас нэрээр дуудахаар нь буцаж очоод "Яасан дуудсан уу" гэтэл "Үгүй" гэсэн. Хамгийн аймар нь миний ор зөөлхөн юм л даа. Заримдаа унтах гээд хэвтэхэд яалт ч үгүй хүн ирээд сууж байгаа юм шиг ор доошоо хонхойдог, бас манай дүүгийн зай нь дуусаад удаж байсан хүүхэлдэй нэг шөнө гэнэт дуугараад бүр зогсоо зайгүй шүү. Аав, ээж бид 3 үхтлээ айгаад, аав маргааш нь тэр хүүхэлдэйг балиар хүүхэлдэй гээд шууд гаргаад шатаасан. Анх нүүж очоод удаа ч үгүй байхад би том өрөөнийхөө зүүн хойд буланд ганцаараа ор засаад унтлаа. Гэтэл шөнө яг миний унтаж байгаа тэр буланд 2 хүн зодолдоод нэг нь нөгөөгөө сүхдээд алчихлаа гэж зүүдлээд тэр явдлаас хойш тэр буланд дахиж унтаагүй юм. Тэгсэн өнгөрсөн жил хашаа байшингаа зарах гээд зар өгсөн юм. Хүн ч нээх ирдэггүй. Гайхаад байж байтал хальт таних найзтайгаа тааралдтал "Танайх ...-ийн ...-д байдаг уу" гэхээр нь "Тийм ээ" гэтэл би танайхыг гэж мэдээгүй энэ урд талын дэлгүүрээс чинь хаана байдаг юм гэж асуутал зааж өгөөд "Залуу хүмүүст дэмий дээ нэлээд хэдэн жилийн өмнө тэнд 2 согтуу нэгнийгээ хутгалж алсан юм даг" гэж ярьсан. Тэгээд тэр найзаасаа салж яваад тээр нэг жилийн зүүдийг санаж байсан юм.

\* \* \*

(Гишүүний хүсэлтээр орхигдсон зүйл байсан тул нэмж оруулав)

Би өдөрт байнга ганцаараа байдаг байсан юм. Тэгээд хийх юмгүй үедээ байнга selfie хийгээд л. Тэгсэн нэг удаа selfie-дэж байгаад зургаа харсан чинь миний ард хаалганы дээр бүүдгэр цагаан хүний толгой шиг юм гарсан байсан. Би маш их айж гэрээсээ гараад аав, ээж хоёрыг орой иртэл гадаа хүлээсэн. Хамгийн сонин нь аав ээжид үзүүлэх гэтэл тэр зураг өөрөө

устчихсан байсан. Яаж ч хайсан ерөөсөө байхгүй байсан. Үнэхээр аймар байсан.

Төв аймгийн Баянчандмань сумын коллежийг би энэ жил төгссөн юм. Мэдээж дотуур байранд байлаа. Манай дээд үеийнхэн нэг удаа бидэн дээр орж ирж юм ярьж сууцгаасан юм. Гэтэл манай өрөөний нэг банди "Энэ байр сүнстэй байх тээ" гэж асуутал нэг ах "Тийм ээ, яасан" гэхэд манай найз "Шөнө унтаж байгаад сэрээд цаг хараад буцаад унтах гэтэл цонхон дээр 1 хүн зогсож байсан. Би айгаад хөнжилөө толгой дээгүүрээ нөмрөөд унтаж ч чадахгүй нэлээн удсан" гэж хэлтэл нөгөө ах "Энэ байранд хэдэн жилийн өмнө нэг согтуу оюутан яг энэ өрөөнөөс 2 давхарын охидын өрөө рүү цонхоор орох гэж байгаад унаад үхчихсэн юм" гэж хэлсэн. Тэгээд бид үүнийг сонсоод дараа нь өрөөгөө сольж байсан юм. Ер нь Төв аймгийн Баянчандмань сумын коллежийн дотуур байр эвгүй санагддаг.

\* \* \*

Баатараа бол Өвөрхангайн уугуул. Өвөрхангайн эрчим хүчний урд талын барилга сүнстэй гэж яригддаг юм л даа ..... Сэтгэл дагаад ч тэр үү шөнө орой тэрүүгээр шөнө оройн цагаар ганцаараа явахаар хүн дагаад ч байгаа юм шиг нэг л эвгүй эл хул.

\* \* \*

Би нэг орой найзуудтайгаа заал авчхаад л явж байлаа л даа [шөнийн 1 цаг орчмын үед]. Бид хэд тараад би гэр лүүгээ салаад явлаа. Тэсийн гүүрээр гараад цаашаа явж байтал нэг эмээ цааш харан газар малтаад л сууж байсан, харахад аймар эвгүй. Би дөхөж очоод "Эмээ танд туслах уу? юмаа алга болгоо юу?" гэхэд гэнэт эргэж хартал (2 нүд нь байхгүй аяганд нь нүдний цөцгий гээд байх ч юм байхгүй эмгэн гэхэд их хурц шүдтэй, шанааных нь яс нь арьстайгаа наалдсан яс арьс болсон эмгэн )

"Эмээгээ урагшаа дөхүүлээд өгөөч, миний хүү урдаас ирж байгаа"

гээд, би ч юм бодолгүй урд нь гараад "Тэгье ээ" гээд дагуулаад явж байтал эрчим хүчний тэнд очоод "За за боллоо, миний хүү яв даа" гэв. Би

-Эмээ хүү чинь ирэх болоогүй бол гэрт чинь дөхүүлээд өгөх үү?

-Манайх энд миний хүү яв яв

\* \* \*

Би хэд алхаад өөрийн мэдэлгүй эргээд харахад эмээ алга болсон байв. Мэл гайхаад харж зогсож байснаа за юмны араар ороод яваад өгсөн биз гэж бодсон боловч тэнд эл хул ямар ч хүн дор хаяж 50 алхаж далд орохоор газар байсан болохоор жоохон жийрхээд явав. Буцахдаа яг тэр барилгынхаа хажуугаар гарч явтал ард нэг юм дуугарлаа, эргэж хартал юу ч алга. Нуруугаар бүр хүйт даагаад нээх сонин болчихсон. Тэгээд эрчээрээ алхтал хашаан дээр нэг юм дуугарахаар нь эргээд хартал хашаан дээр нэг сонин юу ч гэмээр юм дээ нүүргүй биегүй хүн дүрстэй хар юм зогсож байсан. Байж боломгүй зүйл харснаасаа болоод би бүр зогтусаж, хөдлөх гээд хөдөлж чадахгүй орилох гээд дуу гардаггүй. Азаар манай аймгийн Гандангийн

нэг том лам тэрүүгээр айл руу явж байхдаа намайг харж таарсан. Тэгээд намайг машиндаа суулгаад эрхээрээ бие рүү цохиж эхэлсэн. Цохисон газар болгонд нь мэдээ орж , сая нэг юм дуу гарсан хоолой ямар ч өнгөгүй болчихсон мэт их аймшигтай ярьж гээд ч ярьж чадахгүй байсан, шокноосоо гараад гэнэт уйлчихсан. Тэр явдлаас хойш шөнө орой тэрүүгээр байтугай гэрийнхээ энүүгээр явахаас ч айдаг болсон доо.

\* \* \*

Манай найзын хойд гудамжны айлд архи тамхинд дуртай настай хөгшин эмгэн бурхан болоод удаагүй байсан байж. Бурхан ч гэж дээ буг болсон байж. Найзын маань хүү 3 юм уу 4-р л анги байсан байх одоогоос 5, 6 жилийн өмнө болсон явдал. Нэг өдөр найзын хүү / үүнээс хойш Б гэж товлоё/ Б найзындаа очиж тоглож байгаад жоохон хүүхэд л юм болохоороо ядраад тэндээ унтаад өгч. Оройхон шиг гэртээ ирээд аав ээжээсээ хөгшин хүний хоолойгоор тамхи архи нэхээд уналаа гэнэ шүү. Аав ээж нь тухайн үедээ тоглож байна гээд тоогоогүй байна. Тэгээд хөгшин хүн шиг бүгшүүлэн ханиалгаад байж. Маргаашнаас нь сэжиглээд асуухад сонин хөгшин хүний хоолойгоор яриад архи тамхи нэхээд архи ууж тамхи татаад байна гэнэ шүү. Сандраад лам хараас асуухад тэр талийгаач болсон газар унтсанаас болж биед нь шүгэлсэн байна гэжээ. Тэгээд засал ном гээд бөөн л юм болж тэгсэн нэг өдөр л Б хөгшин хүний хоолойгоор энэ хойд овоон дээр гармаар байна гэж, мэдээж хэлснээр нь аваад гарч. Овоон дээр гараад нэг шил архи уугаад “За сайхан бие засчихаад энэ хүүхдийг амраая даа” гэж хэлээд овооны хөл рүү бие засахаар яваад өгч удсан ч үгүй Б эв эрүүл гүйж ирээд “Хүүе аав ээж энд юу хийж байгаа юм хэзээ ирсэн юм” гээд бөөн юм асууж байна гэнэ. Тэгсэн тэр талийгаачийг номын дагуу буяны ажлыг нь хийгээгүйгээс болж буян нэхэж сүнс хорогдсон байх гэж ярьж байсан.

\* \* \*

## Хуучин байр

Өөрт тохиолдсон 2 явдлыг та бүхэнд сонирхуулах гэсэн юмаа. Яг сүнс чөтгөр хий зүйл байсан үгүйг нь нүдээрээ хараагүй болохоор мэдэхгүй юм. Би багаасаа л аймшгийн кино аймшгийн зохиол зэрэг далд ертөнцийн зүйлс сонирхдог байсан юм. За за тэр ч яахав гол яриандаа орьё.

1. Манайх 3-р эмнэлгийн Эрэл-н байранд байдаг байлаа. Нэг өдөр аав ээж дүү 3 маань лагер гарах болоод би гэдэг хүн гэрээ сахиж үлдэхээр болов оо. Орой ч болж дота тоглоод ухаан сөхөөгүй байж байгаад гэнэт 00 ормоор санагдаад 00 орчоод өрөөндөө орохдоо өрөөнийхөө хаалгыг хаасан юм / манай өрөөний хаалга бариулаараа доош нь дарж байж онгойдог ямар ч хүчтэй салхи шуурганд онгойно гэж лав байхгүй дүү маань ч хааяа онгойлгож чаддаггүй юм./ Хаалгаа хаачихаад л яг компютерийн дэлгэц рүү хамаг анхаарлаа төвлөрүүлээд очоод сандал дээрээ суугаад эргээд хартал нөгөө хаасан хаалга маань цэлийтэл онгойчихсон харанхуй урт коридор өөдөөс дурайж байв. Дотор пал гээд л явсандаа.

2. Аав ээж дүү 3 ч лагер-с ирээд эхний явдал мартагдсан байв. Нэг шөнө эмэгтэй сайн найзтайгаа юм хум яриад инээлдээд цонхоо нээчихсэн хотын гэрлийг ширтээд харанхуй өрөөндөө зогсож байтал мөрнөөс угз хийтэл хойшоо татав. Би ч аав л шөнө хэнтэйгээ яриад

байгаа юм унт гэж байгаа юм байна даа гэж бодоод л хартал миний ор шүүгээ компьютер-н ширээ зэрэг байдаг л тавилгуудаас өөр хүн гэж харагдахаар зүйл нүдэнд туссангүй. Тэр үед угз татуулсан мөр бадайраад нэг л эвгүй мэдрэмж төрөөд нрууны шар үс босчихсон хэсэг дуу чимээ ч гаралгүй айсан байдалтай байж байтал утсаар ярьж байсан найз маань хөөе чи тэнэг юм уу дуугараач ээ утас чинь яачихав гээд болсон явдлыг найздаа хэлээд утсаа таслаад л гэрлээ асаагаад унтаж чадахгүй нэлээн удаан хөрвөөсөндөө. Өглөө босоод л аав биш гэдгийг нь мэдсэн ч горьдлого маягаар ааваа та өчигдөр өрөөнд орж ирсэн үү гэж тэнэг асуулт асуухад аав маань үгүй ээ аав ээж 2 нь тэгээд л унтсан ш дээ гэж билээ. Урт үстэй хөх дэлэн нь унжсан биет зүйлс харж байгаагүй ч надад тохиолдсон энэ 2 явдал нрууны минь шар үсийг босгох болон биений минь хүйтэн хөлсийг асгаруулах хүчтэй байсан юм шүү..

### **Миний өрөөний сүнс**

Манайх 2 жилийн өмнө нэг байшин авсан юм би дарханд байдаг байсан болохоор миний өрөөнд байдаг хаалгаар 00 ороход хурдан гээд дамжиж гарах зорилгоор манай гэрийнхэн ашигладаг байсан. Харин би өнгөрсөн хавар гэртээ ирээд өрөөндөө байх болсон, анх юу ч мэддэгддэггүй байсан ч миний өрөө цаанаа л жихүүн хүйтэн байдаг байсан.

12 сард усанд орчоод тольний өмнө үсээ самнаад зогсож байтал нүдний үзүүрт юм хөдлөх шиг болсон. Би айгаад толинд хартал миний хойно нэг гаргүй эрэгтэй зогсож байсан. Би хэр удаан хөшиж зогссоноо одоо ч мэддэггүй нэг мэдэхэд л аав ээжийн өрөөнд байж байсан.

Энэ явдал тэгээд мартагдаж би өрөөндөө унтахаас айгаад гал тогоондоо эвхдэг орон дээр унтдаг болж заавал гал тогооны хаалгыг хаадаг байлаа. Нэг удаа хаахаа мартаад унтчихсан гэтэл орой унтаж байхад хэн нэгэн хөл дээр минь дугхийтэл суугаад ор шажигнах чимээгээр сэрээд хартал хөл дээр минь сүүмийсэн хар юм сууж байснаа муухай инээгээд алга болчихсон. Миний хашхирах чимээгээр аав ирээд намайг өрөө рүүгээ аваад явсан. Үнэндээ аав дүү 2 маань хоёр гурван удаа тэр сүнсийг харсан юм байна лээ. Лам хар авчирч уншуулж чадахгүй явсаар нэг л мэдэхэд аав дархан явсан. Ээж бид гурав үлдээд хоёр хонож байлаа. Орой нь би бие засах гээд гартал хойно маань хэн нэгний хүнд алхаа, амьсгалах мэдрэгдсэн. Гэрэл барьж явсан болохоор шууд эргээд хартал хэн ч байгаагүй харин миний хүзүүнд хэн нэгэн амьсгалах мэдрэгдсэн. Би айсандаа шууд гэр лүүгээ гүйгээд ортол дүү маань бас айчихсан аниа таны өрөөнд гаргүй аймар царайтай хүн яваад байна гэсэн. Тэр орой ээж маань ч бас тэр сүнсийг харсан орой унтаж байтал ээж намайг татаж сэрээсэн. Ээж бүр айчихсан цонх руу заасан би тийшээ хартал сэгсийсэн үстэй эрээн даашинзтай охин яг л хийсэж байгаа юм шиг зогсож байсан. Харин өрөөний хаалганд нөгөө гаргүй хүн, тэгтэл манай хамаатны бөө ах эгч 2 ороод ирсэн. Тэр 2 амжиж ирлээ шүү гээд өөр юм хэлэлгүй хоноод явсан. Тэр 2 ирээгүй бол юу болох байсан ч юм билээ.

Ямартай ч хүн хараар аргалуулаад тэр сүнснүүд харагдахаа больсон ч алга болсон гэдэгт нь итгэдэггүй. Миний өрөө одоо ч өнөөх л жихүүн хүйтэн хэвээрээ байгаа...

### **Өөрт болсон явдал...**

Одоогоос 4 билүү 5 жилийн өмнө партизаны Сангийн Аж Ахуйд манай аав байдаг байсан юм. Би 10 жилийн хүүхэд зуны амралтаараа очиж амардаг байв. Нэг удаа очоод маргааш нь

буцах байв. Тэр Партизаны САА-д нутгийнхан нь айгаад цээрлээд явдаггүй. Хогийн хонхор гээд газар байдаг байлаа. Намайг буцах тэр өдөр аав маань 2 найзтайгаа архи уугаад орой 23 цагийн алдад архи нь дуусав. Хэсэг тэр гурав юм ярьж байснаа “Ээгий ахаа та нөгөө чүдэнзний хайрцагыг тамхины ишээр преткээр зүсэж байгаа юм шиг зүсээд үзүүлээч” гээд Отгоо гээд нэг ах хэлэв. (Манай аавыг Ээгий гэж байгаа юм аав тамхиный ишээр чүдэнзний хайрцгийг преткээр зүсэж байгаа юм шиг зүсдэг) Тэгсэн аав Отгоо ахыг “Чи тэгвэл сумын төврүү архинд яваад ир” гэв. Тэгсэн Отгоо ах “Тэгье ирэхээр үзүүлээрэй” гээд мордов. Сумын төв ороход тэр хогийн хонхроор дайрч гардаг юм. Отгоо ах яг шөнийн 00.00 цагийн үед сумруу явсан би тэгээд хэсэг унтаад өгч. Хүн унтаж байгаа мөртлөө бас хүмүүсийн ярьж байгааг сонсдог үе байдаг ш дээ, би яг тэгээд. Тэгсэн Отгоо ах орж ирээд ийм юм ярьж байна. Би сая хогийн хонхорын хажуугаар явж байтал нэг эмэгтэй муухай хашхираад тэгээд би юу вэ хэн бэ ? гээд орилсон чимээгүй болсон, тэгээд хөдлөх гэсэн морь явдаггүй тэгэхээр нь яг нөгөө буг чөтгөртэй нь таарчихаж гэж бодоод буугаад хөлрүү нь жоохон шээгээд эргээд суусан чинь явж байна, гэхдээ ард хүн суучихсан юм шиг морь чих нь сортолзоод хүндрээд ч байгаа юм шиг паацаг паацаг гээд яваад тэгээд би хальт харахнээ цагаан юм сүүтгэнэхээр нь ахиж эргэж харалгүй явсаар байгаад сумын төвд ирээд тэгээд таньдаг бүх айлаараа орсон бүгд л тийм хүн байхгүй гээд сонин хүмүүс гарч ирээд тэгээд байсан. Тэгээд дүү нь эргэж мордоод эргэж ч харалгүй бүс цулбуур ташуураа хойш нь суган доогуураа гаргаад явсаар байгаад ирлээ гээд амьсгаадаж ярив. Яг энэ үед би гэж гай сэрээд аав гарч бие засья гээд хаалга онгойлготол урдаас салхи сэвэлзээд оров, би ч анзаарсангүй аав салхитай байна тэ гэтэл аав гайгүй л байна даа гэв. Эргэж ороод хаалгаа хаачихаад яг орон дээр очоод л суусан нөгөө Отгоо ах “Ээ Ээгий ахаа нөгөө шулмас чинь намайг авах гээд ирчихэж тэр хаалганы хажууд гээд” уйлаад орилоод хойд орон дээр доошоо хараад тийчгэнээд байв. Тэгсэн аав багадаа ганданд өссөн учир амандаа юм уншиж чүдэнз зурж шидэж байснаа гадаа жингэр хуцсан нөгөө найзыгаа хаалга онгойлго гэсэн нөгөөх нь онгойлготол одоо хаа гээд за за Отгоо миний дүү нөгөөх чинь гарчихлаа гадаа шар жингэр амийг чинь аварлаа шүү дөнгөж гөлгөлсийн маргааш хооллоорой гэв. Отгоо ах тэгсэн “Муу новш миний мориний цулбуурыг барьчихсан намайг боож алах гээд (морин ий цулбуур нь аягүй бүдүүн сур байсан юм бас өөрөө урьд нь лам байсан юм байна лээ) энэ шулмас надтай ингэж байгаа бол үзье” гээд цаасан дээр нөгөө хөө зурсан нөмгөн дээлтэй сэгсийсэн л юм зурж байна тэгээд лаанд шатаасан хамгийн сонин нь нөгөө цаас нь шатаж байснаа зурсан хэсэг нь огт шатаагүй. Тэгээд л нөгөө хөөг хаячихаад унтаад өгөв. Аав намайг цай уу гэсэн би уух гээд буутал хөл мэдээгүй шууд унасан. Тэгээд аав намайг өргөж орон дээр суулгаад, би ч аавын хажуугаар хэвтэж байтал гэр тойроод л нэг юм гүйгээд байх юм, бүгд унтчихсан байсан болохоор бас сая аймар юм болсон болохоор жоохон эвгүй санагдаад тэгээд юм ч бодсонгүй тооно руу хартал нэг баганатай тооны дотор багана тойроод гурван тасарсан толгой намайг хараад эргэж байсан, яг нүүр тулсан болохоор бараг л ухаан алдахаа дөхсөн нуруугаар шууд хүйт даагаад могой гулгаад байгаа юм уу л гэмээр эргээд аавыг сэрээгээд, аав тооно тойроод гурван толгой эргээд байна гэсэн аавыгаа тэврээд нүдээ тас аниад унт гээд тэгээд л шөнөжин хар дарсаар өглөө усан хулгана сэрсэн өглөө гэж үүрээр. Вагон хот явдаг болохоор аав нөгөө зүгээр найддаа “Чи манай хүүг төв оруулаад вагонд суулгаад өг” гээд үүрийн бүрийгээр гэгээ ч ороогүй байхад гарав. Ядаж бас нөгөө хогийн хонхроор явна. Нөгөө ах урд яваад л байсан би ард нь явж байтал яг хажууд өлгийтэй хүүхэд уйлаад, тэр үед би тэрийг харсан ч огт айгаагүй. Яагаад гэдгээ өөрөө ч мэдэхгүй одоо бодохоор нуруу хүйт даадаг. Тэгээд нөгөө ахад энд хүүхэд уйлаад байна гэтэл нөгөө ах чинь чичрээд юу хуцаад байгаа юм дуугаа яваач гээд

тэгээд намайг суулгаж өгсөн. Аав ээжид хэлсэн юм байна лээ, Тэгээд хотод ирсэн, ээж орой нь ширгэ хийнэ гээд манай ахтай гэрэл унтрааж харанхуйд хийдэг гээд унтраах гэхэд нь 15-тай би 25-тай ахыгаа хаанаас гарсан хүч юм айгаад хана руу авч шидэж байлаа. Сүүлд нь аав нутгийн хүнээс асуусан тэр хогийн хонхор гэдэг газар нь 3 эмэгтэй дарааллаад хоолойгоо боомилж үхсэн гэсэн. Ийм нэг явдал надаа тохиолдож байсан юм хүн сүнс хараад айж болохгүй гэдэг яг харсан хүн айхгүй байна гэж худлаа юм байна лээ. Энэ таалагдвал дараа ахиж болсон явдал бичнэ ээ. Би ер нь их таардаг хүн.

\* \* \*

Энэ бол манай гэрийнхэнд тохиолдсон явдал шүү. /азаар би төрөөгүй байсан/. Манай өвөө цэргийн хүн байсан болохоор улсаас зун лагерийн байшин өгдөг байж. Тэгээд манайхан тэр байшинд нь гарлаа. /Шарга морьтод байсан гэсэн/. анх оччихоод манай эмээ эргэн тойрныг нь харж харж байснаа "энэ уулыг нураагаад барьсан юм байна даа" гэж хэлэхийг нь ээж сонсоод энэ тэгээд ямар хамаатай юм бол доо гэж бодоод өнгөрсөн гэсэн. Тэгсэн орой унтаж чадахаа больсон гэнэ. Яагаад гэвэл шөнөжингөө ямар нэг юм хаалга цонх пижигнүүлэн цохиод, хана туурга маажгаад гарч харахаар юу ч байхгүй, эмээ эгч ээж бүгд айгаад унтаж ч чадахгүй их дарамттай байсан гэсэн. Хажуу хөршөөсөө асуухаар тийм үү зүв зүгээр л байдаг ш дээ гээд тоохгүй байж. Бүр нэг шөнө цонх хагарах чимээ гараад босоод очоод хартал бүх цонх зүв зүгээр бүтэн байсан гэнэ лээ. Эмээг нэг үүрээр цонхоор харахад олон цагаан морьд хойно байдаг ой руу давхиж явахыг харж.Ээжийг хот орох бүр хөөрхий эмээ хурдан ирээрэй гээд захидаг байж. Ээж маань хот ороод буцаж очихдоо том хадаас авч очоод байшингаа тойруулаад хадчихсан гэсэн. Харин тэрнээс хойш хаалга цонх нүдэхээ болиод их сайхан болсон гэсэн. Нэг өглөө хажуу айл нь нүүж байна. Ээж гайхаад асуутал --өглөө унтаж байхад хаалгыг нь их чанга нүджээ. Гэрийн эзэн нь босож очоод хэн бэ гээд уурлаад хаалгаа нээтэл маш том хүрэн баавгай байсан гэсэн. Тэгээд орилоон хашгираан болоод гэр бүлээрээ сандралдаж үймэлдээд бөөн юм болж, тэгээд нүүж байгаа нь тэр байж л дээ. Тэгээд ээж ярьдаг юм, гэрийнхээ гадаа гадас ч юм уу ядаж хадаас шаах нь гүйдлийг оруулдаггүй нь үнэн юм байна лээ. Уулыг нь нураачихсан болохоор тэр хавийнх нь эзэн нь уурлаад элдэв амьтны дүрд орж тэгж айлгадаг байсан биз гэдэг юм.

\* \* \*

Сайн байна уу? Би багаасаа л аймшгийн яриа, болсон явдал, сүнс чөтгөр, тайлагдашгүй нууцуудын талаар унших дуртай хүүхэд байсан. Тийм болоод ч тэр үү тиймэрхүү явдалтай биеэрээ хэд хэдэн удаа таарч байсан. Тэр явдлуудаасаа ярьж өгөхөөр шийдлээ л дээ.

10 жилдээ би Багануурт сурдаг байсан юм. Манай гэр 37-р байрны 4-р орцын 2 давхарт байдаг байсан юм. Манай яг хажуу талын айл их сонин байнга л хэрэлдэж байдаг айл байж байгаад нэг л өдөр хэрүүлийн чимээ гарахаа больчихсон. Би ч нээх тоосонгүй. Тэр явдлаас хойш хэд хэдэн айлууд орсон ч удахгүй нүүчихдэг байсан юм. Би нэг удаа орцондоо ангийнхантайгаа уулзаад зогсож байтал нэг архичин бололтой нэг ах жижигхэн гөлөг тэвэрчихсэн нөгөө хаалга руу чинь орох гэж байх шиг байна. Модон хаалгыг нэг хадаасаар тээглүүл чихсэн байдаг байсан юм. Тэгснээ нэг хүүхдийг дуудаад "Ахдаа энийг онгойлгоод өг дөө" гэхээр нь манай ангийн банди очоод онгойлгоод өглөө. Тэгсэн ороод л нөгөө жижигхэн гөлөг чинь гасалж эхэллээ. Тэгснээ хаалга руу нэг юм цохих шиг л болсноо дуугүй болчихсон.



Бид хэд ч тэгсгээд тарцгаасан юм. Маргааш нь хичээлээ тараад харьж явтал нөгөө айлын тагтан дээр шүд нь ярзайсан, нүд гөлөрсөн нохойны тасарсан толгой хэвтэж байсан. Бас манай ангийн хөвгүүд тийшээ орж тамхи татдаг байсан юм. тэгээд нэг өдөр бүгдээрээ тамхи татах гээд орж байсан чинь хамгийн сүүлд явж байсан банди нэг л сонин царай гаргаснаа "Гарья аа гарья л даа" гэсээр байгаад бүгд гарч ирээд нөгөө хүүхдээс асуусан чинь "Та нар хараагүй юм уу? Нэг өрөөний буланд нь цагаан үстэй, цагаан хувцастай эмгэн суучхаад бид нар луу хараад байсан ш дээ" гэж хэлсэн гэсэн. Сүүлд учрыг нь сонсоход, анх нэг эхнэр нөхөр 2 байсан гэсэн. Нөхөр нь байнга эхнэрээ зодож, хэрэлддэг байсан. Нэг өдөр тэр залуу эхнэрээ алаад амиа хорлочихсон гэсэн. Тэгээд гэрийнхэн нь байрыг нь зарчихсан. Дараа нь тэнд орсон айлууд бүгдээрээ л салалт, хэрүүл гэх мэт зүйлүүд болоод тэр гэрээс нүүдэг байсан гэсэн. Тэр алуулдаг бүсгүйн найз нь найзыгаа нас барснаас хойш байнга найзыгаа зүүдэлдэг, найз нь дуудаад байдаг байсан гэсэн. Тэгээд хүнд үзүүлсэн чинь найз чинь чамайг л дуудаад байна, байрандаа амьдруулахыг хүсээд байна, тэгж байж сүнс нь амарна гэжээ. Тэгээд тэр эгч нэлээн бодсоны дараа нөхөр 2 хүүхэдтэйгээ нүүж ирсэн. Тэднийд ямар нэг болоогүйгээр барахгүй одоо болтол тэндээ амьдардаг, ажил амьдрал нь ч өөдөлж байгаа гэсэн шүү. Одоо ч гэсэн гэртээ ганцаараа байхад хажуу айл бодогдоод эвгүй байдаг шүү.

Миний нэг таньдаг ах байдаг юм их архи ууна л даа муу хог. Тэгээд яагаад ингэж архи уугаад байдаг юм бэ гээд асуутал

-Мэдэхгүй ээ ах нь уул нь уудаггүй байсан юм нэг удаа ийм явдал болсон юм гээд нэг ийм түүх ярьж өгч билээ.

Хуучнаар тээврийн жолооч нар бригад болон цуваагаар явдаг байж нэг өвөл өвсөнд явж байгаад хээр буудаллаж хоноглохоор болжээ. Тэгээд бүгдээрээ машинаа өөд өөдөөс нь харуулж тавиад дунд нь жаахан гал ноцоогоод хээр бөөнөөрөө сууж аяны хоол хийж л дээ тэгээд бүгдээрээ өвөл байсан болохоор дотроо халаая гээд архи ууцгаажээ. Нэлээд халамцсан нөхдүүд өглөө эрт хөдөлцгөөнө гээд тус тусынхаа бүхээгтээ ороод унтахаар хэвтэцгээжээ. Гэтэл нэг нөхөр нь босоод гадуур машинаа тойрч гүйгээд хүн амьтан сэрээгээд бүгдээрээ эндээс явцгаая аа гээд байж гэнэ. Залуус жаахан халамцсан байсан болохоор их унтууцаж уурлацгааж гэнэ гэтэл нөгөө залуу та нар харахгүй байна уу бид нарыг авснууд тойроод эргэлдээд байна гэжээ. Залуус инээлдэж архиндаа солиорч байна гээд арай гэж машинд нь оруулаад унтуулж гэнэ. Харин өглөө явах болоод бүгд машинаа асаагаад мань хүнийг хөдлөх боллоо явцгаая гэж нэг нь дуудахаар очтол хөөрхий залуу өнгөрчихсөн байсан гэнэ. Удалгүй тэдний бригадын дарга бас ганц хоёр жолооч нь өөд болж бусад нь яагаад ч юм бүү мэд амьдрал нь доройтож эхнэр хүүхдээсээ салцгаан архинд орцгоож бүгд л амьдралаа алдацгаасан гэдэг юм билээ. Өглөө ажил хөөцөлдөж гараад ч юм уу дэлгүүр орох гэж гараад л нэг мэдэхэд өөрийн мэдэлгүй л уучихсан байдаг нэг мэдэхэд л ямар ч хамаагүй үнэтэй үнэгүй нь хамаагүй архи уучихсан сууж байдаг намайг яг л нэг юм удирдаад байгаа юм шиг хэнтэй юу ярьснаа ч санадаггүй. Уул нь ажил хийж сайхан амьдармаар байна гэж тэр хүн их л санаа алдан ярьж байгааг нь сонсоод үнэхээр гайхаж билээ. Харин дараа нь үнэхээр тийм явдал болж тэдний бригадын замд хамт явсан бүх жолооч нар цагдаад байцаагдаж нэлээн сунжирсан хэрэг болсон гэдгийг учир мэдэх хүмүүс ярьж байхыг нь сонсож билээ.

За энэ группынхандаа ямартай ч энэ өдрийн мэнд хүргье.....Амалсан ёсоороо өөрт тохиолдож байсан явдлаа бичихээр шийдлээ.Одоогоос 8 жилийн өмнө буюу 2005 онд болсон явдал юмаа. Гэхдээ би нүдээрээ сүнс сүүдэр гэж үзэж байсангүй. Нэг тийм дайрлага дайрдаг явж болдоггүй газар гэж байдаг ш дээ тийм газраар мэдэхгүй явж байсан юм аа.....Увс аймгаас УАЗ 469 машинтай гэр бүлээрээ ганц хоёр замын хүнтэй Дархан хот руу явж байлаа. Миний санах ийн гэгээ тасарч байсан үед Архангай аймгийн Эрдэнэ-мандал сумруу орох үед машин маань аймар осолд орсон юм. Азаар хүн нээх сүртэй бэртээгүй араас нэг машин хүрчирээд биднийг гаргалцаж машиныг маань босголцож өгөөд наад замаар чинь явдаггүй ш дээ гэж хэлж байсан юм. Тэгээд тэр сум руу бид нараас хамгийн хүнд бэртсэн 1 эгч манай ах 2ыг сумын төврүү хүргэхээр аваад явсан юм. Манай ах тусламж эрэхээр төврүү орсон юм. Яг тэр үед нар жаргасан хав харанхуй болсон байсан юм. Аав маань ч их шоконд орсон байсан тэгээд хэлэхдээ за бид нар ч эндээ өнөөдөртэй хонож таарах юм шиг байна гээд тэнд байсан юмнуудаараа ор засан хэвтэж байсан юм тийм юм болчхоод байхад яаж ч нойр хүр хэв дээ нохой хуцах чимээ сонсогдоод толгой дээр хөлийн чимээ сонсогдоод ч байх шиг айсан үед санаа дагаж байгаа байлгүй дээ хэмээн өөрийгөө тайтгаруулан хэвтэж байтал азаар ах маань тэр шөнө УАЗ 469 машинтай нэг ах дагуулж ирээд биднийг тэр аймшигт газраас авч явсан юм. Тэр хүн биднийг гэртээ аваачиж бидэнд тусалж бидэнд яг л хамаатан садан нь ирсэн юм шиг хүндэт зочин шигээ харьцаж гэртээ 3 хонуулан машиныг маань янзлалцаж өгсөн юм. Тэр айлын эзэгтэй эмнэлэгт хэвтэж байгаа бэртсэн тэр эгчид хүртэл хоол цай зөөж байсан юм. Тэр хүн хэлэхдээ биднийг та нар машин явдаггүй гүйдэлтэй дайрлага дайрдаг тийм газраар явсан байна Энэ газар өмнө нь маш олон машин осолд орж байсан юм тийм гүйдэлтэй газраар явсан байна та нар ийм танк шиг машинтай байсан тулдаа хүн эрстэж хүнд бэртэл авсангүй хэрвээ ондоо машин байсан бол яг л базсан лааз шиг болох байсан юм хэмээн биднийг их азтайд гайхаж байсан юм. Бидний осолд орсон тэр зам бол ямар ч чулуу хад байхгүй зүгээр л нэг тэв тэгш шороон зам байсан юм. Өмнө нь маш их уул хадтай бартаат замаар ямар ч саадгүй явж ирсэн машин маань яагаад осолдов хэмээн гайхаж байсан юм Тэгээд яагаад машин осолдсоныг харахад машины маань нэг талын дугуйг яг л мэсээр зүсчихсэн юм шиг болгоод хаячихсан байсан тэр айлд 3 хоног машинаа засаад дахиад л урт замынхаа аялалд мордож билээ Тэр айлаас мордохдоо тэр ах дараан аялал зугаалга маягаар манайхыг зорьж заавал ирээрэй манай энэ аймаг үнэхээр сайхан байгальтай газар шүү хэмээн найрсгаар биднийг үдэж гаргаж өгч билээ Тэр үеэс хойш бурхан буга чөтгөр гүйдэл гэж байдагт итгэж эхэлсэн юм Үнэхээр тийм гүйдэлтэй дайрлага дайрдаг газар гэж байдаг юм байна лээ шүү.

\* \* \*

За би энэ явдлыг өөрөөс нь сонссон зүйлээ жаахан сийрүүлээд бичлээ. Энэ явдал 4 жилийн өмнө манай ахад тохиолдсон юм. Ажлынхантайгаа бөөнөөрөө хөдөө ажлаар нэг суманд очсон байгаа юм. Тэгсэн тэр суманд нь буудал байхгүй байж таараад захиргаанаас нь гуйж байгаад нэг хуучин эмнэлгийн хажуу байшинд хонохоор зөвшөөрөл авсан гэсэн. Бөөнөөрөө тэр байшинд юмаа тавихаар ороход өрөөний голд нэг модон ор тойроод дандаа хуучны төмөр ор байсанд манай ах хамгийн түрүүнд тэр модон орон дээр юмаа тавиад унтахаар болж. Шөнө дунд унтаж байхад гэнэт нойр нь сэргээд бие эвгүйрхээд нүдээ нээтэл яг дээрээс нь биеийг нь цагаан даавуугаар ороосон цогцос унасан байна. Ах яаж ч хичээсэн хөдөлж чадахгүй, дээр нь дуу нь гарахгүй нэлээд эвгүй байдалд ороод яахаа мэдэхгүй татганаж

байтал. Лам багшийнх нь хэлж байсан Монгол түмний их Шүтээн Очирваань бурхны тарни нь толгойд нь ороод ирсэн байгаа тэгээд тарин аа унштал нэг юм гайгүй болсон байна. Маргааш нь хүмүүсээс лавлаж асуутал. Тэр хоносон байр нь морго хийж байсан байшин бөгөөд голд нь байсан тэр ор шарил тавьдаг байсан ор байсан байна гэнэ лээ .

Зээ нэгэн сайн гишүүний хувьд өөрт тохиолдсон 32 явдлуудаа нэг амьсгаагаар цуврал болгон хүргэхээр шийдлээ.

## Дугаар №1

Одоогоос 6,7н жилийн өмнө байх 10н жилийн сурагч байхдаа нэг найзтайгаа гадуур явах ажилтай боллоо. Нөгөө л сурсан зангаараа болзсон цагаасаа хоцорсон тул найзыгаа гэрийн гадаа хүлээж байхыг хүсвэл гэж. Хувцас хунар гэж ноцолдсоор байтал нэлээн удаж, гараад иртэл халуун өдөр байсныг ч хэлэх үү их бүгчим орцоор дүүрэн өмхий илжирсэн үнэр хан хийлээ. Манай найз их сонин царайлчихсан ууртайгаар ‘Яасан удаг юм бэ. Ёо оё танай орцонд байх муухай байна хурдан гарая’ гэлээ. Би ч гайхан өмнө нь зүгээр л хүлээдэг байсан мөртлөө энэ удаад яагаад ингээд уурлаад байгааг нь асуутал. ‘сая над дээр 2 цагдаа ирээд энд хэзээнээс ингэж өмхий үнэртдэг болсон энэ тэр гээд баахан юм асуугаад би эндхийнх биш гэсэн чинь яваад өгсөн. Дотор бүр арзайчихлаа’ гэлээ. Манай лифт ажилладаггүй гацдаг байсан тул бид 2 5н давхраас шатаар буусаар 1 давхарт иртэл 1 давхрын хана толь, жижүүрийн пост энэ тэр гээд бүгд битүү ялаа /амьдралдаа тийм их ялаа харж байгаагүй, яг аймшгийн кино дээр гардаг шиг л/, бид 2 цамцаараа нүүр амаа дарсаар орц ноос гүйж гарлаа. Энэ явдлаас нэлээд хэд хоногийн дараа зуны амралт ч дуусаж хичээл эхлээд удаагүй байлаа. Нэг өдөр телевиз үзэж, интернет ухаж аар саар юм хийсээр байгаад гэрийн даалгавраа мартаж орхижээ гадаа ч орой болж байлаа. Надаа ном байхгүй тул ойрхон байдаг ангийнхаа охин луу залгаж авахаар тохирлоо. Сэрүү ороод намар болсных ч тэр үү гадаа юу юугүй л харанхуй болоод ирэв. Хурдхан хувцас хунараа өмссөн болоод гэрээс гараад лифтний товчлуур дээр дартал ирэх шинж алга. Манай лифт 5,6н жил ажиллагаагүй байж байгаад саяхан ажиллагаанд ороод удаагүй байлаа. Хуучны орос лифт тул байнга гацдаг байсан юм. Бас л гацчихаж гэж бодон их яарсан байсан болохоор үглэсээр шатаар буухдаа гадуур хүрмээ өмсөн хувцсаа янзалсаар 1 давхарт ирээд толинд харан үсээ боож байтал 1 давхрын лифтний дотор талаас их муухай маажлаа. Би бас л хүн гацчихсан юм байна гэж бодоод жижүүрийг дуудахаар орцын үүдний зүг өнгийтөл жижүүрийн постын гэрэл унтраалттай түгжээтэй байлаа.

Би ч өөрөө нэлээн хэдэн удаа гацаж байсан болохоор инээд хүрэн ямар азгүй нь ингээд гацчихдаг байн аа гэсэн юм бодоод инээгээд байж байтал дахиад л дотор талаас нь маш удаанаар маажлаа бүр аймшигтай заваан аар . Иймэрхүү юм маажих, цаасан хайрцаг тачигнуулах, тэр байтугай цаасан дээр модон харандаагаар юм зурах зэрэг чимээнд маш дургүй учир дотор аймшигтай арзайж дотроо ‘Юун ч сүртэй юм бэ дээ гацаа л биз зүгээр хаалгыг нь цохиж эсвэл орилж болно ш дээ. Маажлаад байхдаа яа хав дээ’ гэж бодон саяхан л шоолж инээж байсан минь уураар солигдоод ирэв ээ. Ингээд орцоос яг гарахаар үүдний шат руу дөхтөл нэлээн дээрээс лифт доошоо бууж байгаа бололтой тачигнаад тар няр гэсээр явж эхлэв. Гэнэтхэн дотор пал хийж “Хэрвээ лифт дээрээс бууж ирж байгаа юм бол 1 давхарт хэн лифтний дотор талыг маажсан бай хав” гэж бодогдон ёстой зүрх амаар гарах дөхөв. Хөдөлж ч

чадахгүй хөшчихсөн ядаж байхад орцод хүн амьтан байгаа ямар ч шинж байхгүй, жижүүр орцын гэрлээ асаагаагүй харанхуй ёстой л амьдралдаа айж байгаагүйгээр их айлаа. Нээрээ дээрээс лифт ирж байгаа юм чинь дотор нь хүн байгаа байх гэж бодоод арай тайвшраад байж байтал лифт ч тачигнаж пижгэнэсээр 1 давхарт ирэв ээ хөөрхий. За би гэдэг хүн ч лифтний хаалга руу нүдээ ч цавчилгүй харж байлаа, лифт ч онгойв. Онгойж бай байснаа хаагдчихав аймшигтай нь хүн гарч ирсэнгүй ээ. Тэгснээ дахиад онгойв. Би бүр яахаа ч мэдэхгүй зогсож байтал бүр миний нүдэн дээр лифтний хаалга онгойж хаагдаад байлаа. Орцоос орилсоор гүйж гараад ангийнхаа охиныд очиж учир байдлаа хэлээд хүргүүлж билээ. Манайх 10н жилийн сургуулиудтай ойр болоод ч тэр үү хүүхдүүд орцод их суудаг байсан юм. Даанч сүүлийн хэдэн долоо хоног нэг л бүүдийсэн хүн амьтан харагдахаа больчихсон нь ийм учиртай байсан юм билээ. Хэд хоногийн дараа компьютер аа ухаад сууж байтал орцод бөө боллолтой нэг юм пижигнээл нүдээд байлаа. Нэлээн л удаан нүдсэн юм даг. Миний яагаад ч юм дотор онгойгоод нар гийгээд л явчихлаа. Ингээд л хэд хоногоос манай орц урьдынх шигээ хөл хөдөлгөөн ихтэй болсон юм даа smile emoticon.

Үг үсгийн, найруулгын алдаа их байгаа байх. Мэргэжлийн зохиолч сэтгүүлч биш ч чадах чинээгээрээ өөрт тохиолдсон явдлаа найруулан бичлээ. Хэрвээ олон хүнд таалагдвал цааш нь болсон явдлаа бичнэ ээ.

\* \* \*

### **Болсон явдал 2013**

Нэг удаа яагаад ч билээ гэртээ ганцаараа байсан юм. Шөнө 23н цаг өнгөрч унтахаар хэвтээд л зүүдэлж эхлэх шиг болсон юм. Сэрэх хэрэгтэй гэж мэдэж байсан учир сэрэхээр нэлээд хичээж байлаа. Ямар үйл явдал болоод байсныг сайн ойлгоогүй ч хоолой бачуурч, амьсгалахад хүнд болж, дуугарч чадахгүй, хөдөлж ч чадахгүй байсаар нэлээд удах шиг болсон энэ хугацаанд гал тогооны өрөөнд ямар нэг зүйлийн чимээ гарч айж байснаа ч санаж байна. Хэсэг хугацаа өнгөрч гэнэт л орноосоо огцом өндийж гэрлээ асаасан юм. Бүх зүйл хэвийн байсан тул ядарсан болоод л зүүдэлж гэж өөрийгөө тайтгаруулаад арай хийж унтаж билээ.. Дараа нь бас энэ зун нэг амралтын өдөр гэртээ унтаж байв. Нэлээн их унтаад үд дунд сэрсэн хэдий ч дахиж унтмаар санагдаад цаг хараад унтахаар хөнжилдөө тухаллаа... Гэтэл бас л нэг их удалгүй амьсгал авч чадахгүй хоолой бачуурч биеэ хөдөлгөж чадахгүй гар хөлөө өргөж дийлэхгүй тэр ч байтугай нүдээ нээж чадахгүй байлаа.. Сэрэх л хэрэгтэй сэрэхгүй бол болохгүй гэж хичээж байтал байдал бишдэж орны толгой дээр хэн нэгэн ирэх шиг болж улам их айж босохоор илүү их хичээж байсан ч нэмэр болсонгүй. Миний орыг толгой талаас нь газраас хөндийрүүлэн өргөөд байв.. Орилж хашхирах гээд ч хоолой гарсангүй... Аргаа бараад ухаанаа алдахгүй байхыг хичээн чимээ чагнаж хэвтгэл ор хэвийн байрлалдаа орсон ч би босож чадахгүй байлаа... Мөн л хэсэг хугацааны дараа орыг маань дахин газраас хөндийрүүлээд байв... Айсаар л .... босох гэж хичээсээр л .... Гэтэл гэнэт маш хүчтэй амьсгаа аван босож иртэл хамаг бие усан хулгана болтлоо хөлөрсөн байсан бөгөөд унтахаар хэвтэхдээ харсан цаг зөвхөн 1 л минут өнгөрсөн байхыг хараад нүдэндээ ч итгэсэнгүй... Ах руугаа залгаж болсон явдлыг хэлтэл ямар аймар юм бэ? Зарим тохиолдолд хүний зүрх түр зогсох үед тийм явдал болдог талаар уншиж байснаа хэлээд за за одоо тайвшир үхэх нь байна ш дээ гэж билээ... Би ч айсан жигтэйхэн болохлоор намайг аргадаж тэгж хэлсэн ч байж болох юм гэж

бодож байсан юм.

Одоо болтол тэдгээр явдлын учрыг олдоггүй юм. Мэддэг зүйл байвал хэлээрэй.

### **Өөрт тохиолдсон нэгэн явдлыг бичихээр шийдлээ.**

Энэ явдал намайг 3 билүү 4-р ангид байхад болсон юм. 10 жилийнхээ сургуульд ангиа угаагаад өдөр ордог, дээрээс нь өвөл байсныг хэлэх үү гадаа харанхуй болчихсон сургууль дээр хүн амьтан үзэгдэхгүй байсан юм. Хамаг юмаа хийж дуусгачхаад ангийнхаа үүдний ойролцоо байдаг 00-н өрөөнд орж гараа угаах санаатай орсон чинь нэг хөгшин цэвэрлэгч буланд зогсож байна. Эхлээд тоосон ч гүй угаалтуурны урд очоод гараа угааж байгаад толинд хартал нөгөө эмэгтэй алга болчихсон байдаг байгаа. Хүн гарч явж байгаа сонсогдоогүй татаж байсан тамхиных нь угаа хүртэл үнэртээд би гэдэг хүүхэд айгаад эргээд харсан түрүүнийхээ зогсож байсан газраа намайг хараад л зогсоод байна би айсандаа буцаад толь руу хартал бас л толинд харагдсангүй. Нөгөө сүнс гээч нь энэ юм байхдаа гэж бодоод яахаа мэдэхгүй зогсож байгаад зугтах санаатай жоохон хөдөлсөн чинь юу болсон гээч. Нөгөө муу эмэгтэйн толинд тусах дүрсийг би өөрөө таглаад зогсчихсон тэр эндээ ганцаараа айгаад байж байдаг байгаа. Тэгээд л тэр эмэгтэй намайг гайхаад тасралтгүй хараад байсан юм билээ. 00-с гарч ирчхээд баахан инээд хүрсэн гэж.

\* \* \*

### **За би нэг юм бичдэг юм уу даа.**

Одоогоос 3 жилийн өмнө болсон явдал нөхөр бид 2 верхэж эхлээд удаагвй байлаа. Тэгээд хамт л байж байвал зутарсан ч хамаагвй хөллөлцөөд л гвйгээд байна шvv дээ. Нэг өдөр гадаа хвйтэн байсан болохоор 13-р хорооллын нэг орцод орлоо. Бас болоогвй ээ " Ноцтой мэдээ " гээд сонин аваад орсон юм. Тэгээд бид хоёр 13 давхрын дунд шатан дээр суугаад хамтдаа аймшгийн өгvvллэг уншиж байлаа. Тэгсэн гэнэт манай хvний царай нь сонин болсноо л ум хумгвй гаръя гээд л лифтэнд суулаа. Тэгсэн лифт доошоо явж байгаад гэнэт гацаад гэрэл нь мааслаад л удалгвй лифт хөдөлж ашгвй тэр орцоос гарсан. Тэр ведээ манай нөхөр надад юу ч хэлээгвй. Сvvлд шалсаар байгаад хэлvvлэхэд намайг аймшгийн өгүүллэг уншиж өгч байхад нөхрийн маань шилэн хvзvvнээс нэг гар бариад авсан гэсэн. Гайхаад над руу хартал миний цаад талын төмөр сараалжны цаанаас нээх сонин эмх замбараагвй сонин нvvртэй хvн харж байсан гэсэн. Ер нь энд тэндхийн орцод ороод дэмий юм байна лээ шvv ард тvmээн.

\* \* \*

Манай найз Бат-д ( Б гэж товчлов ) болсон зүйлийн талаар ярья. Энэ явдал болоход манай найз 13 настай байлаа. Манай найз чөтгөр шулам гэгчид огт итгэдэггүй нэгэн байлаа. Бид харанхуй шөнө явж байтал араас нэг хүн бид 2-г дуудлаа бид гайхаад очтол нэг эмгэн "хүүхдүүд минь 200 төгрөг өгчих эмээ нь настай хүн гэр лүүгээ явах ёстой" юм гэв. Б угийн хүнд тусалдаг өрөвч хүүхэд байсан тул автобусныхаа 100 төгрөгийг өгөөд өөрөө мөнгөгүй үлдэв.(тухайн үед хүүхэд 100аар суудаг байсан) Би үг нь бүхэл 10000тай явж байсан тул өгөх мөнгө байхгүй гэж хэлэхэд та хоёр сайнаа үзэхгүйдээ гээд есөн шидээр хараагаад яваад өгөв. Бид хоёр гайхаад Б намайг хүргэж өгөөд гэр лүүгээ явлаа. Маргааш нь анги дээр очиход Б

ирээгүй байв. Тэгээд хичээл дуусахын алдад Б-гийн ээж нь ирээд багштай юм яриад багш бүр хачин царайчилчихсан зогсоод байв. Ангийнхан ээжийг нь гарсны дараа юу болсныг асуухад Б машинд мөргүүлээд хөлгүй болсон гэв. Үүнийг сонсоод бүгд цочирдоход би яах гэж мөнгө харамлав даа гэж бодсон. 10000 төгрөгөөс болоод найзыгаа хөлгүй болголоо гэж өөрийгөө бруутгасаар байгаад өдийг хүрч та нарт нууцаа ярь лаа. Үүнээс хойш би шулам байдаг гэдэгт 100% итгэдэг болсон.

\* \* \*

Манай ахад тохиолдсон нэгэн аймшигт явдлыг та бүхэнтэйгээ хуваалцахаар шийдлээ. Ах маань ачаа тавар зөөдөг юм л даа. Нэг КАМАЗ-тай нэг 30тай юм. Нэгэн өдөр үл таних залуу ахад "мөнгө хөлсийг чинь гомдоохгүй өгнө нэг хэдэн жоохон юм Дорноговь луу хүргээд өгөөч" гэв. Ах ч дуртай аяа зөвшөөрч жоохон юм бол 30 араа явчихья гэж бодов. Маргааш өглөө босож цай хоолоо идэж хэрэгцээтэй зүйлсээ баглаж аваад 30аа асаах гэтэл ассангүй хий ПАР ПАР хийн л дуугарав. Ахын 30 КАМАЗ-аас бага бензин иддэг тул ах 30аараа явна гэж зүтгэсээр байгаад арай хийн асаан замдаа гарав. Тэгж асаах гэж зовсоор 5н цаг болов. Өвөл байсан болохоор бараг харанхуй болж байв. Ганцаараа болохоор уйдаад 22ийн товчоон дээр зогсож кассет авж замдаа дуу сонсон явав. Тэр үед 6:30 болсон байв. Төв аймаг даван цаашаа 100КМ явж байтал гэнэт дуу нь гацаж паржигнаж тасалдан сүүлдээ алга болов. Тэр үед 9:00 болсон байлаа. Ах ч янзлахыг хүссэнгүй цаашаа явав. Төд удалгүй шороон зам луу оров. Шороон замд ороод 30КМ явж байтал өнөөх ямбий асаж унтраад байсан машин нь таг болов. Тэр үед 10 болоход 10 минут дутуу байв. Ах за хэрэггүй л шуналдаж бага иддэг машинаа уналаа хэмээн бодон кардаанаа татан гарч шалгав. Бүх юм нь зүгээр байв. Тэгтэл нэгэн нялх хүүхдийн уйлах дуу сонсогдов ах ч гайхан бодлогоширч юун хүүхдийн уйлах чимээ байдаг билээ гэж бодон эргэж харвал тээр нэг цаана зам дээр цагаан өлгийтэй хүүхэд байх нь тэр ээ.... Ах золтой л ухаан алдсангүй хурдхан шиг кабиндаа суулаа. Копутаа хаахаа мартсан тул урд юу болж байгааг харж чадсангүй. Сэмээрхэн хаалгаа онгойлгож урагшаа хартал нөгөө өлгийтэй хүүхэд чинь алга болсон байлаа. Ах гайхан яах учраа олохоо больсон юм. Бараг 10 минут бодож суугаад нэг бүсээ чангалан, хурдхан шиг копутаа хаан эргэж кабиндаа орох гэтэл юу харсан гэж санана. 100 метр-н зайтай байна уу даа? нэгэн зэвхий царайтай урагшаа хамаг үсээ унжуулан 2 нүд нь хүүхэн хараагүй амнаас нь шүлс нь гоожсон эмэгтэй муухай орилон ах руу давхив. Ах ч айн бушуухан кабин лугаа орон суутал яг ардаас нь нөгөө эмэгтэй чинь ПАД хийтэл хаалгыг нь хонхойлготол нь цохив. Ах сандран түлхүүрээ зоон нэг эргүүлтэл ашгүй асан ах давхин алга болов. Сүүлд сонсох нээ тэрүүгээр шөнө орой явсан машинуудыг албаар зогсоож тэр нялх хүүхдийг өгөөш болгож байгаад нөгөө эмэгтэй чинь барьж иддэг гэж сонссон юм...

Замд явах аюултай, говиудын зам бүүр аюултай.....

\* \* \*

**Би шинэ гишүүн байгаа юм аа өөрт тохиолдсон зүйлээ сонирхуулья.**

Манай эмээгийнх Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ялбаг гэх газар амьдардаг. Би зуны амралтаараа эмээгийн дээ очиж амарсан юм. Эмээгийн ойролцоо 2,3 хан айл зусдаг байв. Нэг өдөр манай ард талын айлын эмээ өнгөрсөн. Орой нь манай ах хураастай байгаа ор хөнжлөө

оролдож байснаа "энэ дотроос нөгөө эмээ чинь гараад ирвэл яа хуу"гээд тоглоод байв.Эмээ маань үхсэн хүний ясыг битгий өндөлзүүл гэв.Бид унтахаар хэвтэцгээлээ би жоохон байсан учир эмээтэйгээ унтлаа.Шөнө дундын үед миний гэдэс өвдөөд эмээд хэлтэл түрүүлээд гарч бай эмээ нь араас нь гаръя гэв. Би босоод нүдээ нээгээд хартал аавын минь эмээд хийж өгсөн сандал дээр урд орой өнгөрсөн эмээ аягатай цай барьцан сууж байсан. Би айгаад эмээг дуудах гэтэл миний хоолой гарахгүй орилох гэтэл дуу ч гарахгүй үнэхээр их айчихсан байсан. Хөнжилдөө шургаад л арай гэж өглөө болгосон энэ тухайгаа эмээд хэлэхэд надад итгээгүй. Үнэхээр надад тохиолдсон явдал шүү.

\* \* \*

### **Өөрт тохиолдсон нэгэн явдлыг сонирхуулах зорилгоор нэмэлт хачиргүйгээр бичлээ.**

2004 он Хятадын далай эргийн нэгэн хотод оюутан байлаа. Ихэнх Монгол оюутнуудын жишгээр цагаан сарын амралтаар нутагтаа сар гаран амарчхаад буцсан юм. УБ-с Замын-Үүд үрүү 1 хоног, Замын-Үүдээс Бээжин 1 хоног, Бээжингээс өөрийн сурдаг хот руу 1 хоног нийт 3 хоног хүнд чемодан чирсэн аялал хийсэн. Ганцаараа явсныг ч хэлэх үү ядарч үхэх шахсан амьтан үүрээр дотуур байрандаа очлоо. Өрөөний хамтрагч япон залуу амралтаас эргэж ирээгүй байсан тул нутаг буцахдаа дэлбэлээд орхисон өрөөгөө цэвэрлэхдээ унтахаар хэвглээ. Үүр цайж байсан болохоор хөшгөө хаачихад орондоо орон хэвглээ. Яг зүүрмэглэх тэр агшинд хүн хаалга тогших сонсогдлоо. Нойроо харамлаад хаалгаа нээхгүй дээ гэж бодоод, нэг бодлын зүүдлээд ч байгаа мэт санагдаж байхад дотроосоо түгжээтэй байсан хаалга онгойгоод хаалттай байсан цонхноос салхи нэвт үлээж хөшиг хийсэх шиг санагдахаар гэнэт өндийтөл хаалга цонх хаалттай байхаар сонин зүүд вэ ухааны юм бодогдоод эргэж хараад хэвтээд нүдээ аниагүй байтал орны хажуу талаас яах аргагүй хүн босож ирээд хана руу хараад хэвтэж байсан миний орон дээр сууж байгаа нь амьсгалах болон хувцасных нь чимээ, орон дээр хүчтэй сууж байна зэргээс яалт ч гүй хүн. Айх битгий хэл юм бодож ч амжилгүйгээр хэвтсэн чигээрээ хагас өндийгөөд эргээд хартал жинхэнэ шоконд орсон доо. Нүд болон толгойг нь л харсан. Тэр шар ч юм уу ногоон ч юм уу нүд цоо ширтсэн нүд,, жирийн хүний толгойноос нэлээдгүй том толгойтой хөгшин Европ царай миний нүүртэй бараг тулчихсан байсан тэр мэдрэмжийг одоо ч мартаагүй. Хааяа бодохоор нүдэнд харагдаад нруугаар хүйт оргидог юм. Тэр нэгэн зүйлтэй ширтэлцэж хэсэг хугацаанд шоконд ороод гараад зугтчихсан байсан юм. Хагас жил амьдарсан өрөөнд урьд нь юу ч болж байгаагүй. Хүнд яриад итгэхгүй байх гэж бодоод зүгээр өрөөгөө солиулах хүсэлтээ өгчхөөд тэр өрөөндөө дахиж 2 хоноод өрөөгөө сольж билээ. Нөгөө хүний царай нүдэнд харагдаад гэрэл зурагт 200 унтраалгүй 2 хоносон доо. Миний байсан тэр өрөө дотуур байрны дээд давхарт дуу чимээ бага хэсэгт байдаг байсан юм. Тэнд дахиад 2 хоног байхад шөнө унтахдаа зурагтынхаа дууг хаачих юм бол хачин ойлгомжгүй хэлээр хүмүүсийн шивнэлдэж байгаа нь сонсогдоод унтуулахгүй. Зурагтынхаа дууг үл ялиг чангалахад тэр дуу хоолой сонсогдохгүй болж байгааг хэд хэд туршилт хийж өөртөө нотолсон доо.

Сүүлд энэ явдлыг учир мэдэх хүнд ярь өгөхөд бүх зүйл ерөнхийдөө тодорхой болсон доо. Тэр хүний тайлбарласнаар надад мэдэгддэггүй байсан болохоос тэнд хоргодсон ямар нэг зүйл байсан. Хүнд төдийлөн гай болоод байдаггүй. Харин цагийн эрхэнд хүч суудаг. Бүүр биетэй болох ч тохиолдол байдгийг биелсэн чөтгөр гэдэг юм. Ямар ч буг чөтгөр өөрсдийн хүч чадал

их бага байдаг бөгөөд хүн ч гэсэн өөрийн гэрлэн биеэр тэднээс хамгаалагдсан байдаг. Харин намайг замын турш ядрах үед хамгаалалт бас дагаж муудсанаас болоод бусдаасаа арай илүү хүчтэй нь надад харагдсан гэж тайлбарлаж өгсөн юм.

Эцэст нь сонирхолтой байх болов уу гэж хэлэхэд тэр өрөөний хамтрагч япон залуу шөнө унтдаггүй Анийм үзэж хоноод өдөржин хичээлдээ ч явахгүй унтаж цагийг өнгөрөөдөг залуу байсан нь өвлийн амралтаар яваад эргэж ирээгүй. Бид 2 элдвийг ярьж зарим шөнө цуг Аниймддаг байсан тэр үед надад хэд хэдэн удаа хэлэхдээ, манай дотуур байранд, бүүр манай өрөөнд чөтгөр байдаг. Би багаасаа чөтгөр харж чаддаг байсан болохоор айдаггүй юм. Цагаан хувцастай эмэгтэй хүн, бас том толгойтой шар үстэй орос хүн хаалганы хажууд байна гэж ярьчаад намайг эв гүйцэхээр шоолоод байдаг байсан нь нэгийг бодогдуулдаг шүү. Энэ явдлаас хойш ер нь ирээд бариад авахгүй л бол юунаас ч байсан айгаад байх нь дэмий зүйл юм байна гэж бодох болсон доо.

Энэ бүлгэм надад их таалагддаг ийм идэвхтэй бүлгэм өөр байхгүй байхаа. Үргэлж сонин содон өгүүллэгээр чих дэлдийлгэдэгт их баярладаг. Ингээд өөрт тохиолдсон түүхээ өрнөө.

Тэр үед би 5 орчим настай л байсан байх. Хөдөө зун үе үе очиж хамаатны да зунжингаа хүүхэд л юм аар саар балчирхан биендээ таарсан ажил хийгээд байдаг байсан надад хамгийн хэцүү нь хонин ий хашаа малтах байлаа хамаг хүчээрээ малтийшүүдээ тэр үедээ л нэлээн түүртдэг байж билээ. Манай гэрийн хойд талд томоо гэгч нь өндөр шугуй модтой уул бий би тэр уулыг одооч мартажгүй байх ах эгч нар дагуулаад л гардаг сан. Нэг өдөр мөнөөх л адил ууланд гарч гүзээлзгэнэ түүхээр гарах болов мэдээж хэрэг сав суулга ний юм авч уул өөд мацлаа да төд удалгүй ойд гүнд орж түүж эхэллээ. Бид хэд ч бөөнөөрөө уралдаж түүцгээгээд л савныхаа хэмжээгээр хэн нь их түүснээ шийдчихнэ. Тэгж түүж байтал нэг мэдэхэд би ганцаараа хоцорсон байлаа бага байсан болохоор айж нөгөө хэдийгээ хайж хамаг хурдаараа гүйлээ байдаггүй шүү бүр дуу ч сонсогддоггүй тэгээд арай хийж нөгөө хэдийнхээ барааг холоос харж ямар ч байсан тайвшраад зүгээр болтол гэнэт хойно нэг зүйл дуугарах аятай намайг дуудна. Эргэж хартал хэн ч алга нүдэнд нэг зүйл торох шиг болоод уул өөд хартал надаас холгүй хэн хэдхэн модны цаана нэг толгойгүй хүн мод налан сууж байна. Тэр хүн эрээн сорочкон цамцтай ажлын гэмээр хар өмдтэй харин ямар ч хөдөлгөөнгүй суух нь тэр. Тэгтэл тэр зүйлээс би ерөөсөө айгаагүй гэтэл гэнэт араас хөөш гэхээр гайхаад эргээд хартал ах зогсож байна. Ахаас тэр хүн хэн бэ ? гээд долоовор хруугаараа заатал ах юу ч олж харахгүй байгаа шинжтэй явья гэхээр нь тоох ч гүй дагаад явсан. Төд удалгүй бид уулаас бууж гэртээ харилаа орой болсон тул унтахаар хэвтэцгээлээ. Яг ид унтаж байтал гэнэт сэрчихлээ тэгсгээд тоолгүй унтах гээд нүдээ аньтал гэнэт хүн эрэгтэй хүн дуулж эхэллээ дуун бүр холоос сонсогдох хэрнээ маш тод сонсогдоно дараа нь нэг хүүхэн учир зүггүй инээж гарав энэ чимээ яг нөгөө уулнаас дуугарч байгааг би маш сайн мэдсэн ялт ч гүй ой дотроос гарч байгаа нь илт тэгтэл нөгөө эрэгтэй инээж эхэлсэн дараа нь эмэгтэй нь уйлаад л эрэгтэй нь орилоод учир нь үл ойлгогдох чимээ гарсаар би айсандаа чихээ таг даран хэвтсээр унтаж орхижээ нэг мэдсэн сэртэл өглөө болсон юм шиг гэр дотор маш гэрэлтэй байсан бүр гэрийн хана нэвт гэрэлтэж байсан бусад маань тоох ч үгүй унтах нь их хачин яг тэрнээс юу болсныг санадаггүй юм нэг мэдэх нээ ах намайг сэрээн чи халуураад байгаа юм уу хамаг хөлс чинь цуггачхаж гэж билээ. Одоо санах нээ зүүд биш гэдгийг сайн санж байна. Сүүлд хүнээс сонсох нээ хүүхэд морь хоёр сүнс хардаг гэж сонссон үнэний ортой л байх.



\* \* \*

## **Хүмүүс болсон явдлаа яриад байна. Би ч бас нэг өөрт тохиолдсон явдлаа ярья.**

Тэр үед би 4-дүгээр ангид байсан юм. Манайх Төмөр Замд байдаг байлаа. Нэг удаа найзынхаа байдаг нэг дээр үеийн шар байр луу очлоо. Тэгсэн тэнд нэг 80 орчим насны өвөө хайрцагтай юм бариад арай гэж өргөж байлаа. Тэгээд би тэр өвөөд:

-Өвөө би танд тусल्या гэж хэлсэн.

Тэгтэл тэр өвөө над руу харж сонин инээснээ өнөөх хайрцагтай юмаа газар тавилаа. Тэгээд би тэр хайрцагтай юмыг өргөтөл нэлээд хүнд байлаа. Тэгээд л би нэг л мундаг хүн "Би энийг арай ядан өргөж байхад энэ хөгшин хүн яаж өргөдөг юм. Хүүхдүүд нь ямар арчаагүй юм хөгшин настай хүнээр ийм юм өргүүлээд..." ухааны юм бодоод л нөгөө өвөөг дагаад л орц руу нь орчхов. Тэгээд өнөөх өвөөг дагаад дээшээ явах гэтэл нөгөө өвөө дахиад л хачин инээснээ дээшээгээ хөгшин хүнд баймааргүй тийм их хурд, хүчээр дээшээ гүйлээ. Би өнөөх өвөөг дагаад л гүйсэн тэгтэл тэр өвөө намайг өшиглөж унагаснаа:

-Би чамайг өөрийн туслах... үгүй ээ өөрийн чөтгөрийн туслах болголоо. Үхдэл болсныхоо дараа ирээрэй гэсэн. Тэгснээ гэнэт нөгөө өвөө утаа шиг л замхарсан. Тэгээд би айснаасаа болоод нөгөө хайрцагтай юмыг нь шидэж хаячхаад зугтсан. тэр явдлаас хойш тэр хавиар ахиж ердөөсөө яваагүй. Энэ талаар бараг хүнд нээх ярьдаггүй. Бас одоо болтол шөнө заримдаа зүүдэлж яг сэрэхийн өмнө "Чи надад амласан шүү." гэж тэр өвгөний хоолой нь сонсогддог.

\* \* \*

## **Хэрэв тэр өвгөний тухай мэдэх бол надад хэлээч.**

Сайн байна уу би шинэ гишүүн байна аа. Би 2 жилийн өмнө Сэлэнгэ аймгийн Сайхан суманд очиж байхад надад нэг юм болсон юм аа. Би орой найз нартайгаа 2 цагийн үед гадуур явж байтал тэнд нэг дээр үеийн ганц муудсан хадагтай мод суваг дагаад ургасан байсан. Тэгээд бид нар тэр ний хажуугаар нь гарна. Найзындаа очоод 3 цагийн үед би нэг найзтайгаа явж байтал тэр ний хажуугаар нэг цагаан хувцас юм уу нэг сонин юм агаарт хөвөн явж байснаа тэр модон дээр очоод алга болсон. Тэгээд буцаад нөгөө хэддээ хэлээд маргааш өдөр төв орох болсон чинь тэр модноос өөр газраар тэр модтой холбогдсон сувгийн хажуугаар гарсан чинь ард нэг жоохон хүүхэд уйлаад нэг эмэгтэй хоолой дуугараад л. Дараа таньдаг ах нараасаа асуутал тэнд дээр үед айл байсан тэгээд усны үерт урсаад тэнд сүнс нь хорогдсон гэж хэлсэн. Тэгээд ер нь хамаагүй хадагтай ганц мод суваг дагаж явах аюултай юм байна лээ.

\* \* \*

Би бас нэг жилийн дараа төв аймгийн Батсүмбэр суманд ахындаа очиж амарч байгаад нэг хөрш айлын бандитай нь адуу манах санаатай орой бид 2 явган адуун дээрээ очоод намайг тэр за нэг морь бариад ав гэхээр нь морь барьж авчхаад адуугаа нэг тогтоочоод гал түлээд тамхи татаад сууж байтал тэр банди намайг энд унтаж болохгүй шүү энэ хавь жоохон гүйдэлтэй гээд тэгээд би аан за за гээд тоохгүй байж байгаад бид 2 нэг цэвэрхэн хадны

сүүдэрт унтахаар болж эмээл морио янзлаад галаа унтраачхаад хэвгсэн чинь бид 2 унтаад өгсөн байлаа. Орой би нэг босож бие засах гээд бостол энд тэнд юм дуугараад эвгүй тэгээд шээгээд буцаад унтсан. Дараа нь хэд хоног бие өвдөөд жоохон таагүй болоод хүнд үзүүлсэн чинь тахилгатай газар хонож гүйдэлд дайруулсан байна гэсэн. Ер нь хамаагүй хээр гадаа тэр тусмаа ууланд унтах осолтой юм билээ.

\* \* \*

Би амьдралдаа тоотой хэдэн удаа л сүнс харж үзсэн. Энэ чадвараа цаашаа хөгжүүлэе ч юм уу тэгж бодож үзээгүй ээ. Надад бас сүнснээс гадна чөтгөрийн гал их сонин санагддаг. 2 удаа тааралдсан юм. Эхнийх нь 7 билүү 6 жилийн өмнө Ховд аймгаас Увс аймаг руу аавтайгаа хамт 69 машинаар шөнө явж байсан юм. Тэгтэл нэлээн урд нэг гал гарч байна. Тэгэхээр нь хүмүүс гал түлж байгаа юм байхдаа гээд аавтайгаа сүрхий яриад л яваад байсан. Нэлээн явсан гэтэл тэр гал огтхон ч манай машинд ойртоогүй бас холдоо ч үгүй. Яг л анх харагдаж эхэлсэн зайтайгаа ижилхэн зайд яваад л байсан. Сүүлдээ аав чимээгүй явж байгаад амандаа тарни уншаад намайг нүдээ ань гээд машинаа унтраасан. Тэгээд байж байгаад би нүдээ нээтэл нөгөө гал байхгүй болчихсон байсан. Машинаасаа буугаад бие засчхаад машинаа харахад яг нэг эвгүй эгч газрын ирмэг дээр зогсчихсон байсан. Сүүлд нь чөтгөрийн гал бас ховстдог юм байна гэж мэдэж авсан.

\* \* \*

За найздаа тохиолдсон явдлыг бичье. 4 жилийн өмнө байхаа баргийн худлаа яриад тоглоом хийгээд байдаггүй найз маань надад нэг юм ярьсан юм. Манай найзын 2найз гэж юм юм хийж оролддог охид ууд байсан. Тэгээд тэр 2 цайз руу очоод нурсан балгасан дотор жаал тоглож байгаад гарсан гэсэн. Тэр оройноос хойш тэр 2ын бие муудаад нэгнийх нь гэдэс зүгээр байж байгаад л томроод хамт байхад нь хаалга нь савлаад ер нь сонин болоод ирж л дээ. Тэгээд манай найзтай уулзаад гэрт нь хэд хоног хамт байсан гэсэн. Тэгээд манай найзыг айлгаж гайхшруулсан даа. Надад хэлэхдээ найзыг нь дагаад байсан сүнс манайд үлдчих шиг боллоо гээд нэг утсан дээрх зургаа харуулсан. Тэр зурган дээр орон дээрээ өөрөө суучихсан цаана нь нэг хар зууван дүрс гарчихсан. Яг хувцасных нь шүүгээний урд тэр үед ямар урдаа камертай утас байсан биш. Зургаа авчхаад л харсан яг тийм хар дүрс надад зургаа харуулахад нь л итгэж байсан. Тэгээд тэр сүнсний гэдэс нь цус болчихсон том гэдэстэй эмэгтэй байсан уйлаад л уйлаад л байсан намайг дагаад л байдаг гэж надад ярьсан л даа. Манай найз баргийн юмнаас айдаггүй тоодоггүй байсан тулдаа гайгүй үлдсэн байх өө одоо ч үнэн гээд л байдаг.

\* \* \*

Сэлэнгэ аймгийн Номт-н амралтад 10жилдээ их зугаалдаг байж билээ. Сүүлд төгсөх жилээ зугаалахад амралтын газрын гэр нь дууссан битүү гээд бид цаашаа хилрүү тулж байгаад нэг том модны доор майхан саваа бариад дууссан. Тэгээд өдөржин тоглоод нар жаргахын алдад манай ангийн нэг хүүхэд бөө юм шиг байсан гэнэт онгод нь орж ирээд л хорхог чанаж байсан. Галаас цог атгаад тэр модноос уучлалт гуйгаад мөргөөд байсан. Тэгсэн гэнэт бид нар дээр ирээд шалгаад л байсан. Дараа нь юу болсныг тэр хүүхдээс асуусан чинь нэг хүн энэ модонд хутга зоож унасан боргоцойг гал руу шидэж шатаасан байна гэсэн. Тэгээд удалгүй тас харанхуй ч болоод буцаад нөгөө хүүхдийн онгод нь орж ирээд л яа яа гээд л ташуурдуулж

байгаа юм шиг унаад байсан. Бүх хүүхдийг том асар луу оруулаад мөргүүлээд суулгасан. Өөрөө асар тойроод биднийг уучлаарай зүгээр байлгаач гээд л би танд хэнийг ч өгөхгүй гээд л унаад байсан. Тэгээд жоохон байж байгаад явчихлаа. Одоо бүр хүчтэй ирнэ маш хүчирхэг савдаг байна гээд л ирлээ гэхэд гэнэт шуурга болоод асар нурах шахсан тэгээд шөнөжин залбирч суусан даа. Маргааш нь би ангийнхаа тэр хүүхдээс асуухад энэ мод бөөгийн шүтээн мод бас энэ уулын зүрх гэж хэлсэн.

\* \* \*

Эгчийн гэрт нь болоод байгаа зүйлийг ярьж өгөх гэсэн юм. Яг шөнө дунд 00:30 болохын алдад гэрийнх нь зүүн хойд талд хүн ноцолдоод байгаа юм шиг тэгээд байж байгаад гэнэт гэр цохиж маажиж самарддаг муухай муур шиг орилж хаяа ухдаг тэгээд яг 01:00 болохоор зүүв зүгээр ямар ч анир чимээгүй болдог сонин байгаа биз. Эгч минь яг 00:00 цаг болоход айж айдаст автдаг. Гэрийнхээ бүх юмыг хааж түгждэг. Өчигдөр орой 00 орчиход гэрийн зүг ирж явтал гэрийн яг хажууд хүний толгой шиг юм сүүтгэнээд байсан. Би зориг ороод очоод хартал хэн ч байгаагүй тэгээд гэрийн дотогш ортол эгч байдгаараа айчихсан гэрийн хажууд хүн байна уу гэсэн. Тэгсэн би яасан гэсэн чинь сая гэр самардаж самардаж чиний урдаа гүйгээд явчихлаа гэсэн тэгэхээр нь гар чийдэн авч гараад хойшоо тусгасан чинь ар нруугаар хүйт даагаад гар чичрээд үхтлээ айсан тэгээд ганга уугиулаад зүгээр болсон. Гэхдээ тэр зүйл яг 30минут үргэлжилдэг сонин зүйл.

\* \* \*

Та бүхэнтэй дөнгөж өчигдөр болсон явдлыг ярья. Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яамны нэгэн захиргааны дарга юм аа. Манай яамныхан Дундговь аймагт ажлаар явчхаад өчигдөр орой шөнийн 2цагийн үед тус аймагт очоод Мандалговь буудалд буулаа. Манай бусад захиргааны дарга нар жаахан сууя гээд бөөнөөрөө нэг өрөөнд орсон юм. Би ядраад байсан учраас өрөөндөө ганцаараа унтаад өглөө. Шөнийн 4 цагийн үед миний хажууд нэг хүн ирээд амьсгалаад байлаа. Би сэрээд хамт хонож байгаа Хөвсгөл аймгийн сав газрын дарга байна гэж бодоод эргэтэл маш өндөр толгойгүй миний цээжин дээр дараад авлаа. Би өндийх гэтэл 2гарыг барьж аваад тавьдаггүй бараг 5минут боллоо. Би тэр үед ийм юмнаас айж болохгүй гэж бодоод зайл би чамаас айхгүй байна гээд дотроо хэллээ. Яг тэр үед амнаас нэг ч үг гарч чадаагүй нүдээ аниад энэ бодит биш гэж олон удаа хэллээ. Тэгээд нүдээ нээтэл алга болсон байсан. Үнэхээр чөтгөр гэж байдаг юм байна. Би үг нь итгэдэггүй байсан гэтэл тэр буудалд бас манай нэг сав газрын даргад яг адилхан юм тохиолдсон байсан тэр шөнө. Өнөөдөр би ламаас Улаанбаатарт ирээд асуулаа тэгсэн чинь тэр эрэгтэй чөтгөр байна цээжин дээр дардаг нь эмэгтэй хүн хайж байсан гэнэ ээ. Өнөө өглөө тэр буудлаас гараад явах гэж байтал буудлын хүн нь байгаль орчны 30-аад дарга нар ирж хонолоо. Манайхыг мэдэхгүй ирсэн байна гээд утсаар ярьж байгааг манай Архангайн дарга сонссон байна лээ. Үнэхээр тийм аймар юм байдаг юм байна.

\* \* \*

Эгчдээ тохиолдсон явдлыг бичихээр шийдлээ. Манай эгчийнх Налайхад нэг хуучин сургуулийн байшинд байдаг байсан юм. Би нэг удаа очиж хоноход нэг л жихүүцмээр санагдаад шөнө ч тайван унтаж чадаагүй. Нэг давхар нь цоожтой байдаг байсан ба тэд нар

зөвхөн 2 давхарт нь л байдаг байсан. Өдрийн цагаар ч нэг өрөөнд нь ганцаараа ороход нуруу руу хүйт даагаад жихүүдэс төрдөг байсан. Тэнд байдаг хамгийн том өрөөнд нь баахан том толинууд байдаг байлаа. Би эгчтэйгээ хамт ажил хийдэг байсан юм л даа. Тэгээд нэг өдөр эгч маань маш их ядарсан царайтай ирэхэд би их гайхан асуухад өчигдөр шөнө найз залуутайгаа муудалцаад тольтой том өрөөндөө ороод ганцаараа хоночихлоо толгой дээгүүрээ хөнжлөө хучаад унтаад өгсөн. Гэтэл шөнө юм түжгэнэх шиг болоод халыг сэрээд тоохгүй буцаад унтаад өгсөн. Тэгсэн шөнө дунд хэн нэгэн хөнжлийг минь татсан. Би найз залуугаа юм болов үү гэж бодоод хартал нэг сэгсийсэн хар юм над руу хараад сууж байсан. Би маш их айж нүүрээ дараад хашхирсан гэж хэлж байсан бодохоос аймар санагдаад байдаг юм.

\* \* \*

Одоогийн амьдарч байгаа байрныхаа талаар та бүхэнтэй хуваалцмаар санагдлаа. Одоогоос 3 жилийн өмнө нүүж ирж байлаа. Манайх энэ барилгыг авчхаад ирж үзэхэд гал тогооноос өмхийрсөн мах үнэртэж байлаа би ч нээх юм бодоогүй тэг эс гээд л өнгөрсөн. Тэгээд энэ байрандаа засвар хийлгэхээр болов оо. Хамаатныхаа ах эгч хоёроор хийлгэсэн юм. Тэгээд засвар эд дундаа орж байсан юм даг. ШУТИС-ы хичээл эхэлсэн байлаа. 8 сарын сүүл үед л байсан. Би ханиад хүрсэн байсан хичээл дээрээ нэлээн халуураад гэртээ харьж чадалгүй шууд засвар хийж байгаа байрандаа хоносон юм. Тэгээд орж ирэв үү үгүй юү би хувцастайгаа үсрээд унасан. Харин тэр шөнө зүүдэлсэн зүүдээ би одоо ч санаж байна. Би унтаж байхдаа өрөөний тааз харсан. Тааз холдоод л байсан улам холдсоор тэгээд би хүмүүс юм ярьж байхыг сонссон. Миний талаар ярьж байсан би тэднийг харахгүй байлаа гэвч нэлээн олуулаа байгааг ярианаас төвөггүй мэдлээ. Миний толгой эргэж байлаа тэгээд л би дэмийрч эхэлсэн зүүдэндээ элдэв юм хараад нэг мэдсэн үүр цайж өрөөнд гэгээ татуулснаар би сэрлээ. Хичээлдээ явчхаад гэр лүүгээ харихдаа зүүдээ санахыг хичээж явсан юм даг. Тэд нар хэн байв юү ярьж байв гээд л толгойд юу ч орж ирсэнгүй. Хэсэг хугацаа өнгөрлөө засвар ч дуусаж бид нэг мөр нүүж орсон юм. Ээж маань гадаад руу ажлаар явахаар болж би 7 хоног ганцаараа үлдэхээр болов оо. Хөөрхий эхний шөнө ч яа хав шөнөжин дотадаж хонолоо юу ч мэдрэгдсэнгүй үд хүртэл унтаад сэрлээ. Ходоод руугаа юм чулуудчихаад зурагт үзсээр орой болголоо. Орой болсныг анзаараагүй байсан болохоор гэрт нэг л эвгүй зэврүүн санагдаад явчихлаа. Ямар сайндаа бүх гэрлээ асаагаад коридор луу нэлээн ширтэж суулаа за тэгээд унтах болж том өрөөндөө ороод гэрлээ унтраагаад хаалгаа түгжээд зурагтаа үзээд хэвтэж байлаа. Тэгсэн нөгөө өрөөний хаалга дуугардаг юм байна. Айгаад л явчихлаа за нөгөө сүнс чөтгөр нь байна даа гээд л бодож байлаа чимээ чагнаад хэвтэж байтал гал тогоонд шинэ авсан хөргөгч маань хуучин муу лисва шигээ л тачигнаж дуугараад л хүн балбаад байх шиг сонсогдоод байх юм. Би ч айсандаа зурагт үзсээр байгаад л үү цайлгасан. Айдас ч мартагдлаа нойрондоо ялагдаад яалт ч үгүй жаахан унтаж байгаад сэрлээ. Ер нь өдөр бол юмнаас айдаггүй болохоор байдгаараа л байлаа. Харин орой хамаатнаа дуудаж хамт хоносон. Бид 2 нийлэхээрээ аймшгийн кино их үзнэ ээ тэгж байгаад 3гэж байхад унтах гээд нүд анилаа. Тэгсэн нөгөө хөргөгч яг өмнөх өдрийнх шиг л дуугарч байна хүн цохиод байгаа юм шиг л. Хамаатандаа хэллээ сэрэх янзгүй л унтаж байх юм. Би өөрийгөө тайвшруулаад нэг мэдсэн өглөө сэрлээ босож ус уунгаа хөргөгчөө харсан хажуу талдаа баахан алгаар дарчихсан хээ үлдсэн байсан. Тэр явдлаас хойш би гэртээ ганга асаадаг болсон. Төд удалгүй манайхыг засаж өгсөн ах маань өвлийн хүйтэнд остож үхсэн олдсон юм даг. Одоог хэр нь манай найзууд манайхаас их айдаг жижиг өрөөнд юм дуугардаг гээд л. Ер нь өдөр ч бас л дуугарч л

байдаг. Хаалга өөрөө нааш цааш хөдөлнө. Ер нь би ганцаараа байхдаа орой л их жихүүцдэг байр сүүлдээ ч гайгүй болсон доо. Нохой авч тэжээсэн ойрдоо харин юм руу хуцаад шөнө гий наад байдаг болсон. Заримдаа шөнө 2-4 цагуудад өөрөө сэрчихдэг цагаа харахаар яг энэ цагууд л байж байдаг. Эргэн тойрноо харахаар юу ч харагдахгүй харанхуй заримдаа нэг суусан газраасаа ч хөдөлмөөргүй санагддаг шүү. Одоо ч дасчхаж дээ сая гэхэд л хөргөгч дуугарлаа аз болоход нохой маань дэргэд унтаж байна. Энд би ямар ч давс оруулсангүй ээ ирснээс хойш ийм л зүйл тохиолдлоо.

\* \* \*

## Гүйдэл

Орой бүрэнхий болсон байв хоёр морьтой хүн хөдөө хээр давхиж явтал гэнэт замд нь нэгэн явган хүн тааралджээ . Энэ эзгүй хээр газар гахай нүцгэн нохой явган хүн юу хийдэг билээ хэмээн нэг нь бодож амжжээ.Тэр гурав хоорондоо мэнд мэдэлцэхэд нэг нь таг дуугүй болчхов. Нэг найз нь өнөөх хүнтэй ярьсаар . Удсан ч үгүй тэд салцгаав. Тэр өдрийн оройноос хойш нэг найз нь галзуурч амиа хорлосон гэдэг .Харин хөгөө найз нь тэр хүнтэй мэндлэхэд амаар нь цаад уул нь нэвт харагдаж байсан учир юу ч яриагүй аж .Үнэхээр болсон явдал гэж саяхан нэг хүнээс сонссон юм. Тодорхой мэдээлэх сурвалжаас аваагүй ч болсон явдал гэдэгт бат итгэлтэй байна.

Манай эгчид тохиолдсон явдал. 90-ээд оны үед Хятад хүүхний зураг эд дэлгэрсэн байлаа. Эгч найзынхаа хашаанд тоглож байтал найзынх нь байшин дотор цонхны хажуу хананд нэг том Хятад хүүхний зураг байдаг байсан гэсэн. Тэгээд тоглож байгаад халыг хартал тэр зураг нь цонхон дээр тулсан байсан гэсэн. Тэр үедээ хүүхэд байсан болохоор нээх анзаараагүй тэгээд л хаясан гэсэн. Тэр зураг нь цагаан царайтай улаан руултай хар үстэй туранхай хүүхний зураг байсан гэнэ лээ.

\* \* \*

Найздаа тохиолдсон явдлыг оруулж байна. Сансар-н Tse-ийн ард шинээр нээгдсэн SPAN ресторанд саяхан болсон явдал юмаа. Найз маань оюутны амралтаар тэнд ажиллаж байсан юм. Эгчийнх нь нээсэн газар болохоор нээх оройтдоггүй эртхэн харьчихдаг байсан гэсэн. Гэтэл нэг өдөр яалт ч гүй оройтоод 11 цагийн үед ганцаараа үлдээд ах нь ирж авахаар болж. Манай хүн юм хумаа янзалж дуусчхаад нэг ширээнийхээ хажууд сууж байтал гэнэт эмэгтэй хүн чангаар орилоод ч байгаа юм шиг уйлаад ч байгаа юм шиг болсон гэнэ. Угийн хэрэггүйн болохоороо гадаа байдаг хажуу талын караокэноос сонсогдож байна гэж бодоод байтал гал тогооны өрөөнөөс нь сонсогдоод байсан гэсэн. Нэг тийм зовж шаналсан орилоон байснаа гал тогооны хаалгыг нь нүдэж эхэлсэн гэсэн. Чарлаад л балбаад л юм түжгэнээд манай хүн уйлаад айсандаа ширээн дээрээ өвдгөө тэврээд суусан гэсэн. 30-д минут өнгөрсний дараа гэнэт л таг болчихсон гэсэн ах нь 12-ийн үед ирээд ахдаа бүх болсон юмаа хэлээд маргааш өглөө нь бөө дээр очсон гэсэн. Бөө хэлэхдээ \*Ямар нэгэн юунаас зугтаж яваад золгүйгээр үхсэн эмэгтэйн сүнс байна, бусдад хүчин дүүлж нас барсан байна\* гэж хэлсэн байгаа юм. Урьд нь бараг балгас болсон байсан газар үйл ажиллагаа явуулж байсан бүх газрууд нь удаан тогтдоггүй байсан гэж найзаасаа сонссон юмаа та бүхэнд сонирхуулж байна. Сая 5дахь өдөр найзаасаа сонсоод нийтэлж байна.

\* \* \*

Анх хөдөөнөөс оюутан болж 1-р курс орж дэнжийн мянгад монгол гэр түрээслэн найзтайгаа амьдарч байсан юм. Оюутны амьдралд анх хөл тавьж байсан болохоор их сайхан санагдаж энд тэндхийн зүйлсийг эс ажиглан амьдарч байж дээ... Нэг шөнө 1өнгөрөөд 2болохын алдад хашааны хаалга онгойж нохойнууд хуцаад нэг юм хөөгөөд байх шиг болохоор нээх их ч тоосонгүй угаасаа хашааны хаалга нохой онгойлгоод байдаг болохоор нь тоохгүй унтаад өглөө. Тэгээд маргааш орой унтаж байгаад шөнө дунд хар дараад сэрсэн чинь нохойнууд бас айхтар хуцаад нэг л сонин чагнаад хэвтэж байтал нээх сонин хүн гэхэд хөнгөхөн хөлтэй нохой гэхэд гэрийг гурав дөрөв тойрно гэж байхгүй. Аймар санагдаад найзыгаа сэрээх гэсэн нойроо харамлаад сэрсэнгүй тэгээд би ч айж байгаад унтаад өгч. Маргааш нь амралтын өдөр болохоор телевиз үзэхээр хажуу айлдаа ороод юм ярьж байгаад нэг мэдэхэд л сүнс сүүдэр яриад ахалсан гэтэл манай хажуу талын хашаа сүнстэй гэж палхийтэл хэлдэг байгаа. Юу худлаа яриад юм хүн айлгаад гэсэн чинь нээрээ гэж ирээд баахан юм ярьсан. Тэр өдрөөс хойш шөнө бараг л сэрэхгүйг хичээн чихээ таглаж унтдаг болсон. Нэг өдөр манай хажуу талын эгч дуудаад өнөөдөр манайд хоноорой гэхээр нь яагаад гэж асуутал 3сарын 13нд шөнө дунд нэг эмэгтэй хүн нярай хүүхэд тэвэрсээр арын дэлгүүр болох БАЦЭДЭС дэлгүүрийн тэндээс хажуу талын хашаан дундуур гиншин уйлж нярай хүүхэд нь ярагласаар явдаг гэв. Энийг сонсоод юун буцаж гэртээ орох мантай шууд тэндээ хонохоор болов...

\* \* \*

Би сайн санадаггүй юм аа. Намайг их жаахан байхад болсон юм. Өвөө маань хэвтэрт байсан. Манай хамаатнууд бүгд ирчихсэн өвөөг асарч сувилаад л байсан. Ээж маань тариаг нь тарьдаг байсан шиг санагдаж байна. Гэхдээ хамгийн их санаж байгаа зүйл нь шөнө харанхуй болж би өвөөгийн дөө орж ирээд суув. Өвөө маань надад их сайн байж билээ. Миний араас ээж аав 2 орж ирсэн тэгээд бүгд хоолоо идчихээд унтаж байтал яагаад ч юм би сэрчихсэн. Би сэрэхээрээ өвөөгийнхөө өвөрт орж унтдаг зуршилтай байсан юм аа. Тэгээд л сурснаараа орноосоо босох гэтэл өвөөгийн маань орны хажууд нэг цагаан хүн шиг юм зогсож байсан. Ямар ч үсгүй хувцасгүй цав цагаан нүд нүүр ам чих гэх юм байхгүй. Тэгээд би айсандаа орноосоо босолгүй хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд нам унтчихсан. Өглөө сэрэхэд намайг бас миний эгчийг хажуу айлд оруулаад унтуулсан байсан. Тэгээд ер нь би дахиж өвөөгөө хараагүй ээ. Одоо бодоход аав ээж 2 өвөөг үхсэнийг мэдээд бид хоёрт харуулахгүй гэж айлд оруулж хэвтүүлсэн юм билээ. Гэхдээ тэр цагаан юмны талаар би гэрийнхэндээ яагаад ч юм хэлээгүй. Хэлэх гэхээр яагаад ч юм ам үдэгдсэн юм шиг болчихдог байсан.

# Гуравдугаар бүлэг

## Сүнсэнд дарлуулах

Яг юу гэж эхлэхээ сайн мэдэхгүй байгаа ч энэ явдлыг гэх мэт асуугаад л байсан. Харин Здахь тохиолдол нь 5 сарын сүүлээр болсон шиг санагдаж байна. Найзындаа хонох болсон юм бөөнөөрөө байсан болохоор хөгжилтэй л унтах завгүй л хөгжилдөж байлаа. Гэтэл нэг маань сүнс дуудах уу гэж хэлээд бид хэд сүнс дуудахаар болов оо. Өрөөндөө ямар ч гэрэл оруулахгүй болгоод нэг лаа асаагаад лааны дөлөнд хутган дээрх цус дусаагаад барьж эхлэв. Удалгүй цусан хар үнс болоод муухай үнэр гарч эхлэв. Тэгээд би хутгыг аван дөлөн дээр барьсан юм. Нөгөө хэд маань аймшгийн зүйл ярьж эхэлсэн. Би өрөөг тойруулан харж байсан юм. Тэгтэл өрөөний буланд байрлах хувцасны өлгүүрт эгч минь зогсож байсан. Би эгчийгээ хараад шууд бие маань татаад л сууж байсан сандлаасаа унаад өгсөн. Тэгээд ухаан алдаад сэргэтэл миний футволка нойв нойтон амнаас үнэртэй ус амтагдаад(намайг сэргээхийн тулд үнэртэй ус цацсан юм байна лээ)биеэр хар хөлс урссан юм ухаан орсон. Тэрнээс хойш одоо хүртэл зүгээр байгаа. Харин ээжийн ярианаас сонсоход манай эгч үхэхийнхээ өмнө надтай уулзахыг хүссэн гэсэн. Тэр үед би дөнгөж 1 настай байсан. Харин 2 настай байсан үед би хүүхдийн хөлд оруулдаг манежтай явж байгаад урагшаа толгойгоороо унаад эмнэлэгт очсон гэдэг. Тэгээд нэг сар гаруй ухаангүй хэвтсэн гэсэн. Тэгээд манай ээж аав хүнд үзүүлсэн чинь талийгаач эгчийн минь сүнс нь хорогдсон байна гээд тэр хүн сүнсийг нь явуулсан гэдэг. Одоо бодох нээ сүнс гэж байдаг юм болов уу эсвэл миний хий хоосон төсөөлөл юм болов уу.хуваалцъя гэж бодлоо. Аавын маань эгч 2000 онд төрөлтөөс болоод өөд болсон юм. Тэрнээс хойш 15 жилийн дараа буюу энэ оноос хойш би эгчийнхээ нүүр царайг 3 удаа харж байна. Хамгийн анх 1-р сарын нэг шөнө 2 цаг өнгөрөөгөөд гэнэт сэрсэн. Тэгэхэд гадаа сарны гэрэл туссан салхитай шөнө байсан. Тэгээд яагаад ч юм бэ цонхоороо харх гээд л өндийтөл яг цонхны баруун доод буланд эгч минь над руу хараад зогсож байсан. Тэгээд л өглөө сэрсэн хэд хоног тэр тухайгаа бодоод яаж унтсанаа огт бодоод олохгүй хэд хоног өнгөрөөсөн. Тэгээд бүр мартагдаж байсан юм. Харин 2 дахь удаа харсан нь 4 сарын 20 байсан. Найзүүдаараа нийтийн байранд хоносон тэр шөнө болсон. 3 цагийн алдад найзүүдтайгаа хөзөр тоглоод сууж байсан юм. Тэгээд би хана налан сууж байсан яг тэр үед манай 2 найзын дунд эгч миний өөдөөс хараад сууж байсан. Намайг тас гөлрөөд сууж байсан. Миний гар салганаж удалгүй бүх бие минь татганаж шууд л унасан. Ухаан ороод хартал найзууд минь намайг тойроод зогсож байсан. Бүгд чи зүгээр үү? юу болсон бэ?

\* \* \*

**За би өөртөө тохиолдсон нэг юмыг бичье .**

Одоогоос 4н жилийн өмнө аав.ээжтэйгээ аав ээжийнхээ найзуудтай нь Хөвсгөлрүү явсан юм. Тэгэхэд яг 4гэр бүл явж байсан. Гэр бүл тус тусдаа 4н машинд явж байсан.Машины цуваа тасрах аль эсвэл бруу замаар явж төөрөхөөс сэрэмжилж машин тус бүрд нэг нэг станц байрлуулсан. Бид ч Хөвсгөлийн Хатгалд байрлах нэгэн амралтын газар 14 хоног сайхан амраад ямар ч асуудалгүй буцаж байсан. Тэгээд замдаа нэг хоног амрахаар болоод Булганы Хишиг Өндөр гэдэг газар өнжөөд маргааш өглөө нь эрт хөдөлсөн юм.Тасралтгүй давхисаар

байгаад 22ийн товчоон дээр зогсоод овоо тойрчихоод.эцэг эхчүүд(томчууд) 1юм задлаад тойруулсан. томчууд ч ганц юмандаа нэлээн халсан байсан. Тэгээд яг хот руу орох гэж байхад замын голд нэлээн өндөр шар малгайтай хүүхэд зогсож байсан.яг тэр үед аав бид 2 л сэрүүн байсан. Манай машин хамгийн урд явж байсан болохоор хойноос явж байсан машинууддаа замын голд хүн байна болгоомжтой байгаарай гэж станцаараа хэлсэн. Гэтэл гэнэт станцаар нэг эрэгтэй хүн орилж хөнөөе наана чинь хүн гэж орилсон. Тэр үед аав машин барьж байсан болохоор аав шууд л жолоогоо нүдэн шанаагаа дэрлэн суусан. Тэгээд аав машинаас буугаад хартал юу ч болоогүй манай 3 машин араас эгнээд явж байсан аав гайхаад машинд эргэж суугаад станцаа шалгатал бидний тохируулсан долгионоос өөр долгион нэвтэрсэн байсан. Аав ч гайхаад нөгөө 3 машин дээрээ очоод сая замын голд хүүхэд зогсож байсан харсан уу гэхэд үгүй юун хүүхэд юу ч байгаагүй ш дээ гээд тоглоом болгож эргүүлэв. Тэгээд аав нэлээн сатаарсан бодлогоширч хот руу орж ирсэн. Тэгээд хотод ирээд аав бид2 уулаа яг 6 хоног яг адилхан зүүд зүүдэлсэн. Тэгээд бид 2 ярилцаад ээжид хэлсэн чинь ээж эхлээд итгээгүй. Аав бид2 яаж итгүүлэхээ мэдэхгүй хэсэг хугацаа өнгөрсөн. Гэтэл нэг шөнө би зүүдэндээ тэр шар малгайтай хүүхэдтэй зам дээр хамт зогсож байна,тэгээд тэр хүүхэд намайг зам руу түлхэж байна гэж уйлж сэрэхэд л ээж аав бид 2т итгэсэн. Аав бид 2 бүх зүйлийг ээжид хэлсэн. манай ээжийн дүүгийнх нь нөхөр бөө юм. Тэгээд ээж аав бид 3 ээжийн хүргэн дүү дээр нь очихоор болсон. Очоод бүх зүйлийг эхнээс нь ярьсан. Тэгтэл тэр ах тэгвэл наад яриад байгаа хүүхэд чинь өнгөрчхөж тэгээд ч төрлөө олоогүй сүнс байна гээд л аав бид 2г ташуураараа балбаж өгсөн. Хамгийн сонин нь аймар чанга цохиж байгаа нь мэдэгдээд байгаа хирнээ огт өвдөөгүй. Түшээ нь одоо болсон ахиж зүүдлэхгүй гэсэн. Тэгээд би гэртээ очоод усанд орох гээд хувцсаа тайлж байгаад нруугаа толинд хартал Ү үсэг шиг болоод улайгаад хөхөрчихсөн байсан. Ахиж тэр хүүхдийг зүүдлээгүй ээ. Тэр үед лав үнэхээр аймшигтай байсан.

\* \* \*

Группдээ байгаа юмыг уншихаар зарим хүмүүс янз бүрийн аймшгийн кино үзэж байгаад эсвэл уншиж байгаад элдэв юмтай тохиолдсон байх юм. Миний бодлоор яг айх үед өөртөө хар муу энергийг татдаг байх. Үгүй ч байж магад

Ингээд үүнтэй холбоотой өөрт тохиолдсон юмаа бас бичихээр шийдлээ хэхэ. За нэгэн сайхан тэнгэр цэлмэж нар гийсэн өдөр хичээл урьдынхаасаа эрт тарчхав. Манай оюутны ангийн найзууд ч ямар нэгэн сонирхолтой юм хийе гэсээр сургуулиас гарч алхлаа. Ярьж явсаар ямар билээ дээ монгол аймшгийн кино үзэцгээхээр боллоо. Сургуультай ойрхон байдаг тул Өргөө2 ороод хартал үзэх гэж байсан киноны билет дуусчихсан байлаа. Бид 3 ч хурдан алхахад яадаг юм энэ тэр гэж нэгнийгээ цохиж нүдэн инээлдсээр доош буулаа. Гэнэтхэн надаа 1 гоё санаа төрөөд явчхав. Нөгөө 2ийгоо дуудан аймшгийн юм ярихаар шийдлээ. Өргөө 2-ийн 1 давхарт байдаг хүлээлгийн суудал дээр тухалж сууцгаагаад би ч утсаа асаан группрүүгээ ороод бид 3 хүмүүсийн бичсэн элдэв юмыг уншсаар орой ч болов. Түрүүхэн л инээлдэж байсан бид 3 нэг л айдаст автан хоорондоо ч үг дуугаралгүй Өргөө2-с гарлаа. Яг Өргөө гийн гадаах шатаар буугаад эргээд явтал манай нэг найз траншейнны нүхэнд яваад орчихдог байгаа. Гадаа их харанхуй болчихсон манай найз ч орилж чарлаад, хартал 1хөл нь бүхлээрээ харанхуй нүхрүү орчихсон, яагаад ч юм надад доороос нь нэг юм татаад байгаа юм шиг санагдаад үхтлээ айн бушуухан найзыгаа татаж чангаасаар гаргаад ирвээ. Бид 3 ч инээлдсээр алхаж байтал хажуугаар зөрж байгаа хүмүүс нэг л биш ээ. Өмнө нь яагаад ч юм зүгээр байдаг байсан



мөртлөө энэ удаад хажуугаар өнгөрч байгаа хүмүүс нэг л уур уцаартай, хөмсгөө зангидчихсан бид Злуу аймар хараад, хотын төвөөр алхтал бүх дэлгүүр хоршоо нь хаачихсан, замаар түргэн тусламжийн 2 ч машин, цагдаагийн машинууд дуугаа хангинуулсаар яваад өнгөрлөө. 1-ийнх нь замын нөгөө талд тул яагаад ч юм зам гарч байгаад муу юм тохиолдчих/машинд мөргүүлэх/ юм шиг санагдаад зам гаргаж өглөө. Тэгээд үлдсэн 1 найзтайгаа бид 2 алхсаар салаад явлаа. Гэр лүүгээ харьж байтал ээж залгаж байна аа. Утсаа автал 'Миний хүү гэр лүүгээ орж ирэхдээ болгоомжтой байгаарай 5н давхрын гэрэл байхгүй байна лээ шүү' гэдэг байгаа. Өмнө нь байрны, орцын гэрэл тэр чигтээ байхгүй байхад ингэж залгаж хэлдэггүй байсан мөртлөө ганцхан 5-н давхрын гэрэл байхгүй байхад ингэж залгаж сэрэмжлүүлсэнд яагаад ч юм дотор жийрхээд явчлав. Гэртээ ч ойртож орц руу орохоосоо өмнө орцын цонхнууд руу хартал яг 4,5,6-н давхрын гэрлүүд байхгүй бусад нь ёлтойгоод байж байдаг байгаа. Би ч яагаад заавал 4,5,6н давхар гэж? гэж бодон орц руугаа яваад оров оо. 5н давхарт ирээд яг лифтнээс буух гэтэл саяхан л цэнэг нь дүв дүүрэн байсан утас хангинасаар унтраад өгөв өө. Би ч үхтлээ цочиж айхын дээдээр айж хонхоо дараад ханаа налаад зогсож байтал нөгөө талын айлын үүдний байнга унтраалттай байдаг гэрэл ПАН гээд л асчихдаг юм байна. Би ч нүдээ аниад л хонхоо дараал дараал байлаа. Дүү ч удалгүй онгойлгож өгөв. Би ч үхтлээ айсан хүн дүүгээ хурдан онгойлгоход яадгийн гээд баахан загнав хэхэ. Маргааш нь нөгөө 2найзтайгаа уулзтал траншейнд унасан нь орцруугаа ортол яагаад ч юм хүн дагаад байгаа юм шиг санагдаад. Гэрийнхээ хонхыг дартал тайлахгүй. Бараг 5 гээд гэртээ ирчихдэг хүмүүс 9 өнгөрч байхад байхгүй. Манай найз гэртээ ороод айгаад гутлаа ч тайлалгүй бушуухан гэрлээ асаагаад зурагтаа асаасан чинь зурагтаар нүүрээ аймар будчихсан нэг эмгэн сүнс гэж юу вэ, сүнс гэдэг нь гээд яриад байж байсан гэсэн хэхэ. Тэгээд тэр охин дахиж хэзээ ч аймшгийн юм үзэхгүй, ярихгүй, уншихгүй гэж амласан юм даа хэхэ.

\* \* \*

## **Намайг Японд байхад бага ангийн багш ийм түүх ярьж билээ...**

"100н лааны түүх"

Нэгэн багш 3н бүлгийн бүх хүүхдүүдийг 100н лааны түүх хэмээх аймшгийн туршилт хийхийг санал болготол бүгд баярлаж тэр дороо 100н лаа худалдаж аван заал руугаа явцгаажээ. Гол нь 100н хүн байх ёстой бөгөөд бүгд өөр өөр гэсэн аймшгийн түүх ярих ёстой гэнэ. Багш нь ч заал руу хүүхдүүд ороход нь гаран дээр нь тоог нь бичин хүүхдүүдээ оруулав. Тэнд яг 99хүүхэд байсан бөгөөд багштай нь нийлээд 100хүн цугларсан байлаа. Тас харанхуйд 100хүн лаа асааж чимээгүйн дунд ганц л хүн аймшгийн түүх ярина. Энэ байдал үргэлжилсээр ганцхан лаа асаж байлаа тэр хүүхэд ийм түүх ярилаа...

-Намайг бага байхад хамаатны хүүхдүүдтэйгээ зуслан явж бид ойд тоглов. Гэнэт би сэртэл эмнэлгийн орон дээр хэвтэж байлаа. Юу болсон эсэхийг асуутал аав маань хажууд уйлан, миний хүү гэнэт алга болоод чамайг олтол ямар нэг юманд хазуулж чи баруун хөлөө тайруулсан гэж хэлэв. Би ч айн хартал баруун хөл минь байхгүй байсан юм. Ийм өгүүлэв. 100Н лаа унтарлаа, ямар нэг зүйл тохиолдох ёстой байлаа. Гэтэл багш бодно, манай сургуульд баруун хөлгүй хүүхэд гэж байхгүй, сүүлийн хүүхэд яагаад ийм юм ярьсан юм бол, би гэж ярьсан байж яагаад ийм сурагч байхгүй билээ? гэж. Багш ч гэрлээ асааж хүүхдүүдэд юу ч тохиолдоогүйг хэлж байтал гэнэт утас нь дуугарав. Харин утасны цаанаас:

- Би танай ангийн тэрний аав байна, миний хүү сая нэг зүйлд хазуулж баруун хөлөө тайрууллаа, сургуулиас гарах өргөдөл яаж гаргах вэ гэлээ...

тэр үед багш айн сандарч хүүхдүүдээ тоолоход тэнд 98хүүхэд өөртэй нь нийлээд 99 хүн л байлаа, тэр хүүхэд хэн байсан бэ яагаад тийм зүйл ярьсан бэ гэдэг асуулт тулгарч бүх хүүхдүүдийг сүүлийн түүхийг хэн ярьсан гэж асуултал хэн ч дуугарсангүй...

Энэ явдал нь Японд байсан найзад минь тохиолдсон юм. Япон улсыг сүнсээр баян орон гэдгийг бүгд л мэддэг. Зарим Монгол оюутнууд тэнд очоод хэд хэд сүнс харсан тухай яриа цөөнгүй хэд байдаг шүү дээ.

Манай найз тэнд гурван жил болохдоо тэнд байрлах олон улсын оюутны дотуур байрны хянагч (дотуур байрны манаач) болсон байлаа. Нэг өдөр тэр шөнө 03 цагийн орчим унтаж байгаад юунаас юм болоод тэр дороо сэрж орхижээ. Тэгээд ус уухаар өрөөнөөсөө гарч байрны нөгөө хэсэгт байрлах крант руу хонгилоор явж байжээ, тэгээд крантандаа очиж усаа уучаад харанхуй хонгилоор явж байтал нэг япон оюутны өрөөний хаалга нээлттэй байхыг хараад тэр оюутныг унтсан эсэхийг шалгахаар дөхөж байтал түүний толгой эргэж нүд нь бүрэлзээд явчлав. Тэр хаалганд ойртоод хаалганы бариулаас барьтал онгорхой хаалганы завсраас нэгэн зууван дуу хүний толгой гэмээр цагаан зүйл уусан гарч ирсэн байна. Түүний нүдэнд хүний толгой гэж харагдах боловч тэр зууван толгойд ямар ч хүний нүүр гэхээр зүйл байсангүй зүгээр л нэг зууван гонзгой цагаан цайвар дүрс байлаа. Ингээд түүний толгой эргэж хойшоо болон хэд алхаад ар дагзаараа хана мөргөн ухаан алджээ. Нэг сэрэхэд гэгээ үл мэдэг тэмтрэгдэж хонгилыг харж болохуйц гэгээтэй байлаа, тэрээр хана налан унасан шинжтэй байсан бөгөөд босох гэтэл толгой нь дүүрч бие нь маш хүнд болсон байжээ. Ингээд арай ядан босоод нөгөө япон оюутны хаалгыг дахин хартал хаалга хаалттай харин хаалганы гадна талд байрлах сүнс зайлуулагч тарнитай цаасан наалт нь ховхорч унасан байжээ. Японы энэ тарнитай наадаг цаас нь сүнсийг зайлуулдаг лац маягийн хэрэглүүр юм. Хэрэв энэ цаасны лац хуулагдаж эсвэл ямар нэгэн байдлаар гэмтсэн тохиолдолд сүнс зайлуулах чадвараа алддаг учраас тэр япон оюутны өрөөнд сүнс байсан болов уу гэж бодогдох юм.

\* \* \*

**Зиа миний бичих гэж байгаа түүх надад сонирхолтой санагддаг.**

Энэ түүх нь дээр үед одоогийн Салхитад болжээ. Тэр үед айл бүрийн эмэгтэй хүүхдүүдийг их авч явдаг үе байсан бөгөөд нэгэн айл охиноо өгөхгүй гэж их тэмцэж тэмцэж яах аргагүй өгч явуулжээ. Охин нь ч гэсэн үлдэхийг их хүсэж байсан учраас модны хонхрын хажууд баруун хөлөө тайран үлдээсэн бөгөөд удалгүй амьсгаа хураажээ.

Хэдэн арван жилийн дараа тэр модны хажууханд нэгэн айл буужээ. Айлын эзэн нь лам бөгөөд 3н охинтой байжээ. Нэгэн өдөр тэр лам гэртээ ганцаараа сууж байтал хажууханд нь байдаг модны тэндээс хөлөө чирэн наашаа ирж буй хүн сонсогджээ. Ихэд гайхсан лам номоо уншихаа үргэлжлүүлж байтал хөлөө чирсэн нэгэн охины сүнс орж ирж өөрийг нь 3 тойроод нэг уртаар үнэрлээд буцаад л хөлөө чирээд гараад явчихжээ. Хэдэн өдрийн дараа тэр лам хот руу ажил хөөцөлдөж тэндээ хонохоор болсон тул 3 н охиноо дуудан миний 3 охин маргааш

нар жаргахаас өмнө хаалга, тооноо ямааны цусаар заавал будаарай гэжээ. Маргааш нь болоод хамгийн бага дүү нь ямааны цусаар будья гэтэл 2 эгч нь дургүйцэж өөрөө буд гэж хэлсэнд дүү нь их л гомдож гэрээсээ гарч тэр модны хажууд хоножээ. Өглөө нь гэртээ ортол хамаг юм нь замбараагүй 2 эгч нь нас барсан байжээ. Аав нь хотоос ирээд болсон явдлыг нь харан бүхнийг ойлгожээ. Хамгийн хачирхалтай нь энэ зүйлийг зогсоох ганц арга нь тэр сүнс охиныг өргөж авах байсан бөгөөд тэр лам тэр сүнс охиныг өргөж авчээ. Энэ явдлаас хойш ямар ч тийм охин харагдахаа больсон байна.

\* \* \*

Би нөхөр хүүхэдтэйгээ манай аав ээж дүүтэй нэг байранд амьдарч байхад янз бүрийн аймшигт зүйлс тохиолддог байсан. Угаалгын өрөөнд юм угааж байхад араас хэн нэгэн хараад байгаа юм шиг санагдаж, нруугаар хүйт даагаад эвгүй мэдрэмж төрдөг байлаа. Нэг удаа нөхөр гэртээ үлдээд бид хөдөө явсан юм. Нөхөр маань цамцаа индүүдээд ажилдаа явчхаад эргээд ирэхэд индүү дандаа тагтан дээр гарчихсан байдаг гэсэн. Нэг өдөр нөхөр их айгаад арай хийж гэрийнхээ үүдэнд иртэл гэрэл асаалттай бид нарыг ир чихэж гэж баярлаад ортол хэн ч байгаагүй. Тэр үеэс байр сүнстэй байх гэдэг сэжиг төрж эхэлсэн юм.

\* \* \*

Нэг удаа би аав, дүү хоёртойгоо гэртээ унтаж байтал манай дүү гэнэт чарлаад бүр айчихсан аавын дээрээс эмэгтэй хүн өнгийж харж байсан гэсэн. Энэ мэтийн аймар зүйлс тохиолдоод байхаар нь байраа зарлаа.

Байраа зарсны дараа манай угтай дүү энд ямар ч гэм хоргүй сүнс хамт амьдардаг байсан. Хаалганы тэнд л зогсож байдаг юм та нарыг айлгачихна гээд л хэлээгүй ээ гэсэн.

Тэр байрнаас гарсандаа баярлаад гэр хороололд очсон биш бас л сүнстэй газар орчихсон.

\* \* \*

Манай хүүхэд хоёр шөнө халуураад дэмийрээд ерөөсөө унтаагүй. Тэгээд бөө ахыгаа дуудсан чинь энэ байшин тийрэнтэй юм байна, бүр өөрийн гэсэн замтай болчихжээ. Эн үүгээр орж гардаг зам байна гээд хамгаалалт хийж өгөөд замыг нь хаагаад угтай дүүг маань байшингийн үүдэнд унтуулсан юм. Үүрийн 3 цагийн үед хаалга хүчтэй балбаад бараг цаг гаран нүдэж нүдэж намжсан. Угтай дүүгийн харснаар хүн биетэй хирнээ толгой дээрээ хоёр эвэртэй хүн адгуус нь мэдэгдэхгүй зүйл байсан гэсэн. Тэр шөнөөс хойш дахиж манайхаар эргэлдээгүй юм даа.

\* \* \*

Дахиад надад нэг юм тохиолдлоо. Багадаа сүнс харсан гээд лам бөөгөөр зөндөө явсан нэг хамаатан дүүгийн дээ хонохоор боллоо. Шөнө шээс хүрээд байхаар нь гарах гэтэл хаалганы ардаас хэн нэгэн намайг гаргахгүй гэсэн шиг түлхээд байна шүү. Би ч заавал онгойлгоно гээд шарлаад байсан. Гаднаас түлхэж байсан зүйл түлхэхээ болиод тэр хавьд нэг юм чанга гэгч нь дуугарлаа. Дүүгээ манаж хонох том ажил үүрсэн би айхаа мартаад урагшаа аажуухан алхлаа.

Тэр байрны орцод ороход л муу энергитэй байна гээд лам хэлж байсан. Ах эгч хоёр тийм ч мөнгөтэй биш юм болохоороо хэдэн хоног тэссэн. Том өрөөрүү ортол цонхны тэнд хамгаалалтын малгай өмссөн алх барьсан хүн зогсож байсан. Над руу эргэж хараад л алга болчихсон. Сүүлдээ тийм чимээ байнга гарч ах эгч хоёр нэг өрөөнд оронгуут л цаанаас нь нэг юм түлхээд байдаг болсон. Би одоо 14тэй. Өөрийгөө том болсон болохоор дураараа байж болно гэсэн зүйл бодож явдаг байсан. Энэ явдлаас хойш ах эгч хоёр ч тэр байрнаас нүүлээ. Дүү нэг л сонин зантай бочихсон байсан ба байнга тэр байр луу тэмүүлээд байдаг болсон. Манайх удмаараа толгой сайтай хэрнэ манай дүү нэг л сонин. Тэр байрыг хүн худалдаж аваагүй. Зүгээр л гудамжны хүмүүст өгчихсөн. Тэр гэрт дахиад л тийм хаалга түлхдэг хэрэг гарлаа. Лам авчраад үзүүлтэл манай дүү багадаа мужаан хүний өөрийгөө олсон багаж олсон юм байна лээ. Цусандаа холилдсон тэр хутгыг аав ээжээсээ нуусан дүүгийн минь бруу биш. Энэ миний бруу байсан юм. Учир нь би дүүгээ авч ийш тийшээ их тэнэдэг байсан. түүнээс болоод манай дүү ганцаараа явж байгаад олсон юм байна лээ. Лам хутгыг шинжиж үзээд зууханд хийж улайсгаад гэгч нь бул гэсэн. Бид хэд ч түүнийг нь маш хурдан хийсэн. Дүүгийн сүнс буцаад ирлээ гэмээр толгой нь сэргэж хичээл номондоо шамдах болсон. Үүнээс хойш би тэнэхдээ зөвхөн өөртэйгөө чацуу хүүхдүүдтэй л явдаг болсон.

\* \* \*

Сайн уу би нэг өөрт тохиолдсон зүйлээ хуваалцах гэсэн юм. Өчигдөр орой 03 цагийн үед гэнэт сэрсэн юм. Хамар битүүрээд ханиад хүрэх гээд байх шиг байхаар нь 24 ц аптек орж терапия уучхаад аягаа тавиад гэрлүүдээ унтраагаад орондоо хэвтэж байсан юм. Гэнэт аягыг маань хүчтэй ширээнд аваад шидэх чимээ маш чанга сонсогдсон. Ах бид 2 л байсан юм. А х нөгөө өрөөнөөсөө юу болоод байна? чи хүн дагуулаад орж ирсэн юм уу? очоод хар гээд. Би бүр балмагдаад айж айж гал тогоонд ороод ах аяга аваад ширээнд зөөлхөн шидсэн яг чичгэнээд доргих яг адил дуугардаг юм даа. Намайг ах ам нь цангасан нэлээд хүчтэй чөтгөр дагуулаад орж ирсэн юм би шүү! хэрэггүй гээд байхад чөтгөрийн цагаар гараад гэдэг юм даа.. маш их эвгүйрхсэн тэр үед.. Орц руу орж байхад хүн дагаад байгаа юм шиг эвгүй басан юм. Урьд нь орой энэ тэр ороход нээх тийм сэтгэгдэл төрдөггүй л байсан. Сонин шүү

\* \* \*

Зун хөдөө эмээгийн дээ амарч байхдаа нэг сонин юм харсан юм. Орой болохоор эмээгийнх маргааш хониндоо унах морио гэрийн гадаа чөдөрлөөд орхидог тэрийг нь өглөө болгон би явж авч ирдэг. Угаасаа морь унах дуртай болохоор хэлүүлэлтгүй явдаг. Нэг өглөө морио хайхаар өдөр болтол нэлээн явсан эмээгийн зун буудаг газар нь хад чулуу ихтэй морио хайж явж байгаад нэг том чулууны ёроолд сэгсгэр үстэй хүн сууж байхыг харсан Би бараг л айсандаа орилоод гүйх нь холгүй байсан. Хүн сүүдэрлэж амарч байгаа байх гэж бодсон ч яавч эрүүл хүн үс нь сэгсийсэн чөтгөр царайтай байхгүй нь лавтай . Ямар ч байсан амьд хүн лав биш байсан Би одоо ч хүртэл хий юм харсан байх л гэж боддог. Ер нь тэгээд ч сүнс буг чөтгөр өдөр нээх харагдаад байдаггүй биз дээ. Хөдөө хээр тийм юм ер нь байдаг юм уу.

\* \* \*

**Энэ 2 сард болсон зүйл тийм аймар биш ч надад эвгүй байсан...**

Амралт эхэлчихсэн манай хятад хэлний багш өвөр монгол явчихсан би өдөржингөө завтай нэг хүн өглөө өглөө ч гэж дээ бараг өдөр 12- 1 хооронд босдог. Орой 2 гэж унтдаг байсан юм. Манай ах уурхайд ажил хийдэг юм. Яг тэр үеэр гэртээ байхгүй 5 хоногт би орой бүр 5:00 -5:20-н хооронд сэрээд л эхний 2 өдөр юм бодолгүй 3,4,5 өдрүүдэд нь жоохон эвгүй байсан сэрээд л сэрүүн хэвтэж байгаад л цаг хархаар л... нөгөө 03:30 бодогдоод л за за энэ ч яа хав хамгийн эвгүй нь ах ирсэн яг тэр өдөр "миний мэдрэмж шүү" гэрлээ унтраагаад л хэвтэх гээд ор луу явж байхад нээх эвгүй цонх руу харсан хөшиг өө дугуу татчихсан байна. Очиж татахаасаа залхуураад шууд ор луу орсон тэгж байгаад л нүд анилдаад л унтсан даа... Тэгтэл хана руу хараад унтаж байгаа юм. Араас цонх нөгөө хөшиг хаагдаагүй завсраар намайг нэг юм цоо ширтээд байгаа нь мэдрэгдээд би хөдөлж чадахгүй үг дуугарч чадахгүй нүдээ нээж ч чадахгүй зүүн хөлний шөрмөс тэр чигээрээ татаал гар сонин болоод л би дотроо заа ингээд л үхдэг юм байж гэж бодоод л нүдэнд нулимс дүүрээд хацраар урсаж байгаа нь мэдрэгдэж эхэлсэн яг тэр үед би сулраад л хүчгүй болоод хамаг хүчээ шавхаад орилох гэж үзсэн санагдаж байна. Одоо бодоход орилсон л юм шиг байгаа юм. Гэнэт гэрэл асаад л ах маань яаж байна? зүгээр үү? гэсээр намайг босгосон. Биеэ минь маш хүчгүй болчихсон байсан. Хамт унтъя гэхээс өөр юм хэлээгүй ээ. Хөнжил, дэр аваад ах минь намайг дагуулаад өрөөрүүгээ орсон. Тэр явдлаас хойш дахиж тийм хэрэг гараагүй л байна. Гэхдээ яг тийм үед хүн яаж ч чадахгүй юм байна гэдгийг маш сайн мэдэрсэн дээ...

\* \* \*

Энэ өдрийн мэнд! Би өөрт тохиолдсон нэгэн зүйлийг та бүхэнд сонирхуулах бас сэрэмжлүүлэх үүднээс бичлээ. Манайх нүүхээр болж бид хороололд байрлах нэгэн байрыг худалдан авсан юм. Эхний хэдэн сар зүгээр л байлаа. Харин зуны сарууд эхлэхэд надад хачин жигтэй зүйлс мэдрэгдэх боллоо. Би ихэвчлэн үеэл дүүтэйгээ гэрээ манаж үлддэг байсан юм л даа. Дүү маань намайг Дөдө гэж дуудна. Өглөөний унд бэлдэхээр галын өрөөнд орлоо. Халыг хан эргээд хартал халаад өмссөн махлаг авгай ташаагаа тулан зогсож байх нь тэр, би ч хар хурдаараа галын өрөөг орхиод хөнжилдөө шургалаа. Гэтэл дүү маань Дөдө аниа та наад цонхон дээр юу хийж байгаа юм буугаач! гэлээ би гайхаж унтаж байсан дүү маань сэрчихсэн юм болов у гэж бодоод хөнжилнийхө завсраар хартал дүү унтаж байх юм. Хачин юм даа яалт ч үгүй дүү байсан даа гэж шивнэх төдий хэлээд галын өрөө орохоор шийдлээ. Галын өрөөнд юу ч байсангүй бас юу ч болсонгүй. Энэ мэтээр хачин зүйлс үзэгдэх болсон. Ганц надад ч биш дүүд маань хүртэл. Би тэр үед бүсэлхий хүрсэн урт үстэй байсан юм. Бас нэгэн шөнө унтаж байсан дүү маань ахиад л сэрсэн бололтой. Цонх руу заагаад ээжээ Дөдө эгч цонхон дээр суугаад байна, над руу хараад инээсэн гэж хэлсэн байсан. Эгч маань утсаа оролдоод сэрүүн байсан болохоор миний хүү чин юу яриад байнаа Дөдө эгч нь унтаж байгаа гээд дүүг тайвшруулаад унтуулжээ. Харин шөнө юу болсон талаар өглөө надад хэллээ. Маргааш өглөө нь сэртэл би ганцаараа гэртээ байсан.Намайг унтаж байсан болохоор тэд орхиод гарсан байв. Галын өрөө орохоор явж байгаад коридорт өлгөөтэй байсан халаадыг өнөөх махлаг авгай гэрлэн дээрээс хоолойгоо боож үхсэн байна гэж харлаа. Яг тийшээ зог тусаад зогсож байтал цаад өрөөнд ямар нэгэн чимээ гарах нь тэр. Би очихийг хүссэнгүй. Сүүлдээ би өлгөөтэй хувцас, сандал толинд харагдсан дүрс гээд л бүхий л зүйлийг өнөөх халаат өмссөн махлаг авгай байна гэж харах боллоо. Ингээд наадам ч болж бид хамаатнуудаараа зугаалгаар явлаа. 3-н гэр аваад, гэрүүдээ тойроод машинуудаа байрлуулаад хүүхдүүд бүгд хойд талын том асарт орж унтахаар боллоо. Мэдээж хамаатны найз, дүү нартайгаа уулзсан болохоор яаж зүгээр

байхав аймшгийн яриа ярих гэж л тэр ш дээ. Яриа маань яг ид дундаа орж байх үед гаднаас хэн нэгэн ирж байгаа юм шиг сонсогдсон. Би хүн ирж байна гэхэд бүгд үүдрүү харлаа. Үүд онгойсонгүй. Бүгд л намайг тэднийг айлгах гэж тэгсэн мэтээр боджээ. Буцаад яриандаа ортол миний өөдөөс урьд нь огт харж байгаагүй нэг охин цоо ширтээд байж байсан. Над шиг урт үстэй. Би тэднээс энэ хэн бэ урьд нь харж байгаагүй хүүхэд байна гэхэд аль, хаана байна гээд гайхаад байсан. Энд байна ш дээ миний урдаас хараад сууж байна. Харахгүй байгаа юм уу гэхэд Баясаа энд үү? гээд гараа хүргэлээ тэгсэн яасан гээч Баясаа гийн гар тэр ний дотор ороод алга болчихсон. Ямартай ч надад харагдаагүй. Ээж маань намайг ийм юм харахаараа битгий айгаарай гэсэн болохоор аль болох харахгүй байгаа мэтээр жүжиглэх гэсэн боловч намайг цоо ширтээд л байсан. Сүүлдээ би тэсэхгүй зайл гэж орилоод гараа хүргэсэн. Тэгээд л алга болчихсон. Тэр шөнө би хар дараад унтаж чадаагүй. Маргааш өглөө нь урьд шөнийн явдлыг ээждээ хэлтэл ээж маань чи нэг л болохгүй нь хот орж үздэг хардаг лам хар гэртээ залъя гэсэн. Тэгээд хот орсон. Гэртээ ирээд унтах гэтэл угас дуугарсан. Би гайхаад хэн юм бол шөнийн 2 болж байхад гэж бодоод хартал дэлгэц нь хав хар тэгсэн мөртлөө дуугараад л байсан. Би айгаад утсаа шууд л шидээд ор луугаа гүйсэн. Маргааш нь хааныхн билээ нэг мундаг бөө дээр очтол намайг дэв туссан байна гэсэн. Юунаас болсон бэ гэсэн чин угаа бруу авсан буюу өөрөөр хэлбэл хуурамч бөө дээр очсон байна. Тийм тохиолдол хуурамч бөө нар хүний сүнсийг авдаг, тэгээд ч зогсохгүй өөр олон сүнс үргэлж хамт явж байдаг гэсэн. Тэгээд л ийм зүйл харж мэдрээд байсан хэрэг л дээ. Би одоо болтол энэ байрандаа байж л байгаа. Үе үе эвгүй зүйлс харагдаж л байдаг юм. Гэхдээ бараг дасаж байх шиг байна.

\* \* \*

### **Хоосон ор хонуулах муу**

Танд ороо өөр өрөөнд засчхаад нойроо дийлэлгүй буйдан дээрээ ч юм уу унтчихаж байсан тохиолдол байдаг уу?

Хэрвээ тийм бол анхаарлаа хандуулна уу!

Хүний унтаж буй ор гэдэг бол хүнийг маш сайн амрааж чаддаг байх ёстой ба хэрвээ энэ нь эсрэгээрээ болбол хүн амарж чадаагүйгээс болж сөрөг зүйлс бодогдон урган гардаг байна.

Хоосон ор хонуулбал таны амарч буй(амардаг) орон зайд чинь орохыг хүсэх зүйлс олон байдаг байна. Учир нь тэдгээр зүйлсэд таны амарч алжаалаа тайлах үед ялгарах эерэг энерги чинь 1 үгээр хэлбэл маш амттай зүйл юм. Түүгээр ч зогсохгүй тэр зүйлс хэзээ ч ханадаггүй ба улмаар улам даамжирч таны зүүдэнд сөрөг зүйлс үзэгдэж эхэндээ эерэг зүйлсээр чинь хооллодог байсан бол сүүлдээ айдас гуниг цөхрөлөөр чинь хооллодог. Энэхүү зүйл нь нэг төрлийн чөтгөрийн үйл бөгөөд үүнийг Гэрийн буг, Зүүдний мануухай, Сүнс шимэгч зэргээр нэрлэдэг.

\* \* \*

2007онд аав маань өнгөрсөн юм. 49 хоног нь дуусаагүй байхад тохиолдсон зүйл. Тэр үед би 16тай байсан. Ихэнхдээ гэртээ ганцаараа хонодог байсан. Нэг өдөр би гэртээ ганцаараа унтаж байлаа. Шөнө унтаж байхад хоёр хар гар хоолойг минь боогоод, амьсгалж чадахгүй хар

хөлс цуггаад яг үхэх гэж байгаа юм шиг болоод өнгөрсөн. Маргааш өглөө нь босоод урьд шөнө болсон зүйлийг нэг нэгэнгүй санаж байлаа. Хэд хоногийн дараа бүр аймар шөнө бас унтаж байгаад гэнэт сэрээд тооно руугаа харсан чинь нэг жижигхэн биетэй хар хувцастай хүн тоонон дээр суугаад хөлөө доош нь унжуулчихсан аймар хоёр улаан нүд яг над руу харчихсан байсан. Дахиад миний хамаг бие салгалаад үнэхээр аймшигтай байж билээ. Тэр үед хүүхэд байсан болохоор нээх сүртэй юм бодоогүй өнгөрсөн. Хамгийн аймар юм бол дараахан нь аавын өмсдөг байсан пиджак хаанаас ч юм яаж хэн тавьсан нь мэдэгдэхгүй гудамжны нэг айлын хашаан дээр нь өлгөсөн байсан. Аав орой ажлаа тараад ирж байхдаа согтуу хоёр залууд хоолойгоо хэрчүүлж цээжиндээ хэд хэд хутгалуулаад нас барсан. Тэр үед хүмүүсийн хэл ам аймар байсан болохоор янз янзын юм надад тохиолдсон байх гэж гадарлаж байлаа. Хөөрхий муу аав минь бүр сүүлдээ толгойгоо тастуулж үхсэн болж үлдсэн дээ. Энэ хүмүүсийн ам дамжсан яриа юм. Хамгийн аймшигтай хэцүү үе минь болж өнгөрсөн дөө.

\* \* \*

### **Бүгдэд нь энэ өдрийн мэнд.**

Би найздаа тохиолдсон явдлыг бичих гэсэн юм аа. Би Японд ирээд удаагүй л дээ ирээд 3 сар болж байна. Ажлаа ирсэн болохоор амьдрах байрыг нь компани нь бэлддэг юм аа. Намайг Японд ирэхэд нэгэн хуучны байшинд оруулсан юм. Энд надаас өмнө ирсэн нэг Монгол залуутай цуг энэ байшинд амьдрахаар болов оо. Эхний хэдэн өдөр юу ч мэдэгдээгүй зүгээр байлаа. Харин 3 билүү 4 дөх өдөр нь унтах гээд зүүрмэглэж байтал доод давхарт хана хүчтэй цохих чимээ гарлаа. Тэгээд би гайхаад нөгөө залуугаасаа сая яасан бэ гэсэн чинь харин манай байшин сүнстэй шүү дээ гэдэг юм даа. Энийг сонсоод япон угаасаа их сүнстэй гэдэг болохоор есөн шидийн юм бодоод унтаж чадаагүй. Саяхан буюу 5 сард Японы хаврын баяр гэж боллоо. Энэ өдөр өөр компанид ажилладаг Монгол найзүүдтайгаа уулзаж Ариунаа болон GUYS-н залуучуудын тоглолтыг үзчихээд орой нь найзүүдыгаа дагуулж гэртээ ирэв ээ. Тэр шөнөдөө уулзаагүй удсан найзүүд энэ тэрийг ярьж жаахан пиво ууж өнгөрүүлээ. Хамгийн аймар нь би 2найзтайгаа гурвуулаа байсан юм. Тэгээд нэг найзтайгаа гадаа тамхилж байтал гэрт үлдсэн найз маань царай нь сонин болчихсон гарч ирээд танайх сүнстэй юм байна гэдэг юм байна. Яав юу болов гэтэл сая би буйдан дээр зүүрмэглээд сууж байгаад нүдээ нээсэн чинь өөдөөс нэг өвгөн бас миний 2 талд 2 эмгэн суучихсан над руу хараад сууж байсан гэсэн. Би ч яа хав сүнстэй гэж мэддэг ч гэсэн яг ямар хүний сүнс байдгийг мэдэхгүй болохоор жаахан эвгүйцээд л явсан. Бас л эвгүй шүү манайх. Одоо ч энэ байшиндаа амьдарч л байна. Хааяа нэг унтах гээд хэвтэж байхад доод давхарт хана цохих ус гоожуулах чимээ гарч л байдаг юм. Одоо ч бараг энэ бүхэндээ дасаж байх шиг байна өө. Анхаарал тавьж уншсанд баярлалаа. Өөрт тохиолдсон зүйлээ чадан ядан бичих гэж оролдлоо.

2015.07.03

Саяхан надад нэг иймэрхүү зүйл тохиолдож байсан. Эхнэр хүү 2 маань унтлагын өрөөндөө унтаад би зочны өрөөнд зурагт үзэж байгаад унтаад өгсөн. Үүрээр гэнэт сэрэхэд гэгээ бас овоо орчихсон байсан. Босож жоохон юм уучхаад буцаж хэвтээд нүдээ аньтал хүүгийн маань хөлийн чимээ нь өрөөнөөс нь сонсогдов. Тэгэхээр нь нүдээ аниад худлаа унтаж байгаа дүр эсгээд хэвтэж байтал хажууд ирээд чимээгүй болчхов. Гайхаад нүдээ нээгээд хартал хэн ч байхгүй. Зүүдэлж гэж бодоод нүдээ аниад хэвтэл гэнэт бие хөшөөд толгой эргэж байгаа

мэдрэмж төрөөд толгой дээр шулганасан чимээ сонсогдоод тэгээд чихэнд хүүхдийн шулганасан шүүгисан ойлгомжгүй чимээ сонсогдоод хөдөлж болохгүй нүдээ нээж чадахгүй их тарчилсан шүү. Арай гэж хүчилж хүчилж нүдээ нээхэд хамаг бие хөлөрсөн их сульдсан байсан. Их сонин мэдрэмж зүүд бол яагаад ч биш байсан.

\* \* \*

Энэ нөгөө сүнсэнд даруулах нь мөн үү? Аль эсвэл манайх сүнстэй юм болов уу? Унтаж байхад тал талаас юм хараад байгаа юм шиг санагдаад байх юм хөлөөс нруунаас толгой дээрээс гээд л харах гэхлээр ерөөсөө хөдөлж болохгүй тэгснээ хүйтэн ширүүн гар нруу элээд хэчнээн эргээд хармаар байсан ч биеийг маань 1 юм дараад авчихсан тэгснээ л хойноос жирс жирс хийтэл чимхээд чимхээд л байна бүр тэвчээр алдармаар хажууд байгаа эгчийгээ дуудах гэхлээр ярьж болохгүй байсан, тэр чимхэж байгаа нь үнэн зэвүүн хүн гижигдэхээр сонин байдаг даа тэрэн шиг л нүдээ хүчээр нээсэн ч хойшоо эргэж харах гэхлээр толгой хөдлөхгүй хамаг хүчээрээ эгчийгээ намайг (эгчээ сэрээгээд өгөөч) гэж ээрч хэлж байна тэгээд 1 мэдсэн чинь сэрчихлээ 4:00 болж байсан нруу жинхэнээсээ чимхүүлсэн юм шиг сонин оргиод л явчихсан ийш тийшээ харах гэхээр юм ширтгээд байгаа юм шиг санагдаад дээшээ хараад тааз ширтгээд хэвтсэн дээ сэрсэн ч гэсэн үнэхээр их айсан нүдээ анихлээр юу ч бодоогүй байхад муухай юм харагдаад байсан шүү. Одоо нруугаар хүйт даагаад байна. Өөр айсан юм алга хэхэ.

\* \* \*

Сайн байцгаа нуу. Би дүүдээ тохиолдсон юмны талаар бичихээр шийдлээ. Манай дүү 14 тэй охин байдаг юм. Тэгээд нэлээн хэд хоногийн өмнөөс хар дараад байгаа юм уу яагаад байгаагаа мэдэхгүй байна гэнэ. Яасан гэхлээр шөнө унтаж байгаад гэнэт сэрээд хөдөлж ярьж юу ч хийж чадахгүй. Хамаг бие нь хөшөөд бүр сонин байна гэнэ. Энэ явдал нэлээн хэдэн хоног үргэлжилсэн гэсэн. Тэгээд нэг өдөр зүүдэлсэн гэнэ. Зүүдэндээ нэг юм үздэг ч хүн юм уу тийм хүн дээр очоод л би унтаж чадахгүй байна гэж хэлсэн гэнэ. Тэгсэн чин нөгөө хүн нь өөрийгөө бүүвэйл гэсэн гэнэ. Тэгээд гэртээ ирээд унтахдаа өөрийгөө бүүвэйлсэн гэсэн бүүвэй бүүвэй гээд л бүүвэйлж байсан чинь яг толгойн дээр нь нэг аймар царайтай хүүхэн суучихсан олигтойхон бүүвэйлээч гэсэн гэнэ. Тэгээд цочиж сэрээд дахиад л хөдөлж яаж ч чадахгүй хөшүүн байдалтай байсан гэнэ. Бид 2 давхар ортой дүү дээд орон дээр унтдаг. Тэгээд намайг дуудах гээд яаж ч чадахгүй бүр нүднээс нь бусад нь хөдлөхгүй байдаг гэнэ. Нэг шөнө надад хэлж байсан юм. Ёо оё гээд л орилохоор нь би гайхаад яасан гэсэн чинь хөдөлж чадахгүй сонин болоод арай гэж хөдөллөө гэж байсан. Энэ яг ямар учиртай юм бол ойрын хэд хоног гайгүй л байна гэж байна. Бид 2 гайхаад иймэрхүү зүйл тохиолдсон хүн байна уу? яадаг юм болоо?

\* \* \*

### **Надад тохиолдсон аймар мөртлөө бас их сонин тохиолдол**

Миний аав намайг 5 билүү 6 р ангид бурхан болсон юм. Тэр үед их л сонин аав минь хөдөлгүүр ажлаар их явдаг хүн байсан юм л даа тэгээд гэртээ ирээд л ах бид 2т хамаг дуртай бүх зүйлүүдийг авчирч өгөөд явсандаа гэтэл удалгүй муу мэдээ дуулдсан юм. Хөдөө ажлаар явж байгаад авто осолд орсон байсан юм. Тэгээд тэр үед хэдий жоохон байсан ч хүмүүс ах



бид 2г хуурах гэж оролдож байсан ч бүх л учрыг нь ойлгож их шаналж байлаа. Ингээд хөдөөлүүлэх болж лам дээр очиж алтан харцагыг нь нээлгүүлээд байтал хамгийн хайртай хүндээ сүнс нь хорогдсон байна хурдан аргалуулж ном уншуул гэж байсан учир нь аавынхаа хамгийн хайртай ганц охин нь би байсан болохоор надад их санаа зовж хорогдсон юм гэсэн. Тэгээд аавыг минь хөдөө нутагт нь нутаглуулсан болохоор хотод ирж хамаг ном уншуулж бурхан хөргийг нь авахаар хот руу ээж минь өөр бусад хамаатнуудтай хамт хот руу явах гэж байтал яагаад ч юм нэг л хот руу явмаар санагдаад л уйлан барин байж ирлээ тэгээд л ламтай нь уулзаж бурхан хөргийг нь өгтөл яагаад ч юм надад нэг л биш юм шиг санагдаад би энэ бурхан биш байна өөр бурхан байсан гээд их л зөрүүдлээд орилсон тэгсэн нээрээ л миний хэлснээр лам нь бруу бурхан өгсөн байснаа мэдээд сольж өгсөн тэгээд бид хэд хотоос гараад явж байтал золтой л осолд орчих шахаагүй дээ хойноос машин ирээд мөргөчихдөг байгаа тэр үед яагаад ч юм хамаг л юманд би бүтэлгүйтээд л бэртчихээд л байлаа тэгээд ээж минь их л ном уншуулж хамгаалалт зүүлт хүртэл авч өгсөн. Тэгээд хамгийн сонин 49 дэх хоног нь дуусах дөхсөн тэр нэгэн өдөр ах бид 2 айгаад ээжийн өвөрт ороод л 2 талд нь гэртээ газар унтаж байсан юм. Би яагаад ч юм хажууд нэг хүн хэвтээд байгаа юм шиг санагдаад эргээд хөрвөөгөөд хартал хажуу талд над руу нруугаа харуулсан аав минь хэвтэж байсан тэгээд одоо бодоод байхад би ааваасаа ер айгаагүй үхсэн ч гэсэн бодол толгойноос айл хэдийн арилсан юм шиг хойноос нь тэвэрч ааваа таны бие их хүйтэн байна би даарч байна гэж хэлж байсан тэгсэн аав минь эргэж хараад намайг тэвэрсэн тэгсэн мөртлөө л надад хүйтэн санагдаад байсан тэгээд л нэг мэдсэн унтаад өглөө болсон тэгээд ээжид хэлтэл миний охин зүүдэлсэн байхаа л гэж байсан тэгсэн тэр өдрийн дараахан надтай яг нэг жилтэй эгчид харагдаж бөөн айдас уйлаан болсон гэдэг. Тэгээд л тэрнээс хойш дахиж юу ч мэдэгдээгүй гэхдээ надад тэр зүүд шиг санагдаагүй би яаг тэвэртэл гар хүйтэн оргиод яаг л аав минь хажууд минь байж тэвэрсэн дараа нь сонсох нээ нас барсан хүн 49 хоногтоо багтааж ирдэг гэж сонсож байсан над шиг ийм зүйлтэй учирсан эсвэл сонсож мэдсэн хүн хэр их байдаг бол?

\* \* \*

Бүлгэмийн бүх гишүүддээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Өөрт тохиолдож байсан явдлаа та бүхэнтэйгээ хуваалцъя.

Одоо бодох нээ би 10 11 настай байхад энэ явдал тохиолдсон юм. Манай гэрийн хажууд жижигхэн 1 давхар сургууль байдаг. Тэр сургуулийг сүнстэй гэж суралцдаг сурагч нар болон мөн мэр сэр багш нар ярилцдаг байсан тэхдээ яг яагаад тэгж ярьдаг байсныг нь би огт мэддэггүй байлаа. Заримдаа ганцаараа тэр сургууль дээр очиж ус авна. Гол хаалганаас нь ус авах газар хүрэхэд харанхуй кордороор нэлээд явж хүрдэг байлаа. Тэхдээ л надад юм мэдэгдэдгүй байлаа. Гэвч нэг өдөр сонин явдал тохиолдсон юм. Манай хажуу айлд 3 эгч дүү байдаг байлаа. Дунд бага хоёртой нь нэлээд л найзалдаг байлаа. Харин нэг өдөр бага дүү, би, хажуу айлын бас охинтой Злаа тэр сургуулийн спорт залаанд ширээний теннис тоглохоор явлаа. Жижүүр ахаас гуйгаад заалыг нь онгойлгуулаад тоглож байлаа. Тоглож тоглож ам цангаад бие засмаар аядлаа. Найзыгаа дуудаад хамт 00 орохоор болов. Заалнаас гараад хаалгыг нь хаах гэтэл манай найз "цэцгээ эгчээр тоглох уу" гээд заалны гэрлийг унтраагаад хаалгыг нь хаагаад гүйгээд явчлав. Би ч араас нь гүйлээ. Гүйж явсаар сургуулийн 00-н хажууд ирээд 2-лаа хана налаад инээгээд байж байтал цэцгээ эгчийн дуу бололтой аврал ирэн

орилох шиг болоод дугуй болчхов бид 2 ч эргээд байдаг хурдаараа гүйлээ заалны дэргэд очоод хаалганы бушуухан татаад хартал коридорын гэрэл хаалганы онгорхойгоор тусахад цэцгээ эгч зүүн гараараа газар тулсан, баруун гараараа нүдээ дарсан, хоёр хөлөө солбиод уйлсан сууж байлаа. Заалны гэрлийг асаагаад арай хийнэ Цэцгээ эгчийг тайвшруулан юу болсныг нь асуутал ийн өгүүлж билээ. Дунд эгчтэйгээ хамт шөнө болгон үсээ самнадаг байж. Нэг өдөр яагаад ч юм тэр хоёр 12,00 минутад үсээ самнаж. Тэгтэл харж байсан толинд нь тэр хоёр биш өөр хүн үзэгдэж тэр өдрөөс хойш бага дүү (Цэцгээ) шөнө болгон хар дарж зүүдлэх болжээ. Зүүдэнд нь өнөөх сургуулийн заалны тэг голд өөрөө зогсож байх юм. Гэтэл өөрийн тойроод хар нохой эргэлдэж гүйж байгаад цав цагаан агаар биетэй агаар дээр хөвж явдаг эмэгтэй болж хувираад өөрлүү нь чиглээд ирээд хүрэхийн даваан дээр сэрдэг байж л дээ. Харин бид хэдийн тоглодог өдөр бид 2 гэрлийн унтраагаад орхих мөчид зүүд нь бодит амьдрал дээр биеллээ олж тэр эмэгтэй дөхөж ирээд орхих бус орилж чарлан зохиж, түлхэж оролдсон гэдэг. Яг тэр өдрийн маргаашаас Цэцгээ эгч харагдахаа больж хааяа л гэрт нь таарна. Сураг сонсох нээ Цэцгээ сэтгэл мэдрэлийн өвчтэй болсон гэх ба хааяа унаж татдаг болсон аж. Ихэнхдээ лам хуврагаар явж номын дууг их л сонссон гэж надад сүүлд нь хуучилж байсан. Мөн тэр аймшигт өдрөөс хойш төд удалгүй дунд эгч нь ходоодны хорт хавдраар өөд болсон юм..

\* \* \*

### **Японд амьдардаг монголчуудад элдэв янзын зүйл тохиолддог. Тэдгээрийн нэгийг энд сонирхуулья.**

Эхнэр нөхөр 2 нэлээд хямд боломжийн байрлалтай хөлсний байранд нүүж оржээ. Байрыг үзэхээр ирэхэд эхнэрийн яриа: "анх ороход муухай үнэр үнэртэж байсан яг л зоорь шиг, өчнөөн удаан хүн амьдраагүй нь шууд л мэдэгдсэн, тэгсэн мөртлөө тавилганууд нь ямар ч тоосгүй байхаар нь би гараад дургүйцсэн ч нөхөр маань орьё гээд орсон. Тэглээ ч бид хоёр мөнгө муутай байсан болохоор орохоос ч өөр арга байгаагүй" гэжээ. Орсон өдрөө юм хумаа цэгцлээд, хоол унд хийж идээд унтахаар хэвтэж. Нэг өрөө байр бөгөөд манай хуучны байрнууд шиг гал тогоо угаалгын өрөө нь тусдаа дундаа коридортой байжээ. Шөнө дунд нөхөр нь босоод явахаар нь халыт сэрээд угаалгын өрөө л орж яваа биз гээд унтаад өгч. Маргааш шөнө нь ахиад л нөхөр нь босоод явж л дээ. Нойрон дундаа эхнэр нь бодож "энэ нэг юм чинь шөнө шээдэггүй байж ойрд яагаад шээс алдаад байгаа юм бол чийгтэй газар ирээд ингээд байгаа юм байхдаа" гэж бодоод л хүлээгээд байж. Удаад байхаар нь гайхаад "хөөш" гээд орилтол нөхөр нь хажууд нь цочоод сэрж л дээ. Эхнэр нь хаалган талдаа унтдаг болохоор нөхрийгөө босоод явахаар нь эргэж хараагүй байж. Яалт ч гүй хажуухнаас нь хүн босоод хөлийн чимээ нь гараад өрөөний хаалга онгойлгоод хаагаад гарсан гэж байгаа, тэгээд бүр 2ч удаа шүү. Нөхөртөө хэлтэл итгээгүй, чи л зүүдлээ биз гээд тоогоогүй өнгөрч. Түүнээс хойш эхнэр нь гэртээ ганцаараа байхдаа элдвийн чимээ энд тэнд гардаг, эхэндээ хулгана харх биз гэж бодсон ч сүүлдээ юун хулгана болж таарч. Нэг орой эхнэр нь ирж явахдаа цонх руугаа хартал гэрэлтэй байж ашгүй нөхөр нь түрүүлээд ирж гээд гэртээ ортол харанхуй байж " энэ одоо хэзээ дээ гараад явчихдаг юм бол" гээд утас руу нь залгатал автобуснаас буугаад очиж явна гэжээ. Чи сая энд байгаагүй юм уу гэсэн чинь юу яриад байгаа юм буудал дээр буучаад явж байна гэжээ. <буудал нь нэлээд зайтай байдаг гэсэн, ер нь манайхны амьдардаг хөлсний байрнууд буудлаасаа хол байдаг> иймэрхүү маягаар элдэв зүйл болдог байж. Хоолоо хийгээд зогсож байхад нь ард нь хүний хөл хулдаасан дээр явж байхад гардаг чимээ гарна, зурагт нь

өөрөө унтарна, тавьсан юм нь байрандаа биш бүр далд орчихно хайж хайж олно, гэнэт үнэртэй ус нь сая цацсан юм шиг үнэртэж эхэлнэ, шалан дээр нь энд тэнд дөнгөж ус асгачхаад арчихсан юм шиг нойтон байдаг байж энэ бүхэнд ч сүүлдээ дасажяпон сүнстэй нь үнэн юм байна гэж бодож. Нэг удаа эхнэр нь 00руу тогоотой угаадас асгах гээд явж байтал нүдний үзүүрт коридорын харанхуй буланд өндөр саарал (нөхөр нь өндөр) зүйл харагдахаар нь "ёо хүн цочоочхын" гээд эргээд хартал юм ч байхгүй, нөхөр нь нөгөө өрөөндөө зурагт үзээд хэвтэж байж. Энэ бүхнийг эхнэр нөхөртөө хэлээд энд нэг юм байна, нэг л биш гэж өчнөөн хэлсэн ч тоогоогүй байгаа юм. Нэг орой нөхрийгөө ирэхэд<эхнэр нь ажлаасаа эрт тардаг, дандаа түрүүлж ирдэг байж> архины төрлийн юм огт амсдаггүй, дургүй эхнэр нь ганцаараа архи уугаад тасарчихсан унтаж байж. Маргааш нь яагаад архи уусан юм гээд асуухад эхнэр нь мэдэхгүй байна нэг мэдсэн архи уугаад сууж байсан, зүүдлээд ч байгаа юм шиг байсан гэж ярьжээ. Нөхөр нь сэжиглэж эхэлжээ, гэхдээ бруугаар сүнс сүүдэртэй холбох нь битгий хэл өөр хүнтэй болчихож гэж сэрдэж эхэлжээ. Ам зөрөх нь цөөн, зөрсөн ч айх тар зөрдөггүй байсан хоёр маань байнга хэрэлдэх болж, хамар амнаасаа цус гартал зодолддог болжээ. Эхнэрийгээ цохиж аваад өнөөх нь уйлаад сална энээ тэр гээд найзынх руугаа яваад өгч, нөхөр нь хэд хоног ганцаараа хонохдоо орой болгон согтуу ирээд тасраад унтчихдаг байж. Нэг орой эрүүл ирээд 00д сууж байсан чинь гал тогоонд хөлийн чимээ гарч л дээ мань хүн дотроо "ашгүй эхнэр ирчхэж" гээд л баярлаж гараад иртэл хэн ч байдаггүй гэнэ, тоглоод нуугдаад байгаа юм болов уу гээд шкапаар хайж, хүн багтаж болох бүх л газар хайгаад байдаггүй гэнэ шүү. Утас руу нь залгатал утсаа авдаггүй, за гадаа хүлээж байгаа юм байна гэж бодоод буцаад угаалгын өрөө ороод гар нүүрээ угаачхаад, гарч хооллохоор шийдэж тэмдэглэлийн дэвтрээ (тэд сарын хэрэглээний мөнгөө тэр завсар хийдэг, орлого зарлага авсан бүх зүйлээ тэнд бичээд тэндээс мөнгө авдаг байж) авахаар шилэн шүүгээ( энэ шилэн шүүгээ энэ байранд нь байсан бөгөөд ар талдаа тольтой, урд хажуу талууд нь шилэн) онгойлгоод урд нь өвдөглөөд сууж, хальт толинд харсан чинь ард нь нэг саарал юм харагдаад өнгөрснөө, тодроод саарал үстэй эмгэн болж харагдсан байгаа юм бол. Мань хүн ухаанаа алдтал айж, нэг мэдсэн л гадаа гудамжинд эхнэрээ тэврээд зогсож байсан гэсэн. Эхнэр нь өөдөөс нь харьж таарсан юм байна лээ. Гэхдээ гэртээ ороогүй орох гэж явсан гэж байгаа. Ээж нь Монголд бөөд үзүүлсэн, "гялалздаг юм наас сэвтсэн байна, сүнс нь одчихож" гэж хэлсэн гэсэн. Тэр толь хоймор талдаа яг нөхрийн унтдаг хэсэг харагддаг байсан байгаа юм, эхний өдөр тэр босож явсан зүйл нь нөхрийн сүнс байж таарч, унтаж байгаа дүрс толинд харагдах ямар олиг бай хав дээ бодоход л..... Өмнө нь хэчнээн зүйл харагдсан ч толь юм билээ. Бас тэр бөө нь "өргөөгөө соль, самган тийрэн орогнож байна" гэж хэлсэн байгаа юм. Тэгээд тэр хоёр хурдан тэндээс нүүж, нөхөр монгол явж сүнсээ дуудуулсан гэсэн. Эхнэр нь ярихдаа: анхнаасаа тэр байшинг үзэх гэж очиход л надад нэг л биш санагдсан, тэнд орсноос хойш элдэв янзын юм сонсоно, үнэр үнэртэнэ, ажил үйлс ч бүтэхээ байж, муудалцаж хэрэлдэж зодолддоггүй хүмүүс чинь алалцаж байгаа юм чинь, тэгээд би нөхрийгөө байхад зүгээр унтчихдаг байж ганцаараа унтахаараа л элдэв янзын чөтгөр, шулам заваан дүрстэй амьтан зүүдэлнэ, тэд нар нь хөл гарнаас чирээд татаад л, би сэр чихээд өрөөн доторхоо хараад байвч сэрж чаддаггүй, өөр өөртөө сэр сэрээч гэж хэлнэ, энд ер нь наргиж цэнгэх дуртай ганц бие авгай байсан гэсэн, тэгээд эмгэн болоод үхэн үхтлээ байж байгаад өнгөрсөн юм байлгүй, заримдаа гал тогоонд хүмүүс шуугилдаад л инээлдээд л баяр болж байгаа юм шиг л байна, ирж хаалга онгойлгож харчхаад л инээлдээд л намайг шоолоод байна гэж зүүдэлнэ, сүүлд судлаад байсан тэр нь сүнсэнд даруулах буюу шинжлэх ухаанд нойрны саажилт гэдэг юм билээ. Гэхдээ би зөвхөн энд ирээд нойрны саажилттай болно гэж юу

байдаг юм, Монголд гэртээ 4өрөө байранд ганцаараа хонохдоо ганц ч хар дарж байгаагүй, хар дарах ч гэж дээ миний хар дарсан зүүд бол өндрөөс унаж байна, хүнтэй муудалцаж байна, хүн үхэж байна, өр шир, онигоонд орж байна гэх мэт болохоос байнга чөтгөр шулам зүүдэлж лав үзээгүй, тэр байрнаас нүүгээд дахиж зүүдлээгүй сонин л байгаа биз дээ. Нөхрийгөө бодвол арай ч сүнсээ зайлуулчхаагүй, намайг чинь бөө болох ёстой хүн гээд, алтан бөгжөөр хамгаалалт хийж өгсөн тэр нь ч нөлөөлж хамгаалж байсан байх, би өөрөө ч жоохон зөнтэй гэж өөрийгөө боддог ш дээ. Байр саванд нүүж орохоор бол ер нь лам хар болж, хуучин айлынх нь шил толь байвал гаргаж хаяж байж орж байгаарай даа, бид хоёрт болсон шиг юм мэдэгдэхгүй ч гэсэн ажил амьдралд саад болоод байдаг юм шиг байгаа юм, юмыг яаж мэдэх эв муугаар бодоход бие биенээ алж, наанадаж салж мэднэ шүү, би л гэхэд өөрийн мэдэлгүй архинд гараад бүр авч ирээд уучихсан байсан ш дээ" гэж ярьжээ.

\* \* \*

Миний ярих гэж байгаа зүйлийг бага сага хүмүүс мэддэг болохоор би нэрээ нууцалъя гэж бодлоо. Би ноднин жил 17 хүрсэн. Аав минь 1 ой хүрч байхад өөд болсон. Ээж маань ноднин төрсөн өдрөөр минь өөд болсон юм. Би одоо эмээтэйгээ Гачууртад амьдардаг. Бид 2 тийм ч баян цатгалан амьдардаггүй л дээ. Гэхдээ бас хэн хүнээс гуйлга гуйх дээрээ тулаагүй . Ноднин ээж минь өөрийгөө үхэх цаг болж байгааг мэдсэн юм шиг намайг дуудаж чамайг жаахан байхад чинь аав чинь энэ бойтгийг чамд авчирч өгөх гэж явахдаа уулын хавцлаас хэн нэгэн рулийг нь булааж машинтайгаа унаж өөд болсон гэж ярилцдаг. Гэвч тэр машинд ааваас чинь өөр хүн байгаагүй. Би үг нь 18 хүрэхээр чинь чамд өгнө гэж бодож байсан чамайгаа 18 хүртэл хажууд чинь байж чадахгүй юм шиг байна охин минь ээж нь чамлаа хайртай шүү гэж хэлээд духан дээр минь үнэсэж тэр шөнөдөө амьсгал хураасан. Юунаас болж өнгөрсөн нь тодорхойгүй эмээ ч надад хэлдэггүй байсан. Түүнээс хойш би тэр бойтгийг үргэлж цүнхэндээ авч явдаг болсон. Нэг орой би автобусанд цүнхээ мартаад эргэж хайхад ч оройтсон байсан.

Тэр орой эмээ бид 2 хоолоо идчихээд би орондоо ороод хэвтгэл шөнө дунд ам цангаад болдоггүй босоод гэрлээ асаатал пийшингийн хажууд миний 2 бойтог байж байсан. Би цүнхэндээ хийснээс хойш гаргалгүй 4 сар болж байна. Хэзээ гаргаснаа ч өөрөө санахгүй уг нь гаргаагүй юм. Өглөө нь эмээгээс асуувал би цүнх савыг чинь оролдоогүй ухаагүй юу ч гаргаагүй гэдэг юм байна. За за би өөрөө л гаргасан юм байлгүй гэж өөрийгөө тайвшрууллаа. Өдөр нь хичээл дээр нүд харанхуйлаад болдоггүй ходоод хоосон байсныг хэлэх үү юу болоод байгаагаа сайн ойлгохгүй багшаас чөлөө авах гэтэл багш нүүр өгсөнгүй гүрийж суусаар байгаад нэг мэдсэн ухаан алдчихаж. Нэг сэртэл эмнэлэгт харанхуй өрөөнд гав ганцаархнаа аппарат залгуулчихсан хэвтэж байна. Би хэчнээн их босохыг хүссэн ч толгойгоо дийлсэнгүй дээрээс нь ам цангаад болдоггүй хүн байна уу гэж орилтол өрөөн дотор хаалганы хавьцаа эн нэгэн эрэгтэй хүн та муу сайн новш нар намайг 17 жил тамлаж би энэнээс илүү тэвчиж чадахгүй гэх дуу маш зөөлхөн сонсогдлоо. Би хаалганы цаана хүн муудалцаж байна гэж бодсон ч тэр бодол минь намайг өөрт минь итгүүлж чадсангүй. Миний ор луу хүн алхах чимээ гарлаа харанхуйд юу ч харагдахгүй би гараа ширээн дээгүүр гүйлгэвэл доторх нь юмгүй юм шиг хөнгөхөн шил байхаар нь юм дуугарч байгаа зүг рүү орилон шидлээ. Төд удалгүй гэрэл асаад эмч нар юу болоод байна юун чимээ гарсан бэ гээд гэрэл асаатал шалаар дүүрэн цус болсон байсан би юу ч мэдэхгүй над руу хэн нэгэн хүн дайраад байсан би

сандраад тавиур дээр байгаа шилийг л авч шидсэн тэгээд та нар орж ирсэн эмч тавиур дээр байсан шилэнд юу байсан юм гэтэл сувилагч охин эмнэлэгт ирэхэд бие дэх цусан хангамж 37% бид цөм гайхаж яаралтай цус шилжүүлэх арга хэмжээ авсан үлдэгдэл шилэн дотор байсан гэлээ. Тэгээд бүгд тайвширч намайг 2 хоногийн дараа гаргана 2 хоног заавал эмчийн хяналтад байхгүй бол болохгүй гэлээ. Би ч тэнд байхыг хүссэнгүй. Гэвч өөр ямар ч арга алга байлаа. Маргааш болж танайхаас хүн байна уу гэвэл би эмээ маань л байгаа гэтэл багш чинь харин тэгж байсан эмээд чинь хэл хүргэж чадсангүй хөөрхий минь санаа нь зовж байгаа байх багштайгаа яриад та хэл хүргээд өг гэж хэл гээд би багш руугаа ярьж эмээд минь хэл хүргээрэй маргааш эндээс нь гарна гэж хэлээрэй гээд утсаа тасаллаа. Орой боллоо би гэрлээ унтраахыг хүссэнгүй унтраахгүй болохоор бусад өрөөний хүүхдүүд өрөө хэсээд тайван байлгадаггүй болохоор унтраахаас өөр арга байсангүй. Ингээд гэрлээ унтраагаад орондоо ороод хэвтлээ. Нэлээн юм бодож ийш тийшээ чих тавин чагнаж хэвтгэл орон доор юм дуугарах шиг боллоо. Гялс босох гэтэл бие минь хөшчихсөн хэн нэгэн цээжин дээр минь дарсан юм шиг хөдлөх гээд чадсангүй эмнэлгийн пүрштэй орны завсраар хэн нэгэн хруугаа явуулаад байгаа юм шиг мэдрэмж төрж миний биеийн зүүн гарын чигчий хруу л үл ялиг хөдөлнө. Ядаж байхад яасан нимгэн гудастай юм бэ гэх бодол толгойд орж гэнэт хаалга онгойгоод сувилагч орж ирж байна гээд баярлаад л тэгтэл өрөөний охин үүдний өлгүүрт цамцаа тавьсан тэрийгээ шүүрч аваад гараад явчихлаа. Би ч дотроо өө хараал ид сувилагч аа гэж мянга дуудах гээд чадсангүй. Тэгсэн мөртлөө хаана юу болоод байгаагаа маш сайн мэдэж бас мэдэрч байлаа. Миний хөлнөөс хэн нэгэн маш чанга атгаж ямар нэгэн юм өмсүүлэх гээд байгаа аятай чихээд байлаа. Тэгснээ тээр энэ чинь таарахгүй байгаа биз дээ. Би Төмөрийг аваад явахад нь л хэлсэн миний хөгшин 1 ой хүрсэн хүнд наадах чинь яагаад ч таарахгүй чи надаас заавал юм авах гээд байгаа юм бол наадахаа миний зүлны өмнө тавиад эхнэрийг минь аваад арилж үз гэж зөндөө хэлсэн болов ч тэр намайг сонсоогүй. Тийм ч учраас тэр үхсэн хэнийг гаргаж ирснээрээ ээж чинь ч бас үхсэн. Харин одоо чиний ээлж чинь энэ муухай хөлийг тастаж аманд чинь чихэх болно гэж хэлэхэд би үгүй гэж орилоод босохыг хичээсэн ч чадсангүй хэсэг хугацаанд юу болоод өнгөрснийг мэдэхгүй. Сэрвэл өрөөнд хэн ч алга тас харанхуй харин миний дээрээс дарсан зүйл байхгүй болсон байлаа. Би босож гэрлээ асаавал миний хөл мөн орны хөл тэр чигээрээ цусанд будагдсан байлаа. Тэр орой би унтахгүй гүрийж маргааш эмнэлгээс гарч таньдаг эгчээсээ гуйн хамт лам дээр очвол нэгэн залуу хүүдээ бойтог аван гэр лүүгээ яарч явахдаа хүмүүст зодуулан амиа алдсан байна. Энэ хэргийн эзэд одоо болтол олдоогүй бас энэ бойтгийг лам аваад үлдсэн. Тэр өдрөөс хойш надад өөр юм тохиолдоогүй. Би тэр ламд одоо болтол маш их баярладаг.

\* \* \*

Манай эгчийн сайн найз нь хавар болохоор л шар хадны эмнэлэгт хэвтдэг зуршил ч гэх юм уу тэгээд л эгч эргэж очно. Сүүлд эгчээс яагаад найз нь хэвтдэг болсон тухай сонссон юм. Тэр эгч хөгшин ээж ээ нас барахад орь ганцаар үлджээ. Гашуудал дуусаад хагас жил гаран болж байж өдөр орон дээрээ цаашаа хараад унтаж байтал зуухыг нь галын төмөр хайчаар түншээд байгаа нь сонсогдоод сэрж чадахгүй хүчлээд сэрээд эргээд хартал нас барсан ээж нь үхээрийн муухай царайтай зуухаа ухаад сууж байсан гэдэг. Яг тэрнээс хойш юу болсныг санадаггүй ба нэг мэдэхэд эмнэлэгт ухаан орсон байж. Одоо тэр эгч хавар болохоор л хууч нь сэдэрдэг сар гаруй эмчлүүлээд гардаг юм.

Саяхан 15нд өвөө маань хагалгаанд орсон юм. Гэтэл амжилтгүй боллоо гээд сэхээнд нэлээн хэвтсэн үр хүүхэд ач зээ нар нь ээлж ээлжээр сахиж байсан. Би өдөр 2-н үед өрөө лүү нь орох гээд эмнэлгийн коридороор алхаж явлаа. Ард нэг цагаан халаадтай хүн явж байсан юм. Тэгээд лифтэнд хамт ороод эргээд харсан чинь хэн ч байхгүй би ганцаараа аймар урт бүдэгхэн гэрэлтэй лифтэнд зогсож байдаг юм даа .

\* \* \*

### **Идэвхтэн гишүүний явуулсан аймшгийн өгүүлэг**

Очироо хот хооронд таксинд яваад 3 сар гаруй болж байлаа. Улаанбаатар руу орж явах замд бие давхар эхнэр нь залгаж, хугацаанаасаа өмнө гэнэт өвдөж, эмнэлэгт хэвтэх болсноо хэлэв. Очироо ч хүмүүсээ буулгаад шөнө дунд ганцаараа буцахаас өөр арга байсангүй. Замын жолооч нараас УБ-с гараад хэсэг газар үе үе хүүхний сүнс үзэгддэг гэж дуулсан ч угийн сүнс сүгд итгэдэггүй болохоор элдэв зүйл бодолгүй хөгжмөө чангалан, тамхиа сорсоор давхиж явлаа. Цагаа харвал шөнийн 2 цаг болж байв. Гэтэл хажуу суудал дээр хүн сууж байх шиг санагдаж, ихэд жихүүцэн цочин хартал яах аргагүй дээлтэй эмэгтэй хүн сууж байлаа. Хэр баргийн юманд айдаггүй тэрээр ихэд цочирдсондоо хурдтай явсан машиныхаа рулийг нь мушгиж, яах ийхийн зуургүй замын хажуу руу орчхов. Гэнэт сэхээ аван нүдээ нээтэл эзгүй хээр хэвтэж байх бөгөөд машин нь замын хажуу руу өнхрөөд дөрвөн дугуй нь дээшээ харсан байлаа. Очироо хөшсөн биеэ арай хийж хүчлэн босож тусламж дуудах гэтэл замаар ямар ч машин явсангүй. "Юу болчхов оо?" гээд машинруугаа зүглэтэл яг ард нь эмэгтэй хүний муухай инээх дуу сонсогдов. давхийн цочиж эргэн харвал машинд байсан хүүхэн мөн байлаа. Очироо айж балмагдсандаа "Чи хэн бэ? Надаар яах гэв?" гэхэд мөнөөх хүүхэн хяхтнасан муухай дуугаар "Би их өлсөж байна" гээд ад зэтгэрийн инээдээр инээлээ. Очироогийн дотор жихүүдэс төрж, хүүхний хонхорхой хар нүднээс харцаа салгаж чадахгүй ширтэн зогсов. Залуу муу ёрын сүнсэнд ховстуулж байгаагаа яахан мэдэх билээ. Хүүхний нүд Очироогийн хүчийг сорон авах мэт нэг мэдэхэд хамаг бие нь тамирдан унав. Нэг сэртэл уул ус тэгширсэн хээр талд хэвтэж байлаа. Ажиглан харвал осолд орсон газар нь лав биш байв. "Юу вэ? Юу болоод байна аа? Би хаана байна аа?" гэж өөрөөсөө асуусаар алхаж явгал голын эрэг дээр нэгэн жаал хүү ямар нэг юм руу гөлрөн гунигтайхан сууж байв. "Хөөе хөөе, миний дүү" гэж дуудтал мөнөөх жаал Очирооруу хүзүүгээ гилжийлгэж дүрлэгэр хар нүдээрээ цоо ширтээд хруугаараа чичин "Чи үхсэн, чи яг над шиг үхсэн" гэж хашхиртал амнаас нь түмэн шавьж бужигнан нислээ. Очироо айсандаа ухаан балартан хамаг хурдаараа гүйж явтал урдаас нь хурц цагаан гэрэл асан Очирсүх ээ гэж дуудах чанга сонстов. Энэ ердөө зүүд байж хэмээн баярлан сэртэл бөөн хадаг яндар, тахилга, зул болсон айлд байлаа. Хажуу өрөөнөөс Очирсүх ээ миний хүү гэж ээжийнхээ мэгшин уйлах чимээнээр гүйн очтол нэгэн сүртэй өмсгөл хувцастай зайранг гэрийнхэн нь тойрон сүсэглэж, эхнэр нь нялх хүүхэд тэврэн гунигтайхан сууж байлаа. Миний хүү гээд очин тэврэх гэтэл гарт нь юу ч баригдахгүй, хэн ч түүнийг харахгүй байв. Ээж ээ, би энд байна, энд байна шүү дээ гэхэд огт сонссонгүй. Харин зайрангийн нүүрээ халхалсан гивлүүр ний цаанаас хөгшин өвгөн өөрлүү нь дотно инээмсэглэх шиг санагдав. Очироо баярлаж, та намайг харж байна уу? юу болоод байгааг тайлбарлаад өгөөч гэхэд зайран гэрийнхэнрүү нь хандан "За хүү ирчихлээ, тэр их өлсөж ядарчээ, эвий сүнс нь их холуур төөрч явсан байна" гэх нь тэр. "Ээ гэгээн минь, ээ тэнгэр минь, хүүгийн минь хойдын зам саадгүй байгаасай" гэж ээжийгээ хэлэхэд Очироо бүгдийг ойлгож авчээ...

## **Намайг бага байхад болж байсан явдал**

Увс аймгийн Улаангом сумын төвд манай эмээгийнх байдаг байлаа. Би зуны амралтаар эмээгийнхэндээ очиж амардаг байсан юм. Манай ээжийн дүүгийнх эмээгийнхэндээ ойролцоо хашаа худалдаж авсан юм. Тэднийх 3 хүүхэдтэй бөгөөд хоёр том нь эмэгтэй хамгийн бага нь банди. Ах эгч хоёр наймаа хийдэг байсан болохоор хааяа хааяа орос руу бараандаа явна. Тэднийг эзгүйд эмээ маань хүүхдүүдийг нь хардаг байсан. Нэг удаа би хамаатныхаа нэг ахтай хамт нөгөө ах эгч хоёрынх очиж хоносон юм эмээ маань тэднийд байсан. Бүгд унтах гээд л хэвтэцгээгээд хамт явсан нэг ах маань бие засчхаад ирье гээд гараад явсан төд удалгүй царайн сонин болчихсон их л айсан шинжтэй орж ирсэн. Тэгээд юу болов яав гэтэл ах: - Гадаа жорлонд нэг өвгөн байна, бас хажуугаар нь гавлын яснууд хэвтэж байна гээд л уйлж орхив. Эмээ маань тэр үед их л санаа зовсон байртай харж байснаа яах гэж ганцаараа гарсан юм гээд загнаж байсныг санаж байна. Тэр өдрөөс хойш ахын маань 3 хүүхэд шөнө уйлаад ерөөсөө унтахгүй эмээ маань их л ядарч билээ. Ах эгч хоёр бараандаа явах хугацаа нь болсон болохоор хүүхдүүдээ эмээд үлдээгээд явцгаасан. Эмээ маань ихэд санаа зовж хамаатны нэгэн зоос татдаг хүнийг дуудаж үзүүлсэн. Тэгээд тэр ах тарни ном уншаад юу ч гэсэн эндээ хоноод үзье гээд хоносон. Шөнө дундын алдад нөгөө ах хар дарж орилоод байсан. Өглөө нь босоод юу болсон талаар асуухад “цонхоор нэг их урт сахалтай өвгөн толгойгоо цухуйлгаж байснаа хоолойг маань хоёр гараараа боогоод, тарни ном уншиж байж хөөж явууллаа” гэдэг байгаа. Манай ахынд хоносноос хойш зоос татдаг ахын бие нь бараг сар гаруй өвдөж эмч домчоор явсан ч нэг их нөлөө өгөөгүй. Эцэст нь нэгэн сайн лам дээр очиж ном айлтгуулаад зүгээр болж байсан юм. Сүүлд эмээ маань ярихдаа энэ хашаан дотор үүрээр нэг араг үүрсэн өвгөн дандаа явж байдаг юм гэж билээ. Сүүлд тэр хашаанд байгаа хүмүүсийн бие нь байнга өвдөж болохоо байгаад бүүр эгч маань дэмийр балайраад галзуу хүн шиг л болчихсон. Юм л бол орилж чарлаад их хэцүү байсан гэдэг. Тэгээд эмээ маань арын дөрвөн замын ойролцоо нэг сайн лам байдаг гэж сонсоод тэр хүнээс очиж учир байдлыг асуухад: - Энэ газарт буусан айлын эмэгтэй хүн тогтдоггүй бузартсан газар байна. Түргэн холдохгүй бол илүү зовлон амсах болно. Тэр хашаанаасаа юу ч битгий аваарай тэгээд хурдан нүү гэсэн гэдэг. Ахынх ч гэрээ аваад хашааг орхиод нүүсэн дээ. Намайг сүүлд нэг амралтаараа очиход нөгөө хашаа яг бахь байдгаараа байсны дээр, хажуу хаврынх нь айлууд бүгд нүүцгээсэн байсан. Бодвол хажуу айлдаа хүртэл нөлөөлдөг болоод ирсэн юм байлгүй дээ.

\* \* \*

Манай нэг таньдаг ах Багануурт байдаг. Нэг хуучны байр байдаг юм. Тэнд нэг айлд очиж архи уусан гэсэн. Олуулаа байдаг хүмүүс дандаа тэнд архи уудаг байсан гэсэн. Тэгээд нэг өдөр тэр ахыг орхиод бүгдээрээ гараад явсан юм байна л даа. Нэг өрөөнд нь унтаж байхад тог тог гээд хүний алхах чимээ дуугараад хаалганы бариул нь хөдлөөд байсан гэсэн. Тэр ах хүн байгаа юм уу юундаа тоглоод байгаа юм гэсэн чинь хүн дуугараагүй гэсэн. Тэгээд шууд л гараад гүйсэн гэсэн. Одоо өөрөө ярихдаа айгаад байдаг. Тэнд эхнэр нөхөр хоёр амьдардаг байсан тэгээд нөхөр нь эхнэрээ алсан гэсэн. Тэгээд сүнс нь хорогдсон юм шиг байна лээ.

\* \* \*

## **Манай ахад тохиолдсон явдал**

Циркийн зүүн талд байдаг хуучны 5 давхар байранд манай ах эхнэртэйгээ хамт олон жилийн өмнө байр хөлсөлж байсан юм. Эхний хэд хоног юу ч мэдэгдээгүй гэсэн. Удалгүй шөнө унтаж байхдаа нөхөр нь алгадуулаад сэрдэг. Сэрээд эхнэрээ чи яагаад хүнээр тоглоод байгаа юм гэхээр эхнэр нь гайхаад байдаг байж л дээ. Сүүлдээ тэр 2-г хоёуланг нь шөнө дунд алгадаад, хөнжлийг нь татаж хаяад, гэрэл асаагаад байдаг болсон. Залуу хүмүүс болохоор эвгүйтсэн ч мөнгөө урьдчилаан өгчихсөн болохоор гарч болохгүй байсан юм. Тэгээд л шөнө болохоор л алгадаад, хөнжлийг нь хуу татаал, шкафных нь хаалгыг онгойлгоод аймаар хүчтэй хаагаад байдаг байсан гэсэн. Гал тогоонд нь плиткийг нь асаачихсан байдаг бас усыг нь гоожуулна. Сүүлдээ тэсэхгүй лам дээр очиж үзүүлсэн чинь их догшин олон хүний сүнс байна. Гэртээ хоргодчихож, би дийлэхгүй байх, хурдхан нүү гэж хэлжээ. Тэгээд хөлслүүлсэн хүндээ хэлээд нэг сарынхаа мөнгийг буцааж аваад 2 сар болоод л гарсан даа. Гэтэл тэр байранд хуучин нийгмийн үед сайд байсан хүнийг гэр бүлтэйгээ байхад нь хүргэн нь ирээд бүгдийг нь алдчихаад өөрөө амиа хорлосон байсан юм байна лээ. Хөлсний үнэ нь их хямдхан бас манай ахыг гарснаас хойш тэр байр нэг хэсэг бүр хаягдсан байсан гэнэ лээ. Одоо юу болсныг мэдэхгүй юм. Энэ явдал 10-аад жилийн өмнө болсон юм.

### **Дэвтэй холбоотой түүхүүд**

Архи байнга хэрэглэдэг хүн бузартаж, сүлд хийморь нь доройтдог бөгөөд нүдэнд нь элдэв хий зүйлүүд харагдах гэх мэтээр илэрдэг байна. Дараах болсон явдлуудыг надад тухайн хүмүүс нь өөрсдөө ярьсан юм. Өөрсдөө дэв гэж хэлээгүй ч миний бодлоор архины дэв байсан гэж бодож байна.

1-р түүх. Миний нэг сайн найз хориод настай байхдаа ер нь нэлээн уучихдаг шоучин гар байсан юм. Гэрээ сахиж үлдэхэд нь найз нар нь бөөнөөрөө очоод хоноод уучихдаг, үүрлэдэг байсан гэж болно. Тийм л нэг үед сар гаруй гэрээ сахихдаа өдөр болгон шахуу гэртээ архидсан гэдэг юм. Нэг тасраад босоход нь л огт танихгүй хүмүүс сууж байдаг, босож ирэхээр нь дахиад архи өгөнгүүт нь уучхаад дахиж тасарч унаад, дахиад л сэргэхэд нь шал өөр хүмүүс орж ирчихсэн сууж байдаг байсан гэж өөрөө ярьж билээ. Нэг удаа харин эрүүлжээд сэрсэн чинь харанхуй шөнө таазан дээр нь ямар нэгэн амьтан гэхэд амьтан биш, хүн гэхэд хүн биш зүйлүүд таазанд нь наалдчихсан мөлхөж байсан гэдэг. Хий юм харж байна гэж бодоод нүдээ сайн арчиж байгаад дахиад хартал өнөөх зүйлүүд яг л байсан гэж байгаа. Харин яаж алга болсныг нь надад яриагүй юм даг.

2-р түүх. Таньдаг ах маань залуудаа нэг геологийн бригадын ачааны машиныг жолоодоод хөдөө явж байсан гэдэг юм. Тухайн үед бригадынхан жижиг машинтайгаа өөр тийшээ яваад яалт ч үгүй ачааны машин, монгол гэрээ сахиад үлдсэн гэдэг. Ганцаараа үлдэнгүүтээ гэртээ сууж байгаад хагас шил архи уучихсан сууж байгаад гэрийн тооно руу харсан чинь сэгсийсэн урт үстэй хүн шиг хэлбэртэй хар бараан өнгийн зүйл тоонон дээр цомцойгоод суучихсан өөр рүү нь хараад байж байсан гэдэг. Үүнийг харангуутаа тэр ах үхтлээ айгаад уусан бүх юм нь гараад эрүүлжчихсэн гэдэг. Гэртээ байхаас айгаад ачааны машины кабиндаа ороод шөнөжингөө унтаагүй, бас зоригоо чангалах гэж хоёр шил архи ганцаараа уусан ч айснаасаа болоод согтоогүй, арай гэж өглөө болгосон гэдэг. Тоонон дээр суусан тэр сүнс гүйдэл шиг зүйлээс санаа авч Алтны үнэр өгүүллэгтээ би оруулж байсан юм.



Дундговь билүү Өмнөговьд нэг том албан байгууллага байдаг гэсэн. Тэнд хүмүүс сайндаа л 6 хоноод ажлаасаа гардаг нэг тийм сонин газар гэсэн. Тэгээд манай эгчийн найз тэр газарт ажилд ороод эхний шөнөдөө юу ч болоогүй өнгөрсөн гэсэн. Хоёр дахь шөнө нь хаалга хүчтэй салхинд онгойгдож хаагдаж байгаа юм уу хүчтэй онгойгоод л хаагдаад л тэгээд байж байснаа гэнэт ширээ сандал нь байрнаасаа хөдлөөд байсан гэсэн. Тэгээд зүгээр өөрийгөө тайвшруулаад тэр шөнийг аргацааж өнгөрөөсөн гэсэн тэгээд 3 4 дөх шөнө юу ч болохгүй чимээгүй өнгөрөөд 5дахь шөнө зурагт үзэж байгаад цонх руугаа харж жаахан зогсож байсан чинь нэг эмэгтэй хүүхдээ дагуулаад яг ардуур нь өнгөрсөн гэж байна лээ. Тэгээд эргээд харсан чинь хэн ч байхгүй зүгээр байсан зурагт нь гарахаа болиод зурагтынх нь дуу ихсэж багасаж байснаа таг болсон гэсэн. Тэгээд маргааш өдөр нь ажлынхаа хүнээс асуусан чинь нэг тийм гүйдэлтэй газар баригдсан байгууллага гэж хэлсэн гэж байна лээ.

\* \* \*

Манай нэг хамаатны ах юм аа. Одоо бурхан болсон л доо. Тэгээд талийгаач ах минь үхэхийнхээ хэд хоногийн өмнө нэг найзынх нь ээж нас барсан юм. Тэр найздаа тусалж ажил явдалд оролцсон юм. Тэр нэг удаа машиндаа цогцсыг ачиж явж байгаад төөрсөн гэсэн тэр айл нь хөдөөнийх л дөө. Тэгээд ах минь цогцос ачсан машинтайгаа яахаа мэдэхгүй найз луугаа залган би төөрчихлөө гэж хэлсэн. Гэтэл найз нь би ногоон өнгийн лазерын гэрэл тусгая тэрийг хараад ирээрэй гэж л дээ. Тэгээд ногоон гэрлийг хайн зогсож байтал нэг улаан гэрэл асах шиг болсон гэсэн. Тэгээд улаан гэрлийг мөн юм байхдаа гэж бодон улаан гэрэл рүү явсан гэсэн. Улаан гэрэл рүү ойртох тусам улам томроод тодроод байсан гээн тэр үед ах минь айсан гэж хэлж байсан. Тэгээд ажил явдал нь дуусаж гэртээ ажилдаа явж байсан хүн ажлынхаа хашаанд ороод шууд зүрх нь зогсоод бурхан болсон доо. Сүүлд нь алтан хайрцгийг нь нээхэд сүнс зайлсан байна гэж хэлсэн дээ.

\* \* \*

Сурагч байхдаа Сүхбаатарын сүнсийг дуудаж юм асуудаг байсан. Гэхдээ ирсэн үгүй нь бүү мэд ямартай ч улаан утсаар ороосон ном өөрөө эргэдэг байсан. Ирсэн бол баруун тийшээ гурав эргэнэ үү гээд тэгэхэд я баруун тийшээ гурав эргээд зогсдог байсан. Хэд хэдэн удаа дуудсан. Сүүлд тэр гэртээ шөнө халуураад 00 орох гээд явахад гал тогооны өрөөнд нэг хар сүүдэр ширээ тохойлдоод сууж байсан. Эхлээд эмээгээ сууж байна гэж бодоод эргээд ор луугаа явахад эмээ минь нөгөө орон дээрээ унтаж байсан. Тэр үед эмээтэйгээ хоёулаа хонож байсан

\* \* \*

Манайх хэдэн жилийн өмнө Эрдэнэтэд амьдардаг байсан. Манай байр ер нь жоохон эвгүй талдаа би жоохон байсан 7 8 настай байсан байх. Аав ээж 2 хот руу ирчихсэн. Ах эгч бид 3 хонож байсан. Тэгээд шөнө ахыг нэг юм дуудаад байж л дээ тэгээд харсан чинь цагаан халаадтай урт үстэй хүүхэн зогсчихсон гөлрөөд байсан гэсэн. Ах ч хөөрхий 2 дүүгээ айлгахгүй гээд бид 2ыг тэврээд нүдээ тас аниад унтсан гэсэн. Энэ тохиолдсон хачин жигтэй явдлаа ерөөсөө огт ярихгүй байдаг байсаар байгаад хот руу нүүж ирсэн хойно л нэг ярьж айлгаж билээ.

## Гүйдэлтэй дайралдсан нь

2004 оны зун найзуудтайгаа зусланд амрахаар явсан юм. Тэндээ очоод сагс тоглож , хоол эргүүлж , хажуу бүлгийн дүү нараараа массаж хийлгэсэн шиг л их л додигор байцгаасан даа. Орой үдэш нь нүүрээ оодож цагаан даавуу нөмрөн бүх бүлгийн байшингуудаар яваад л хүүхдүүдийг айлгаж, багшид хөөгдөн барин уйдаж завгүй л өнгөрүүлсэн санагдаж байна. Нэг өдөр нь зуслангийн цаахна нөгөө уулын энгэрт хэдэн том оврын машинтай хүмүүс гэр барьж байгаа харагдах юм. Бид ч юун хүмүүс юм бол гээд л анзааргатай байцгаасан юм. Төд удалгүй 2 гэр баригдаад л утаа униар болоод л хэнгэрэг хэц нүдээд эхлэлээ. Анх удаагаа бөөгийн хэнгэрэг хэцний дууг сонсож буй нь тэр юм. Уг нь тэр өдөр нартай сайхан өдөр байсан атлаа хар үүл нүүж ирээд нартай бороо орох нь тэр ээ . Бид ч гайхаад ямар сонин юм бэ гэж гайхшран харж байтал. Бороо зогсож , тэнгэр цэлмэж нөгөө уулын бэлээс тэдний байгаа зүгт бүр бөөгийн гэр рүү солонго татчихлаа шүү. Бид ч бүр алмайрч гайхаад багшийг гуйсаар о очиж үзье гэж гуйсаар байгаад багшаас зөвшөөрүүлж чадсан юм. Багш ч очиж уулзаад орой галын наадмын ёслол болно. Тэр үед ирж болно гэсэн гэнэ. Бид ч догдолж юм хумаа бэлдээд орой болтол хүлээсэн дээ. Орой ч боллоо бид ч очихоор болж бараг дийлэнх хүүхдүүд очсон доо. Анх очиход гэрийн тойруулаад улаан утсаар хашаа болгон хүрээлүүлэн татсан байсан юм. Бөө бөөлж байх үед тэр хавийн бүх л сүнс тийрэн чөтгөрүүд цуглачихдаг учир. Тэр улаан утсаар хамгаалалт хийсэн нь тэр юм гэж бидэнд тайлбарлав. Бөөлөх ёслолтой танилцаж , үзүүлэх хүмүүс нь үзүүлж. Мөнгө чадарлүүлэх нь мөнгө чөдөрлүүлж , охин чөдөрлүүлэх нь чөдөрлүүлэх зан үйл хийлгэв. Тэгээд буцах цаг болоод явахын өмнө түшээ нь бололтой үүдэнд зогсож байсан эгч бидэнд:

- За та нар орилж хашхирч чанга ярих , инээж болохгүй. Чимээгүй яваад зусландаа очоод амарчих гэв. Хоёр хоёроороо сугадаад хэлхэлдэж явбал юманд өртөхгүй. Гэхдээ чимээгүй яваарай гэсэн юм. Би Хосоо гээд бандитай сугадалцаад түрүүлээд явав. Зуслан луу дөхөж байхад нэг бургас модтой газрыг өнгөрөөд. Дээшээ өгсөөд л зуслалуугаа орчихдог байсан юм. Яг тэр бургастай газраар явж байтал. Хажууд явж байсан Хосоо гэнэт галзуу солиотой юм шиг инээгээд эхлэв. Яг тэр үед биднийг тойроод хар сүүдэр шиг юм тойроод гүйгээд байв. Гарах чимээ нь шувууны далавчны чимээтэй төстэй болохоор. Шувуу нисээд байна гэж бодтол шувуу гэхэд шувуу биш хүн дүрстэй сүүдэр шиг юм л тойроод гүйгээд байв. Бид хоёр ч сандарсандаа харанхуйд нүдээ аниад дл бургасыг хуга хуга дайраад цаашаа зуслан луугаа гүйсэн дээ. Тэгээд нэг мэдэх нээ өрөөндөө орчихсон бүгд намайг тойрчихсон уйлчихсан байх юм. Багш аргадаад л найзууд тайвшруулаад л өглөө болгосон доо ...Тэгээд өглөө нь бөө нар дээр буцаж очоод үзүүлтэл , дайрлагад дайруулчхаж. Сүнс чинь зайлсан байна гээд засал хийлгүүлээд дээрдсэн дээ. Тэр цагаас хойш бөөгийн зан үйлд итгэж . Мөн гүйдэл гэж байдаг юм байна гэж бодож. Орой үдэш сонор сэрэмжтэй явдаг болсон юм.

\* \* \*

Энэ явдлыг эмээ минь надад хуучилж суухдаа муу ээж минь олон хүүхдүүдээ өсгөх гэж их л зовсон байхдаа гээд л эхэлсэн юм. Иймэрхүү сүнс сүүдэр чөтгөр шулам гэгчийг элэнц эмээгийн маань үед ярихыг хориглодог байж л дээ эмээг маань өлгийтэй байхад л болсон явдал юм гэнэ хэзээ сүүлд нь эмээд маань ээж нь ярьж өгсөн гэдгийн. Дээхэн үед юм гэсээн өөрөөр бол манай элэнц эмээгийн үед юм. Одоогоор бол Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд

болсон явдал гэсэн. Манай элэнц эмээ залуудаа найз хүүхнийхээ хамт энд тэндхийн найранд уригдаж дуулдаг нутагтаа алдартай сайхан дуулдаг нэгэн байсан юм гэсэн тэгээд нэг удаа нөгөө л найрандаа найзтайгаа уригдаж дуулж хуурдаж айраг цагаа нэрмэл энэ тэр их уугаад найз хүүхэн нь нэлээн халамцуу мориндоо мордоод явсан гэсэн тэгээд давхиж яваад мориндоо чиргүүлээд нас барчхаж. Тэр явдлаас хэдэн жилийн дараа манай эмээ төрсөн гэдгийн. Тэгээд эмээг маань өлгийдөж орхиод элэнц эмээ маань аргал түүх гээд явсан гэсэн. Тэгтэл нээх танил хоолой л дуулаад байсан гэж байгаа гайхаад дуу гарч байгаа зүгрүү хартал нөгөө нас барсан найз хүүхэн нь аргал түүгээд тоорцог-он малгай өмсчихсөн дуулаад л явж байсан гэсэн элэнц эмээ ч айгаад тэр чигтээ гэр лүүгээ харайчихсан гэсэн гэртээ орж ирээд л байж байтал араас нь хаалга нь онгойгоод хий юм дараад л орон дээр унасан гэсэн мэддэг маань мэгзэмээ уншаад нэлээн удаан зууралдсаны дараа л аажмаар суларсаар алга болсон гэсэн. Тэгээд хөөрхий дээр үеийн эрчүүд нь мал хуй гээд л алга болчихдог байсан байгаа юм тэгээд элэнц эмээ маань хөөрхий өөрөө гэрээ буулгаж тэмээн дээр ачаад л эмээг маань аваад тэр газраас холдож нүүсэн гэж ярьж билээ.

\* \* \*

Манай эмээгийнх хотоос 37 км.т байдаг 361 гарам гээд газар байдаг байлөө 10 гаран жил бараг байсан бай хөө. Тэнд зун өвөл гээд л хичээлийнхээ амралтаар их очин оо. Тэнд сүнстэй газар гээд л хүмүүс их ярина тэгээд нэг удаа найзуудтайгаа сагс тоглочхоод 3 найзтайгаа яв байлаа тэгсэн харуй бүрий л дөнгөж болж байсан байх нөгөө сүнстэй гээд байдаг жижиг жалганы хажуугаар өнгөрч байтал манай найзыг хүн нэрээр нь дууддаг юм байна эргээд харсан 40 орчим насны ах жалганы хажууд завилаад сууж байна би ч саваагүйтээд гүйж очоод л дуудсан уу гэсэн чинь миний хөлийг гараараа тэврээд л авах шиг болсон тэгсэн мөртлөө гар нь миний хөлийг нэвтлээд л гарчихсан бид хэд ч орилолдоод л гүйчихсэн хэсэг гүйж байгаад эргээд харсан тэр ах алга болчихсон байсан. Бас нэг удаа найзуудтайгаа нэгнийхээ төрсөн өдрийг тэмдгэлдийм болоод л ууж идэв ээ тэгсэн манай 2 найз хоорондоо маргалдаж байснаа нэгнийгээ басаж байн аа тэнд байдаг нүхэн гүүр гээд нэг газар байдаг байсан юм бас л сүнстэй гэгддэг тэгсэн чаддаг юм бол тийшээ явчих энэ тэргэсэн нөгөөх нь уучихсан гар тэгнэ чадна гээд л гараад явлаа тэгэхэд шөнө 12 хавьцаа л болж байсан байх хэсэг байж байгаад орж ирэхдээ элийрчхээд ороод ирсэн ийш тийш зааж намайг авч явна гэж байна гэж хий юм хараад л тэгээд өглөө үүр цайтал элийрсэн тэгээд арай гайгүй болохоор нь асуутал гүүрэн дээр очсон ард нь юм дуугарсан тэгээд л эргэж хараад юу болсныг санахгүй байн аа гэж билээ.

\* \* \*

Манай ахын найз байдгийн тэгсэн тэр шөнө болохоор л унтдаг өрөөнийх нь толинд ээж нь өөрийнхөө хөдөлдөг сандал дээр сууж харагдаад унтаж чадахаа байлаа заавал архи ууж байж л унтдаг боллоо гээд л байсан юм. Ээж нь нас бараад удаж байгаа юм л даа. Тэгээд нэг бөөд үзүүлж гэнэ яах ёстой вэ гээд тэгсэн нөгөө бөө нь энэ толинд их учир байн аа наад толио гаргаж хаях хэрэгтэй гэсэн гэж байгаа. Хэсэг байж байгаад ах асуусан гэнэ за яасан нөгөө толио яасан унтаж амарч чаджийнуу гэсэн нөгөөх нь өө сайхан амарч байгаа толио гаргасан гэсэн тэгээд хаана хаясан гэсэн ахынхаа өрөөнд оруулаад тавьчихсан гэсэн гэж байгаа сайхан гар шүү. Тэгсэн харамсалтай нь тэр ах нь тэр явдлаас нээх удаагүй машины ослоор нас

барчихсан. Тэгэхээр толь их муу энергитэй ялангуяа хүний хуучин толь их муу энергитэй гэдэг юм байна л ээ аль болох хуучин толь хэрэглэхгүй байхыг хичээгээрэй...

# Дөрөвдүгээр бүлэг

## Завсрын ертөнц

Би нэг удаа найзындаа очиж хоносон юм. Тэднийх ногоон толгой гээд газар байдаг л даа. Удаан уулзаагүй гээд л найз маань хоол унд хийж гүйгээд л дайлж цайлаад сүйд. Тэгээд унтах болов оо миний нойр хүрдгүй тэднийд нэг дээр үеийн хавгастай эвхдэг орос толь байсан юм надад нэг л ёозгүй санагдаад унтахдаа эвхээд хаачихья гэсэн айлын юмыг дураараа бас хаашаа ч юм гээд тэр чигт нь унтахаар болов ядаж байтал яг тэр толиныхоо доор газар ор засаад өгчхөв. Унтах гэж нэлээн хэвт сөөн яагаад ч болдгүй хөрвөөгөөд л шөнийн 3 хавьцаа болж байсан байх би сэрчхэв ээ тэгсэн хөл доор нэг өвгөн сууж байна би ч гайхаад л юун өвөө вэ гэж бодоод л хэвтээд байлаа нэг л сонин хөдлөхгүй дуугарахгүй нэг л эвгүйтээд явчлаашүү би ч бушуухан хөнжлөө бүтээгээд хэвтээд байсан нэг мэдсэн унтчихаж. Өдөр бараг 12 болтол унтаад хоолны үнэрээр сэрэв ээ найз маань хоолоо идээрэй босоорой л гэж байна хоол идээд сууж байхдаа яаж дуугүй бай хав гээд шөнө харсан юмаа хэллээ тэгсэн тэднийх төмөр замын гармын байшин л даа 1 байшинд 2 юм уу 4 айл байдаг тэднийх бол 2 айлтай байшин. Тэгсэн нөгөө талд нь амьдардаг байсан ганц бие өвгөн байж байгаад нас барчихсан гэнэ тэгээд шөнө болохоор л ямар ч хүн байхгүй байгаа атлаа хүн байгаа юм шиг дуугараад л түжгэнээд байдаг гэнэ тэгээд тэр өвгөнийг л би харсан юм шиг байгаа юм. Харин тэр толь бол хадмынхаас нь ирсэн толь юм гэсэн хадам аав нь бас нас барчихсан юм гэсэн. Тэгэхээр би бол толинд их муу энерги шингэдэг гэж боддог болохоор аль болох хуучин толь хэрэглэхгүй байхыг хичээдэг дээ.

\* \* \*

Тэрэлжийн мэлхий хаданд болсон юм өө 2р курс л байсан байх ангиараа амрахаар очсон юм. Мэдээж л орой нь ууж идээд л баахан л сүнс чөтгөр ярив өө. Тэгсэн нэгнийх нь ах нь тэр амралтыг ажиллуулдаг байсан юм тэгээд л тэр хойно уулан дээр 2 давхар цагаан байшин байдаг юм тэнд бүх юм нь яг хэвээрээ хэн ч орж юу ч авдаггүй авсан хүнд муу юм болдог залуухан эхнэр нөхөр 2 байдаг байсан гэнэ тэгээд нөхөр нь эхнэрээ хардсанаасаа болж мөчилж алаад камен зуухандаа хийгээд шатаачихсан гэсэн энэ тэр гээд ярьж гарав өө тэр шөнөдөө тэгсгээд л унтацгаалаа. Маргааш нь үд нэлээн өнгөрчихсөн байсан юм. Нар арай ч жаргаагүй байсан тэгээд охид хөвгүүд нийлсэн 8 9үүлээ л нийлээд нөгөө байшинд орж үзэхээр болоод очсон юм. Хаалгыг нь 2 том банзаар хадчихсан байсан харин цонх нь нэлээн өндөр том бас хагарчихсан тэр зайгаар нь зүсэгдэхвий гээд л маяглалдаад сүйд болж байж л орсон юм даг үүдээр нь ороход үнэхээр л камен зуух байна шүү зарим нэг тавилгууд бас байсан дээшээ 2 давхар луу нь шууд гарсан нэг жижиг өрөөнд орсон тэнд дээр үеийн хавгастай орос толь байсан нэг талынх нь хавгасны толь хагарчихсан байсан тэгээд том өрөө рүү нь дөнгөж ороол байж байтал жижиг өрөөнд эмэгтэй хүн орилоод л явчихсан бид хэд ч гүйгээд очсон чинь ангийн нэг охин нүүрээ дараад газар хэвтэж байсан яав ийв гэсэн сая намайг тэр толинд харахад миний хойно нэг эмэгтэй хүн зогсож байсан гэж авдаг юм бүгд пир пар гээд л гараад л гүйсэн нөгөө зүсэгдэхвий гээд байсан хагархай цонхоороо яаж ч гарсан юм бүү мэд амралтын гэртээ ирэхэд нөгөө охин маань бүр элийрээд хий юм хараад орилоод л үүр цайлгасан бид хэд ч багшдаа аймшигтай их загнуулсандаа харин өглөө болоход

ухаан санаа нь гайгүй болсон юм даг.

\* \* \*

2006 онд сургуулийн төгсөлт болж хөдөө хээр ангиараа зугаалж яваа хүүхдүүдээс их юмгүй болсон байлаа. Тэдний л нэгэн адил Базараагийн төгсөлт болж ангийнхан нь хотоос холгүй хэн нэгэн амралтын газар явж амрах болж 2 багш эцэг эхийн төлөөлөл гээд нийт 31хүн амралтын газрыг зорилоо. Замдаа саатаж удалгүй 2 цаг хэртэй давхиад өнөөх амралтын газартаа ирцгээж тус тусын гэрүүдэд хуваагдан орцгоолоо. Базараа ч 4 найзтайгаа нэг гэрт орж юм хумаа цэгцэлсэн болоод нэг шил архи тойруулаад дуусгачхав. Залуус ч жоохон халаалт аван сэтгэл санаа сэргээд ирсэн байна. Төд удалгүй орой ч болж шөнийн галт наадам хийцгээж ууж идэн багш шавь эцэг эх гэлтгүй халцгаасан байлаа. Базараа 2 найздаа хажууханд нь байх уул гарч юм ярьж суунгаа ганц хоёр шил юм уух санал гаргахад нөгөө хоёр нь ч уухайн тас зөвшөөрөв. Олуулаа гарч хоёр шил юмаа алдчихгүй гэсэндээ амьхандаа л ангийнхнаасаа нуугдаж явцгаалаа. Уулан дээр гарч хоёр шил архиа ч тойруулж эхэллээ. Эхний шил архи дөнгөж талдаа орж байлаа. Нэлээн харанхуй болсон байсан учир нэгнийгээ дүрснийх нь баримжаагаар л харж байлаа. Гэтэл нэг мэдсэн дөрвүүлээ болсон байлаа. 2 найзынх нь голд нэг хүн ирж суужээ. Базараа ангийнх нь нэг тэр 3-г уул гарахыг хараад дагаад ирж гэж боджээ. Аяганд нь архи хийгээд өгтөл чимээгүйхэн авч уугаад буцаагаад өгч байна гэнэ араас ирсэн юм байна дахиад нэг уучих гэж хэлээд хийгээд өгтөл дахиад л уучхаад өгч гэнэ. Гэтэл хамт явсан 2найз нь Базарааг чи хэнтэй ч яриад байгаа юм гэхэд Базараа: Та 2-н дунд сууж байгаа нөхөртэй ярьж байна чи хэн бэ гэтэл хариу дуугарахгүй суугаад л байлаа. 2 найз нь гайхаж нэгэн рүүгээ харлаа тэгснээ гурвуулаа л байна шүү дээ юу яриад байгаа юм гээд Базараа найзуудыгаа тоглож байна гэж бодоод за за юундаа тоглоод байгаа юм ангийнхан юу болцгоож байна чи хэн юм гээд мөрөн дээрээс нь барих гэтэл хий атгагдаж гарт нь маш хүйтэн зүйл мэдрэгдэв. Тэрхэн үед Базараагийн уусан архи гарч хойшоогоо саван уналаа. Хамт явсан хоёр нь ч айж гайхах зэрэгцэн байхад Базараа арай ядан босож 2 найзаа дагуулан зугтлаа. Өнөөх хүн нөгөө л байрандаа суусаар байв. Базараа найзуудынхаа хамт зугтаж байхдаа халыг гишгэн гуядаа мод шааж орхижээ. Хэчнээн өвдөж байсан ч 2 найзыгаа хүзүүдэн гурвуулаа санд мэнд ангийнхан дээрээ ирцгээлээ. Болсон зүйлийг ээрч мууран багш нартаа хэлэхэд тэр гурвын хувьд зугаалга нь түүгээр төгсөж 2 найз нь гэр лүүгээ Базараа гэмтлийн эмнэлэг явжээ. Эмнэлгээс гараад аав ээжтэйгээ бөө дээр очиход сархад хүртэх есгүй газар сархад хүртэж авч явсан сархдаасаа амсуулсандаа амь мултарсан байна гэж хэлсэн гэдэг.

\* \* \*

Манай суманд бас нэг хуучин эмнэлэг байдаг. Гэхдээ одоо ахуй үйлчилгээний газар болчихсон ашиглаад л байгаа. Дэлгүүр явах замд байдаг юм. /товчлоод явбал хажуугаар нь гарна/. Хажууд нь нэг айл буучихсан нэлээн удаж байна. Эмнэлэг хашаа 2н дунд нарийн гудам шиг юм гаргачихсан. Би гурван настай жоохон дүүтэй юм. Зуныг дүүгээ хараад л өнгөрөөж байгаа юм өө. Дэлгүүр энэ тэр явбал дүүгээ аваад л нөгөө нарийн гудамжаар явна шүү дээ. Манай дүү тэр хавиар явахаар дандаа тэврүүлж явна. Нэг удаа жоохон хүүхэд сүнс сүүдэр янз бүрийн юм хардаг гэсэн гэж уншиж байснаа санаад энд мангаа байна уу? гэсэн чинь манай дүү шууд хуучин эмнэлгийн дээвэрлүү зааснаа тэнд байна гэсэн. Дараа нь бас

цонхруу нь заасан. Би ч пал гээд л явчихсан. Гэрлүүгээ буцах замдаа өөр тойруу замаар яваад харьсан. Хашаандаа ороод энд маньгаа байна уу? гэсэн чинь байхгүй байна гэсэн. Их л сонин санагдаад байдаг юм үнэхээр жоохон хүүхдийн нүдэнд сүнс чөтгөр нь харагддаг юм гэж үү...

\* \* \*

### **Хүний гэрлэн бүрхүүлийн тухай нэгэн гишүүний сэтгэгдэл**

Аура бүрхүүл гэж их эмзэг. Бүрхүүл тод байх тусам л муу муухай зүйл хол байна. Бүрхүүлийг үгүй хийж байдаг зүйлс бол нөгөө л нэг архи дарс муу муухай зүйлс дээр нь амьдарч буй орчны нөлөө өөрийн санаа бодол их нөлөөтэй. Өөрөө хэдий чинээ сайхан юм бодож санана тэрний хүчээр аура улам тод гэрэлтэнэ. Муу муухай зүйлс хэлж бодох. Хэрэглэх тусам гэрлэн бүрхүүл бүдгэрч, муу муухай албин тийрэн гэгч үүд салахгүй ойр болно. Ингээд л наад зах нь ажил төрөл бүтэхгүй, өөрийгөө ч хянаж чадахгүй муу зүйлсрүү руу татагдаж амь насаа ч алдах аюултай гэж боддог .

\* \* \*

Хүнд атаархана гэж бас их хар энергийг цацдаг юм шиг. Миний сайн найзад нэг зүйл тохиолдсон юм ./ гэртээ ахтайгаа байдаг/ Өөртэй нь өрсөлддөг ч найз гээд л явдаг нэг охин байдаг юм. Наанаа няль няль гээд л цаагуураа жоохон бруу санаа өвөртөлж явдаг юм шиг байгаа юм. Нэг орой манай найз гэрлүүгээ орох гээд лефтнэс буусан чинь орц нь харанхуй гэрээнүүд нь асахгүй харанхуй байжээ. Тэгээд түлхүүрээ гаргаад л нүхээ тэмтчээд л хаалганыхаа бариулаас нь барьтал хаалганы бариуланд нь сүүзжний яс өлгөчихсөн байсан гэсэн. Угийн нэлээд аймхай юм болохоор гэртээ яаж орсноо санадаггүй гэсэн. А х нь ирээд тэр ясыг нь гаргаад хугалаад хаячихсан гэсэн. Тэгээд маргааш нь таньдаг бөөдөө үзүүлтэл нөгөө охиных нь гадаад төрх нэрний эхний үсэг энэ тэрийг нь хэлсэн гэсэн. Тэгсэн их атаар хуу охин байна. Гэрээрээ нэг үзүүлж харуулдаг их хүчтэй хүнтэй юм. Нээх муу биш ч ажил төрөлд чинь саад хийх гэсэн байна. Би хариулж чадах юм байна гээд өнгөрсөн гэсэн. Тэрнээс хойш өөр иймэрхүү юм болоогүй. Харин өвчин ороогоод, байхаар нь бас үзүүлтэл удмын сахиус нь ирчихсэн юм байна гэсэн. Гэхдээ одо болтол сахиусаа буулгаагүй байгаа байхаа, бие нь дээрдээд л буцаад л өвдөөд л. Сахиусаа буулга гэхээр өөрөө айгаад ч байгаа юм уу дургүй байгаа юм уу үгүй л гэнэ. Тэгээд сахиусыг нь хариулна ч гэлүү буцааж болдог юм шиг байгаа юм. Таньдаг бөө ах нь хариулж чадна гэсэн гэж байсан одоо уулзаагүй удаж байгаа болохоор юу болсны сайн мэдэхгүй байна. Нэг өдөр удган болчихсон гээд гараад ирж магадгүй л яваа байх. / Хэхэ / Ярьсан яриа нь болохоор санаж байгаа эвлүүлж бичих гэж оролдлоо.

\* \* \*

2012 Онд Америк улс руу ээлжит аяллаа хийх гээд яв бөө. Очоод л ээж эгч 2ыг тэндэх гэрт үлдээгээд л ганцаараа баруун эргээр зугаалав. Дээрээс нь доош явах төлөвлөгөөтэй Сиэтл хотод очоод таньдаг нэг ахынд хэд хонов. Ах хүүгийнх тэндхийн нэг хөгшчүүл асардаг байранд нэг өрөө түрээсэлдэг байсан юм. Хэд хоног ч гайгүй байсан юм. Би ч өдөр нь баахан явж явж оройхон ирээд л унтаад өгдөг байсан юм. Тэгсэн нэг өдөр ах хүү ярьж байна. Энд ер

нь хөгшчүүл тэгээд л байж байгаад гарах нь гараад, эндээ нас барах нь барна. Заримдаа ч эвгүй шүү. Хаалга онгойно, хана тогшино, хүн алхана. Дүү ирээд ханьтай хоноод амар байна гээд л ярихаар нь би нээх тоосон шинжгүй заа тоглоод гээд л өөр юм ярьж байгаад унтацгаалаа. Ах нэг нарийхан ганц ор, зурагт ширээ нэг сандалтай. Ганц өрөөнд өөр юу байхав. Би газар унтана. Сандал дээр нь би өөрийнхөө хувцсыг эвхээд л, цамцаа тохчихдог байсан юм. Тэгээд л тэр шөнө унтаж байгаад л нэг эвгүй оргиод сэрлээ. Хойно байгаа сандал нэг л эвгүй санагдаад эргээд харсан шоконд орсон.

\* \* \*

Яалт ч гүй сандал дээр нэг хар юм суучихсан доор унтаж байсан надруу дээрээс гөлрөөд сууж байна. Миний тохсон цамц, эвхээд тавьсан шорт футболк ингэж аймаг сүртэй харагдана гэж байхгүйдээ гээд л хараад л байсан чинь яалт ч гүй урдаас хараад, нүдээ цавчлаад ч байгаа юм шиг харагдаад. Тэгээд бүүр гараа явуулж үзсэн хаха. Заа больё гээд эргээд хараад хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд хэвтсэн чинь зүрх авангаа алдсандаа. Онгойх төдий Хаалганы засвараар нарийхан зураас төдий харагдаж байсан хаалга саваад л хаагдсан. Ах цочиж сэрээд юу вэ гээд л, би ч тэгээд тэгсэн ингэсэн гэж хэлээгүй, буцаад л хэвтэцгээсэндээ. Хөнжил дотроо ороол утсаа оролдоод л, фэйсбүүк ороод Монголд өдөр болж байсан болохоор энд байсан найзуудруугаа сенсацлаал бөөн юм болж билээ.

\* \* \*

Ер нь тэнэмэл гэдэг билүү тиймэрхүү сүнс тийрэн нуурын эрэг дээр их байдаг уу гэлтэй Архангай Өгий нуурд би бас айхтар юм харсан аймшгийн гэхэд хаашаа инээдтэй юм болсон. Архангайгаар аяллаа энэ зун тэгээд л Өгий нуур дээр буудаллав аа оройн нь бөөнөөрөө нохой дөрөв харагдтал ууж идэв ээ . Зөнгөрлөө цаг ч сүнс муу бүхэн сэрэх цаг гээд л би ч дотроо бодоод бушуухан унтъя гэж бодоод л найзууд эхнээсээ энэ тэнд бөөлжих нь бөөлжөөд тэгээд л би найзыгаа бөөлжүүлэв ээ тэгээд л нрууг нь араас нь дараал өөрөө харчихвал бөөлжих гээд болдоггүй нүдээ тас аниад гартаа бас жожколкны гэрэл барьчихсан тэгээд л за за одоо болоо байлгүй гээд найзруугаа чийдэнгээ тусгаад л харсан чинь яг цаана нь эмэгтэй хүн шиг ч юм шиг эрэгтэй хүн шиг ч юм шиг эрэмдэг дүү юм зогсчихсон хэсэгтээ шоконд орж зүгээр зогссон байхаа тэгээд л гэнэт сэхээ ороол орилов оо тэгээд юун найз ганцаараа мангар хурдан гүйчихсэн араас яав аа яачхав аа гээд л уйлаад нөгөөх чинь бас гуйдаг юм. Тэхээр нь би харин сая хараад гээд л найзыгаа тайвшруулах санаатай яриад л байсан байх яах аргагүй л тэр охины ард л байгаад л байгаа нь тэгээд л бусдыгаа дуудаад нөгөө охиноос арай гэж салсан дахиад тэр охинтой харьцаагүй дээ нэг л жийрхээд.

### **Хөдөө гүүр хийсэн сурвалжилга / хөгшчүүлийн хууч яриа/**

Манайхан алмас хээрийн хүн гэж янз.бүрээр л ярьдаг нэгэн буурай түүний талаар надад ингэж ярьж өгсөн юм

Нэгэн залуу малд явж байгаад.ор мөргүй алга болж гэнэ. Нутаг усаар.л.нэг хайж сүүлдээ ч бүр горьдлого тасарч эрэл сурлаа зогсоож гэнэ. Харин өнөө залуугийн хувьд бол нэг юм араас нь маш хүчтэй нударх шиг л болсон , тэгээд л ухаан алджээ.



Тэгээд гэнэт их л халууцаад сэргэсэн чинь ихээ том агуйд байж байх юм гэнэ .Эргэн тойрноо харвал хүн байдаг гэхээргүй хэдэн муу адсаганаас өөр юмгүй үүдний зүг малынх бололтой эрүү толгойн яс байна гэнэ. Юу юугүй эвгүйрхээд гарах хаалга хайхад үүдийг нь маш том чулуугаар тагласан байх юм гэнэ. Залуу цангаж гарах арга чарга хайж амь.тэмцэж байтал ямар нэг нүсэр юм алхлан ирж чулууг хөдөлгөн орж ирсэн нь еэ бүү үзэгд үс гээг нь сэгсийж хөх дэлэн нь.унжсан осолдохгүй л эм хүйстэй өнөө хөгшчүүл үлгэр домог шиг яриад байдаг алмас гээч нь аж. Хатаж үхэх гэж байсан залууг юу юмгүй барин авч амнаасаа ус нүүрэн дээр нь.асгажээ

Залуу хашхиран орилвоос өнөөх чинь.уурсан догшрох нь.их бөгөөд өнөө муу агуйгаа нураачих шахах нь ганцхан үсэрч ирээд алчих вий гэх бодол төрүүлнэ. Ингэж өдөр.хоногийг барж үүдээ дарж яваад л ирэхдээ залууд тарвага зурам ус гэх зэргийг авчирч тэжээхээс гадна хамаг хувцсыг нь.уран тастаж бүх биеийг нь.долоох юм гэнэ . Улмаар эвцэлдэж алмас ч хөл хүнд болж тамир тэнхээ алдаж залуу хаа нэг ойр орчим ус гол хавьцаа ойр зуур гардаг болж. Нэг л мэдэхэд биеэр нь алмасынх ижил үс ургажээ Гэвч хүн юм болохоор яаж түүний гараас гарах арга чарга хайсаар байж уснаас айдгийг нь мэдэж авчээ. Цаг хугацаа өнгөрч алмас ч төржээ .

Залууг одоо хаачхав гэсэн байдалтай хаа нэг гаргадаг ч болж залуу үүнийг нь ашиглаад нэг л өдөр зугтжээ. Өнөөх амьтан чинь муухай орилоод араас нь хүүхдээ шүүрээ л хөөж л дээ. Залуу арай гэж амжин үерлэн шуугьсан их голын цаана гарахад алмас ч ойрхон ирж .Алмас их хурдлахаараа хоёр хөхөө мөрөн дээгүүрээ давуулж шидээд гүйдэг гэнэ Тэгэхээр улам хурдан болдог ажээ Өнөө алмас уурлан бархирч гасалж сүүлдээ хүүхдээ цээж бөгсөөр нь.салгаж ус шидчхээд нөгөө эргээсээ буцаж л дээ Хадан дунд амжиж нуугдсан залуу хөл мэдэн гүйсээр айлын бараа харж гэгээ тасрахыг хүлээж байгаад холоос арга учраа хэлэн хувцас хунар өмсөөд тэр айлд ороход халиурсан их үстэй түүнээс бүгд.жийрхэн чөтгөр харсан юм шиг л болж .Залуу ч хамаг учраа хэлж Халиурсан их үсийг нь баавгайн тосоор гуужуулж авсан гэнэ лээ. Энэ бүүр сүүлд 80аад оны эхээр ч нутагтаа эсэн мэнд байсан гэнэ лээ Түүний талаар тэмдэглэсэн баримт сэлт ч байдаг нь үнэн юм билээ.

\* \* \*

Би найзтайгаа шөнийн 4цагт машинтайгаа халтуур хийж байгаад " Цайз " аас хүн аваад буцаж байхад нэг жоохон 4 настай хүүхэд нэг хашааруу орсон юм. Ийм жоохон хүүхэд харанхуй шөнө юу хийж байгаа юм бол гэж бодон харсан чин тэр хашаа хаалгагүй бас ямар ч гудам нүхгүй. Ногоо хүүхэд хашааруу уусчихсан юм шиг алга болчихсон хамаг үс босож билээ.

9-р ангид байхад аав ээжийн найзуудтай Хөвсгөл явсан юм. Тэгэхэд аавын найз нэг ах сэргэлэн, царайлаг ер аягүй лаг мундаг ах байдаг байсан юм. Тэгсэн сая зун дахиад найзуудтай нь явсан чинь тэр ах саажилттай хүүхэд шиг хэл яриа нь ойлгогдохгүй хачин хүн болчхож энгийн гэж лав хэлэхээргүй яасан юу болов яагаад ингэв? гэсэн чинь найзтай болохгүй газар хөндөөд алт ухаж байна гээд л лусын хорлол болсон сурагтай. Тэр найз нь нээх удаагүй нас барчихсан харин тэр аавын найз нь нас барахыг нь харахдаа шоконд орсон уу яасан бас хаа нэг юм ярихдаа нөгөө нас барсан ах хажууд нь байгаа юм шиг ярьдаг. Орилж хашхирна их юм болно ш дээ лус энэ тэр гэж байдаг л юм шиг байгаа юм. Бодолтой явахгүй бол бас болдоггүй хорвоо гэж.

\* \* \*

Баян хошууны 112-н буудал байдаг даа тэр газар гүйдэл ихтэй юм байна лээ. Би 2 жилийн өмнө түрүүвчээ алдаад автобусанд суйлуулсан юм аа. Тэгсэн оройхон надруу нэг хүн залгаад түрүүвчийг чинь оллоо ирээд ав гэж байна намайг 112-н буудал дээр ирээд ав гэж байна би урьд нь тэнд нэг ч удаа очиж үзээгүй газарлуугаа яаж ганцаараа явах вэ тэгээд ээжийгээ дагуулаад явлаа. Нөгөө газраа ч очлоо ээжийг машиндаа үлдээгээд буулаа. Түрүүвчин дотроо бүх бичиг баримтаа хамт хаясан болохоор очиж авахаас өөр арга байгаагүй юм л даа. Нөгөө утсаар ярьсан хүнийг хүлээгээд дэлгүүрийн тод гэрэл доор зогсож байтал яг хажууд нэг улаан пальто өмссөн 10 юм уу 12 настай охин эрээд зогслоо би ч эхэндээ харанхуйд хүн бараадаж яваа жоохон охин байна гээд тоосонгүй тэр охин юм хэлэхгүй их удлаа би чи хүн хүлээж байгаа муу гэж асуулаа дуугардаггүй ээ тэгсэн нөгөө түрүүвч олсон ах ирлээ би ч түрүүвчээ аваад машиндаа суулаа тэгсэн нөгөө охин тэр ахыг дагаад яваад өглөө би юун айхтар юм бэ хүүхдээ эхэлж явуулаад цагдаа харуулж байгаа юм байна даа. Хэрэггүй мөнгө өглөө гээд бодчихоод машиндаа суусан чинь ээж чи хэнтэй юм яриад байсан бэ гэхээр нь тэр хүний охинтой гэсэн чинь тэр чинь ганцаараа ирсэн ш дээ гэдэг байгаа би бүр хамаг бие арзайгаад хүйтэн хөлс цуваад л дуу гарахаа больсон сүүлд бодох нээ зун пальто өмсдөг ямар хүн байхав дээ тэр охины өвдөг нь шалбарсан байсныг нь сүүлд санасан шүү

\* \* \*

Бичих гэхээр эвлэхгүй юмаа. Ноднин цагаан сараар хүргэн ахындаа очсон юм. Аав ээж айл хэсээд явчихсан. Тэднийх гэрээрээ ахындаа ч билүү хаматныхруга явчихсан байсан. Би ганцаараа үлдчихсэн том өрөөнд нь тв үзээд сууж байсан юм. /тэднийх Знастай бандитай. Бэлгэндээ макуин машин авна гээд манайх удирдлагатай макиун бэлгэнд өгсөн байсан юм/ тэгсэн жижиг өрөөнд нь машин хаазлаад л түг гэл юм мөргөд ахиж явж байгаа юм мөргөөд байгаа чимээ гараад байсан. Би гайхаад /иймэрхүү юм мэддэг л дээ.гэхдээ анх удаа болохоор айх гэх нь хашаан жоохон сонин болсон/өрөөний хаалга нь онгорхой байсан болохоор очоод харсан чинь нөгөө бэлгэнд өгсөн машин нь цонхны тавцан дээр урагшаа явж хана мөргөөд л буцаж явж хана мөргөөд л гэрэл нь асаалттай анивчаад байж байсан. Би очоод харсан удирдлага нь компьютерийн ширээн дээр унтралттай байсан. Харин машин нь асаалттай. Тэгэхээр нь машиныг нь унтраагаад тавьчихсан.тэгээд нэлээн гайхаж жоохон ажиж зогссон. Ахиж хөдлөөгүй. Уг нь шинэ байранд орсон байсан болохоор юм баймааргүй л юм. Гэхдээ гэрийнхэнд хэлээгүй ээ. Хэлсэн ч итгэхгүй байсан байх. Анх удаа юм бичиж байна.

\* \* \*

За би бөөгийн түшээ хийдэг хүн л дээ. Би их аймхай болохоор онгод ууд надад юу ч харуулж мэдрүүлдэггүй юм. Харин өөр түшээ улаач нар бол албингуудыг мэдэрч зарим тохиолдолд мэдэрдэг. Нэг удаа улаач маань буух гээд дэлдлээ. За.тэгээд. өвөө ч буугаад ирлээ. Аахилж уухилаад л... би ч цай мах тогооны нэрмэл гээл ундаалаад л байлаа. Юу ч дуугарахгүй л байлаа. хажууд нэг өөр зайран байсан юм. Тэр гэнэт л хаааааш гээд л аймар орилоод буусан улаачийн араас ташуурдсан. Тэгээд хөл толгой нь мэдэгдэхгүй орилоон болоод байсан. Би маш их айгаад юу ч хийж чадаагүй.тэгээд гэнэт улаач орилоод майхавчыг нь авахад хамар амнаас нь зэрэг цус садарсан. Улаач сахиусаа зүүхээс мартсанаас болоод биед нь албин орсон байсан. Би сул хүчгүй байсан болохоор албинг хооллож ундаалаад маш хүчтэй

болгосон байсан. Дараа нь улаач хувцсаа тайлахад нруун дээр нь маш муухай хумсны урчихсан улаан ором байсан.

\* \* \*

Булганы Орхон суманд нэг хун чулуу байдаг гэнэ. Нутгийнхан тэр чулууг юм уу тэр хавийн газрыг нь ч юм уу гүйдэлтэй гэж ярьдаг юм байж. Нэг удаа нутгийн хэдэн залуус архи ууж халамцаад үдшийн бүрий тасарсан хойно тэр гүйдлийг нь очиж харъя үзье болоод явж. Тэгээд л тэр чулуу луу хэдүүлээ очоод нэг нь уусан юмандаа их л зоригтой хүн. Хүүе хаая сүнс буг чөтгөрөө гээд л орилж хашхирч тэгсэн ногоо чулуу хавиас л яасан бэ чи чинь хэний сүүхэд вэ гэж гэнэ. Ногоо халамцуу баатрууд морьдоо эргүүлээд л ум хумгуй зугтаж араас нь л хөөе хаая гээд л орилоод дуудаад байна гэнэ. Ногоо хэд ч архи нь гарчихсан сүнс нь зайлчихсан юмнууд л ирж гэнэ. Гэрт үлдсэн хэд нь шоолоод боон инээдэм очиж үзье юу л байв гэж гээд мордоцгоож, явж очсон чинь нутгийн нэг хун мориноосоо унаад гэмтчихсэн чулуу түшээд сууж байсан гэдэг. Айсан хунд аргал хөдөлнө гэж нэг юм байна шүү.

\* \* \*

Дамбад билүү хаана билээ нэг хаягдсан эмнэдэг байдаг гэсэн. Би очиж үзээгүй л дээ. Манай найз жаахан байхдаа дүрсгүйгээд хэдэн найзуудаараа очсон юм байхаа. Учир нь сүнстэй шат нь алга болдог гээд шалгахаар явсан юм байх очоод 3 4 найз нь ороод энд тийм юм байна энд ийм юм байна гээд л хэлээд байж. 2 нь 2 давхраар 2 нь 3 давхраар явж л дээ. Нар жаргах дөхөөд найзууд нь буух гэтэл шат алга болчихжээ. Шатаа олохгүй байна гээд л байж манай найз болон үлдсэн найз нь эхэндээ тоглож байна гэж бодоод хурдан буу маяглаад бай гэсэн нөгөөдүүл нь нээрээ олдохгүй байна гээд айж эхэлсэн юм байх. 2 давхарт байсан нь үсэрч буугаад 3 давхарт гарсан ууд нь орилолдоод явчихсан гэсэн. Тэгээд аргаа бараад шууд үсрээд хөлөө хугалж үлдсэн нэг нь байдаг хараалаа урсгаад орилоод уйлаад байсан гэсэн. Тэгээд хажууд нь байсан хийд дээр очоод лам нарт хэлээд туслуулах гэсэн чинь хэн тийшээ гар гэсэн юм гал команд дууд гээд гал команд дуудаж буусан гэсэн. Тэд нар ирчхээд 7 дахь удаагийн тохиолдол гээд дээшээ гарахгүйгээр шат өгч буулгуулсан гэсэн бүгд хэн ч юу ч дуугарахгүй бүгд чимээгүй хараад дараа нь ч юу болсноо яриагүй дахиж зүглээгүй гэсэн.

\* \* \*

Ганц юм бичье гэж бодлоо. Миний хувьд машин бариад хол замд явах нь сайхан л даа, мэдээж юу гэж зүгээр явах билээ ачаа тээвэрлэж явна л гэнэ шүү. Ихэвчлэн сонирхолдоо хөтлөгдөөд ганцаараа явдаг байсан. 2008 оны өвөл тачигнасан тэр хүйтнээр нэг найзаа гуйгаад нүүрсэнд явах болоод хамт явдаг юм билүү гээд уурхай дээр очоод нүүрсээ ачуулчихлаа. Хоёулаа таньдаг айлд орж хоол идээд зүгээр байхгүй ээ бас ахтай шар айраг уунгаа кино үзэж тухалж байтал. Харин шөнийн 1 болонгоо алдаж хоёулаа замд гараад л дэмий юм ярьж явтал замын талд орчихсон гайгүй явж байна. Гэтэл гэнэт түлш тасалдаад болохоо байлаа шүү түгжирсээр байгаад л машин унтарлаа гэж гараад ойр зуурын үзлээ 20 мин оролдоод зөв зүгээр яг хөлдөж үхлээ. Тэрнээс гадна уурхайн төв зам юм чинь араас машин ирнэ гээд горьдоод кабинд ороод сууж байлаа. Кабин дотроос гадаа үнэн сайхан сартай од түгсэн шөнө хавь ойрын уулс битүү цас гэхдээ жинхэнээсээ хөлдөж үхэхээр хүйтэн хоёулаа зарим юмаа шатаах талаар ярилцаад сууж байтал. Г эв гэнэт өөдөөс харсан уулын

ёроолоос нэг цагаан юм үзэгдэх боллоо шүү.Цаснаас арай өөр цагаан юм .Бид 2 юу ч ярихгүй чимээгүй хараад л байлаа. Өнөөх чинь нүдэн дээр наашлаад л байгаа нь яг бас болоогүй баг багаар томроод л Байх юм. Томроод л томроод л ойртоод л ойртсоор л.Хоёулаа ч ,юу ч ярьсангүй чимээгүй хараал байсан. Тэр цагаа юм ойртож томорсоор яах араггүй хүрээд ирлээ. Тэгсэнээ юу ч харагдахгүй өтгөн манан. Жинхэнэ аймаар гэхдээ л хөлдөж үхэх гэж байгаа хүн тэрнээс айдаггүй л юм байна лээ. Хоёулаа бууя ард байгаа ойр юмнаас шатааж гал асаая наадахыг чинь хараад яа хав хөлдөж үхлээ гээд хоёулаа гарч юу ч харагдахгүй тэр мананд зүгээр л гал түлхээс өөр юу ч хийгээгүй юм даа. Хэчнээн айлаа гээд хөлдөж үхэлтэй нь биш.Анх удаа оруулж байгаа болохоор тийм байж магад.

\* \* \*

Эмээд минь тохиолдсон аймшгийн явдлуудыг бичмээр санагдлаа. Жоохон доо алга болсон хонио хайж явж байгаад гэнэт тээгэлдээд урагшаа тэрийгээд унасан гэнэ, тэгсэн нүдэнд нь цагаан дээлний хормой харагдахаар нь толгойгоо өндийлгөөд харсан чинь маш өндөр, аварга биетэй, урт цагаан сахалтай өвгөн өмнө нь зогсож байсан гэсэн. Тэгээд гэртээ ирээд халуураад бие нь өвдөөд эхлэхэд нь аав нь хүн дуудаад алтангэрэл уншуулаад, дэрлүүлээд унтуулаад зүгээр болж байсан гэсэн. Бас дараа нь хонио хариулж явж байгаад нэг даваа даваадахсан чинь голомтоороо сүйрчихсэн айлийн гэрийг харж л дээ. Хот нь харлачихсан, авдар сав нь гэрийнхээ гадаа нь гарчихсан, урагдаж сэмэрсэн муухай гэр харчхаад дотор нь эвгүйцээд эргээд явах гэтэл гэрийн нэлээн цаахнатай нэг хар юм хөдөлж байхаар нь гайхаад хартал маш хурдан эмээгийн урд хүрээд ирчихсэн байсан гэсэн. Амьтан биш араг үүрчихсэн үс нь сэгсийсэн муухай царайтай эмгэн амандаа ямар нэг юм бувгнаад байх байсан гэнэ лээ. Эмээ орилоод л гүйсэн юм шиг байгаа юм. Орой нь бас халуураад аав ном уншуулж байж зүгээр болсон гэнэ лээ. Дээр үед айл болгон Алтангэрэл ганжуур ч юм уу судартай байдаг байж. Тэгээд эмээ маань шөнө оройн цагаар хөдөө гадаа явахдаа өнчин ганц мод, хүн чулуун дээр хонож болдоггүй шүү. Бас тогорууны өндөг битгий хагалаарай, тогорууны хараал маш хүчтэй, голомтоор нь сүйрүүлдэг юм шүү гэж захиж билээ. Эмээ тийм тогорууны өндөг хагалсан хүүхдийн явдлыг нүдээрээ харсан байж. Их аймаар тэр хүүхдийг их муухай дуугараад тоншоод хөөгөөд байж, нөгөө хүүхэд нь айсандаа мэдээж гэр лүүгээ гүйгээд орж л дээ. Тэгсэн хоёр тогоруу нь муухай дуугараад далавчаараа гэрийг нь цохиод эргэлдээд байж байгаад нисээд өгсөн гэсэн. Удалгүй тэр гэрийнхнээс нэг нэгээрээ бурхан болооч болоод нэг ч хүн үлдээгүй гэсэн дээ. Тогоруу ч гэлтгүй ер нь аливаа амьд юмны аминд хүрэхгүй л байх хэрэгтэй шүү..

\* \* \*

### **Хэдэн жилийн өмнө өөрт тохиолдсон юмаа бичлээ....**

Нэг орой би эгчтэйгээ дэлгүүр гарахаар боллоо цаг 21, байна уу 22 болж байсан шиг санагдаж байна. Тэгээд өвөл байсан болохоор гялс гүйж дэлгүүрээс юмаа авчхаад орц луугаа дөхөж иртэл эгч маань хөлдлөө гээд түрүүлээд орц луу гүйгээд орлоо. Би ардаас нь орцын хаалгаа татахын завдалгүй өөдөөс нэг эгч гарч ирлээ тэр эгч гэрийн халат өмсөж нүүр гарны алчуураар үсээ хумьсан дөнгөж л усанд ороод гарч ирсэн юм шиг байдалтай байв. тэгээд яг хаалгаар нүүр тулах шахам зөрөхөд надруу хараад малийтлаа инээчихсэн (шүдээ гаргаагүй руулаа жимийж малийсан) мөн руулаа час улаанаар будчихсан хүн ховил билүү руулын дээр

байдаг? тэр юм нь байхгүй байсан шиг санагддаг юм би ч даарч байсан болохоор гялс зөрөөд л гэртээ орсон. Гэртээ ороод эгчээсээ та нэг сонин халат өмссөн эгч харсан уу нээх эвгүй тэ дотор сонин болчихлоо гэсэн чинь гүү ануаараагүйшт хүн зөрснийг гэдгийн.. Хааяа2 тэр малийтлаа инээсэн мөртлөө нүд нь ямар ч хөдөлгөөнгүй хүйтэн зэвхий царай бодогдоод байдаг юм. Айдаггүй л дээ. Гэхдээ анх их эвгүйцэж байсан даа...

\* \* \*

Бага байхад л болж байсан явдал л даа. Одоо бага сага л санадаг юм. Эмээгийн дээ хөдөө зун амархаар очиход саахалт айл гээд гурван айл байсан юм. Тухайн вед эмээгийнх маань нүүж очоод удаагвй байсан юм. Тэнд очсоноос хойш манай нохой гэрийн хаяанаас барагтай холдохгвй, тэр 3 айлийн нэгнийхрүү нь зүглэдэггвй, шөнө гасалж, хуцаад нэг л биш болоод байсан юм. Манайхан ч тэр айлуудтай нээх харьцдаггвй ч мэнд устай л байв. Нэг өдөр өвөө маань нэг айлаас нь балтийг нь гуйж аваад буцааж өгөхдөө өөрийнхөө балттай андуураад егчихеж л дээ. Тэгсэн шөнө зүүдэнд нь балтийг минь өг гээд л нэг хар юм хеегед хэд хоног зовоосон юм байх. Тэгхээр нь нээрээ л зүүд зөнтэй, нэг шалтгаантай болоод л хөөгөөд байсан байх гээд балтаа шалгаад хартал нөгөө айлын балт болж таараад буцааж өгөөд зүүдэнд нь хөөдөг хар юмнаас салж л дээ. Дараа нь бас согтуу дарвиж яваад нэг айлд нь ороод хоночхож. Тэгсэн шөнө хөнжилийг нь угз татаад ер унтуулсангвй гэнэ. Гайхаад хартал тоононы толгойгоор нээх муухай арзайсан юм харж байснаа гэрээс нь буугаад яваад өгч. Уньны завсараар хөлний ором хүртэл хонхойж харагдаагвй гээд л өглөө нь яриад байсан. Дараа нь юм мэддэг хвнээс асуухад танах 3н модорын дунд буужээ. Дариухан нүү гэсэндээ. Сүүлд эмээгээсээ лавшруулж асуухад модортой айл гэж хөдөөгүүр мэр сэр байдаг юм аа л гэж байсан. Энэ талаар хэд хэдэн хвнээс сонсож байснаас биш сайн мэдэхгвй юм. Гишвүүдээс энэ талаар мэддэг хвн байна уу? Модор гэж юу юм?

\* \* \*

Би бас өөртөө тохиолдсон сонин ч юм шиг аймаар ч юм шиг нэгэн зүйл бичье. Манай удмын сахиус буудаг юм л даа. Нэг удаа манай нэг хамаатны нас барсан ээж нь хүүхдүүдтэйгээ уулзмаар байна гээд манай буурайгаас гуйсан юм байна. Буурай маань ч чадах ядахаараа тусля л гэж. Нэлээн удаан бөөлж бөөлж ээж нь орж ирж байгаа бололтой яг эмэгтэй хүн уйлаад л эхэлсэн. Бид ч юу ч хэлж ярьж амжаагүй байтал нээх муухай инээгээд л гар хөл нь сарвалзаад л /яг л нөгөө Бушхүүгийн үлгэр дээр гардаг шиг инээсэн/ яг л татаад байгаа юм шиг хамаг хруунууд нь нээх сонин болоод байсан бүх хүмүүс хөшөөд яаж ч чадахгүй хараад л зогсоод байсан. Гэтэл харин түшээ нь морд чи гээд ташуурдаад байсан чинь манай буурай дайраад аймар ууртай орж ирээд хэсэг чимээгүй сууж байснаа ингэж ярив. Уул нь яг манай буурайтай зөрөөд ээж нь орж ирээд удаагүй байтал ээжийнх нь сүнсийг зуурдад гацаагаад явах ёстой газар луу нь явуулахгүй хориод зовоогоод байгаа тийрэн гээч нь дайраад ороод ирсэн гэнэ. Тэгээд л аймаар инээгээд ёо зүрх хагарчих дөхсөн гээч. Уул нь ээж нь тусламж гуйх гэж үр хүүхдүүдтэйгээ уулзья гэсэн юм шиг байна лээ тэр муухай юмнаас салгуулах гэж. Тэр тийрэн маш хүчтэй байна гэсэн. Манай буурай ахин хүчээ зузаатгаж байгаад тэр муу тийрэнтэй үзэлцэнэ гэсэн. Тэр дуу тэр биеийн хөдөлгөөн тэр инээд эд нар нь ямар зэвүүн байсан гээч одоо болтол тэр муухай инээд нь ерөөсөө мартагдахгүй юм. Би бас өөртөө тохиолдсон сонин ч юм шиг аймаар ч юм шиг нэгэн зүйл бичье. Манай удмын сахиус буудаг

юм л даа. Нэг удаа манай нэг хамаатны нас барсан ээж нь хүүхдүүдтэйгээ уулзмаар байна гээд манай буурайгаас гуйсан юм байна. Буурай маань ч чадах ядахаараа туслья л гэж. Нэлээн удаан бөөлж бөөлж ээж нь орж ирж байгаа бололтой яг эмэгтэй хүн уйлаад л эхэлсэн. Бид ч юу ч хэлж ярьж амжаагүй байтал нээх муухай инээгээд л гар хөл нь сарвалзаад л /яг л нөгөө Бушхүүгийн үлгэр дээр гардаг шиг инээсэн/ яг л татаад байгаа юм шиг хамаг хруунууд нь нээх сонин болоод байсан бүх хүмүүс хөшөөд яаж ч чадахгүй хараад л зогсоод байсан. Гэтэл харин түшээ нь морд чи гээд ташуурдаад байсан чинь манай буурай дайраад аймар ууртай орж ирээд хэсэг чимээгүй сууж байснаа ингэж ярив. Уул нь яг манай буурайтай зөрөөд ээж нь орж ирээд удаагүй байтал ээжийнх нь сүнсийг зуурдад гацаагаад явах ёстой газарлуу нь явуулахгүй хориод зовоогоод байгаа тийрэн гээч нь дайраад ороод ирсэн гэнэ. Тэгээд л аймаар инээгээд ёо зүрх хагарчих дөхсөн гээч. Уул нь ээж нь тусламж гуйх гэж үр хүүхдүүдтэйгээ уулзъя гэсэн юм шиг байна лээ. тэр муухай юмнаас салгуулах гэж. Тэр тийрэн маш хүчтэй байна гэсэн Манай буурай ахин хүчээ зузаатгаж байгаад тэр муу тийрэнтэй үзэлцэнэ гэсэн. Тэр дуу тэр биеийн хөдөлгөөн тэр инээд эд нар нь ямар зэвүүн байсан гээч одоо болтол тэр муухай инээд нь ерөөсөө мартагдахгүй юм.

\* \* \*

Эмээ маань асаргаанд ороод олон жил хэвтэрт байж байгаад 4 жилийн өмнө өнгөрсөн юм. Үүрээр ээж бид 2 хоёулханаа байсан тэр үед өглөө нь шарилыг нь моргийн эмч нар аваад явсан. Өдөр нь яа хав хүмүүс ирж очоод л эмгэнэл илэрхийлэл тэгээд ээж гандан орж ном уншуулаад зураг хөргийг нь янзлуулж ирээд зул мандаагаад зургийнх нь урд бас маанийн хөгжим авчраад тавьсан юм. Тэгээд орой нь болж хүмүүс явцгаагаад бид нар яг гэр бүлээрээ үлдэцгээгээд манай үеэл эрэгтэй дүү маань хоносон юм. Тэр орой нэг л эвгүй унтаж чадахгүй айгаад зураг луу нь ч харж чадахгүй юм л даа. Яагаад ч юм би тэр орой аймар айгаад байсан. Тэгээд байж байтал удалгүй эмээгийн өрөөний шкафын хаалга дуугараад л онгойж хаагдаад хөлийн чимээ сонсогдоод яг хүн юм хайгаад байгаа юм шиг. Би яг галзуурах шахсан. Ээжийгээ сэрээх гэснээ айгаад сэрээж чадаагүй. Уг нь тэр орой эмээгийн өрөөний гэрлийг асаалттай унтсан юм. Гол нь манай үеэл дүү эмээгийн орон дээр унтаж байсан. Хаалга нь онгорхой байсан учраас тэр зүг рүү харсан чинь дүү маань хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд унтаж байхаар нь дүүгээ шкаф онгойлгоогүй гэдгийг нь багтай мэдэж авлаа. Тэгээд цуг унтаж байсан эмэгтэй дүүгээ аяархан сэрээгээд хэлсэн чинь манай дүү бид 2 хэсэг хүлээж байгаад сонссон чинь ахиад л сонсогдоод аймар байсан. Шууд хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд л дуугарч чадахгүй байж байгаад нэг мэдсэн унтчихсан байсан. Тэгээд өглөө сэрээд ээжид хэлсэн ээж итгээгүй загнаад бид 2-г тэгсэн чинь манай нөгөө үеэл дүү хэлдэг юм даа. Шөнө унтаж байгаад юм дуугарахаар нь сэрээд харсан чинь хөл дээр хар хувцастай аймар царайтай хүн сууж байсан. Аймар айсан тэгээд орилох гэсэн дуу нь гарахгүй айгаад хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд унтталаа айж хэвтсэн гэж хэлж билээ. Тэрийг сонсоод ээж итгэсэн юм даа. Ер нь тэгээд гэрт хүн өнгөрөхөд ямар нэгэн юм 3 хоногтоо эргэлдээд байж байдаг юм шиш санагддаг. Яг юу байсныг мэдэхгүй лав л шөнөжингөө айлгасан даа бид нарыг.

\* \* \*

Өчигдөр орой болсон зүйл. Манай ахынх 21-н тэнд энх орчлон хорооллын 10 давхарт байдаг.

Ахындаа оройн хоол идчихээд гарч зайрмаг авчидэх санаатай лифт хүлээгээд зогсож байтал ард юм дуугарах шиг хүн алхаад ч байгаа юм шиг эргээд хартал юу ч алга. Эргэн тойрноо сайн харж ажиглавал айл байхгүй л болохоос бараг 11 давхарт тооцогдох дээвэр лүүгээ гардаг шатунуудын тэндээс нээх аймар царайтай нэг ах шатны дамнуурга модноос даваад намайг хараад байж байсан. Хараад ямар их айсан гэж бодно айсандаа хөл хөдлөхгүй дуу ч гарахгүй зүгээр л зүрх хүчтэй цохилж лифтээ дуудсаар байн байн товчлуур дарна. Дахиад л нөгөө чимээ гарч дээшээ харвал нөгөө аймар хүн чинь 10 шатны зайтай цаад буланд ирчихсэн зогсож байсан. Намхан ноорхой хувцастай царай гэж аймар сонин төрхтэй айсандаа хамаг чангаараа орилсон. Тэр даруй ах хөрш айлын хүмүүс гарч ирсэн лифт ч ирсэн. Харин нөгөө ах харагдаагүй дахиж лифт болоод ахынхаа давхарт очно гэхээс маш их айж байна даа.

\* \* \*

Аниа дүү хоёрыг камераар харьцаж байхад дүү гэнэт л цухалдаад наад найз чинь ямар хэрэгт дуртай юм бэ байес гээд л өнгөлзөөд байх юм. Хаашаа юм болиулаач гэсэн гэнэ ээ. Тэгсэн чинь л аниа царай нь сонин болоод л байж байгаарай гээд хамаг юмаа шалгаад шкафаа онгойлгоод унасан гэнэ. Тэр үед юу болсон гэхээр эгч маань өрөөндөө ганцаараа дотор талаасаа хаалгаа түгжээд сууж байсан гэсэн. Дүүгээс яг ямар хүн яаж хараад байсан юм гэсэн чинь араар нь нэг яваад л дэлгэц рүү нэг өнгийгөөд л байсан гэсэн. Тэр байрны зарим өрөөнүүд нь оронгуут гал тогоотой тэгээд цаад талдаа 2 унтлагын өрөөтэй юм байна л даа. Тэгээд эгч 3 4 найзтайгаа нийлээд шөнөжингөө юм ярьж суусан юм гэнэ ээ. Харин яг хажуу өрөөнийх нь охин маргааш шалгалттай гээд ярианд оролцолгүй өрөөндөө ороод унтаад өгсөн гэсэн. Харин өглөө нь нөгөө охин чинь хаалгаа налаад хөшчихсэн хувхай цайгаад бүр гөлөрчихсэн байсан гэсэн. Аймар сандралдаад эмч дуудаад л бөөн юм болж байж нөгөө охин нь маргаашаас арай хүнтэй юм ярихтайгаа болоод ингэж ярьсан. Унтах гээд хэвтэж байлаа. Тэ хэдийн дуу хадаад л байсан. Тэгээд хэвтэж байтал гэнэт хөнжил ар талаас татаад унасан гайхаад та хэдийн нэг нь орж ирсэн юм байхдаа гэд эргээд хартал таазанд тулсан шахуу өндөртэй тас хар хүн дээрээс нь хараад хөнжлийг нь угзраад байсан. Айсандаа шууд орноосоо унаад хаалга рүү очсон чинь хаалга онгойхгүй. Та хэдийг хааг чадлаараа орилоод дуудаад л байсан. Та хэд уг нь хоорондоо ярилцаад инээгээд байсан хирнээ ерөөсөө намайг тоогоогүй одоо яаж байгаа бол гээд эргээд харсан бараг яг ард талд доошоо суучихсан над руу аймар хараад байсан. Тэгээд л мэдэхгүй нэг мэдэхэд бөөн хүмүүс бужигнаад намайг тойрч байсан гэж ярьсан байна лээ. Харин эгч минь хэлэхдээ тэр шөнө нэг юм пид пад гээд л дуугарсан нээх тоогоогүй. Харин ямар ч орилох чимээ бидэнд сонсогдоогүй бас хаалга нь түгжээтэй байгаагүй гацаа ч үгүй байсан. Тэгээд яг хажуу талынх нь зэргэлдээ өрөө. Хөөрхий тэр охин тэгээд бие нь дээрдэхгүй байсаар байгаад тэр чигтээ нутаг буцсан. Сүүмийсэн бүр сүнс сүлд нь доройтчихсон амьтан явдаг болсон байсан хүнтэй ч нээх харьцахгүй үг нь их дуу шуутай яриа хөөрөөтэй охин байсан гэсэн. За тэгж байтал эгчид минь өөрт нь их эвгүй юм тохиолдсон. Манай эгч 3 курс болдог жилдээ 10 сарын дундуур шөнө ээж рүү залгаад уйлж гарав аа. Ээж ч тайвшруулаад миний охин айж болдоггүй юм шүү гээд л баахан арц хүж уугиулаад л яваад өглөө. Сүүлд учрыг нь сонсох нээ эгч маань хожимдож очоод өрөө олдоогүй юм гэнэ ээ. Тэгээд сургуулиасаа нэлээн зайтай өөр их сургуулийн ч юм уу даа харьяа дотуур байрны 5 хүний өрөөнд ганцаараа орж л дээ. Шөнө болохоор л дээд талынх нь өрөөний хүүхэн л учиргүй өсгийтэй гутлаараа таг таг хийгээд яваад байдаг байж л дээ. Тэгээд орж хэлсэн чинь өсгийтэй гутал өмсөх нь битгий хэл

олигтой нүүрээ ч буддаггүй 2 хөдөөний гэмээр охин байсан гэсэн. Тэгээд бид 2 тэгж явдаггүй ш дээ сонин юм гээд л өнгөрч. Тэгээд эхэндээ ч тоохгүй байж тэгсэн тэр шөнө унтах гээд хэвтэж байсан чинь гэнэт хөгжим нь хамаг чангаараа асаад л гэрэл нь унтарч асаад л сүйд байжээ. Эгч сандраад л. Хөгжмөө унтраачхаад гэрэл нь яагаад унтарч асаад байгаа юм бол гээд гэтэл нөгөө дээд айлд нь яваад байна гэж анх боддог байсан өсгийтэй гутлын чимээ нь өрөөн дотор гарч байна гэнэ ээ. Бүр айж гайхаад байж байсан чинь сэрээч ээ сэрээч ээ гээд л нээх муухай хоолой наана ч юм шиг цаана ч юм шиг сонсогдоод л тэгснээ хаалгыг нь мажаад л унасан гэсэн. Тэгээд аний айгаад ногоон дарь эхийг амандаа уншаад суугаад л байсан гэсэн. Харин хаа очиж тэр маань мэгзэм нь тусалсан уу гайгүй болохоор нь ээж рүү залгасан юм билээ. Маргааш нь ээж мэддэг сайн үзмэрч ламдаа үзүүлтэл дориухан нуу, амиа хорлож үхсэн хүүхний сүнс байна. Их хүчтэй юм байна. Тэгээд л ганц өрөө хувийн орон сууцанд эгчийг оруулсан даа. Эгч дараа нь бодоод байхад их сонин нийтийн байранд өрөө олдохгүй байна гэсэн хирнээ тэр 5 хүний өрөөнд би ганцаархнаа ордог нь. Анхнаасаа анзаарах хэрэгтэй байж л гээд байсан.

\* \* \*

Би гэртээ байхдаа сүнстэй таарч байж билээ. Маргааш нь үзүүлдэг удган дээрээ очиж асуухад чамд халгүй тэнүүлчин сүнс байна гэсэн. Шөнө унтах гэж чихэвчээ зүүгээд сүрхий охин хэвтэж байв аа. Би нэг жижигхэн гөлөгтэй байсан. Дуугаа болно гэж ерөөсөө байхгүй мөнхийн л гав гав хийж байна. Хөгжим сонсоод дуугарах нь сонсогдохгүй хэвтэж байтал гэнэт ар нруугаар хүйт даагаад хүн хараад байгаа юм шиг мэдрэмж төрөөд яваад өглөө. За тэгээд л нээх тоохгүй мөрөөдөлдөө умбачихсан хачин сайхан юм төсөөлөөд нөгөө тал руугаа эргээд хэвтгэл харин яг өөдөөс нь хүн дүрстэй хар бараан юм нүүр тулаад харж байсан. Сандраад орон дээрээ босоод суутал өрөөний цаад буланд суучхаад өөдөөс хараад байсан. Хамаг зүрх зориггоо чангалаад л хамгийн гол нь айж болохгүй гэсэн үгийг санаад л босоод гэрлээ асаасан ашгүй алга болчхов оо. Тэгээд л арай гэж тайвшраад нохойгоо дуудтал бүр гарч ирдэггүй ээ. Юмны доогуур ороод нуугдчихсан над руу айсан харцаар харчихсан. Тэгээд санаандгүй цонх руу хартал харин саравчаар толгойгоо оруулчихсан над руу харж байдаг юм. Шууд нулимс сад тавиад л ам зуураад гөлөрчихдөг юм билээ дээ.

\* \* \*

### **Хөгшчүүлээс сурвалжилсан домог яриа**

Манжаас өмнө юм гэсэн .Ажлын шугамаар хөдөө орон нутгаар явж байгаад санаандгүй хөдөөний хөх өвгөнтэй хууч хөөрч нэгэн орой жоол суусанн юм.Тэр хөгшин олон зүйл ярьснаас ам барих ач гэдэг үгийн утга үүслийг сонссоноо энд сийрүүлье Нэгэн хот айлд холоос шуурганд туугдан зүг алдаж уналга улдсан нэгэн гийчин буужээ.Орсон айлын эзэгтэй монгол сайхан ёсоор цайлж ундаалаад хажуу гэрт орж амар даа хөгшин эжий минь л бий гээд хажуу гэртээ оруулжээ.Хажуу гэрт нь нэг хөгшин бруу хараад дээлээ нөмөрчихсөн хэвтэж байна гэнэ .Хүүхдүүд нь ээжээ хоол ид гэхэд идэхгүй гэж дохиж байгаа бололтой байна гэнэ .Эзэгтэй дэрнийх нь хажууд буй модон тагшинд жоол үзэм хийж өгөөд ...хөгшин эжий маань зөнөөд байгаа юм аа хоол идэхгүй үзэмхэнээр болдог болчхоод байна даа за та энд.амар гээд ор засаж өгөөд гарч оджээ .Алжааж ядарсан гийчин ч төд удалгүй нам унтжээ.Нар хөөртөл нам унтсан гийчин босж айлын хар хүнтэй адуунд явж адуунд нь морио тавьж тэнхээ



оруулаад ганц хоёр хоног өнжөөд явахаар болж л дээ Гэрийн эзэгтэй мөн л өнөө хөгшинд юм уулгаж идүүлэх гээд барахгүй байгаа бололтой зөнөөд юу ч идэж уухгүй байна гэгцгээж байх юм гэнэ. Ингэж тэгсээр орой ч болж гийчин унтахаар хэвтэж .Өмнөх шөнө нам сайхан унтсан тул сэрвэлзүүрхэн.шиг унтаж ядан байтал нэг юм дээрээс нь.тонгойх шиг болж .Гэнэт.палхийж сэмхэн харвал өнөө эмгэн чинь дэргэдээс нь.цааш эргэн явж нэгэн уут барьсаар гараад явчхаж .Хэвтрээсээ босдоггүй хүн лүү харж ганц үг дуугардаггүй хөгшин хөнгөн шингэн гараад явчихлаар нь гайхаж ядан байж байтал өнөөх чинь нэг юм үүрчихсэн орж ирээд гал хурдан гээч нь.түлээд нэг юм чанаж идчихээд нурмаа дараад унтаад өгч .Гийчин охиноо хоол өгөхөөр идэхгүй хар шөнөөр.юу авчирч иддэг билээ гэж гайхсаар өглөөтэй золгож хүүхдүүдэд нь хэлжээ .Гайхсан хүүхдүүд нь юмыг ухаж онгичиж бөөн уйлаан шуугиан айдас хүйдэс болж .Гэтэл өнөө эмгэн чинь бүхэл бүтэн.айлын хүүхэд авчирч идээд талыг нь нуусан байсан гэнэ Хүүхдүүд.нь манай энүүгээр айлын хүүхэд алга болоод байгаа юмаа одоо яадаг билээ элий минь халай минь.л.болцгоож Ингээд зөнөж хүн ухаанаа алдсан өнөөх эмгэнийг хонины шаантаг ясаар ач хүү нь хахааж амыг нь барьж өөр ертөнц рүү илгээсэн гэнэ лээ Үнэн худлыг нь мэдэхгүй ээ гэхдээ ам барих ач гэж ийм учиртай л гэж сонссон гэж хуучилсан юм даа.

\* \* \*

Надад нэг ийм асуудал үүсээд байна аа. Би өчигдөр сансарт нүүж ирсэн юм л даа энд хувиараа юм хийж байгаа ухаантай уг нь энэ байрыг түрээслээд сар болж байгаа юм. Тэгээд өдөртөө л хүнтэй байдаг байсан. Тэгсэн чинь би өчигдөр шөнө анх удаа ганцаараа хонолоо. Шөнөжингөө хар дарж зүүдлээд цаг тутамд сэрсээр байгаад өглөө болголоо. Өдөр нойр хүрээд байхаар нь жаахан унтсан чинь даруулаад бас л хар дарж зүүдлээд энэ байрны бүх тавилга нь өөрчлөгдчихсөн танихгүй орчинд байх юм. Бас нэг хүүхэдтэй тэгсэн чинь миний чихэнд нэг хүүхэд босоорой хаалга тогшиж байна босоорой гээд л би бүр арай гэж л сэрлээ. Миний хамаг бие сульдаад эрч хүчгүй ядраад байгаа юм шиг л болчих юм. Тэгээд энд хамт ажилладаг эгчид хэлсэн чинь би бас анх энэ байранд ирээд чамайг байхгүй байхад бие засчхаад нойлоос гарсан чинь нэг хүүхэд над руу хараад явган сууж байхыг харсан. Энэ байр юмтай юм шиг санагдаад байгаа. Дандаа л хэл ам гаргаж байдаг гэх юм. Одоо өөр байр олтлоо эндээ байхаас өөр аргагүй ядаж байхад би ганцаараа оройдоо үлдэж хонож байх болчихоод маш их айж байна яавал дээр вэ? Арц хүж асаан ариулах уу бас мэддэг тарни байвал хэлж өгч туслаач?

\* \* \*

Одоо бол айх юм алга аа хүмүүстэй хамт байгаа болохоор ажлын цаг дуусаад явахаар нь би ганцаараа үлдэнэ тэгж бодохоор л дотор арзайж байна аа. Найзууддаа хэлээд цуг хоночих гэж гуйсан чинь бүгд айгаад ирэх хүн алга аа.

Манай аав цагдаа хүн л дээ. Ээж аав хоёр маань хамт амьдрахаа болиод удаж байгаа юм. Тэгээд цагдаа хүмүүс хэрэг гарахаар дуудсан цагт л явдаг хойно. 90 ээд оны сүүлээр байсан юм. Тэгээд л хэсгийн төлөөлөгч нар чинь хаашаа ч явсан хоёр хоёроороо явдаг байлаа ш дээ. Тэгээд нэг удаа хөдөө дуудагдаад явж л дээ. Хоёулаа мотоциклтой хөөрхөөн хэхэ. Тэрийгээ унаад л сундалдаад гараад өгч. Хөдөө очих газарлуугаа яваад л байж. Тэгсэн бас харанхуй шөнө гэнэт л эзгүй хээр талд хөгшин эмгэн гараа өргөж л дээ. Тэгээд манай хоёр зогсоод. Та

хаа хүрэх нь вэ? ийм шөнө ? гээд л асууж. Эмээ нь ойрхон очно хүргээд өгөөч гэж л дээ. Тэгэхээр нь нөгөө ард сундалдаад явж байсан цагдаа найзаа буулгаад эмээг суулгаад явж . Тэгтэл ард нь хүн суусан шинжгүй ганцаараа давхиад л байгаа юм шиг мэдрэмж төрөөд байсан гэсэн. Эмээ та сайн бариарай гэсэн чинь аан за гэсэн мөртлөө огт барьсан шинжгүй яваад байхаар нь их л жийрхээд явчихсан гэсэн. Шууд л нрууных нь хөлс ялгараад л юу аваад явчхав аа ухааны юм бодоод л давхиад байж. Тэгээд хэсэг явж байгаад нэг том манхан ойртоод ирэхээр нь эмээ ойртож байна уу? гэсэн чинь өө наад манханлуугаа орчих гэсэн гэнэ лээ. Тэгээд орсон чинь ингээд зогсчихооминий хүү гээд л манай аав ч хурдан буухын түүс болоод л за гээд л ороод зогсчихсон гэсэн. Тэгээд л мотоцикл зогсохдоо гэрэл нь унтраад буцаад асаагаад харсан чинь ард нь хэн ч байгаагүй гэсэн аймар . Хамаг шар үс нь босоод мотоцикл ээ асаагаад давхисан гэсэн. Замаараа найзыгаа аваад л нөгөө болсон явдлаа яриад л хоёулаа жийж гарсан гэсэн . Ард нь сууж явсан найз нь хүлээж байхдаа эзгүй хээр чоно ноос айгаад тамхи тасралтгүй татаад хүлээж байсан гэсэн. Чоно галаас айдаг гэсэн . Тэгээд сүүлд сонсож байхад тэр манхны хавьд нэг тийм шөнө эсгий гэр болоод өглөө нь юу ч байхгүй болчихдог тийм айл байдаг байсан гэсэн гэж сонсож байсан юм байна. Хоёулаа үнхэлцгээ хагартал айсан гэж ярьж байсан.

\* \* \*

Үүр шөнийн зааг дээр үнэгэн гүйдэл эхэлдэг гэж эмээ өвөө нар маань ярьдаг байж билээ. Таксинд явдаг хүмүүс л сайн мэдэх байхдаа. Үүр цайж гэгээ орохын өмнө гүйдэл гүйдэг замаараа гүйж эхэлдэг гэсэн. Миний нэг таньдаг хүн таксинд яваад удаж байна аа. Тэгсэн нэг шөнө үүр цайтал явж байжээ. Тэгсэн яармагийн гүүрэн дээр нэг цэнхэр палажтай охин гар өргөөд Дамба ярья гэж тэгэхээр нь нөгөөдөх чинь харих гэж явснаа болиод эмэгтэй хүүхдийг шөнө үүр цүүгээр орхиод яа хав гээд аваад Дамба явж л дээ. Гэтэл Дамба дөхөөд ирэхийн алдад утаа шиг замхраад алга болсон гэсэн. Ер нь тэр охин зөвхөн дээрээ такси гэсэн бичигтэй машинд л гар өргөж суудаг гэсэн. Тэр охиныг 90-ээд оны эхээр яармагийн гүүрэн доор ес бусаар хөнөөсөн юм гэж намайг бага байхад ярьдаг байж билээ.

\* \* \*

Надад утгагүй нэг тийм зүйл болж байлаа. Тухайн үед хүмүүс юу гэж хүлээж авах байсныг мэдэхгүй юм. Одоо ч хүмүүс инээх л байх. 10 жилд л зун байсан юм. Би орой унтах гээд нүдээ анив уу үгүй юу 2 өндөр байшин нураад л утаа маналзаад ирэхээр нь нүдээ нээв ээ. Тэгсэн ч үргэлжлүүлэн харагдаад л байлаа. Нөгөө 2 байшин нурж дууссаны дараа үл таних хүмүүсийн зураг ээлж дараалан харагдаж билээ. Ихэвчлэн хүүхдүүдийн зураг ганц хоёр том хүмүүс бий танихгүй бас яагаад тэгж харснаа ойлгодоггүй. Тэр үедээ мартаггүй гээд тогтоочихсон байлаа л даа. Тэгсэн тэрийгээ ч мартчихсан байсан. Би жилийн дараа юу сарын дараа юу гэдгийг нь яг мартчихаж лав л ихэр 2 цамхаг нурсан гээд хүмүүс бөөн юм болж байхад бичлэгийг нь олж үзэв ээ. Тэгсэн яг миний харсан дүр зураг байсан яагаад харагдсан юм бүү мэд.

\* \* \*

Манай найз охин бид хоёр 2 байр түрээслэхээр болоод хайж гарав...Тэгээд л Жуковын 9 давхруудын нэгд эзэн нь амьдардаггүй дан оюутнууд амьдардаг байранд амьдрахаар болов.

Ороод л юм хумаа цэгцлээд хөөрхөн тохижоод авав. Анх ороход нээх тийм зэврүүн хүйтэн энергитэй онцгүй юм шиг сэтгэгдэл надад төрж байсан ч тухайн үед хүүхэд байсан учраас тоогоогүй юм. Тэгээд л амьдардаг болоод яагаад ч юм ганц нэгээрээ хонохоос айдаг байсан юм. Бид хоёр байнга хамт байна гэж юу ч байхав. Би хааяа өөр найзынд очиж хонодог байсан юм л даа. Тэгээд нэг удаа тэр найз охины доо хонохоор явлаа. Манай нөгөө найз охин ганцаараа үлдэхээр болоод хоносон юм. Манай тэр найз охин уг нь бол хэр баргийн юмнаас айгаад байхаар гүй хээгүй эршүүд охин байдаг юм. Одоо ч тийм хэвээрээ. Тэгээд ялт ч гүй ганцаараа хоносон тэр найз маань. Маргааш өглөө нь би эрт ирсэн юм. Тэгээд л хоёулаа юм хум ярьж сууж байгаад нөгөөх чинь тэгсэн чинь юу ч болоогүй юм шиг өчигдөр шөнө шөнөжингөө намайг эрэгтэй хүн ширтэж хонолоо...Хүнд нэг тийм мэдрэмж төрдөг дөө ширтээд байхаар мэдрэгддэг ш дээ гэж байна .Би тэгэхээр нь юу тэнэгтээд байгаа юм ,солиороод л хэн байдаг юм чи хүн оруулсан юм уу? хаалгаа онгорхой орхичихсон юм уу? энэ тэр гээд л уурласан чинь. Үгүй ээ хаалгаа ганцаараа юм чинь гээд түгжиж хоносон ингээд түгжсэн хар гээд л үзүүлж байна. Угаасаа орос замган түгжээ учраас ойлгомжтой байгаа юм чинь. Тэгээд чи яасан айдаггүй юм уу? Надлуу ярихгүй яасан юм. Чи зүүдэлсэн юм байлгүй дээ гэсэн чинь үгүй ээ бүр яг хөлний чимээ тэнд сандал дээр суучихсан хав хар хувцастай гадаах гэрэл цонхоор өрөөнд тусаад харагдаад байсан гэдэг юм даа. Ёо ох бүр айчхаж байгаа юм чинь ..Шөнөжингөө л хөнжлөө битүү нөмөрч хонолоо хөдлөхөөс айгаад гэж байна нөгөөх чинь...Би тэгээд за за тоглоод байгаа юм уу хаашаа юм гээд л би тэрүүхэн тэндээ тэгээд л өнгөрсөн юм..Тэгээд л бид хоёр хоёулаа байхаар ерөөсөө тийм юм ахиж харагдаагүй юм манай найзад. Бараг сарын дунд үед ороод л хоёулаа өглөө ажилдаа явах гээд эрт сэрүүлэг тавиад унтсан юм нэг орой. Үүрээр 4 цагийн үед тухайн үед зун байсан учраас эрт гэгээ орчихсон байлаа. Би бол угаасаа нэг унтахаараа нам унтдаг хүн. Тэгээд л яг унтаж байсан чинь манай найз охин намайг аяархан дуудаад би сэрээд л яасан гэсэн чинь тийшээ хаалга руу хардаа гээд л байна. Би харлаа юу ч байдгүй ээ юу ч байхгүй л байна ш дээ гэсэн чинь зогсоод байна ш дээ нөгөө хар хувцаст залуу мөн байна саравчтай малгай өмсчихсэн нүүргүй хүн гэдэг юм даа. Ёо ох би ахиад л үхтлээ айж байгаа юм чинь болилдоо битгий хүн айлгаад бай гээд л . Тэгсэн чинь нөгөөх чинь жинхэнээсээ бүр айчихсан хөдлөхгүй хөнжлөө толгой дээгүүрээ тавьчхад л надтай хөнжил дотроосоо аяархан яриад л би бүр айгаад уйлсан байх өө сүүлдээ.Хоёулаа тас тэврэлдээд тэврэлдээд унтаад өглөө. Тэр өглөө сэрүүлэг ч дуугарч хоёулаа ажилдаа яваад замдаа ахиж нэгнийгээ орхиж үлдэхгүй энэ тэр гээд л юм яриад салцгаав. За тэгээд л ахиад хэд хоног өнгөрөөд байж байтал манай нэг найз охины төрсөн өдөр болоод бид хэд гадуур тэмдэглэж байгаад манайд хэдүүлээ хонохоор боллоо. Шөнөжингөө юм яриад л , жоохон ууж муугаад л хонолоо.Бүгд пивондоо согтоод унаад өглөө. Би ми бол эхэнд явчхаж байгаа юм чинь.Тэгээд л ид нойрондоо унтаж байсан чинь манай нөгөө найз бүр орилоод л хөнжилрүү бид нарын голоор ороод ирдэг юм даа. Уг нь захад унтаж байсан юм.бид хэд бүг яав ийв ? гээд л сандраад л үүрээр сэрцгээлээ. Гэрлээ асаагаад яасан гээд л найзаасаа асуусан чинь нөгөө хүн чинь сая яг миний дээгүүр агаар дээр хийсээд л хүрээд ирсэн гэдгийн. Ёо ох би бүр гүн шоконд орсоон. Нэг нь хараад байдаг нөгөөх нь харахгүй болохоор бүүр эвгүй байдаг юм билээ.Тэгээд л найзууддаа наадах чинь дээрээс хойш ингэсэн тэгсэн гээд л хэлээд л манай найзууд бид хоёрыг бөөд үзүүл гээд л тэгээд л найзыгаа тайвшруулаад бид хэд ч сэрчихсэн. Ахиж унтаагүй ээ эвгүй байгаа юм чинь. Өглөө ч болж миний таньдаг нэг бөө эгч дээр очоод л хоёулаа үзүүлсэн чинь харин. Өө наад байр чинь өвчнөөр өөд болсон залуугийн сүнс хоргодчихсон байр байна. Гэрийн асаргаанд байсан их л шаналж өвдөх зовж өнгөрсөн хүний сүнс байна гэдгийн. Яг өөдөөс харсан өрөөнд чинь

амьдардаг байсан юм байна гэж хэлсэн юм тэр эгч. Тэгээд л манай найзуудад засал хийж өгөөд. Бид хоёрт арц энэ тэр юмнууд өгөөд гэртээ очоод бид хоёр хэлснийх нь дагуу юмнуудаа гүйцэлдүүлсэн. Тэгээд тэр байрнаас удаа ч гүй ганцхан сар болоод л гарсандаа. Одоо бодоод байхад тэр бүр үнэхээр эвгүй байр байжээ. Орц лифт энэ тэр гээд бүгд эвгүй. Тэр байр луу ер нь хүн ороод л нэг тийм жихүүдэс хүрэм мэдрэмж төрөхөөр байр. Ий одоо бодсон чинь нруугаар бүр хүйт даачихлаа.

\* \* \*

Баянзүрх дүүрэгт баригдаад удаагүй шинэ байранд дүүтэйгээ бараг л хоёулаа байдаг байлаа. Аав ээж нь томилолтоор гадаад руу явчихна эсвэл хөдөө. Дүү минь найзуудтайгаа нийлж их гарна аа. Би ч гарах дургүй болохоор ганцаараа үлдэнэ. Үүрээр унтаж байхад хүн түлхүүрдээд ороод ирнэ хүн орж ирж дээ гээд байж байтал жинхэнээсээ хүн нь ороод ирнэ эсвэл хий зүйлс харагдаж эхэлнэ. Хамгийн хачирхалтай нь нүдээрээ биш доошоо харахаар л духаар харагдана. Орой хичээлээ тарж ирчхээд толгой өвдөөд байхаар нь хэвтэж байгаад хоол хийе дөө гээд нүдээ анив уу үгүй юу нэг охин баруун талын чихэнд би 17 хон настай шүү дээ би одоо яах юм бэ гэсэн уйлсан дуугаар нүдээ нээгээд харсан чинь хэн ч байхгүй тэгээд салганасан шүү. Харагдахгүй сонсогдох нь жаахан тиймхэн!

\* \* \*

10 жилд байхад одоогоос чинь бараг 6 жилийн өмнө байх. Би тийм нээх сониуч гэсэн юм байхгүй байсан. Манай тэнд хуучны нэг байшин байдаг байсан юм. Ногоон өнгөтэй тийшээ хүмүүс огтхон ч орохгүй тэр үед манай ангийнхан тэр байшингийн хажуугаар нь алхаж байгаад ийшээ орж үзэх үү гэсэн яриа гэнэт гараад л ирсэн. Тэгээд би ч тэр манай ангийн хэдэн банди нар ч тэр охид ууд байсан болоод ч юм уу жоохон онгироод л тэгье гээд ар талаас нь нэлээн намхан цонхтой шил нь хагарсан тэрүүнгээр нь тавуулаа орсон юм. Ортол нээх муухай тоос шороо болсон цаана нэг хаалга байсан. Түүгээр нь цаашаа гартал манай нэг найз хаалгыг нь түлхээд гацаачихсан. Тэгээд бид нар нээх ч тоосонгүй цаашаа явсан юм. Доошоо явсан шатаар нь яваад тэр дор хав харанхуй бид нар утасныхаа гэрлийг асааж 3 гэрэлтэй л байсан байх. Сүүлдээ тэр хавиар явж байгаад гарах болсон чинь гарч чадахгүй хаалгаа олдоггүй төөрөөд сандралдаад тэгээд бас жоохон байсан болохоор бусад даа онгироод битгий ай гээд сүүлдээ гарч чаддаггүй 30 минут болсон байх аа. Харин сүлжээ байж утсаараа найзууд руугаа залгаж багш ирээд гаргаж билээ. Одоо бодоод байхад хөгжилтэй ч юм шиг тэр барилга дээр үед эмнэлэг байсан гэсэн.

\* \* \*

Намайг ой өнгөрч байхад болсон юм гэсэн. Манай аав бөөн мод унагааж бэлтгэсэн юм гэсэн. Тэгсэн чинь миний баруун хөл шууд татаад тэнийхгүй болсон гэсэн. Тэгээд нутгийнхаа юм үздэг Бадрах гээд настайвтар хүнд үзүүлсэн гэсэн. Тэр хүн арга засал хийлгэж зүгээр болсон гэж ээж аав хэлдэг юм. Эмнэлэгт үзүүлэхээр зүгээр байна гэхээс өөр юу ч хэлээгүй гэсэн. Би одоо болтол хурдан гүйж чаддаггүй. Энэ хүнд их баярлаж явдаг юм. Одоо хүү нь гээд хонины далаар мэргэлж үздэг хүн бий. Бас улайссан төмөр зүүгээр долоочихдог гэж аав ярьсан.

Одоогоос хэдэн жилийн өмнө аав маань хүний ажил явдалд явчхаад ирсэн юм. Тэр өдрөөс

хойш гэрт таагүй үйл явдлууд ихээр болох болсон юм. Би өрөөндөө ганцаараа унтдаг байсан юм. Том өрөөнд аав дүү хоёр унтдаг байсан юм. Намайг унтаж байхад өрөөнд хүн яваад байгаа юм шиг чимээ , мэдрэмж төрөөд л цаанаасаа л нэг эвгүйрхээд л байсан юм. Хүн ер нь зургаа дахь мэдрэхүйгээрээ тиймэрхүү зүйлийг маш сайн мэдэрдэг байх. Яг унтах гээд л зүүрмэглэх үед хэн нэгэн цээжин дээр дараад бие рүү орох гээд байгаа юм шиг мэдрэмж төрөөд сэрчихнэ. Буцаад л унтах гэхээр болж өгдөггүй. Тэгээд л гэрлээ асаагаад үүр цайтал кино үздэг байж билээ. Гэрийнхэнд хэлэхлээр бүгд тийм юм мэдэрсэн л гэнэ. Унтаж чадсангүй л гэнэ. Би сүүлдээ ядаргаанд орох шахаад орой болохоор айлаар хоноод эсвэл ажил дээрээ очоод хоночихдог байсан юм. Тэгээд төд удалгүй гэртээ бөө залснаас хойш гайгүй болсон шүү. Хамаагүй хүний ажилд явдалд очсон ч болгоомжтой байх хэрэгтэй юм шиг. Янз бүрийн юм дагаад ирчихдэг юм шиг байгаа юм.

\* \* \*

Энэ явдал 8 жилийн өмнө Налайхын тоосгоны үйлдвэрт болсон юм. Зуны амралтаараа ажил хийхээр Налайх гэдэг газар очив оо. Хятадын тоосгоны үйлдвэрт цалин гайгүй болохоор сар ажиллах бодолтой байв. Ажилчдын байрлах газар нь гэрт бүгдээрээ нааран орон дээр л унтацгаана. Хамгийн захийн гэрт орсон анхны шөнө надад ийм зүйл тохиолдсон юм. Орой ажил дуусаад угаалга хийж , хоол идэх нь идэцгээгээд унтахаар болов. Маргааш өглөө эрт 7 цагаас ажилтай учир удалгүй бүгд унтацгаав. Бүгд л хурхиралдан дуу дуугаа авалцаж байлаа. Яг л трактор шиг чанга дуутайг нь яана. Миний нойр хулжсан юм уу. Яасан ч юм бол маш их ядарч сонсогдохгүй байна чи бруу юм дуулсан байх унтъя өглөө ажилтай гэлээ. Би гарч бие засангаа гэрээс гараад хартал юу ч байсангүй .. Гэр тойроод нэлээн харчхаад буцаж орж ирээд бас л унтах гэж орон дотроо тийчлэв ээ. Тэгсэн төд удалгүй гэрт юм түжгэнээд л байлаа. Хулгана ороод ирчихсэн юм болов уу ? гэхээр юу ч байхгүй мөртлөө гялгар уут өөрөө хөдлөөд л юм тойроод гүйгээд байв. Хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд унтах гэж хичээсэн боловч чихэнд нэг эмэгтэй хүн юм байсан ч унтаж чададгүй ээ. Тэгээд л хөрвөөгөөд юм бодоод унтах гэж хичээлээ. Нэлээн хэдэн цаг тэгж хэвтсэн байх өө. Шөнийн 2 юм уу 3 л болж байсан байх. Гадаа хүмүүс хэрэлдээд байх юм аа. Сайн сонсох нээ Хятадаар л хэрэлдээд байх шиг байгаа юм. Шулганалдаад л хэрэлдээд болдоггүй ээ. Хажууд талын хүүхдийг сэрээгээд сонсож байна уу? гэтэл юу ч хэлээд инээх шиг болов. Бүр ч эвгүйрхээд үүр цайтал гүрийж байгаад . Өглөө нь ажилдаа яваад даамал Өвөр монгол залууг гуйж байгаад өөр гэрт орсон юм.

\* \* \*

4-р ангийн зуны амралтаар үеэл дүүтэйгээ Налайх хамаатны даа амрахаар явсан юм. Тэгээд хамаатны ах дүү бид 3 үлдчихээд ярьж байгаад жимсэнд явахаар болов. Ах маань төгсөх анги байсан. 3-уулаа нэг нэг сав ус жимсээ хийх тор бариад Тэрэлжийн зүг гарлаа даа. Ах нэг л их мэддэг хүн мойл гүзээлзгэнэ энэ тэр түүнээ гээд л мань 2 юугаа мэд хэв дагаад л явсан. Явсаар байгаад оршуулган дундуур явлөө. Хулгана туулай гээд л гүйлдээд л байсан дүү бид 2 айгаад л ах өдрийн цагаар зүгээрээ битгий ай одоо ингээд л дундуур нь гараад явчихна гэв. За тэгээд явсаар байгаад Тэрэлж оров оо зорьсон газраа очоо л мойлоо түүж түүж уутны тал болоод ах ч эртхэн явцгаая гээд буцаж явтал гол гатлах болов. Ирэхдээ голоор гараагүйг бодоход бид хэд баахан л тойрсон юм шиг байгаа юм. Ах бид 2-г нэг нэгээр нь үүрээд л гол

гаргасан юм дүүг үүрч байхдаа өрөөсөн углаашыг нь голд урсгаад хойноос яваад авж чадаагүй. За одоо нэгэнт өнгөрсөн хэсэг хөл нүцгэн яваад л хэсэг үүрүүлээд л халуунд ч ёстой нэг үгээ хэлсэндээ. Гэрийн зүг гэлдэрч байтал хогийн цэг байхыг хараад өрөөсөн гутал ч болтугай олж авья гэр хүртлээ ядаж чирнэ гээд ах очив оо аз болж тэнд цоо шинэ эрэгтэй хүүхдийн сандал байсныг хараад дүү шууд л өмсчихсөн тухайн үед бидний хэн нь ч юу ч бодоогүй аргагүйдээ жоохон байсан болоод тэр байлгүй. За тэгээд арай гэж гэртээ ирээд ядарч өлссөндөө болоод л гэрийнхэндээ баахан гомдоллож уйлсаар байгаад унтав. Нэг мэдэхэд амралт дуусаж бид 2 ч гэр гэртээ харилаа. Тэрнээс хойш бараг 7 8жил налайх яваагүй яагаад юм бүү мэд. Тэгсэн нэг өдөр дүү гаднаас орж ирээ л учиргүй л уйлаад хаалганы хажууд нэг банди надаас юм нэхээд байна гээд л духнаасаа цус гартал хана мөргөөд л сонин сонин болж эхлэв. Бид хэд ч гайхаад яах уу ий хүү гээд л ярилцсаны эцэст Налайхад үздэг сайн хүн байгаа сургаар налайх орж тэр хүнд үзүүлэв. (тэр хүн нь ахын маань найз бөө болсон юм билээ). Дүүг маань хээрээс болохгүй юм авсан байна гээд л байсан бид хэд таг мартчихсан санадаггүйгээ. Ямар сонин юм бэ хөдөө хээр яваагүйдээ. Чи найз нөхөдтэй гээ нууцаар ийш тийшээ яваад болж бүтэхгүй юм олсон юм биш биз дээ. Овооноос мөнгө авцымуу гээд л шалгааж гарав дүү бүр яахаа мэдэхгүй ерөөсөө тийм юм байхгүй л гээд байсан. Нөгөө бөө ч сүүлдээ хүүхдийн сүнс хорогдсон бойтог байна гэхээр нь санасан. тэгээд л хэдэн айлын тогооны хөө, хонины шийр энэ тэр гээд л баахан юм бэлдээд л засал хийлгүүлээд шинэ сандаал аваад авсан газраа буцааж тавьж билээ. Тэр бөө хэлэхдээ тэр сандлыг авсан өдрөөс хойш тэр хүүгийн сүнс дүүг маань өчнөөн олон жил дагасан юм гэнэ лээ. Аз болж яаж мэдэв ээ мэдэхгүй явсаар өдийг хүрвэл юу ч болох байсан юм байгаан. Гэхдээ одоо дүү маань нэг л биш үе үе архи нэхэж уугаад л сонин сонин юм ярьдаг болсон. Магадгүй тэр явдлын нөлөө байж болох!!! Анх удаа бичиж байгаа болохоор хэтэрхий нуршуу бас алдаа дутагдалтай байж магадгүй шүү. Уучлаарай.

\* \* \*

Манай эмээг жоохон байхад дээр үед чоно их галзуурдаг байсан юм гэсэн. Анчид хор тавиад тэрнээс нь болж дутуу хордоод чоно мал их галзуурдаг байсан юм гэнэ лээ.Тэгээд айл саахалтаараа мал хуйгаа хашаад орой болцгоож бүгд гэр гэртээ орцгоож л дээ . Тэгсэн манай эмээгийнхтэй их ойрхон нэг эгч хүүтэйгээ хоёулханаа байсан юм гэсэн. Нөхөр сүүдэр байсан үгүйг мэдэхгүй юм.Тэгээд унтах гээд байж байтал шөнө хашаа хороогоор нь нэг юм яваад л байгаа нь сонсогдсон гэсэн. Тэр хавийнханд айл айлын гэрийг тойроод архираад самардаад л аймшигтай байсан юм байх. Чоно галзуурахаараа дуу чимээ гаргасан газрыг юу ч үгүй болтол самарддаг юм гэсэн. Хүн мал амьд юу л байна бариад идчихдэг гэсэн. Нүд нь сохроод зөвхөн сонсголоороо л орчноо мэдэрдэг болчихдог юм байх. Тэгээд л хүмүүс бүгд чимээгээ аядаад л хүүхдүүдээ сэрээд уйлчих вий гээд л манай эмээ хоёр эгчтэйгээ гэртээ байсан гэсэн. Хоёр эгч нь эмээг маань сэрчих вий гээд л их л айж байсан гэсэн. Төд удалгүй нөгөө хүүхэдтэйгээ байдаг байсан эгчээс чимээ гарсан юм уу яасан юм нөгөө галзуурсан чоно чинь гэрийг нь юу ч үгүй самардаж ороод улаан галзуу улайрсан нүдтэй муухай амьтан ээжийг нь юу юу гүй л зуугаад авсан гэсэн. Тэгсэн чинь хөөрхий ээж хүү нь 4 5 настай хүүхэд байсан гэдэг байх аа . Хүүгээ миний хүү эндээс зугт ээж нь ингээд өнгөрлөө хурдан зугт хажуу хэн ч билээ тэр айлынх руу хурдан гүй гэсэн юм гэсэн өрөвдмөөр. Хаанаас нь ч чоно зуусан юм мэдэхгүй. Зуулгаж байгаа хирнээ л голнь тасран тасартлаа орилсон гэсэн. Хоёул хоёулаа чонын хоол болж байхаар хүүгээ авраад өөрийгөө өгье гэж бодсон байх. Хөөрхий тэр ээж тэгж орилдог

нь бас хүүгээ яаж хөдөлж байгаа нь сонсогдохгүй гэж чоныг саатуулсан байх. Тэгээд л хүү нь гарч зугтаад л тэр саахалт айлынхаа ахынх луу орилоод л очсон гэсэн. Тэгээд л хүмүүс бүгд сэрцгээгээд буу шийдэм бариад л гарсан гэсэн. Тэр хавийн эрэгтэйчүүд нь тэгээд очтол. Ээж нь хүн харахын эцэсгүй болтол сийчээд хаячихсан байсан гэсэн. Чоныг газар дээр нь буудаж алаад булсан гэж ярьж байсан. Манай эмээгийн хоёр эгч нь хөөрхий эмэгтэй хүмүүс болохоор их л айж байсан байхдаа гэж боддог юм. Тэр үед хүмүүс ер нь галзуу чоноос их айдаг байсан юм гэнэ лээ.

\* \* \*

Сүнсэнд даруулах, хар дарах. Би бол байнга шахуу л хар дарж элдэв юм харна. Гол нь өөрийгөө хар дарах гэж байна гэдгээ өөрөө мэдээд байдаг. Тэр болгондоо өрөөнд хэн нэгэн байгааг баттай мэдэх юм. Өчигдөр орой гэхэд хүүгээ тэврээд унтаж байхад зүүдэндээ гэнэт сонин болоод нүдээ бага зэрэг л нээлээ. Харанхуйд ширээний чийдэн асаагаад унтаж байсан болохоор гэрэлд нь сайн харагдаж байгаа юм. Яг хүн дүрстэй үсгүй, (үстэй бол арзайж сэгсийгээд мэдэгдэх биз) яг тийм юм харагдаад арай гэж гүйцээд нүдээ нээтэл юу ч байсангүй. Айгаад буцаж унтаж чадсангүй ээ. Өмнө нь бас өрөөнд холхих, хөнжилтөөс татах, хөл барих, орон дээр хүн сууж байгаа нь мэдэгдээд хонхойгоод гээд л элдэв юм мэдэгддэг байсан. Энэ одоо нөгөө хэлээд байдаг зүүдний гажиг юу билээ тэр нь үү?

\* \* \*

Наана гэдгийг нь мэддэг байсан юм. Гэхдээ одоо мартсан байна. 9-н хүүрийн уул гэдэг газар хэдэн залуус гарч л дээ. гэхдээ залуус тус газрыг ямар аймшигтай газар гэдгийг урьд нь мэддэг байсан бөгөөд залуу хүний зүрх зориг бас дээр нь сониуч зандаа хөтлөгдөн юунд энэ уулын сүнс чөтгөр оршдог талаар судлах гэж гарсан юм байх. анх гарахдаа 10-уулаа гарсан бөгөөд замдаа явж байхдаа нэг залуугийн хөл нь гэмтэж тэгээд 9-үүлээ гарсан гэсэн. очих газраа очоод майхнаа босгоод бүгд л гурвуулаа майхандаа орцгоогоод төвхнөж гэнэ. Тэгсэн юу юугүй л хэн нэгэн хашхирах шиг болсноо нэг майхны гадна тал тэр чигтээ цусаар будагдахаар нь бусад майхнуудаас нь хүмүүс зугтаагаад гарцгааж гэнэ. Нэг залуу нь эргэж хартал харагдаж үзэгдэхгүй хирнээ л улаан цус агаарт цацраад байсан юм байх тэр залуу эргэж нэг хараад дахин эргэж харж чадахгүй зугтаасаар байгаад арай гэж нэлээн холдсоныхоо дараа хэсэг амс хийж байгаад эргэж хартал юу зүссэнийг бүү мэд хоолой нь хэрчигдэж дуугарч чадахгүй байж байгаад өглөө аврах багийн хүмүүс ирэхэд энэ болон зүйлийг ярьж өгөөд уулнаас бууж амжилгүй нас барсан гэсэн нэг ийм л түүх байна бодит биш шүү зүгээр л ангийнхан маань бөөнөөрөө сууж байгаад ярьдаг зүйл

\* \* \*

Одоогоос 3 жилийн өмнө юмуу даа би Архангайд хамаатны оюутан эгчтэйгээ хамт байдаг байсан юм. Манайх төвөөсөө жаахан зайтай хичээл өглөө эрт орно эгчийн сургууль хол болохоор надаас түрүүлж явдаг би хэдэн минут унтаж байгаад явдаг байсан юм. Т л даа би ер нь аймхай гэхүүдээ ганцаараа унтаж чадахгүй эгчтэйгээ хамт унтана манай тэр хавиар жаахан гүйдэлтэй гэж өвөө маань хэлдэг байсан юм. Тэгсэн нэг өдөр эгч босоод хичээлдээ явахыг нь хаалганы чимээнээр эгч явж байна даа гээд дотроо бодоод буруу хараад хэвтэж байсан чин хаалга дахиж дуугараад л орж ирэнгүүтээ хүйтэн гараа хөнжилрүү шургуулаад

бас дэрэн доогуур хийж тэмтрээд би нойрон дундаа та утсаа мартаа юу гэж хэлсэн юм. Тэгээд юу ч дугараагүй гараад байсан юм. Тэгээд нээх юм бодолгүй орой эгчийг ирэхэд нь та чин утсаа мартцымү хүйтэн гараараа хүн хайраад гэсэн чин үгүй ээ аниа нь буцаж орж ирээгүй гэхэд дотор пал хийгээд чичрээд өглөөгүүр үүрээр шахуу байсан болохоор манай гэрт тэнэсэн сүнс ч юмуу нэг юм орж ирсэн байх гэж бодсон.

## Тийрэн

Тийрэн гэдэг нь дайсан гэсэг утгатай үг ба тийрэн нь амьд ахуй цагтаа муу зүйл хийн үхсэн хойноо сүнс нь завсарийн оронд гацсаныг хэлнэ.

Тэд өөрсдийнхөө хүслээ гүйцэлдүүлэхээр хүмүүсийг отож тохиромжтой муу энергитэй газаруудад байрладаг.

Мөн монголчууд үсээ битгий задгай тавь үс гээгээ боо гэж хэлдэг нь хүний задгүй үсэнд тэд шингэдэг гэж үздэг тул.

Мөн монгол гэр бөөрөнхий байх учир нь муу зүйл нэвтрэхгүй суварга болохоор тэр ба Египетийн пирамидад мах тавиад долоо хоноход огт ялзраагүйн ариун энергитэйг илчилж байгаа бол монголчууд зүгээр суварган дотор амьдардаг.

Мөн тийрэн өмхий үнэрт татагддаг монгол ёс заншилд аргал шатааснаар уг утаа агаарт байх олон нян бактер устгана энэ үнэрээс тийрэнгүүд хүртэл зугтдаг аж.

Харин хотод тийрэнгүүд хамгийн их цуглардаг мөн баар саванд тэд бөөнөөрөө байдаг зугаа цэнгэл архидалт бол тэдний гол бай.

Хүмүүсийг тийрэн дагаж байгааг тухайн хүн өөрөө ч мэдэхгүй байх явдал бий ба тийрэн гэрт шүглэвэл тэр айлд ойр ойрхон хэрүүл тэмцэл гарах нялх хүүхэдтэй бол хүүхэд нь шөнө болгон уйлж айж цочих мөн хэн нэгэн хүний зан араншинд эрс өөрчлөлт орно огт танихгүй хүн шиг болох гэх мэт

Хэрэв тийрэн орсон бол зарим үед өөрийгөө эсвэл бусдийг хөнөөх ч үе гардаг.

Шалиг тийрэн хүнд орвол нөхөр нь эхнэрээсээ сална амьд ахуй цагтаа гүйцэлдүүлээгүй хүслээ өөр бусад хүмүүст хангадаг ба уг тийрэн өөртэй ижил завхай явдалтай хүнд татагдах нь элбэг хэрэв тэр тухайн биед орсон бол хүн мэдэлгүй явах боломж ч бий.

Түрүүхэн фэйсбүүк хэвлэл мэдээллээр охиноо зодож хөнөөсөн цагдаа үхсэн хүмүүс дээр ажилж байх үед сүнс нь тэр хүнд орсон гэж би үздэг.

Учир нь ийм үзэгдлийг харж байсан болохоор.

Мөн тэд гудамжинд тааралдвал нэрээр дуудах эсвэл хойноос хэн нэгэн хараад байгаа мэт сэтгэгдэл төрнө хэрэв дагасан бол тухайн айлийн хаалгийг шөнө дунд балбана энэ үед нээсний ч хэрэггүй ба бөөд үзүүлж тусламж авснаар түүнийг баттай хөөх юм.



Минийх аймар биш ч яг тэрхэн үедээ хөлс зутгаж үг дуугарч чадаагүй юм. Манайх жилийн өмнө 13т байдаг байсан юм . Нэг өдөр эгч маань орой гарах гээд аав ээжээс зөвшөөрөл авах гэтэл намайг хамт гар гээд тэгээд орой үдшээр гарж үзээгүй би чинь эгчээ дагаад гэлдэрлээ манай эгч урд талын байрны сааданд найзуудтай уулзаад юм хум яриад л суугаад би наахна талд нь савлуурандээр савалж байсан юм. Өөд өдөөсөө хардаг савлуур байсан ганц гэрлийн шонтой тэр нь бүдэгхэн асдаг би ч хүчтэй савлаад л савлаад л гэнэт чихэн дээр ирвэгнээд явсан үс ирвэгнүүлээд байна гэж бодоод үсээ чихнийхээ хойгуур хийсэн юм. Сөөнгөдүү хоолойгоор чихэн дээр бос гэж хэлэх сонсогдоод би ч унах шахам буугаад эгчдээ уурлан байж орсон юм . Тэрнээс хойш савлуурандээр нэг ч суугаагүй дээрээс нь мартаж эхэлж байсан юм. саяхан 6 Сарын дундуур налайх яваад анх удаа харгалзах хүнгүй гэрээсээ хол хамаатнындаа хоолоо. Орой 12 өнгөрч байхад хамаатны эгч дүү 2тойгоо гарлаа манай эгч найзуудтайгаа уулзаад дүүтэйгээ наана нь савлуултлаа бас л өөдөөсөө хардаг савлуур гэтэл од хармаар санагдаад дээшээ хартал босооч гэх сөөнг дууны хажуугаар тас хийх чимээ гарсан газар дээрээ ухаан алдаад маргааш өглөө нь гэмтэл орж тархины томографын зураг авахуулсан гавлын ясны хугаралтай дотор цус хуралттай гээд хүүхдийн 2р тасгийн 8 палатанд хэвтэхдээ орой бүр хар дарж зүүдэлсэн харин 2 дахь шөнөдөө нүүр нь түлэгдсэн үү зулгарсан уу гэмээр эрэгтэй хүү өөдөөс хараад бос гэж хэлсэн биздээ гээд хөхөрч инээнгээ хэлсэн. Зүүд байсан гэхэд арай өөр мэдрэмж байсан. Яг тэр хүүг нүдээ нээлттэй байхдаа харсан юм шиг л санагдаад байгаа. энэ 3 үйл холбоотой гэж батлагдаад аав ээждээ хэлээд Туул гэх удган эгч дээр очиход дэв шүгэлсэн байна гээд үхтлээ ташуурдуулж зодуулсан . Одоо надад муу зүйл тохиолдохгүй байгаасай гэж хүсэж байна. сарын дараа тархины хагалгаанд орохоор болсон амжилттай байгаасай гэж найдаж байгаа. Бас их нуруу юм биччихлээ уучлаарай.

### **Энэ л надад тохиолдсон хамгийн аймшигтай зүйл юм даа.**

Тэр үед ч сүнс сүүдэр их сонирхдог байж билээ. Тэгээд бүүр шийдчихсэн 2 найзтайгаа 3 уулаа далан давхар орж үзэхээр шийдээд тэнд очиж үзсэн юм. Бид 3 ч очих замдаа их хөгжилтэй бичлэг хийсэн шиг явж байлаа. Тэгээд удалгүй ирлээ, булшнуудынх нь наагуур шар өндөр хашаатай наагуур нь овоолсон өндөр шороотой юм байна лээ. Тэгээд бид 3 дотор нь орох уу яахуу гээд ярилцаж байсан чинэ бүр аймар том хар хэрээ бид 3ын хажуухан талд ирсэн байсан. Тэр нь манай нэг найз бөөгийн удамтай тэгээд буруу юм хийх үед хэрээ болж ирдэг өвөө маань байна гэж хэлэхээр нь айгаад зүгээр гаднаас нь бичлэг хийж үзэхээр шийдлээ. Тэгээд наад талынх нь овоолсон шороон дээр авирч гараад утсаа бариад бичлэгээ эхлүүлээд удаагүй байсан чинэ нэг хүн залгасан юу ч дуугарахгүй байхаар нь салгах санаатай чихнээсээ аваад хартал дэлгэц нь ув улаан өнгөтэй болчихсон. Тэгээд ер нь болихоор шийдээд барах гүйхээрээ явж байгаад автобусанд суугаад гэрийн зүг явцгаалаа. Бид Зинх Зөөр зүгт учир цуг алхаж яваад салцгаалаа. Салаад нэг их удаагүй байтал надруу нууцалсан дугаар залгадаг юм байна. Аваал байна уу гэсэн чинэ салхи салхилах чимээнээс өөр юу ч сонсогдоогүй. Гэтэл тэр нууцалсан дугаар бид 3 луу Зланлуу нь залгасан байхыг маргааш нь мэдсэн. Тэр үед үнэхээр айж сандарсан ч маргааш нь олуулаа явж үзье гээд бид 3 дээр 1охин 1банди нэмэгдээд явсан юм. Тэр өдөр бүүр дотор нь ороод дундуур нь алхахад нээгдсэн

авснаас өөр айлгах юм юу ч байгаагүй. Тэгээд орой сургууль дээр хуралтай байсан болохоор бүгд сургууль орлоо. Манай нэг найз утсаа хүүхэд түр бариулж байгаад хичээлийн сүүлийн өдөр байсан тул нэхээд симгүй утсаа өөртөө авсан байлаа. Хурал дуусахын алдад нөгөө нууцалсан дугаар чинэ нөгөө симгүй утасруу залгадаг байна шүү бүр аймшигтай 3,4н ч удаа залгасан тэгээд ер нь муу ер шүглэсэн газрыг зүглэвэл заавал нэг юм тохиолддог юм байна лээ шүү!!

\* \* \*

2002-2009 оны хооронд манайх Дамбадаржаад амьдардаг байсан юм.Тэгээд 2009 оны намар хотод нүүж ирснээсээ хойш би хэт их тураалд ороод биеэр минь писроз/арьсны өвчин/ туурж эхэлсэн.Гайгүй болчих вий дээ гээд ойр зуурын эмчилгээнд яваад 2013 оныг хүргэтэл өвчин маань дунд шатандаа явж байсан санагдана.Тэгээд ээж аав хоёр минь яаж ч зүгээр суухав бөөд хандаад хуучин хашаа хороондоо очтол "Танай газар дээр өмнө нь нэг эмээ амьдардаг байж.Тэр эмээ өвчнөөр нас бараад удаагүй байхад та нар газар дээр нь байшингаа босгосон байна.Өөрийнх нь газар дээр байшин барьчаад тэр эмээд талархал илэрхийлээгүйд гомдож,хорссон эмээ бага охиныг чинь лусын хорлолд автуулжээ" гэдэг байгаа.Тэгээд тэр эмээ миний хаана байгаа газар намайг харж,дагаж байдаг байсан гэсэн.Тэр үедээ их л эвгүй байсан юм .

\* \* \*

Анх хөдөөнөөс оюутан болж 1-р курс орж дэнжийн мянгад монгол гэр түрээслэн найзтайгаа амьдарч байсан юм. Оюутны амьдралд анх хөл тавьж байсан болохоор их сайхан санагдаж энд тэндхийн зүйлсийг эс ажиглан амьдарч байж дээ... Нэг шөнө 1өнгөрөөд 2болохын алдад хашааны хаалга онгойж нохойнууд хуцаад нэг юм хөөгөөд байх шиг болохоор нээх их ч тоосонгүй угаасаа хашааны хаалга нохой онгойлгоод байдаг болохоор нь тоохгүй унтаад өглөө. Тэгээд маргааш орой унтаж байгаад шөнө дун хар дараад сэрсэн чинь нохойнууд бас айхтар хуцаад нэг л сонин чагнаад хэвтэж байтал нээх сонин хүн гэхэд хөнгөхөн хөлтэй нохой гэхэд гэрийг гурав дөрөв тойрно гэж байхгүй. Аймар санагдаад найзыгаа сэрээх гэсэн нойроо харамлаад сэрсэнгүй тэгээд би ч айж байгаад унтаад өгч. Маргааш нь амралтын өдөр болохоор телевиз үзэхээр хажуу айлдаа ороод юм ярьж байгаад нэг мэдэхэд л сүнс сүүдэр яриад ахалсан гэтэл манай хажуу талын хашаа сүнстэй гэж палхийтэл хэлдэг байгаа. Юу худлаа яриад юм хүн айлгаад гэсэн чинь нээрээ гэж ирээд баахан юм ярьсан. Тэр өдрөөс хойш шөнө бараг л сэрэхгүйг хичээн чихээ таглаж унтдаг болсон. Нэг өдөр манай хажуу талын эгч дуудаад өнөөдөр манайд хоноорой гэхээр нь яагаад гэж асуутал 3сарын 13нд шөнө дунд нэг эмэгтэй хүн нярай хүүхэд тэвэрсээр арын дэлгүүр болох БАЦЭДЭС дэлгүүрийн тэндээс хажуу талын хашаан дундуур гиншин уйлж нярай хүүхэд нь ярагласаар явдаг гэв. Энэ зүйлийг сонсоод юун буцаж гэртээ орох мантай шууд тэндээ хонохоор болов.

**Шүлхий гэж өвчин сонсоогүй хүн гэж бараг байхгүй биз ээ...**

Ийм өвчин туссан мал яг л эргүүтчихсэн юм шиг хээр талд юу ч болж байсан зогсоод байдаг аж. Харин тийм малын мах идсэн араатан амьтан ялангуяа чоно шууд галзуурдаг байна. Галзуу чоно их аюултай, хүн рүү шууд л дайрна, тийм ч учраас манайд жил бүр шүлхийгийн эсрэг вакцин хийж, шүлхий өвчин илэрсэн газар хөл хорио тавьдаг. Хавар, намрын цагт энэ

өвчин дэгдэх магадлал өндөр байдаг байна. Энэхүү гай зовлон дагуулдаг өвчнөөс болж аав, ээж болон эгчийгээ алдсан хүүгийн гунигт түүхийг дор өгүүлье...

1980 аад онд байхаа даа сайн санахгүй байна. Өвөрхангай аймгийн зах руу Батхаан гэж нэг хайрхан бий. Энэ хайрханыг түшиглэн амьдардаг Баярынх (өөрийнх нь нэрийг дурьдаагүй болно) гэдэг айл 2 хүүхэдтэй ажээ. Эцэг эхийнхээ үлдээсэн хэдэн малыг овоо өсгөж хөдөлмөрийнхөө ачийг амталж яваа их л ажилтай айл байжээ. Хойдхон талд нь хэдэн толгод бий, хадтай учраас тэр ууланд чоно элбэг. Нутгийн залуучууд хааяа нэг үргээлгэнд гарна. Хонь малаа сайн харахгүй бол чононы хоол бэлдэнэ л гэсэн үг. Нэг өглөө Баяраагынхтай айл Буянаагын мал чононы дайралтад өртжээ. Тэр голынхон бүгд л сүйд майд болж, 8 хонь үхсэн байж. Гэхдээ чоно л юм хойно идэлгүй сэглээд сэглээд алчихсан байгаа нь бүр ч зэвүүцмээр. Буянаа : Муусайн гөлчгийнүүд хайран сайхан хэдэн бор хонийг маань ингээд зооглочих гэж, одоо чононууд цатгалан байгаа хэдүүлээ үргээлгэнд гарья аль болох холуур үргээчхээд ирье. Ер нь энэ муусайн чононуудыг цөөлөх цаг болсон байгаа гэж бусдыгаа уриалав. Нутгийн залуус ч дэмжиж бүгд гэр гэрээсээ хамгийн сайн, хурдан гэсэн морьдоо барьж хойд уулын зүг буугаа аван шогшицгоов. Чоныг цатгалан байхад нь уулын өөд хөөвөл хурдан гүйж чадахгүйн дээр бүх идсэн юмаа бөөлжиж гаргадгийг мэдэх тул тэд аль болох уулын өөд хөөхөөр зэхэж байлаа. Уулын бэлд ирээд хэрвээ чонотой таарвал буудаж бусдадаа дохио өгөхөөр болоод тал бүр тийш салж явлаа. Баяр арай өөр газраар морио гуядан явав. Бараг цаг шахуу хайлаа хэнээс ч буун дуу гарсангүй. Баяр сүүлдээ чоно биш өөр зүйлд бодлогошрон гэлдэрж байтал гэнэт урд нь бүхэл бүтэн чонон сүрэг байгааг харав. Тэдний дотор бусдаасаа хавьгүй том биетэй, арьс үс нь алт мэт гялтганасан нэгэн чоно эрхгүй ялгарч байлаа бодвол азарган чоно бололтой. Түүний хурц ширүүн харц нь Баярыг нэвт сүлбэх шиг үнэхээр сүрдмээр, балмагдсанаасаа болоод бууныхаа гохыг ч дарж чадахгүй байлаа. Чоно барагтаа бол хүн рүү дайрдаггүй амьтан, Баяр яахаа мэдэхээ болин гөлөрч байхад нь морь нь чоноос үргэн зугтаж буцаад давхилаа. Энэ явдал хэдхэн хормын дотор болов. Юу болсныг дөнгөн данган ойлгохтойгоо болсон Баяр тэнгэр лүү биш газар луу тас хийтэл буудаж орхив. Морь нь улам үргэж ухасхийн салхи мэт давхиж, Баярыг унагаагаад давхичихлаа. Гэнэт урдаас нь сүрэг чоно яг л Баярыг тас татан хаях гэж байгаа мэт хурдлан давхив. Айх гайхах нь зэрэгцсэн Баяр хөлийн хурдаар зугтав. Нэг мэдсэн чинь чононуудтай мөр зэрэгцэн давхиж байна гэнэ. Айсандаа ухаан алдаад уначхав. Нэг сэрсэн гэртээ байж байна, хамт явсан залуус нь мах идчихсэн Баярыг ярин тас тас хөхөрөн инээж байна гэнэ. Босоод иртэл бүгд инээлдэн чи чинь харин айхаараа чононоос дутахааргүй гүйдэг адтай золиг байнлээдээ гэв...

\* \* \*

- Өөрийгөө амьд байгаад баярласан Баяр юу болсныг асуухад Буянаа : Аз болж бид хэд чамтай ойрхон явж байлаа буун дуу гарсан газар луу ухасхийсэн чинь сүрэг чоно биднийг хараад зугтчихсан, хойноос нь хөөж байтал чононуудын урд нэг хар юм эргэж харах ч сөхөөгүй гүйгээд байнаа. Гайхсан гэж хаха тэгээд чононууд чиний хажуугаар давхилдаад зугтаж байхад чи ухаан алдаад уначихсан гээд бүгд л инээлдэж Баярын тухай паян тэр голд нэг хэсэгтээ л хит болов. Нутгын залуучууд 3 чоно агнасан ба чонон сүргийг нэлээд хойш нь үргээсэн аж.

Баярын ганц хүү Аюуш нохойгоо дагуулан хониндоо явлаа. Нохойг нь Баянбаатар гэх бөгөөд

их олон жил тэдний үүдийг манасан хөгшин сөөнгө хуцдаг нохой байжээ. Гэрт үлдсэн малчин залуучууд ойрд агнаагүй чонынхоо махыг идэн, шимийн архи ууж, ойр зуурын юм хуучилна. Хонинд явсан Аюуш замдаа буудаллан аавынхаа дурангаар ойр зуурыг нягтлан харж байхдаа нэгэн шар үхэр хээр зогсож байгааг харлаа бараг 30 минут тэндээсээ огтхон ч хөдлөхгүй зогсоно. Аюуш хүү шүлхий гэж өвчин сонссон боловч туссан мал яадгийг сайн мэдэхгүй эргүүтсэн үхэр байх гэсэн бодол л түүний толгойд бууж байлаа. Хонио тогтоочоод гэртээ харив, үд болж хонио хариулахаар ирэхэд нөгөө үхэр зогсож л байлаа. Хонио хотондоо авааччихаад гэртээ ирээд аавдаа хэллээ. Баянаа шуудхан л буугаа аван хүүгээ дагуулан мордлоо, замдаа Аюушд "Миний хүү хээр талд зогсож байгаа үхэр, тэмээ, хонь мал байвал шуудхан аавдаа хэлж бай. Эртхэн устгахгүй бол араатан амьтан тэр малын махыг идвэл аюул болно шүү" гэж хэлээд заасан газар нь очтол шарын сэгнээс өөр зүйл байсангүй. Баянаа : Гэнэт их идээд гэдэс нь дүүрчихсэн чононуудыг хөөгөөд хамаг идсэн юмыг нь бөөлжөөд гаргачихсан, одоо өлөн байгаа чононуудад шар үхэр гэдэг өдрийн од л гэсэн үг аль хэдийн идчихсэн байх шив, чи Буянаа ахынх руугаа давхи "Чоно галзуурсан" гэж хэл ойлгох байх, замдаа зогсож болохгүй, шогшиж ч болохгүй хамаг хурдаараа давхиарай. Тэнд очиж хэл дуулгачхаад тэндээ хоно наашаа зүглэж болохгүй шүү гэж захиад хүүгээ мордуулав. Өөрөө гэрийн зүг хар хурдаараа давхив. Гэртээ ирээд авдраасаа ахиухан шиг сум аван, эхнэр хүүхдээ гарж болохгүйг сануулав. Удалгүй нохой хуцлаа ашгүй Буянаа ирж байх шиг байна гэж бодтол нэг л бишээ !! Баянбаатар сөөнгө хоолойгоор их л ярдаглан хуцна. Тэдний 2 залуухан банхар нь сав л хийвэл хуцаж байдаг, харин Баянбаатар хэр барагтаа хуцдаггүй нохой. Нэг л түгшүүртэй санагдаад явчихлаа. Хонь мал майлалдаж ноход гаслаж эхлэв, буугаа сумлан гарах гэж байтал тооноор нь яг өөрийнх нь харсан азарган чоно ам шүд нь цус шүлсэндээ баригдсан байдалтай архирч охиныг нь ганц л зуулаа, ээж нь орилон Баянаа тас хийтэл чонын дал руу буудав. Галзуурсан чоно яасанчгүй нүд нь улаанаараа эргэлдэн Баянаагын гарийг тас хазав. Ийнхүү орилоон уйлаан тасарч галзууран сүргээсээ тасарсан чоно хэсэгхэн хормын хугацаанд тэр айлын голомтыг нь самарч орхив. Буянаа Аюушыг дагуулан дүү нартайгаа арваад хүн буу тачигнуулсаар давхин ирсэн болов ч оройтсон байжээ. Уян дээр байсан морь дүүжлэгдсэн мэт үхэж, хэд хэдэн хонь ямаа, үхэр, 2 залуухан банхар нь үхжээ. Баянбаатар нил шарх сорив болон шүлсээ гойжуулан хэвтэж байлаа. Чоно гэр дотор байгааг нь мэдсэн Буянаа бусдыгаа командалж гэрийг нэвт шувт буудаж эхэллээ. Хэд хэдэн удаа тас тас хийн ээлжилж буудсаны эцэст гаслах дуу сонсогдов. Ийнхүү галзуу чоныг устгажээ. Аюуш тэр үед аавдаа эртхэн сануулаагүй дээ одоо болтол харамсан дурсдаг ажээ.

\* \* \*

## **15 16 настай яг л өсвөр насан дээрээ байлаа даа**

Бидний үеийнхэн заал нтр авнаа хотын төв бараад л

Зун байсан юм дэг...

-1 найзтайгаа харих гээд 32 тойрог дээр алхаж явлаа лагерлуу явж байгаа нь тэр

нэг жаахан архи үнэртүүлсэн нөхөр тамхи байна уу? л гэж байна шүү тухайн үед татдаг байсан болохоор нээх юм бодсонгүй 1-г гаргаж өгчөөд цаашаа явах гэтэл мөнгө нэхдэг байгаа 1 хүнээс айна гэж юу байхав 20 нилээд гарцан байрын залуу тэгээд үзэж тарсан банди залуу

2-н ялгаа бол гарч байгаа л даа 2лаа юм чинь нилээн юм болж найзтайгаа нилээд гөвчихлөө

Тэгээд замдаа лагер явж байгаа машинд дайгдчих санаатай л машинд гараа өргөөд лагер явж байгаа бол дайгдаад явчих уу? гээд гуйгаад л явлаа гэсэн дандаа таксинд явж байгаа хүмүүс ер халгаасангүй

За тэгтэл нэг микро суу суу л гэж байна 3 4 хүнтэй юмаа жолоочоосой гадна.Орж суугаад л хаалгыг нь хаатал заалны гэрлээ асааж байна шүү!!!

Нөгөө зодуулсан бачка чинь 3 4 хүн дагуулаад ирж дандаа гүзээтэй том том залуучуудаа...угаасаа тэр үедээ том харагдаж байсан юм

Уг нь мань 2-г барих санаатай л өдөж хамт байсан гарууд дэлгүүр ороод анзаараагүй байхад нь найзтайгаа гөвчхөөд хээв нэг яваад өгч л дээ.

Ямар овоо с.... нар вэ гээд л зодож гарлаа шууд микро дотор мань 2 бол гөлөг болж байгаа юм чинь утсаа пүүзээ гээд л бүх юмаа л өглөө мөнгө бол байгаагүй л дээ

За ах нараа ингээд 2 дүү нь явъя л даа гэлээ...чи бид 2 хэзээ ах дүү байсан гээд нөгөө зодуулдаг бачка ахиад намайг хэд хэд шанаадлаа

Нэг нь за наад муу 2 гөлөгөө явуул явуул гэсэн жолооч нь нөгөө юмруугаа аваад явъя гэсэн өө нээрээ тийн гээд санаа нийлж байна шүү гарууд

Дүү нар гээд л утас пүүз нтр буцаагаад өглөө дүү ажил хийнээ гэлээ шүү тэгээд дэнжийн 1000руу эргэлээ

За яах гэж байгаа болдоо одоо ч зодохгүй байлгүй дээ гээд тамхилцгаагаад юм ярилаа овоо гайгүй зөөлөрч байан шүү дүү нар айж байна уу битий ай гэлээ үгүй үгүй гэсэн мөртлөө л дотроо пал пал гээд байгаа юм чинь

Нэг л эвгүйтэйд явчихлаа шүү засмал замаас гараад нилээн яваад зогслоо буугаад ир л гэж байна.Эргэн тойрноо харсан баахан булшин дотор зогсож байх юм.

-За ах нараа яах гээд байгаан вэ 2 дүүгээ ээ гээд уйллаа

зүгээрээ дуугүй аль хүрзээ аваад ирээ л гээд 1нийгээ дуудлаа

ПАЛ ПАЛ ПАЛ гээд зүрх амаар гарах шахлаа даа

Энэ булшийг ух гэж байна ээ ахаа яаж дээ гээд эсэргүүцлээ ахиад зодоод эхэллээ ....за за ахаа ухнаа л гэлээ

Айгаад байгаа бол май гээд 1 шил архи 50 аягаар бид 2 хуваагаад уулгалаа.

Тэгээд ухаад эхэллээ. Тэд нар хоорондоо ярьж байна өнөө өглөө тавьсан юм овоо баян гар байгаа даа гэлцэж байна

Гүн ухуулсангүй авс нь гараад ирлээ. Хадаасны лоом шиг юм өгснөө онгойлго гэхээр нь үгүй ээ яаж дээ ээ нтр гээд л бөөн юм боллоо.Тэгсэн ахиад 50 аягаар дүүрэн архи бид 2 өглөө ойлгохгүй юм бол та муу 2-г энд алчхаад булчхад хэн мэддэгийн айн тийм биздээ

Айсандаа ойнголлоо тэгсэн хөв хөх царайтай шарил бараг харж чадахгүй өмдөндөө шээх нь холгүй юм боллоо.Бид 2 нүхнээс нь гараад иртэл май 2 дүү сайн байна айгаад байх юм байхгүй байгаа биз дээ гээд ахиад л архи өглөө уугаад л тавчихлаа

Тэгсэн буцаж ороод тэр алт мөнгөн эдлийг нь аваад өг ээ ахаа гээл уйллаа ална шүү та 2-г гэсээр байгаад орууллаа.

Тойруулсан сул хийсэн юмнуудыг бүгдийг нь авч өглөө.

За амисгаанууд тэр гаранд нь байгаа бөгжнүүдийг нь аваад аль ээ агаа нтр гээд уйллаа ахиад л архи өглөө

Тэгээд хуруунаас нь бөгжийг нь салгах гэсэн хуруунууд хөөцөн гардаггүй....Тэгсэн хутга өгснөө наадахаа тасдаа хөөе үгүй ахаа яаж дээ ална шүү та 2-ыг гээд хүрз далайлаа

Тэгээд гар хөл чичрээд хамаг биенийг хар хөлс жахраад л яг тастдаг даваан дээр

ЭЭЖ миний хүү бос хичээлдээ яв гэдэг байгаа...

Энэ түүхийг зун зүлгэн дээр найзтайгаа нилээд үеийнхээ охидуудыг тойруулж суулгачхаад ярьдаг байлаа даа хэхэ

Сүнс гэснээс би анх 1989 онд сүнстэй таарсан байгаа тэгэхдээ өөрөө мэдээгүй л дээ би жоохон дөнгөж 1-дүгээр ангид орсон жил байсан юм гэр хороололд амьдардаг байсан тэр үед одоогийн үе шиг хог ачдаг машин энэ тэр гэж бараг байдаггүй байсан манай гэрээс зүүн тийш их том хогийн цэг байдаг байлаа тэр хогийн цэгийн наана булангийн хашаанд нэг аймаар ууртай эмээ байдаг байсан юм нэг өдөр дүү бид 2 шөнө поошигтой үнс асгах гээд түрээд явж байсан чинь нөгөө эмээ шөнө хашааныхаа үүдэнд аймаар үс нь хийссэн сав саарал үстэй болсон зогсож байна шүү дүү бид 2 анзаараад нөгөө ааштай эмээ зогсож байна гээд хажуугаар дуугүй гараад л үнс ээ асагчаад буцаад явсан нөгөө эмээ зогсож байлаа тэгээд сайн харсан чинь яаж зогсож байсан яг тэр хэвээрээ л байна бид 2 яахав үнсээ асгачхаад поошиг тэрэг 2 оо түрээд гэртээ ороод ирлээ тэгээд мундаг 2 ах эгчдээ сая нөгөө ааштай эмээ үүдэндээ зогсож байна гэсэн чинь тэгээд бид 2 ыг харчхаад загнасангүй гэсэн чинь юу яриад байна та 2 чинь энэ тэр гээд уурлаад худлаа яриад бай гээд уурлаж байна бид 2 нээрээ гээд л хэлээд байсан чинь тэр эмээ 1988 өвөл нь гэртээ нас барсан юм байлаа зайлуул тэгээд дараа нь хүмүүс ярих нь хүү нь шоронд байсан юм байна лээ их л хүлээсэн болохоор хөөрхий эмгэн төрлөө олохгүй байгаа юм гэж томчууд ярьж байхыг сонсож билээ одоо ингээд бодохоор хүүхэд болохоороо л анзааргагүй байсан байгаа шүү.

### **Цамцнаас татдаг хий юм**

Зуны өглөө л байсан юм даг. Зургаан цагийн үед ажлынхаа бие засах газар сууж байлаа би.

Тэгсэн чинь коридороор хүний хөлийн чимээгараад 2-р давхар луу өгсөн явах нь дуулдаж байна. Нэг их удалгүй өнөө чимээ дээд давхраас шатаар уруудан буусаар бие засах өрөөний хаалга онгойн орж ирэх дуулав. Ийм эрт хэн нэг нь дуудагдаж ирж дээ гэж бодож байтал миний өмссөн ноосон цамц минь мөрнөөс гэнэт өргөгдөн зах нь эрүүнд тулахаар нь хамаг бие арзайгаад л явчихлаа.Цамцаа буцаагаад татгал нэг угзарснаа сулраад ирэв. 00-д яадгийг мэддэг учир нэг их айж сандарсангүй. Нэг сайн амьсгаа авч биеэ сэгсрээд тайвшрав. Инээд ч хүрэх шиг энэхий юм эмэгтэй байсан биз. Тэгээд л намайг шохорхоо болов уу гэж муу юм бодолгүй өөртөө эерэгээр тайлбарлаад морь харах үйлээ дуусган гарч явлаа. Үүдэнд ирвэл жижүүр унтаж байна. Корпусын хаалга дотроосоо түгжээтэй хэвээрээ байв. Намайг гаднаас орж ирэхэд жижүүр ганцаараа байсан ба жижүүр намайг оруулсны дараа хаалгаа түгжсэн билээ. Жижүүрийг сэрээн гаднаас ажилтнууд ирсэн эсэхийг асуухад хэн ч ирээгүй гэв. Намайг бие засах өрөөнд орсны дараа чи дээшээ гарсан уу гэвэл үгүй гэнэ. Намайг 00-д оронгуут шууд унтсан байв. Бүх юм тодорхой боллоо. Гар хатаах сэнсийг разетканаас нь салгасан байхад л ажиллуулж дөнгөөд байдаг өнөөх чинь маниараа дамшигласан байж л дээ. Ер нь манай ажил дээр нэг сонин нөхөр байдаг юм. Тэндхийн ажилтан биш л дээ. Мөн бие нь харагдахгүй. Ер нь түүнийг хэн ч хараагүй. Тэхдээ зарим хүмүүс гадарладаг. Жишээ нь би. Тэр их дэггүйтнээ. Хэн ч гаднаас орж ирээгүй байхад мөн хэн гар хүрээгүй байхад хурууны хээгээр ажлын цаг бүртгэх төхөөрөмж гэнэт амь орсон мэт БАЯРЛЛАА гэж дуугарна. 00-д тольны хажуу хананд байх гар хатаах сэнс шөнө дунд гэнэт ажиллана. Жижүүрүүд айгаад сэнсний залгуурыг разетканаас нь салгачихсан байхад шүү дээ. Шөнө дунд хувцас солих өрөөний төмөр шкафнуудын хаалга галзуурсан мэт гэнэт дараалан хүчтэй савагдана. Корпусын гадна талд байх том төмөр хаалга өөрөө нээгдэж хаагдана. Тэр хаалга нь хар салхи дэгдсэн ч хөдлөхөөргүй хүнд зузаан лист төмрөөр хийсэн зэвэрсэн нугастай зуурч онгойдог эд шүү дээ. Ер нь хааяа хааяа сонин сонин юм болноо манай ажил дээр.

### **Надад саяхан тохиолдсон зүйл эхэндээ аймар байснаа сүүлдээ хөгжилтэй.**

Би гэр хороололд амьдардаг юмаа.Тэгээд манай хашаанд урьд надад юу харагдаж сонсогдож байгаагүй.Би ч хэр баргийн юмнаас нэг их айдаггүйшдээ.Нэг удаа баахан аймшгийн нийтлэл уншчихаад л гарч бие засах гэж гарав.00-руу ойртсон 1 гөлөг ханиах шиг дуу гарахаар нь хажуу айлыхнаас 1 нь орсон болуу гээд хоолой засан чимээ өгөв.Хүн дугардаггүй.Тэгэхээр нь хүн бнуу гэсэн нөгөө хачин юм дугарав.тэгэхээр нь гөлөг уначихсын болуу гээд халыт шагайсан юм.Т эгсэн бүр тодоор дугардгийн . Дотор пал гээл явчхсан. Харанхуйд ядаж юу ч харагдахгүй ёоо.Гэрлүүгээ хар хурдаараа гүйж ороол нөхрөөрөө харуулсан юм. Тэгсэн манай нөхөр юу ч алга гэдгийн.Манай гэрийхэн надад итгэдэггүй.Хачин юм уншсаар байгаад шар хадны хурцын тасаг явчихваа гээд даажигнаад хха.Тэгээд 2,3 хоногийн дараа хажуу айлд ороод үеэл дүүдээ хэлсэн чинь тас тас инээгээл явцан.Би гайхаад яасан бэ гэсэн чинь манай үеэл тэр чинь би байсан юмаа ээжтэй муудалцаад уйлж байсийн тэгээд та хүн байна уу? гэхээр чинь би сонссон таныг шагайчихаад гэрлүүгээ гүйхээр чинь намайг харсан л гэж бодсоншд гээл шоолоод л.Би бас өөрийгөө шоолоод л. Ххаха.Балайн

### **Шунхлайн сүг**

Төв аймгийн Баяндэлгэр суманд алдар хүндтэй юм цөөнгүй бий. Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Дашдоржийн Нацагдорж одоогийн энэ Баяндэлгэр сумын

нутаг Гүн галуутайн Аяга хэмээх газар эхээс мэндэлжээ. Төрсөн гэрийн буурин дээр нь дурсгалын хөшөөт самбар одоо хэр нь байдаг билээ. Социалист Монгол хайрт нөхөр ЗХУ-ын өгөөмөр халуун тусламжаар мөн энэ нутагт Багануурын уурхайг нээж шинэ хот босгосон нь эдүүгээ нийслэлийн дагуул хот болжээ.

Гүн галуутайд Гүн нуур гэж холбоо хоёр нуур байдагсан. Байдагсан гэсний учир нь одоо бараг ширгээд шалбааг болох шахсан юм. Хоёр нуурын том нь Их гүн нэртэй бөгөөд төмөр зам, 82-р өртөөнөөс урагш байв. Тэрхэн хавьдаа томоо нуур байв. Загастай, усны шувууд чуулна. Хунгийн сүрэг, ангир, нугас, цахлай гээд шувууд жиргэн чуулж, эргээр нь адуу мал бэлчсэн сайхан нуур байваа. Бага нуур нь Бага гүн нэртэй агаад Багануурын уурхайн Уулын 2-р карьерийн баруун хойно бас л сайхан мэлтийж байдаг байлаа. Ийм л сайхан нутагт нэг хэсэг амьдарч байхад энэ явдал болсон юм.

\* \* \*

Баяндэлгэр сумын төвөөс урагшаа тариа ногооны Шунхлайн бригад гэж байв. 1996 оны намрын налгар өдрүүдэд ШШГЕГ-н Багануур дахь хорих 427-р ангийн 300 гаруй хоригдол хавар тарьсан хүнсний ногоогоо хураан авах ажилд идэвхийлэн зүтгэх ажээ. Хорих ангийн ногоо тарих энэхүү газрыг Шунхлайн хэсэг гэнэ. Ногооны талбайн баруун хойно 200-гаад метрт модон хашаатай тэг дөрвөлжин гортиг дотор урдаа багашаархан талбай бүхий цөөхөн цонхтой урт цагаан байшин байх бөгөөд уг байшинд ногоо хураах хоригдлууд байрлахаас гадна хэсгийн дарга офицерууд болон хянагч нар байрлана. Хашааны гадна урд талд таван ханатай гэр барьжээ. Гэрт хоригдлуудыг манах үүрэг гүйцэтгэх Дотоодын цэргийн салбарын нэг харуул байрлаж цагийн манаанд гарна. Шунхлайн хэсэгт гэрэл цахилгаан байсангүй. Урьд нь ажил амьдрал ундарч байсныг хашааны баруун хойд булангаас 10 метрт байх ганц шонгийн мод болон урт цагаан байшингийн хананд ганц нэгээр цайран харагдах эвдэрхий разетка гэрчлэх мэт.

Ногоо хураах ажил эхлээд арваад хоног болжээ. Харуулын 12 цэрэг, манаа халагч 2 түрүүч, нэг офицер нийлээд 15 алба хаагч албан үүргээ хэнээс ч хамааралгүй яг таг ээлжлэн гүйцэтгэж байтал нэгэн шөнө.

02 цагийн манаа халаад удаагүй байтал хашааны зүүн урд булангийн 2-р цэгт үүрэг гүйцэтгэж байсан Булган аймгийн Сайхан сумын харьяат Загдбазарын Сайханбаяр гэдэг цэрэг харуулын гэрт ороод ирлээ. Харуулын дарга дэслэгч гайхаж чи харуулын цэгээ орхиод юу хийж явнаа гэвэл Анхбаяр түрүүч тамхи аваад ир гэсэн гэдгийм байна. Чи чинь тэнэг юм уу ? Хэзээ би тэгж хэлээв гэж зандарсан түрүүч Анхбаярыг зуухны өмнө сууж байхыг олж хараад мөнөөхөн цэрэг гайхсандаа юм уу загнуулсандаа юм уу хэлэх үггүй түгдэрч байснаа дэслэгчийг гүй ээ чи байрандаа очооч гэж хэлсний дараа хэзээ ороод ирчихвээ гэж дуулдах төдий үглээд хаалга хаан явж одов. Гэрт сэрүүн байсан хоёр түрүүч нэг дэслэгч учрыг нь ололгүй гайхаж байснаа хөхрөлдөв. Тэнэг чинь тамхи татмаар санагдсан юм болов уу ? Тэгээд Анхбаяр түрүүч байхдаа яахав дээ. Тэнэг хог вэ гэж ярилцан инээлдэж хэсэг сууцгаав. 4 цагт манаа халлаа. Сайханбаярыг орж ирээд буу сумаа өгсөний дараа дэслэгч нь чи тамхи татая гэсиймуу гэвэл үгүй гэнэ. Тэгээд тамхиар яах гэсийн гэвэл Анхбаяр түрүүч аваад ир гэсэн гэж нөгөө тэнэг үгээ хэлэв. Ямар тоглоомтой шинэков бэ гэж бодсон дэслэгч май энийг тат гээд нэг янжуур өгвөл би тамхи татдагүй гэв. Дэслэгчийн инээд ч хүрэх шиг, уур хүрэх



шиг болжээ. За яахав шинэ цэрэг юм даа чааваас гэж бодоод орхилоо.

Хоёр хоногийн дараа шөнийн 04 цагийн манаа халсаны дараа хашааны зүүн урд булангийн 3-р цэгт үүрэг гүйцэтгэж байсан нэг цэрэг гэнэт гэрт ороод ирэв. Чи юугаа хийж явнаа. Цэгт байх ёстой юм бишүү гэж дэслэгч нь асуувал Анхбаяр түрүүч гар нүүрийн алчуур аваад ир гэсэн гэж байна. Офицер уурлаж юугаа хуцаад байгаа п...а вэ чи Анхбаяр энэ унтаж байна гэвэл мөнөөх цэрэг илт сандран гэрийн хаалгыг чанга савж хаагаад цааш гүйх нь сонсогдов. Дэслэгч бодов. Энэ юу болоод байнаа. Эртээд Сайханбаяр, одоо энэ. Тэгээд дандаа шөнө цэгээ хаяад худлаа хэлж орж ирлээ. Нэг л биш дээ. Энэ муусайн хулгайчууд цэргүүдийг айлгаж шоглоод байгаа юм биш биз дээ. Тэгвэл ч новш боллоо шүү гэж бодон тайван сууж чадсангүй. Энэ мөчөөс үүр цайтал хоёр түрүүчдээ ч итгэсэнгүй өөрөө манаа халж өглөөний бослого болтол модон хашааг тойрон явж харуулаа шалган алхсаар нар мандахад сунаж унах дөхжээ.

10 цагт ээлж халалцсаны дараа худалч хоёр цэргийг хажуудаа суулгаад тамхиар дайлж яриа хөөрөө болов. Баяндэлгэр рүү нэг түрүүчээ морьтой давхиулж ууттай гөөхий авчруулан өнөө хоёроо дайлан гүйцэтгэх ажлаа эхлэв. Сайханбаяр нь тамхи татсангүй. Харин ууттай гөөхийнөөс горойсон ч үгүй суурин дээрээ дөрвийг цааш нь харуулав. Нөгөө цэрэг нь даргынхаа хайрцаг тамхийг олдсон дээр гэсэн шиг манартал угсруулаад гөхий рүү шилжив. Харин олигтой яриа болсонгүй. Элдэв янз айсан ичсэн юмгүй. Анхбаяр түрүүч л тамхи, алчуур авчир гэсэн. Худлаа яриагүй, өөрөө тэгж хэлчихээд гэрт байсанд нь гайхсан гэж онц сонин юмгүй, ярьсан зүйлээ л тоть шиг давтжээ. Уур нь хүрсэн дэслэгч онцгой юм сонсож чадаагүйдээ бус хамаг тамхийг нь хоосолсонд уур нь хүрэн худалч хоёрыг хөөн гаргаж орчны цэвэрлэгээ хийх ажлаар шийтгэв.

Гурав дөрөв хоног элдэв юм болсонгүй. Ингэж тэгсээр дөрөв хоног өнгөрлөө. 96 цаг нүд анилгүй харуулаа биечлэн удирдсан офицер залуу сунаж унадгийн даваан дээр хэдэн цэргээ тойруулж суулгаад дараах үгийг хэлжээ.

Дэслэгч нь яг нойр хүрээд үхлээ. Би жаахан унтаадхая. Миний цэргүүд үүргээ сайн биелүүлээд байж бай. Эвтэй найртай, болгоомжтой байгаарай гэж үхэх дөхсөн хөгшин үр хүүхэддээ эцсийн үгээ хэлэх мэт хэсэг лекц уншаад унтахаар хэвтээд тэр дороо давсанд явжээ. Мөн хоёр түрүүчдээ тусад нь үүрэг өгч итгэл хүлээлгэхээ мартсангүй. Үхсэн мэт унтаж байсан офицерыг сэртэл гэрт нь сэрүүн амьтан нэг ч байсангүй. Зуухны өмнө гал нэмээд сууж байх ёстой ээлжтэн цэрэг бараа сураг алга. Хоёр түрүүч зүүн хаяагаар тэрий хадсан нь даргынхаа өгсөн үүргийг хэр сайн биелүүлж байгаагийн тод жишээ болов. Уур нь хүрсэн дэслэгч ЭЭЛЖТЭЭН гэж орилбол хэн ч хариулсангүй. Дахиад хоёр гурав хашгирхад хүн хариулах нь байтугай унтаа хэд сэрсэн ч үгүй. Муу совин татсан дарга нь босох гэж өндийтөл гэрийн баруун хатавчинд налуулж тавьсан шуудайтай ногоон дээр нэг цэрэг элгэндээ гараа зөрүүлэн бариад сууж байх нь тэр. Малгай ч байхгүй тэр цэргийг харсан дэслэгч хүүе гэж хэд дуудаад ч нэмэр алга. Мэдрэлгүй мэт хөдөлсөнгүй. Даргаа дуудхад суугаагаараа унтаад сэрдэгүй цэргийг цохиод авахаас өөр яалтай билээ. Өмнөө байсан бакиал гутлыг дүлий годил руу нүүлгэж орхилоо. Үр дүнгий нь харсан дэслэгч залуу нүдэндээ ч итгэсэнгүй. Цэрэг эрийн тах хадсан зузаан ултай хүнд бакиал гутал дүлий цэргийг нэвт цохиод цаана нь байх ханын толгойд өлгөөтэй байсан никель шанагыг дэлсэж унагаах нь тэр.

Гайхсан дэслэгчийн нүд нь бүлтийх үед хаалга нээгдэн ээлжтэн цэрэг өмдөө татсаар орж ирэв. Цэргээ харж бага зэрэг тайвширсан дэслэгч энэ цэрэг гээд баруун хатавч руу заатал тэнд нь шуудай ногооноос өөр бөртийх ч юм байсангүй. Ээлжтэн цэрэг гайхан харна. Энд нэг цэрэг сууж байсан хаачив гэвэл ээлжтэн мэдэхгүй гэлээ. Өөр юу ч хэлэх билээ дээ. Хачин юмаа гэж бодсон дарга нойрондоо дийлдээд хий юм хардгийн байх даа гэж үглээд толгой сэгсрэн нүдээ нухлаж нойроо сэргээлээ. Тэртэй тэргүй нойр нь хульжжээ. Маргааш шөнө нь 04 цагийн манаа халах болж ээлжийг сэрээн хувцасыг нь өмсүүлж зэвсгийг нь өгч үүрэг тавиад асуух зүйл байна уу гэтэл Налайх дүүргээс татагдсан Э гэх малигар шар цэрэг дэслэгчээ би энэ баруун хойд талын 4-р цэгт гармааргүй байна гэв. Яагаад гэтэл өөр хаана ч гарсан яахав. Тэнд л гарахгүй гэв. Уурлаж үзэв. Загнаж үзэв. Гэтэл нүднээсээ том том нулимс унаган уйлж би дахиж тэнд гарахгүй та намайг яавал ч яа гэдэг байна. Арга нь барагдсан дэслэгч өөр нэгнийг сайн дураар нь томилоод Э-г дахиж харуулд гаргасангүй. Хажуудаа суулган миний дүү ахдаа юу болсоноо ярь. Дарга нь чамайг дахиж харуулд гаргахгүй гэж жаал аргадав. Дэслэгчдээ Э дараах зүйлийг ярьжээ. Хэд хоногийн өмнө шөнө 04 цагт манаанд дөнгөж гараад байж байтал Э дээр нэг цэрэг иржээ. Хэн гэдгийг нь таниагүй байна. Ирээд баруун хойд талд байх шонгийн модноос холдолгүй цаг гаран зогсож байгаад манаа халахаар ээлж ирэх чимээнээр алга болсон байсан. Манаа халагчтай таних нэрээр харилцаад эргээд хартал алга байжээ. Хоригдол оргуулчихлаа гэж ихэд айсан боловч хэнд ч хэлээгүй байна. Маргааш өглөө нь ямар ч бужигнаан болсонгүй. Тэгэхээр хоригдол биш байх нь. Манай хэдийн нэг биз гэж бодоод тайвширсан байна. Хоёр хоногийн дараа дахиад шөнө 04 цагийн манаанд дөнгөж гараад байтал буу үүрсэн цэрэг ойртон иржээ. Зогс хэн бэ гэтэл юу ч хэлсэнгүй. Шонгийн модны доор ирээд буугаа үүрсэн чигтээ хөлөө жийгээд суучихжээ. Хамгийн сонин нь тас харанхуй, саргүй шөнө цэрэг хувцас, буу зэрэг нь Э-д тод харагдаж байжээ. Чи хэн бэ, юу хийж яваа юм бэ гэж хичнээн асуугаад ямар ч хариу аваагүй Э уур нь хүрээд хайж байж чулуу олон өнөө цэрэг рүү нүүлгэж орхивол цэргийг нэвглээд шонгийн модонд чулуу тусаж ДОН хэмээсэн дуу гарчээ. Гайхшаа барсан Э өнөө цэрэгт ойртон очиж тонгойн хараад хамаг бие нь арзайн хөшиж орхисон байна. Цэрэг хувцастай тэр юманд погон тэмдэг бүс товч ер нь юу ч алга гэнэ. Хамгийн аймаар нь тэр цэрэг НҮҮРГҮЙ БАЙЖЭЭ. Айж хөшсөн Э арай ядан биеэ хүчилж тэр сүгээс хэдэн алхам ухран холдож чаджээ. Ингээд манаа халах ээлж иртэл хөдөлж чадаагүй бөгөөд үүр хаяархад өнөө сүг алга болсон байгааг сая л анзаарчээ. Манааны ээлжийг ирхэд манаа халагчид илтгэл өгөөгүй бөгөөд нойрмог манаа халагч нь илтгэдэггүй юм уу п...а минь гэж хараасан боловч нэг их тоолгүй өнгөрчээ.

\* \* \*

Энэ яриаг сонссон дэслэгч өөрөө багагүй айсан бөгөөд тэр нэг шөнийн явдлыг нэхэн санахнээ шуудай дээр сууж байсан цэрэг НҮҮРГҮЙ байсныг сая л ойлгожээ. Учир нь нойрмог дэслэгчид харагдсан мөнөөх цэрэгт нэг л юм дутуу байгааг өчүүхэн төдий анзаарсан ч байраа орхисон ээлжтэнтэйгээ албаны хэрүүл хийгээд нухацтай хандалгүй орхисон байжээ. Дахиж Э-г харуулд гаргасангүй. Байнгын невалд суулгаж байгаад ногоо хураалт дуусгажээ. Ажил дуусаж хоригдлуудыг хорих анги руу ачих машинууд ирлээ. Цэргүүд гэрээ буулган ачиж байхуйд Баяндэлгэрийн төвөөс морин тэрэгтэй хүн айсуй. Ойртон ирвэл хүрэн дээлтэй өвгөн байх аж. Хорих ангийн аж ахуйн даргатай уулзан морин тэргэндээ хэдэн шуудай ногоо ачив. Ажлаа дууссан хэдэн цэрэг зөөж ачиж өгөв. Мань өвгөн дэслэгчтэй

тамхилангаа одооны цэрэг сайхан болжээ гэх зэргээр ярьж байснаа танай үүгээр шөнө оройд гайгүй л байна уу хүүхээд гэв.

Энэ үгнээс санаа авсан дэслэгч

-Өвгөн гуай та юу гэвээ ? Манай цэргүүд нэг хачин юм яриад байх юм ямар учиртай юм боловоо ? гэхэд өвгөн хэлсэн нь :

Орос цэргүүд явсан жил энэ Шунхлай бригад нэг хэсэг эзэнгүйдээд удалгүй сумаас хүмүүс очиж хашаа хороог нь сэлбэж, байшинг цэвэрлэсэн юм. Урт цагаан байшингийн доторхи хогийг цэвэрлэж байхдаа мухрын өрөөний шаланд зоорьны нүх байхыг олжээ. Шалтай нь хадсан тагыг салгаж доош орсонд тас харанхуй байж. Гэрэл тусган ороод бөөн хог новш олсон ба дороос нь орос цэргийн хувцастай хатаж хорчийсон хүүр гарсан байна. Цагдаа ирж бүртгэж л байсан. Тэгээд яасан нь бүү мэд. Түүнээс хойш энэ хавиар юу нь мэдэгдэхгүй юм үзэгдээд байдаг болсон юм гэвээ.

Хүний төрлийг олж төрөх нь...

Энэ группт Нямка Нарсайны нийтэлснийг уншаад нэгэн домог санаанд оров. Мөн нийтлэлд оруулсан зургийг нь татаж энд оруулсан болно.

Энэхэн ШАГШААБАДАд шар чөтгөрийн биеийг олон төрнө гэдэг ховорхон олдох заяа юм гэдэг. ШАГШААБАД гэдэг нь мөнөөхөн энэ замбуулин хорвоо бөгөөд бурханы номонд ШАГШААБАД хэмээмүй. Шар чөтгөр хэмээгч нь ариун сайхан ШАГШААБАДАд мөн биеийг олж төрсөн байтлаа нүгэл бүхнийг арвитан үйлдэгч хүмүүн бээр өөрөө бүлгээ. Хүмүүний биеийг олж төрөх нь зүүний үзүүрт ширхэг будаа тогтохын дайны олдохуйяа бэрх чухам ховор нандин буян заяа юм гэдэг.

Хүн хэмээх нүгэлтэн биеийг барж насан хутгийг үзүүлэн энэ насны сайн муу үйлээ дэнслүүлхээр ЭРЛЭГ НОМУН ХААН лугаа нэгэнт учирч арван хар нүгэл хийгээд арвин их буян хурааснаа шүүлгэх болой. Энэ насандаа үйлдсэн нүглийн их бага олон цөөнийг ЭРЛЭГ НОМУН ХААН үнэн зөвөөр шүүн ялгах агаад одоо манай нийгэмд байх авилга хийгээд ар өврийн хаалга, танил тал гэх юм нөгөө ертөнцийн мөнхүү саванд үзэгдэх бүү хэл дуулдах ч үгүй, хүнд хөнгөнд нь таарсан шийтгэлийг хүн бүрт алагчлалгүй оноох бүлгээ. Хэрэвзээ тамд унаж тарчлах заяатай ахул АРЪЯАБАЛЫН АРВАН НАЙМАН ТАМД унаган гэсгээн шийтгэх агаад энэ нь халуун галд шатах, улайсгасан төмрөөр хайрах, халуун шороор шорлох, хэл ба бусад эдийг тайрах, хүйтэн там зэрэг үзэх нь байтугай сонсохоос ч хирдхийм аюумшигт тарчлааныг биеэр эдлүүлэн ЭРЛЭГийн заасан шийтгэлийн тоог заавал гүйцээлгэх нигууртай гэнэ.

Ийнхүү зовсоор сая нэг шийтгэл нь дуусвал ЭРЛЭГ НОМУН ХААН аас дараагийн төрөлдөө чухам халуун цөлд хонин гүрвэл болж төрөх ба Хандмаа хүүхний хэвлийд хүмүүн заяаг олохын аль нэгийг нь зааж зурах учиртай болой.

Харин нүглийг тэвчин буян үйлдэж эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд энэ насаа харамгүй зориулсан бол айх аюулгүй бөгөөд ЭРЛЭГ НОМУН ХААН шүүж үзээд

ДИВААЖИНд морилуулж хүмүүн төрөлд буцаан төрүүлэх нигууртай байдаг байна. ЭРЛЭГ НОМУН ХААН хүмүүн заяанд төрөх болсон буянтан хийгээд нүглийн үйлнээ тарчлан зовсоны эцэст шийтгэл нь дууссан болон орчлонгийн олон амьтанд хувиран төрсний эцэст хүмүүн төрлийг олохоор заагдсан хэнбугайд ч энэ замбуулинд байх хүнээс эхлээд хөлхөн мөлхөгч, архиран хүрхрэгч араатан амьтан, жигүүртэн шувууд гээд бүх л амьтаны арьсийг үзүүлэн алийг нь авмаар байна гэж асуух ажээ. Хүн гэгч хэдий буянтан байвч ад мөрийн шуналтай тул ан амьтан араатан жигүүртэн болж төрөх хүслээ хэлэх буюу. Яагаад гэвэл тэр олон амьтаны арьс үснээс хамгийн үзэшгүй муухай харагдах нь гагцхүү хүмүүний арьс байдаг гэнэ. Өр бусад ан амьтан, араатан жигүүртний арьс үс нь алаг эрээн өнгө зүстэй байх бөгөөд түүнийг харсан хүн ийм сайхан арьс үстэй болж төрөхсөн гэж ихэд хүсэмжлэх авай. ЭРЛЭГ НОМУН ХААН чи бол хүний орчлонд тэр гэх эмэгтэйн хэвлийд хүний биеийг олох заяатай болой гэж зарлиг лүндэн буулгаад хонгон дээр нь алгадан илгээдэг гэнэм. ЭРЛЭГ НОМУН ХААН хүний хонгон дээр алгадан илгээсэн учраас МОНГОЛ хүний хонгон дээр алгадсаны мөр болох хөх толбо гардаг гэх домог байдаг билээ хэмээн энэхүү нийтлэлийг уншигч хүмүүнд ТАЙЖ овгийн НАМБАРЫН хүү ӨЛЗИЙБАЯР би бээр чадан ядан сийрүүлэн хүргэвэй.

Мичидмаа Н.-гийн нийтэлсэн Тарлангийн гэрэл гэсэн нийтлэлийг уншаад цэрэгт байхад болсон явдал санаанд оров.

### **Мэнэнгийн тал дахь гэрэл**

1990-ээд оны эхээр шинэ татагдсан бидний хэдэн цэрэг Дорнотын Халх голоос 8-р сарын сүүлчээр идэшний мал тууж байв. Ид халуунд мал тууна гэдэг ёстой тамын ажил билээ. Өдрийн халууныг майхан сүүдрэвч бариад унтаж, идэж өнгөрөөнө. Оройн сэрүү орохтой зэрэг үндсэн ажилдаа ордог байв. Биднийг хариуцан явсан ахлагч сав л хийвэл ууж согтуурхана. Тууврын хэсгийн дарга дэд хурандаа 69 машинтай түрүүлж давхин төв бараадан хүлээж хэвтэх зуур согтуу ахлагч дураараа дургин дунд чөмгөөрөө нааддаг байлаа. Нэг сайхан нь шинэ цэрэг биднийг элдэв янзаар дэглээд байхгүй мөрөөрөө гудардаг амгалан амьтан байв. 20-оод хоног тууж явсаар согтуу даргын балгаар замаасаа төөрч их тал руу орчихсон нь алдарт Мэнэн байжээ. Баруун зүгт Нийслэл хүрээ байх нь тодорхой тул наран шингэх зүг рүү нэлээд хоног намирав. Тал гэдэг зах нь харагдахгүй уудам, айл амьтан таарах нь нүдний гэм. Ойрын хэдэн шөнөөс машины гэрэл харагддаг болов. Бид хэд баярлан ядахдаа тамхи олдох болов уу гэж угтаж давхиад тусыг эс олов. Дөрвөн шөнө араасаа машин дагаастай. Холддог ч үгүй, ойртдог ч үгүй. Километр хэртээ л дагаж байдаг нэг дагуултай болов. Нэг бол далд орно. Удалгүй гараад ирнэ. Гуу жалга, хонхор газраар давхиж ороод гараад ирж байна уу гэлтэй харагдана. Заримдаа бидний хажуугаар явах юм шиг жишиж давхина. Нэг хачин нь машины моторын дуу үл сонсогдоно. Сүүлдээ биднийг тойрон гараад урд орж давхидаг болов. Доогтой нь нэг урд, нэг хойно, нэг хажууд гарч гайхаш барна. Бүүр хачин нь энэ машин хойно урд хажууд гарсан ч, зэрэгцэж явахдаа ч машины хоёр их гэрэл нь бидэн рүү чанх чиглэн харсаар явах ажээ. Ийм юм гэж байх уу ? Хөндлөнгөөрөө явдаг машин гэж байдаг л юм байх даа. Тэр ч яахав байж болно гэж бодоход бидний урд гархаараа мөн л их гэрлээ бидэн рүү харуулан сурамгай гэгч нь ухарч давхиад байв. Энэ ч арай дэндлээ шүү. Долоо хоног энэ талаар маргалдсан бидний шинэковууд уг машин бол жинхэнэ машин биш юмаа. Энэ бол хий бие, эсвэл байгалийн сонин үзэгдэл байна гэж санал нэгтэй тогтов.

Согтуу даргадаа хэлсэнд тоглоомтой новшыг буудчихгүй юу гэв. Бид яахав гэж ярилцаад залуу насны хөөрүү дэвэргэн зангаар буудаад үзэе гэж шийдэв. Харин Төв аймгийн нэг онжав минь дэмий юм бишүү дээ гэж дуугарав. Ганц хүний саналыг тоосон ч үгүй. Шөнө болов. Малаа тууж явтал өнөө машин удалгүй гараад ирлээ. Бид л машин гээд байгаа болохоос угтаа юу нь үл мэдэгдэх хос гэрэл юм л даа. За яахав буудах уу гэж ярилцаад тэгье гэж дахин шийдээд Сэлэнгийн Мөнхбат бидэн дундаа ганц байсан СКС буугаа 7,62 мм-н автоматын 5 сумаар сумлав. Тэр л буудах гэж бусдаасаа илүү хүсэмжилж байсан билээ. Би дуугүй байсангүй. Буудвал нэг мөсөн буудаарай. Хоёр гэрлийн яг дунд нь гэв. Мөнхбат хариу хэлсэнгүй суугаа байдлаас хараалж байна. Удалгүй тас буугаад л явчихлаа. Яасан гэвэл яааг оносон гэхэд нь бид инээлдэв. Хачирхалтай нь гэрэл унтардагүй шүү. Зүй нь даруй зогсоод кабинаас нь айж гайхсан хүмүүс буун харайж аллаа хядлаа гэж орилон аврал эрэх ёстой л доо. Гэвч юу гэж тэгхэв дээ. Гэрэл бахь байдгаараа ёлтойгоод байв. Говь-Алтайн нэг цэрэг өө оносонгүй би буудая гээд бууг гартаа авав. Сумтай шүү гэж амжиж хэлэхээс өмнө пан хийгээд явчихлаа. Хажууд байсан нэг нөхөр тэрий хадан унаад ёолон орилж сүйд болов. Хэн ч хөдөлж чаддагүй. ЧИ ХҮН АЛЧИХЛАА ШДЭЭ. Яасан муухай орилвоо. Бүгд айв. Унасан нөхөр дээрээ овоорон яваа хаана чинь өвдөж байна гэж зөөлхөн асуувал ёолж байснаа БИ ЗҮГЭЭРЭЭ гэдгийг байна. Үхэтлээ айсан бид нар тэгээд яагаад орилов. Хүн айлгаад хаячихлаа гэж тал талаас нь хэлсэн ч амьд байгаад нь бүгд баярлав. Буугаа газар зөөлхөн тавиад дуу ч гарахгүй хөшиж орхисон Говь-Алтайн цэрэг миний найз амьд байна, амьд байна гэж дахин дахин хэлж тэвэрч аваад хамгийн ихээр баярлав. Биеийг нь тэмтэрч үзэн чи ёолоод байсан зүгээр үү гэж байн байн асуув. Мөнөөх цэрэг үсэрсэн хонгионд оногдсыймаа гэхэд нь бид хэд үхэтлээ инээлдэв. Буудсан цэрэг хамгийн ихээр инээсэн ба мөн өөрөө алуурчин болоогүйдээ баярлан уйлав. Би хэлэв. Энэ бол дохио шүү. Дахиж буудаад хэрэггүй байх гэвэл сум алдсан Алтайн цэргээс бусад нь за юун сүртэй юм. Дахиж алдахгүй л байвал болоо юм бишүү гээд намайг шоолон хөхрөлдөв. Харин Алтайн цэрэг одоо дэмий байхаа больё гэсэнд бас тоосонгүй гоожуур гэж хочлов. Хонгионы бай болсон нөхөр саваагүйрхэн одоо би буудна гээд бууг авах гэхэд би гарнаас нь зуураад хоолойд нь сум байгаа шүү гэхэд мэднээ гэж хэнэггүй дуугарсан нь айдас нь арилсаныг илтгэнэ. Одоо буунд гурван сум байгаа гэж би бодов. Би аргаа барж бүгдээрээ холдоцгооё гэвэл харин намайг даган хэдэн алхам ухарцгаав. Гурав дараалан буун дуу гарлаа. Хэн ч бэртсэнгүй. Мөн буудуулсан гэрэл унтарсангүй. Бид хэсэг харж зогсоод хий юм гэдэгт зуун хувь итгээд малаа туун аянаа үргэлжлүүлэн явсаар нар мандав.

Маргааш шөнөөс нь л жинхэнэ юм эхэлсэн дээ. Урьд нь зүгээр туугдаад байсан үхэр сүрэг тарж бутран оодогнох болов. Харанхуй шөнөөр шүү дээ. Хоньний суурь хуйларч майлалдаад тогтохоо байлаа. Бөөгнүүлэх гэж шөнөжингөө үйл тамаа барав. Өглөө болж нар мандахад үхэр мал зүв зүгээр. Бид хэд жодгороо босгож аваад үхсэн мэт тэрий хадав. Нам унтжээ. Оройхон хэрд татуулж чангаалгуулан увж цувсаар босвол тууж явсан идэшний мал хуйгаараа алга. Сандарч эхлэв. Тал тал тийшээ санд мэнд давхилдхад ашгүй холгүй нэгэн хонхорт ихэнх нь байж байв. Мунгинасаар байтал оройн сэрүү орлоо. Туувар эхлэв. Шөнө дунд үхэрнүүд урагшаа гишгэхээ болив. Арав гаран үхэр өөөдөөд босдогүй. Гэрэл гаргаад үзэхэд дандаа туруу нь мултарч унажээ. Айхдаа согтуу толгойтод илтгэвэл олон таван үггүй нядал гэв. Хэлснээр нь нядалж орхив. Тэр шөнө ийнхүү өнгөрөв. Дараа хэдэн шөнө ашгүй үйлээ үзсэнгүй явсаар ганц айлын бараа хараад бөөн баяр болов. Цөөн тооны малтай өвгөн эмгэн хоёр байв. Хоол цайгаар дайлуулж тараг ууж цадсан бид мөн л гэрийн сүүдэр жодгорын

хаяагаар өрөөлдөн унацгаав. Согтуу толгой өвгөнийг шордож байгаад шимийн юмыг нь гаргуулсан болтой хоёулаа дуу нь өндөрсөн яриа дэлгээд сүйд. Бид хэд ч яаж дутхав өвгөний тамхийг баагиулах шиг болов. Нэг мэдсэн орой болжээ. Ахлагч хөдлөх янз алга. Өвгөнд хэллээ дээ. Тууврын паянгаа нэг бүрчлэн ярилаа. Харин өвгөн юмны учир мэдэх хашир догь хүн байв. Өвгөний хэлсэн нь :

Энд ийм хий гэрэл байдаг бөгөөд Халх голын дайнд төөрч бөмбөгдүүлсэн орос цэргийн дарга машинтайгаа явдаг юм гэнэ лээ. Оролдохгүй бол гэмгүй ээ хүүхээд гэв. Анх буудаад дэмий гэж анхааруулсан Төв аймгийн цэрэг бид хоёр өвгөн эмгэн хоёрын заавраар шөнө хий гэрэлд идээ цагаа өргөн уучлал гуйж гэм нүглээ нөхдийнхөө өмнөөс наминчлав. Манай хэд тоосон ч үгүй. Гэхдээ бас шоолсонгүй ээ. Ингэж хөглөж явсаар туувраа дуусгаж билээ бид.

### **Тэрэлжийн амралтын толгойгүй сүнс**

Энэ бяцхан түүхийн манай ажлын Б надад ярьсан билээ.

Хоёр жилийн өмнө зун цагаар Б гэр бүлтэйгээ мөн найзуудтайгаа Тэрэлжийн гэр амралтанд очжээ. Байгаль сайхантай Тэрэлжид үзэж харах байгалийн тогтоц, уул ус, ургамал гээд хүний сэтгэл сэргэх бүх юм бий. Тэхдээ л хүний орчлон юм хойно сайхан бүхний хажуугаар муухай юм бас л бага сага байх ажээ.

Тэрэлжийн гүүр гараад замынхаа зүүн талд хэдэн гэрүүд байх нь хэн хүний нүдэнд ил. Зуны цагт амарч зугаалхаар оройхон гарсан хүмүүст сайхан байгальд тохьтой л бол улам цаашаа газрын мухар зүглэх ямар шаардлага байх билээ. Тэрүүхэн тэндээ сондгой маягийн хэдэн гэрт очицгоовол гэр амралт байв. Долоон гэр байх бөгөөд зүүн урд талдаа жаахан зайтай барьсан ганц гэрээс бусдад нь инээд хөөр дуу хуур хангинаж байж. Хоёр айлын хэдэн хүнд ганц гэр хаваасаг тулд үнэ мөнгийг нь төлөөд уг гэрт буудаллав. Амралтын хоол цай ч бэлэн зэлэн байж. Гэрийн гадаа зүлгэн дээр хүүхэд багачууд тоглож ойрхон урсах голд том багагүй хөгжилдөцгөөжээ. Мөн томчууд аяны болон амралтын юмаа задлахаа мартсангүй. Энд зураг тэнд ч зураг. Орой болсон ч найр наадам дууссангүй. Тохьтой гэрийн буйдан дээр олуулаа суугаад пагиараа татуулжээ.

Маргааш өглөө нь бүгдээрээ цайлцгааж хүүхэд шуухад тоглож наадан эцэг эхчүүд энэ долоо хоногийн амралтаа үр бүтээлтэй өнгөрөөхөө яаж мартаж билээ. Оройхон хэрд амралт өндөрлөж явахын өмнө дахин зургаа авхуулцгааж зургыг үзээд нүд нь орой дээрээ гарчээ. Олуулаа гарсан зурган дунд ягаан цамцтай жинсэн өмдтэй ТОЛГОЙГҮЙ ХҮН байх нь тэр. Бүгд их л тавгүй болж хам хум юмаа цэгцлэн гэрээс гарцгаажээ. Амралтын зохион байгуулагч аятай эмэгтэйг дуудвал иржээ. Тэд аймшигт зургийг үзүүлэн юу болохыг нь асуувал гайхсан шинжгүй ч мэдэхгүй гэдэг хариулт авчээ. Амрагчид байдлыг гадарлан муу ёртой газраа хүнд сануулалгүй хонуулж өнжүүлсэнд дургүйлхэн таатай бус байгаагаа хэлээд дуу шуугүй явцгаалаа. Тэрэлжийн амнаас гарах гэж явтал үхэр тууж явсан залууг таньсан Б зогсож мэнд мэдлээ. Салхинд гараад буцаж явна. Новшийн газар хоножээ бид гэвэл найз нь хаана хонов гэхэд нь гүүрний зүүн талын гэв. Найз нь тэнд яах гэж очив доо. Мэдэлгүй л хонож дээ. Эндхийнхэн бүгд мэднэ. Тэр амралт дээр оюутан охин усанд живээд өнгөрсөн газар. Тэрнээс хойш хий юм харагдаад байдаг болсон доо гэжээ.

Хэд хоногийн өмнө би Цамцнаас татдаг хий юм гэдэг нийтлэлийг энэ группт оруулсан билээ. Энэ удаад дээрхи нийтлэлтэй холбоотой өөр нэг нийтлэл оруулж байна. Дашрамд дурдахад миний нийтлэлд гарч байгаа үйл явдал нь зохиомж хийгээд өгүүллэг биш, дандаа үнэн бодит болсон явдал билээ.

### **Хар цамцтай ах**

Ням гаригийн өглөө ажилдаа ирэхэд хамт ажилладаг Э бүсгүй 7,8 орчим насны охин дагуулан ирсэн байв. Манайх ажил дээрээ хүүхэд дагуулж ирэх нь дотоод журамд хориотой байдаг тул би жаахан дурамжхан байлаа. Миний байдлыг гадарласан Э эгчийн минь хүүхэд юмаа. Өнөөдөр харах хүн байдаггүй. Аргаа бараад дагуулаад ирлээ. Өдрийн ээлжинд гарч орой буух тул хамт байж болох уу гэж зөвшөөрөл хүсэв. Эзэнгүй хүүхдийг буцаагаад хөөлтэй биш, тэгээд өвлийн хүйтэнд шүү. Амралтын өдөр объектын ажилтнууд ирэхгүй учир за одоо тэг дээ л гэлээ. Ажлын өдөр ингэсэн бол ч хэл ам гарч бөөн асуудал үүснэ шүү дээ. Э дүүгээ дагуулан ажлын байр руугаа явлаа. Энэ өдөр ямар нэгэн хэл амгүй өнгөрч орой Э дүүгээ дагуулан ээлжнээсээ бууж явлаа. Хоёр хоногийн дараа оройн ээлжинд дотор постоо шалгахаар очвол ажлаа шалгуулсан Б бүсгүй бие засах өрөөнд хамт оръё гэнэ. За ямар хүүхэд биш гэвэл айгаад байнаа гээд байх юм. За битгий маяглаад бай гэсэн чинь өнөөх чинь сүүлийн үед бүр өдрөөр харагддаг боллоо. Өдрөөр харагдаад байгаа юм чинь шөнөөр яах ч юм билээ гэнэ. Дотор постонд дандаа эмэгтэйчүүд ажилладаг учир би тэднийг айж ичихээс сэргийлж өөрийн ажигласан зүйлээ ярьдаггүй билээ. Тэглээ ч тэд нар энэ тухай тодорхой мэддэг юм л даа.

Юун өдрөөр харагдах вэ ? Юугаа донгосоод байнаа гэвэл нээрээ нээрээ Э-гийн дүүд харагдсан гэсэн гэв. Э-гийн дүүг ажил руу нэвтрүүлсэнийг бас мэдээдэхжээ. Бас нэг хэл ам болох нь дээ. Эмэгтэйчүүд ч хэл ам гаргахдаа гаргуун шүү дээ.

### **Тэгээд Б дараах зүйлийг ярив.**

Жижүүрийн өрөөнд Э болон түүний дүү, жижүүр авгай гурав байж. Жижүүрийн ширээн дээр гэрийн даалгавараа хийж суусан Э-гийн дүү гэнэт эгчээ тэнд хар цамцтай ах над руу хараад байна гэжээ. Корпусын байранд амралтын өдрөөр тэр гурваас өөр амьд амьтан гэвэл энд тэндхийн булан тохойгоор торжигнон гүйдэх хулганаас өөр юм байхгүй гэдгийг сайн мэдэх жижүүр, Э хоёр маш их гайхан хаана гээд нэг нь цаг бүртгэгчийн цонхоор, нэг нь өрөөнөөс гарч коридор ба шат, үүдний хонгилийг харсан боловч тэнд нь хэн ч байсангүй. Тэр хоёр нэг л тавгүй болж теле камерийн бичлэгийг шүүж үзэхээр болов. Харсан гэх хүүхдээс тэр хүн яг хаана зогсож байсныг тодруулан асууж нягтлахад тэр газар нь теле камерт тод харагдаж байсан байна. Дүүгийнх нь хэлсэн цагаас урагш 10-20 минутийн, хойш 10 минутийн бичлэгийг шүүж үзэхэд хүн бүү хэл хулгана ч байсангүй. Э дүүгээсээ яг юу харсаныг дахин асуувал хар цамцтай өндөр ах над руу хараад байсан гэсэн байна. Э юмыг яаж мэдхэв гэж болгоомжлон гадагшаа гарч корпусын гадна талын цонхнууд болон аврах гарц хаалгыг шалгаад хүн амьтан орчихмоор онгорхой цоорхойг олсонгүй гэнэ.

Танд энэ тухай яриагүй юу гэж Б надаас асуулаа. Үнэндээ надад Э ямар нэг юм хэлэлгүй ажлаасаа бууж явсан билээ. За ингээд өнөөхийн тухай яриа нэгээр нэмэгдэх нь тэр шүү дээ.

## Ийм л нэг юм болсон доо.

Аав маань залуу байхдаа тээвэрт явдаг байж.1950 оны дундуур ойрхон өдөртөө очидог газар ачаагаа ачаад өглөө эрт баазаасаа хөдөлж.Зуны дэлгэр цагч байж .Замдаа цайлаад машиныхаа бүрэн бүтэн байдлыг шалгачихаад цааш хөдөлтөл шуудайтай зүйл байх юм гэнэ.Бууж очоод нээж үзтэл торго,цай,чихэр,боов гээд л зөндөө бараа байхаар нь урьд явж байгаа хэн нэг нь гээсэн боловуу гээд ачаан дээрээ сайн бөхлөөд явжээ.Тэгээд л замдаа баазынхаа нилээд ахмад жолоочтой таараад тамхилангаа замд гээгдсэн зүйлийг хэлтэл за хө чи буулгаад тээр хол аваачаад тавь наадах чинь дутуу төрсөн хүүхдээ ингэж тавьдаг ёстой гэхэд аав маань дотор харанхуйлаад хөлс дааварлаад ай мөн хэцүү юм болсон шүү гэж ярьж байж билээ.

Сайн байна уу та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье.!

Яг л тэр зөн билэгтэн шиг

Би өөрт тохиолдсон нэг сонин ч гэмээр гайхалтай ч гэмээр зүйлийг та бүгдтэй хуваалцхаар шийдлээ.

Манай өвөө нас бараад олон жил өнгөрч байна.

12 сарын 7 нд ээж маань өвөөг зүүдэлсэн гээд бид нар газар дээр нь очмоор байв ч очиж чадахгүй байлаа.Учир нь хаана нутаглуулсныг нь мэдэх хүн байгаагүй.Тэгээд хамаатнууд маань бүгд цуглаад сайн гэх бөө төй цуг 70 давхарт үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл хайсан боловч олдоогүй юм.

Сүүлдээ тэр бөө ч шал худлаа нтр гээд манайхан уурласан би өөрөө шүтлэггүй хүн болхоор нэг их тоогоочгүй.

Тэгээд бид нар гэр гэртээ харьцгаалаа би ч гэртээ ирж хоол ундаа идчихээд унтсын.Тэр шөнөдөө нэг хүүхэн миний зүүдэнд над руу хараал инээгээд намайг хамт явья гээл байсан. Би ч муухай зүүд зүүдлэлээ гэж бодоол тоогоогүйн.Тэгээд бүр өдөр болгон шөнө болгон зүүдлээд сүүлдээ нөгөө хүүхэн чинь нэг жоохон охин хөтөлцөн чиний охин гээд л байсан.Тэгээд би 12 сарын 16 билүү 17 нд ээж дээрээ очоод хэлсэн чинь лам дээр очье ном уншуулы гандан орно гээд хамт явсын.Тэгээд лам дээр ч очлоо тэгсэн нөгөө хүн маань худлаа хүн байж мэднэ гэж бодоод ээждээ миний зүүдний талаар битгий хэл зүгээр юу гэхыг нь сонсоё гэв. Нөгөө лам дээр ороол намайг үзэх боловоо.Тэгснээ намайг найз охиноосоо сал та 2 бүтэхгүй нтр надад найз охин ч байхгүй байхад шүү.За бүткүн байна шэж бодоод ээжтэй гараад нилээн хэдэн үзмэр ч бөө дээр ч очлоо тэгээл ном унших нь уншиж зодох нь зодоол барцад хөөнө гээл.Тэгээд л гайгүй байх гээд гэртээ ирчээд унтсын шөнө зүүдэнд маань нөгөө хүүхэн чинь байхгүй охин нь ааваа ааваа гээл намайг бүр хөөжын уул нь зүгээр л байдаг жоохон охин шиг.Тэгсэн мөртлөө л би айгаад зугтаал байсан.Тэгээл өглөө нь ээжид яахуу нтр гээл ярьж бгад ажил руугаа явсан.Ажлынхаа газар ирчээд цайны цаг болхоор нь тамхилдынмуу гээд хамт гарах хүн байна уу гэсэн манай ажлын залуу хамт гары гээд.Тэгээд тамхилж байх даа бүх юмаа хэллээ.

Тэгсэн нөгөө залуу чи манай найзтай уулзаад үз гэсын



Тэгээд орой ажилаа тараад нөгөө найзтай уулзхаар явлаа тэгсэн 12 -р ангийн бацаан байнаа. Гэхдээ аймар эвгүй хүзүүндээ аймар том соривтой цав цагаан цонхийсон царайтай цус багадалттай юм шиг. Тэгээд тэр гарных нь шивээс их сонин би өөрөө их шивээс сонирхдог хүн тийм тэмдэг нтр амьдралдаа харж сонсож байгаагүй. Хамгийн их нүдэнд туссан зүйл гэвэл хүзүүны зүүлт бөгж нь

Хүзүүны зүүлт нь бөөрөнхий дотор таван хошуу шиг юм

Бөгж нь авс за энэ ч яахав яриад байвал миний харсан юм дуусахгүй.

Бид нар гэр лүү нь явсын тэгсэн нөгөө хүү гэнэт л намайг ард суучих гэсын тэгээд найздаа жолоогоо өгчөөд суугаад явжыв нэг хэсэг дуугүй явж байснаа миний талаар яриад эхлэвээ ажил төрөл нас нтр гээл

Тэгж байснаа нөгөө зүүдийг маань ярьлаа би ч аймар гайхаал .Тэгээд гэрт нь ч ирэв цаа чинь орж ирээд бид 2т цай аягалж өгөөд нөгөө өрөөрүүгээ орчоод нилээн удсаны дараа гарж ирлээ гарж ирэхдээ хар өнгийн лаа барьцан.Тэгээд бас нэг шилэн том хоолны тавганд дүүрэн ус хийгээд аваад ирсын.Харанхуй ч болж байсан болхоор тэр хүү бүх гэрлийг унтраагаад харанхуйд хэсэг дуугүй сууж байснаа нөгөө лаагаа асуугаад урдаа тавиад над руу харлаа би чинь сүнс зайлах ньээ бүр аймар айдастай шар үс босоол гар хөл салагнаад.Тэгснээ гараа өг гэхээр нь гараа өгсөн чинь шууд зүүгээр хурууны өндөг хатгаад авдаг байгаа п\*цда чинь гэж бодоол дуугуй суусан Тэр хүү: миний цусыг шилтэй усанд хийсын

- Намайг хараагаад хэрэггүй. Чамайг сүнс дагаад байна.Эмэгтэй хүн

Би- Дуугуй шоконд ороол сонсоол байж байгаад нөгөө охин тэгээд юу юм бол гэсэн бодолтой харсан чинь

Тэр хүү- Тэр охиныг тоох хэрэггүй зүгээр ( Сэнтосиа ч билүү сэнтоси ч гэлүү нэг юм хэлсын)

Тэр нь зүгээр надад хүчээр үзүүлдэг юм юм байх

Би- Надаар яах гээд байгаан бол би яахуу ?

Тэр хүү- Чамайг сонирхоод байна.Ганцаардал! Гашуудал! Зовлон !

Тэр эмэгтэй үхсэн хэдий ч мэдэрж байна.Тэрэнд үүнийг бага болов ч нэмэглэх хүн хэрэгтэй чамайг л гэж бодож байгаа бололтой.

Тэгээз тэр хүү хар лаагаа устай шилэн хоолны тавганд хийгээд сайн хараад бай гэсэн би ч харлаа үнэхээр сонин мэдрэмж өөрийн эрхгүй нулимс гараал явцан.Намайг үргэлжлүүлээд хараад бай л гэлээ тэр хүү ч нэг сонин үг хэлсэн хаанахаар ч юм тэгээд л лаагаа унтраагаад тэр лааг надад өгөөд өнөөдөр дэрлэж унт чамд сүүлийн удаа зүүдлэгдэнэ.! гэсэн

Тэгээл би гараал явжаагаал найзаасаа асуугаал аймар сонин санагдаал ёстой л лаг авьяастай хүү байна нтр гэсэн чинь.Манай найз наад хүү чинь өөрөө авьяас гэдэггүй юмаа зүгээр л

гутамшиг зовлон гэдийн.Тэгэжл би бүр аймар гайхширцан.Гэртээ орж ирээл аймар нойр хүрээд шууд орлуугаа шургалаа нөгөө лаг нь ч дэрэн доороо хийлээ тэгээд тэр шөнөдөө үнэхээр зүүдэлсэн гэхдээ тэр хүүхэн намайг хараал байсан би ч өөдөөс нь хараао байсан тэгээл сэрсэ өглөө болсон.Тэгээд тэр өдрөөс хойш ёстой л дахиж зүүдлээгүй яагаачгүй.

Тэр хүү яаж ингэсэн юм бол гэж найзаасөө байн2 асууна харин хариуд хэлж байгаа үг нь хүнтэй битгий холбож өгөөрөй

Чамайг манай найз гэсэн болхоор л тэр чамд тусалсын хариуд нь зүгээр март л гэсэн дээ. Тэгж л би гэдэг хүн намайг яах гэж дагсан нтрыг ойлголгүы зүгээр болсон доо

Жич: тэр хүүгийн талаарх мэдээлэл өгөхгүйг анхаарна уу.

### **Зүүнхараад нэгэн удаа**

2002 онд шиг санагдаад байх юм. Зүүнхараад нэгэн албан газрын аж ахуйн гэж хэлж болохоор хашааны сахиул эмгэн охин хүргэн хоёртойгоо амьдардаг байв. Хүргэнийг нь Б гэнэ. Хүргэн нь хааяадаа нэг халамцуу харагдах бөгөөд агсан согтуу тавьж элдэв бус болж харагддаггүй байлаа. Манайх тэдний өөдөөс харсан хашаанд байшин барьж байсан юм. Би хоёр нөхрийн хамт палкан торхны дээр тааз тавьж байхад энэ явдал болсон юм. Үдээс хойш 3-ын банзаа тааз руу гаргаж байтал сахиул эмгэн өргөст торон хашаан дотроо тусламж гуйн орилж хаалга руугаа чадах тэнхээгээрээ гүйж байв. Таазан дээр зогсож байсан би эмээ яасан бэ гэж хашгирвал манай хүүхэд үхэх гээд байна наашаа яваарай гэж орилов. Таазан дээрээс хоёулаа үсрэн буугаад доор байсан нэгийгээ дуудан гурвуулаа гүйж сийрэг татсан өргөст торыг татаж ороод явдал дундаа хаана байна гэж хашгирвал эмээ өндөр цамхагтай бункерийн зүг уйлан заалаа. Гүйсээр бункерт орлоо. Тэнд нэг хүн шатны төмөр хашлаганаас дүүжлэгдэн байх бөгөөд хөлийг нь тэврээд орилж чарлах хүүхэн бас байв. Хөлийг нь тэврэхдээ ташаагаар нь нугалаад Г хэлбэртэй болгочихсон байлаа. Эхнэр нь байв. Юу болсон нь тодорхой. Амиа хорложээ хөөрхий. Гүйж очингуут удсан уу гэж асуутал эхнэр нь мэдэхгүй ээ гэнэ. Санаачээ гэж орилтол 20-оод минут болсон байхаа гэлээ. Одоо би нэгэнт ирсэнийх үзээд алдах хэрэгтэй гэдгээ л мэдэж байв. Хамт очсон хоёроо тэврээд өргөж бай гэсэн чинь айгаад ойртдоггүй шүү. Наадах чинь үхээгүй п...а минь хурдал гээд Буянхишигийг шанаадаад авсан чинь хоёулаа чичирсээр байж муухан тэвэрч байна. Шатаар өгсөж гүйж дүүжлүүрийг нь тайлах гэтэл өмдний тэлээ болох өргөн хар арьс тайлагдсангүй чивчирчээ. Морозовын Отгонбаатар, Буянхишиг хоёр айж гайхан нүд нь бүлтийгээд өргөсөн нэртэй хүрч ядна. Уур хүрээд тайлагдахгүй байнаа хоёр хүүрээ гэж орилбол харин айсан хэрнээ арай дээр өргөв. Манай хоёр ч айснаасаа болоод эхнэрээс нь дутхааргүй нулимс гаргав. Халаасаа ухтал нэг муу тонгорог шүү юм гархаар нь дэлгэж бариад тэлээг огтлов. Сайн бариарай унана шүү гэж хэлж амжихаас өмнө тосч авсан өнөө гурав маана цементен шалан дээр буулгаж байхдаа алдаад бараг шидэж орхилоо. Сүүлд нь толгойн талд нь байсан Буянхишигээс яагаад алдав гэж асуухад нүүрийг нь харж цочоод унагачихсан гэж билээ. Хоолойг нь боосон тэлээг арай гэж тайлав. Цэрэгт байхад бага эмчийн курст юу заалгаснаа санахыг хичээв. Гэвч тодорхой санаж сэргээх зав яаж байх билээ дээ. Цамцыг нь урлаа. Цээжийг гаргаад өмдийг нь бас тайлав. За бас бараг л урсан даа. Зүрхийг нь чагнав. Энэ ч мэдээж л дээ. Яаж цохилох вэ дээ. Төвөнхийг нь тэмтрэхэд чихэгдсэн байв. Номын ёсоор болжээ. Ам хамар хоёрыг нь таглаад аймхай дунд нь хүчтэй дэлсэв. Тэмтрэхэд төвөнх нь гарсангүй. Дахин дэлсэв. Бүгт дуу гарлаа

шүү. Тэмтрэхэд байж байна. Баярласан гэж юүхэв. Нөгөө гуравдаа хэллээ дээ. Энэ хүн амьдаа. Битгий ай. Одоо бүгдээрээ бүх биеийг нь хөдөлгөж массаж хийж цусыг нь эргүүлэе, зүрхийг нь ажиллуулая гэв. Манай хоёр хүрэх янз алга. Өөрөө л эхэллээ дээ. Аймхай дээр нь тоолж байгаад 40-50 удаа дарсан санагдана. Мөн зүрхэн дээр нь ээлжлэн даралт өгч байв. Энэ хооронд нөгөө гурав маана миний заавраар дөрвөн мөчийг нь тасралтгүй хөдөлгөн булчин шөрмөсийг нь атгаж байлаа. Миний хувьд цээжин бие, хүзүү хоолойтой ноцолдсоор цаг руугаа халт харсаар байлаа. Маш удаан ноцолдож байж эхэндээ хамаг бие нь татвагнан хөдлөхөд нь өөрийн зөв байсныг маш сайн ойлгов. Манай гурав үүнийг хараад улам зоригжсон бөгөөд эхнэр нь баярласандаа уйлан нөхрийнхөө булчин шөрмөсийг улам хурдан атгаж иллэг хийж байв. Удалгүй ам нь ангалзан хүндээр амьсгалж эхлэн цустай цагаан хөөс хамар амнаас нь сахарч нүд нь хялайгаад ирлээ. Бид улам идэвхийлэн биеийнх нь бүх булчин шөрмөс үе мөчийг тасралтгүй хөдөлгөсөөр л байлаа. Тэгж тэгж амьсгал нь арай дээрдэн жигдэрч түргэн түргэн амьсгалж эхэллээ. Бас өтгөн шингэнээ зэрэг алдаж дээгүүр доогуур зэрэг зэрэг л юм болов. Бүгдээрээ сая л нэг юм тайвширцгаав. Цагаа хархад бид дөрөв яг 48 минут чадлаа шавхан ноцолджээ. Одоо бүх айдас ард хоцорлоо. Өргөж дамжлан эмгэний гэрийн үүдний амбаарт байх амраг хосын орон дээр нь хэвгүүлэв. Жигд амьсгалж байсан боловч нүдээ нээх ч тэнхэлгүй байгаа нь илхэн байв. Аргагүй шдээ. Нөгөө ертөнцөөс эргэж ирсэн юм чинь. Бид гурав явлаа. Эмгэн охин хоёр баярласан талархсанаа дахин дахин хэлж байв. Байшин дээрээ очоод юу ч ярилцсангүй. Таазан дээрээ тамхи татан сууцгаав. Цаг гарангийн дараа түргэний машин ирж байдаг байгаа. Маргааш нь нэг цагдаа манайд ирлээ. Цагдаагийн хэлтэс дээр очоод гэрчийн мэдүүлэг өгнө үү гэнэ. Дахиад л гурвуулаа очлоо. Хэлтсийн үүдэн дээр харин мань аварга эхнэртэйгээ зогсож байна. За сайн уу бие гайгүй юу гэсэн чинь урдаас ингэж онигоо болж байхаар үхчихдэг байж гэж солиордгийн. Уур хүрээд хэлтэс рүү орсон доо. Саяхан жилийн өмнө хотод тааралдхад эрүүл саруул сайн сайхан л явна лээ. Яамай даа хөөрхий.

Би саяхан хот хооронд явж байгаад машин эвдрээд таньдаг хүнээ дуудаж айлд хоносон юм. Маргааш өглөө нь машинаа засая гээд бүгдэрээ унтсан юм. Надаас гадна 4 хүн цуг явсан гэтэл шөнө миний машин асаад унтрах чимээ гараад тэр үед би сэрээд гэрэл бариад гараад хартал хучсан хэвээрээ байжил байсан. Тэгээд унтаад маргааш өглөө нь машинаа өдржин ноцод асааж чададгүй дахиад нэг хоносон .Ц уг явсан хүмүүсээ өөр машинд өгөөд орой ч болсон найзында орж хоол иджэд унтгал шөнөжин хар дараад миний машин дотор 2 жоохон хүүхэд тоглоод л байхын харанхуй шөнө сайхан байна гээл инээгээд л хаалга онгойлгохгүй гарад явчина. Тэгж шөнөжин хар дараад өглөө нь надад нэг л сонин санагдаад машин гуйж чирүүлээд хашаанаас гараад л зүв зүгээр асцан ямарчгүй болцон би л хувьдаа юу уч янзлагүй одоо болтол гайхаал байна.

### **Гавлын яс**

Багадаа хөдөө гавлын ясаар их тоглодогсон. Хааш нь ч зөөсөн ч маргааш нь эргээд хаана байсан тэндээ л байж байдаг сонин шүү. Аргаа бараад зориуд дээс шидэмс авч очно. Хэдэн нүх, ухархайгаар нь баглаж хүлээд өөр газар аваачин гадас зоож уяна, том чулуунд оосорлон орхино. Маргааш нь ирээд үзвэл ухархайгаар нь баглаж уясан уяа тайлагдаагүй хэрнээ гавлын яс нь байхгүй болчихсон байдагсан. Анхны олсон газар нь ирвэл алин хэзээний тэндээ ирчихсэн хаашаа хараад хэвтэж байсан яг тэрүүгээрээ л байж байна шүү дээ. Одооны

хүүхдүүдэд ярьвал худалч гэх байх даа. Тэхдээ үнэн шүү. Аав ээжээсээ асуугаарай даа. Мэдэх нэг нь мэднэ дээ.

Манайх өнгөрсөн оны 4сард хуучин байранд орсон юм. Ороод 2сар өнгөрсний дараа манай дээд айлд засвар хийгээд амралтын өдрүүдээр ч амраадаггүй байлаа. Удалгүй засварын ажил дууссан бололтой чимээгүй болсон. Сарын өмнөөс юмуу даа дээд айлд эмэгтэй эрэгтэй 2 хэрэлдэнэ шөнө хүүхэд уйлна, бас хүүхдийн гүйх чимээгээр гэрлийн авжуур хөдөлдөг байлаа. Өчигдөр өглөө бас л өнөөх эрэгтэй эмэгтэй 2 хэрэлдэж байх шиг сонсогдсон. Гэтэл өнөөдөр дээд айлаас манайхруу ус алдаад болдоггүй би сандарч очоод хаалгыг нь 10минут шахуу тогшсон хүн байхгүй байлаа. Арга ядаад сөхрүү утастаж тэр айлын эзэнрүү залгуулж дуудуулсан. Нэг 40 гаран настай эгч ирээд яанаа миний охин эгч нь лагерь яваад 10 гаруй хонож байгаа юм уул нь саяхан нэг эргэчхээд явахдаа хамаг усны крантаа хаасан юм гэтэл крант дээшээ нээгдсэн бх юм гэсэн. Тэр эгч энэ байрыг худалдаж аваад засвар хийгээд удахгүй гадаадаас ирэх хүүхдэдээ хадгалж бгаа гэсэн тэгээд 7-10 хоногт нэг удаа эргэж ирдэг гэсэн гэтэл бараг өдөр өнжөөд тэр айлд 2 хүн хэрэлдэнэ орой болохоор хүүхэд гүйгээд л....  
Эвгүй2

За нэлээд дээр үед болсон явдал санаанд орлоо. 1999 оны зун би амралтаараа Ховд аймагт ирсэн байлаа. Тэр үед өмнө нь аймгийн дарга байсан Дамба гуай, жолоочийн хамт бид 3 Ховд аймгийн Мөст сумаас ноос авахаар явлаа. Замдаа нэг хоноод хэдэн айлуудаар ороод "За ер нь ноос олох шинжгүй юм байна" гээд буцаад Мөст сум руу шөнийн 3 цагийн үед явж байтал яг замын голоос 4-5 настай болов уу гэмээр нэвсийсэн хувцастай толгойгүй хүүхэд босоод 3 минут орчим машины гэрэлд гүйж байгаад алга боллоо. Бид тухайн үед "Төөрсөн хүүхэд юм болов уу?" гээд тэр газраа хэсэг эргэлдэж нөгөө хүүхдийг хайгаад олсонгүй. Цааш 20 орчим км яваад Мөст сумын айлд ирээд цай уунгаа сонирхуулж ярьтал гэрийн эзэн нь "Тийм ээ, хэдэн жилийн өмнө сургуулийн хүүхэд ачсан 30 машин явж байгаад яг тэр газар осолдсон юм. Тэр үед нэг жаахан хүүхэд толгойгоо тэвшинд даруулж таслуулсан" гэж билээ.

2005 оны намар юм даа. Олон жил уулзаагүй аавтайгаа уулзах гэж Улаанбаатараас Баянхонгор аймаг руу дүүтэйгээ гарав аа. Нутаг орноо сайн мэдэхгүйг ч хэлэх үү, ямар ч байсан аймаг ороод аймгаас Батцагаан сум орох унаанд амьтан хүнээс асууж сураглаж байгаад суугаад очсон юм. Очоод зорьсон хэрэг ч бүтлээ, аавтайгаа өвөөтэйгөө ах дүүтэйгээ уулзаад сайхан байсан. За тэгээд яваад очиход аав маань өвөөгийн дунд байж таараад тэндээ 2 хонож аваад аавынхаа гэр лүү гарлаа даа. Өвөөгийн байсан газраас нэлээн зайтай гадаа говь болохоор өвөөгийн гэр нь зэрэглээ татаад ард үлдсэн. Байдрагийн голыг дагаж уруудсаар явтал ганц жижиг гэр гараад ирлээ дээ. Аав ч за эндээ л гээд, бид ч буулаа. Сайхан говь хирнээ Байдраг гол хаяанд урсаад усны чимээ сонсогдохын хажуугаар үл ялиг сэрүү татаад л. За тэгээд л хоол унд, цай цүү болов оо. Аав ч нэг юмаа гаргаж шинэ шөл уулгачхаад миний хоёр хүү эндээ хонох уу? Аав нь сум ороод ирье. Амжвал хоногтоо ирнэ ээ гэдэг юм байна. Дүү бид хоёр ч яахав за л гэлээ. Аав ээжээс минь хойш нэг хүнтэй ханилжээ. Тэр хоёрын дундаас гарсан охин нь тухайн үед дөрвөн настай байсан хэлд ороогүй, огт ярьдаггүй гайхмаар. Тэгээд л нөгөө жоохонтойгоо гурвуулаа үлдэв ээ. Хотын мань хоёрт говийн ямааны гэдэс хурцдаж байгааг ч хэлэх үү үе үе гарч сур харваад л, ер нь зүгээр болох шинжгүй шүү. Орой ч боллоо, тал хээр ганц гэр харагдах юм. Тэнгэрт байгаа сарнаас өөр юмгүй уг нь холхон очиж суугаад сур харваж байсан бол оройн жихүүнд бараг л хаяандаа ойртоод суугаад авсан. Гэрэл ч

тасарч харанхуй болов оо. Нөгөө жаахан амьтан нь уйлаад аккумуляторт холбосон гэрэл асахаа ч байлаа. Ер нь унтъя даа болоод л би баруун орон дээр нөгөө хоёр маань зүүн орон дээр хэвтгээд хэрч удсан юм. Гэдэс дуугараад гарахаас ч аймар цаанаа л зэвүүн байсан болохоор унтмаар аядаж дэн дүн хийгээд л байснаа санадаг юм. За тэгээд л гадаа хүүе гэх чимээ гарлаа даа. Яах аргагүй хүн шүү, ахиад л хүүе хүүе би зүүдлээд ч байна уу гэж бодоод нүдээ аниад хэвтгээд л байв. Тэгснээ гэрийн гаднаас гэр шоргоогоод хүүе хүүе хүүе за энэ чинь болохоо байлаа гээд л ум хумгүй нөгөө хоерын ор луу үсрээд орчлоо би. Хэвтэж байхдаа бодов. За хаалга түгжээтэй арай ч ороод ирэхгүй байх, элдвийн юм болвол энэ хоёрыгоо л айлгахгүй юм шүү гэсээр бас л нойрондоо дийлдээд хэсэг унтсан бололтой. Гэнэт л хажууд хүн яваад байна аа. Юм хум түжгэнүүлээд л гал тогооны модон шкафын хаалга онгойгоод л хаагаад л нээрээ бүр яах аргагүй хүн шүү. Тэр зуур за би хаалгаа түгжсэндээ гэж бодохтой зэрэгцэн өнөөх муу дуудаад байсан гайхал чинь ороод ирж гэж бодохгүй юу, за тэгээд л юун айхгүй баатар ёстой хулхи минь буусан даа. Хөдөлж ч чадаагүй хажууд ирээд суух шиг л болсон. Яг л хөлд чинь хүн сууж байгаа мэдрэмж. Тэгснээ сонин сөөнгөтсөн хоолойгоор босоод ир, тоглоё гээд л хүүе босоод ир тоглоё хэд хэдэн удаа хэлсэн. Дараа нь босоод ахиад юм дуугаргаад л яваад байсан. Гэнэт надад хүрэх шиг болсон. Тэгээд л нам айх балмагдах зэрэгцээд л дүүгээ тас тэврээд нүдээ тас аниастай амьсгаа ч авч чадахгүй үүр цайлгасандаа. Үүр цайлгасныг ч мэдээгүй дээ. Тэр гэрт нам гүм болсон. Гадаа мотоцикл дуугараад л тэгээд л нүдээ нээгээд өглөө болсон байсан. Харахад хаалга яаж түгжсэн яг тэр хэвээрээ. Харин зарим нэг шанага түмпэн сав нь газар хэвтэж байсан. Аавын дүү гараад л хаалгаа гээд л тэгээд л нэг амьсгаа авсан даа. Бүгд босоод л цай цүү болоод сууж байх зуураа ааваас шөнийн болсон явдлын талаар асуусан. Харин нэг нөхөр байгаа юм аа. Заримдаа гэр ороод ирдэг юм хум нүдэхээр гараад явчихна гээд хээв нэг хэлдэг юм даа. Сураг сонсохнээ мөрийтэй тоглоомоос л амиа өгсөн нөхрийн сүнс юм уу даа. Хамгийн гол нь тэр зүйлийг би ганцаараа сонсож мэдрээгүй. Миний дүү бас бүгдийг сонссон гэдгээ өглөө аав бид хоёрт хэлсэн дээ. Одоо хааяа нэг найз нөхдөөрөө сууж байгаад сүнс чөтгөр ярихаараа хоёулаа тэр тухайгаа ярьдаг юм. Цагаа тулахаар таарсан үедээ эвгүй хар шаар байна лээ шүү.

Сүнсэнд даруулсан гэсэн пост олон уншаад энэ талаар тайлбарламаар санагдлаа. Олон хүн сүнсэнд даруулсан гэж ярьдаг. Энэ нь үнэндээ сүнсэнд даруулах биш. Зүүд ч биш яг бодит бөгөөд сонирхолтой үзэгдэл. Зөн совин ухамсар өндөр төвшинд сайн байгаа үед ихэвчлэн тохиолддог. Чадах ядахаараа тайлбарлая. Жоохон сунжирсан бол уучлаарай. Сүнсэнд даруулсан хүмүүс бүгд унтахынхаа өмнө, тайван байхдаа, зүүрмэглэх тэр үедээ энийг мэдэрсэн байдаг. Хүн унтахдаа хүний астрал бие (сүнсэн бие) махан биеэ орхиж астрал аялал хийдэг. Энэ нь зүүд юм. Хүн зүүдэндээ ухамсаргүй байдаг (яг бодит амьдрал шигээ хүн зүүдэндээ өөрийгөө удирддаггүй, зүүд цаанаасаа үйл явдалтай байдаг) харин далд ухамсартайгаа байдаг. Энгийнээр тайлбарлахад зүүдлэх үед махан бие ухамсартайгаа үлдэж, астрал бие далд ухамсартайгаа астрал аялал хийж байдаг. Харин сүнсэнд даруулах үйл явц нь хүн яг унтахын өмнө тайвширч бие сулласны дараа яг астрал бие махан биес гарахад бэлэн болох тэр зааг дээр хүний зөн совин ухамсар асар хүчтэй байвал хүн трансд ордог (компютерээр ярьвал ERROR гацаанд орно гэсэн үг). Энэ үед хүн материаллаг ертөнц хийсвэр ертөнц 2 төвшний зааг дээр байна гэсэн үг. Энэ үед хүн махан биеэ удирдаж чадахгүй асар их даралт хэлбэлзлийг мэдэрдэг. Энэ үед ухамсар оюун ухаан ажиллаж байгаа хирнээ махан биеэ удирдаж чадахгүй орилёо орилж чадахгүйхөдлөж чадахгүй сэрж чадахгүй. Сэрэх шаардлага байхгүй айх хэрэггүй ямар ч сүнс таныг дараагүй. Харин ч та энэ

үед ухамсартайгаар яг бодит амьдрал шигээ зүүдээ удирдах бүрэн боломжтой болдог. Энийг астрал аяллын хамгийн дээд хэлбэр буюу биенээсээ гарахыг хэлээд байгаа юм. Хамаг биеэ чангалаад хоолойгоо зангиртал орилох гэж хичээхдээ хүн махан биеэ удирдах гэсээр байгаад сэрчихдэг. Харин ч махан биеэ сул тавиад биенээсээ гарч байна гэж гүн төсөөлж хийхэд л яг жинхэнэ та махан биеэ аажмаар орхидог. (махан биеэсээ гарч сүнсээ удирдахыг хэлээд байгаа юм) яг бодитоор өөрийнхөө сүнсэн биеийг удирдаад агаар дээр нисээд хана нэвглээд бодлын хурдаар хурдлах боломжтой болно. Энэ тохиолдолд хүний оюун бодол тушаал болдог махан биеийн хийж чадахгүй бүх л зүйлийг хийдэг. Та хаашаа очмоор байна Лондон уу? Лос Анжелес? Бүр эсвэл Ангараг уу?..

Намайг 7 настай байхад болсон зүйл. Би нэг орой яг балконы хажууд унтаж байлаа. Тэгээд л унтаж байсан чинь гэнэт л сэрээд яагаад ч юм бүр айгаад байлаа. Балкон онгорхой түүгээр баахан эгч нар миний ор луу ороод би хашхираад аав ээж хүрч ирээд унтуулж байсан. Манай өвөө бөө байсан болохоор өвөө дээр очиж үзүүлсэн чинь яг манай гэрийн доод давхарт 12 эмэгтэй 1995 оны сүүлээр хутгалуулж үхэж байсан гэсэн. Тэр үед миний аура давхарга гэмтсэн гээд нэг бондгор төмрөн юм зүүлгэдэг болсон.

Би 2 юмуу 3 настай байхдаа 5 шард амьдардаг байлаа. Манай гэр их эвгүй байдаг байсан тэр үед болсон зүйлийг их сайн санадаг эмээтэйгээ цуг унтдаг байлаа шөнө болох үед манай өрөөний хаалганы хажууд нэг өндөр (жаахан байсан болохоор өндөхарагдсан байж магадгүй) цагаан өнгөтэй зүйл зогсож байдаг байсан тэрийг харчхаад их айна. Тэгээд эмээг сэрээгээд харуулах гэхээр цаашаа яваад өгдөг байсан. ихэнх шөнө цонхлуугаа харах үед нэг том хар юм унаж байгаа нь харагдаж байсан. Тэр байранд байхад их эвгүй байдаг байсан. Би байнга л өвддөг байлаа. Тэр газраас нүүснээс хойш миний бие сайжирсан тэгээд сүүлд эмээгээс сонсоход тэр байранд өмнө нь хүн ерөөсөө ерөөсөө амьдардаггүй байсан гэсэн. Шал нтрийг нь янзан бүрийн өнгөөр давхарлаад будчихсан тийм байр байсан гэж сонссон.

\*\*\*

Ний нуугүй хэлэхэд би 2009 онд савны хавдартай байсан юм л даа. Эмнэлгээр яваад ерөөсөө эдгэхгүй байсан. Тэгээд нэг сайн Хөвсгөлийн бөө дээр очтол золиосонд гаргах л хэрэгтэй гээд ээж аавд минь учир битүүлэг юм яриад байлаа. Тэгээд л зан үйл хийгээд л байлаа. Би ч нээх тоосонгүй хэд хоногийн дараа гайхалтай юм болсон. Манай гэрийн нохой зүв зүгээр байж байснаа бөгс хавиар нь нэх аймар цус нөж болсон байж байдаг юм. Бид хэд ч эмнэлэг аваад явлаа. Нэмэр болсонгүй шууд тариа тариад алчихлаа шүү. Дүү бид 2 өдөржингөө уйлаад л хөөрхий минь төрж чадсангүй гээд л (тэр үед хээлтэй байсан юм.) уйлаад оршуулаад бөөн юм болсон. Харин аав ээж 2 огт тоогоогүй. Тэгс ингэс гээд л мартсан. Сүүлд ээж минь нохой чинь чиний өмнөөс үхсэн гэдэг юм. Би гайхаад нохойгоо өрөвдөж билээ. Одоо ч гэсэн санаж байна. Маш их баярлаж явдаг.

Би саяхан эмнэлэгт хэвтээд гарсан юм. Хуучнаар тээвэрчдийн эмнэлэг. Өрөөндөө хоёулаа байж байгаад цуг байсан хүн маань гарсан юм л даа. Тэр хооронд ганцаараа хонолоо. Унтахаар болоод хэвтэж байтал аягүй сонин хар дарлаа. Нэг байшингаас гарч чадахгүй олуулаа байна гээд. Тэгээд аймшигтай үйл явдал болж байгаад тэнд байсан нэг хүн гарч яваад машинд дайруулсан юм. Түүний цогцосон дээр нэг хүүхэн ирж хэвтчихээд уйлаад тэгснээ арьсыг нь хуулангаа үнэсэж байна гээд тэр үед зүүдэндээ тэрийг болиулах гэж гарахыг

завдтал яг бугуйгаас хүн татаад сэрээсэн. Гараа ил гаргаад унтаж байсан цагаа хартал 03:27 болж байлаа. Тэгээд жоохож жийрхээд унтаад өглөө боссон. Хамгийн аймар нь гар ийм болсон байсныг орой тариа хийлгүүлэх гэж байхдаа анзаарсан. Магадгүй тариа дулаас болсон байх гэж бодсон ч нөгөө гар маань зүгээр байсан. Хоёуланд нь ээлжилж тариа хийлгэж байсан юм аа.

\*\*\*

Олон жилийн өмнө би нэг сонин зүүд зүүдэлсэн юм. Тэр үед өвчтэй байлаа. Тэр шөнө нойр хүрэхгүй их тарчилсан, арай гэж унтлаа даа. Тэгсэн чинь би өөрөө өөрийгөө хөндлөнгөөс хардаг юм байна аа. Би аймар хөх царайтай бас муухай аашгай болчихсон бололтой хавь ойр байсан хүмүүс айгаад л. Би хүртэл өөрөөсөө айгаад аавынхаа ард нуугдсан чинь миний хөлнөөс нөгөө зүүдний ихэр гэх юм уу тэр нь зуураад авдаг юм байна. Үхтлээ айсан. Сэрье гээн ч сэрж чадахгүй бас би өөрөө өөртөө энэ зүүдийг мартаж болохгүй гэж сануулаад л арай гэж сэрсэн. Одоо хүртэл тэр зүүд минь өчигдөрхөн зүүдэлсэн юм шиг тодхон санагдаж байна. Хааяа нүдээ аниад бодохоор нээх сонин айдас авгчихдаг.

\*\*\*

Энэ явдал намайг 4 жилийн өмнө анх бөөрний өвчтэй болоод эх нялхаст хэвтэж байхад болсон юм. Тухайн үед тусгай төлбөртэй өрөө гэж байдаг байсан юм л даа. Тэнд нэг хүнд өвчтэй хүүхэд ээжтэйгээ цуг хэвтэж байсан юм. Нэг шөнө бие засах гээд угаалгын өрөө ороод буцаад өрөө лүүгээ нойрмог явж байлаа. Нөгөө өрөө өөдөөс харсан байдаг болохоор яалт ч үгүй дайраад өнгөрнө. Тэгээд хальт харсан буланд нь нэг хар сүүтгэнэсэн юм ажиглагдсан юм. Нойрмог болохоор нээх тоолгүй унтсан. Харин маргааш нь тэр өрөөнд байдаг хүү нас барсан байсан. Тэгээд юу харснаа тэнд байдаг бөө охинд хэлтэл угаасаа жоохон эвгүй өрөө тийшээ ер нь яваад байх хэрэггүй гэж хэлсэн.

Би 10 настай байсан. Лагерь дээр ах нар аймшгийн юм яриад намайг айлгаад л тэгсээр байгаад унтлаа. Нээх гоё зүүд зүүдэлж байтал яагаад ч юм бүү мэд сэрихлээ. Гэтэл гэнэт орноосоо өргөгдөөд эхлэв. Биеэ хөдөлгөж чадахгүй, хаалганы хажууд нэг охин уйлаад хажуу тийшээ хартал баахан үхсэн цагаан даавуугаар хучигдсан муухай үнэртэй цогцоснууд ахын ярсан аймшгийн юмнууд гарч ирээд золтой л зүрх амаар гарчихсангүй. Шал баахан цус таазнаас намайг нэг хүн татаад маргааш өглөө нь сэртэл яагаа ч үгүй бүх зүйл зүв зүгээр. Харин тэр оройноос хойш манай нэг ах ерөөсөө аймшгийн юм ярьдаггүй болчихсон.

# Table of Contents

[Эхлэл](#)

[Өмнөх үг](#)

[Нэгдүгээр бүлэг](#)

[Хоёрдугаар бүлэг](#)

[Гуравдугаар бүлэг](#)

[Дөрөвдүгээр бүлэг](#)